

С
363.2
Б-342

Албан хэрэгцээнд зориулав

ЦАГДАА СУДЛАЛ

Онол арга зүйн
улирал тутмын
сэтгүүл

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Баянмөнх

Хэвлэлийн хуудас: 10.5 х/х

Цаасны хэмжээ: А.4

Өрөлтөд орсон огноо: 2024.05.08

Дугаарыг эрхлэн гаргасан: Доктор (Ph.D) Б.Баянмөнх

ISBN 978-99962-8882-2-7

2024 №2 (39)

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга: **Ж.Болдбаатар** Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Зөвлөлийн гишүүд:

Ж.Долгорсүрэн Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Ж.Болдбаатар Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Б.Пүрэв Хууль зүйн доктор (Ph.D), хүндэт профессор

Ж.Заанхүү Түүхийн шинжлэх ухааны доктор, (Sc.D), дэд профессор

Г.Гантөмөр Хууль зүйн доктор, (Ph.D), профессор

Ч.Нямсүрэн Хууль зүйн доктор (Ph.D), профессор

З.Төрмандах Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Т.Оюунчимэг Хууль зүйн доктор (Ph.D), профессор

Сэтгүүлийн эрхлэгч: Хууль зүйн доктор (Ph.D), профессор **Бө.Бат-Эрдэнэ**

Нарийн бичгийн дарга: Хууль зүйн доктор (Ph.D) **Б.Баянмөнх**

Сэтгүүлийн редакцийн зөвлөл:

Т.Бямбаа Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

О.Цэцэгмаа Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Д.Энхжаргал Хэл шинжлэлийн ухааны доктор (Ph.D)

Д.Мягмарцэрэн Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Ш.Ариунбилэг Хууль зүйн доктор (Ph.D) дэд профессор

Б.Баянмөнх Хууль зүйн доктор (Ph.D)

Г.Бямбадорж Хууль зүйн доктор (Ph.D)

*Манай хаяг: Дотоод хэргийн их сургууль Баян зүрх дүүрэг, Цагдаагийн Академийн өргөн чөлөө, хилчиний гудамж-1, утас: 99878219
мэйл хаяг: b.bayadaa2007@gmail.com*

ЦАГДАА СУДЛАЛ
Онол арга зүйн улирал тутмын сэтгүүл
(дугаар 2024 №2)

АГУУЛГА

ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Ганболд. OSINT (open-source intelligence) буюу нээлттэй эх сурвалжаас мэдээлэл цуглуулах.....	4
Б.Батзаяа. Хүн худалдаалах гэмт хэрэг ба хохирогчидилрэх сэтгэцийн гэмтлийн нийтлэг шинж тэмдэг.....	9

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Энхцогт. Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн талаарх эрүүгийн эрх зүйн түүхэн уламжлал, шинэчлэл.....	9
Б.Баярболд. Гэм буруугийн андуурал ба олон улсын туршлага.....	17
М.Болор. Өсвөр насны хүнээс хүчингийн гэмт хэрэг үйлдэж буй шалтгаан нөхцөл.....	24
Б.Наргулан. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, түүний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал.....	29
А.Баасанцэрэн. Монгол Улсын мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, түүнээс урьдчилан сэргийлэх нь.....	
Ц.Очгэрэл. Галт зэвсгийн хууль бус эргэлтийн тухай ойлголт, төрөл, хэлбэр.....	37

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Одбаатар. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны орчинд хийсэн нөлөөллийн шинжилгээ.....	44
М.Эрдэнэбилэг. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд олон нийттэй харилцах ажил, арга хэмжээний эзлэх байр суурь.....	53
Д.Нямдорж. Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах зарим асуудал.....	59
Б.Батбаяр. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам.....	64
Д.Цэрэнлхам. Үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэхэд эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг, оролцоо.....	73

ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ОНОЛ ПРАКТИК

Г.Төртүлгэ. Цагдаагийн байгууллагын алба хаагчаас нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхэд анхаарах зарим асуудал.....	78
--	----

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

С.Индра Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчилд оногдуулж буй шийтгэлд хийсэн дүн шинжилгээ.....	84
М.Ринчинбу. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдалд хийсэн шинжилгээ.....	93

ДОТООДЫН ЦЭРГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Г.Мэндбаяр. Харуулын албаны журам зөрчих гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлага.....	99
---	----

**OSINT (OPEN-SOURCE INTELLIGENCE) БУЮУ НЭЭЛТТЭЙ
ЭХ СУРВАЛЖААС МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ**

*Б.Ганболд, Дотоод Хэргийн Их Сургуулийн
Цагдаагийн сургуулийн Гүйцэтгэх ажлын
тэнхимийн багш, цагдаагийн ахмад
B. Ganbold, lecturer of the Department of
Criminal intelligence at the Police School of
the University of Internal Affairs, police
captain*

Хураангуй: OSINT гэж юу вэ? OSINT гэдэг нь нээлттэй эх сурвалжаас мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг хэлдэг. Нээлттэй эх сурвалжууд гэдэгт засгийн газар, банк санхүүн мэдээллийн сан, хувь хүн албан байгууллагын веб сайтууд, олон нийтийн мэдээллийн платформууд болон сонин хэвлэл гэх мэт бусад мэдээллийн эх сурвалжууд орно.

Abstract: What is OSINT? OSINT refers to the collection of information from open sources. Open sources include government and banking databases, websites of individuals and organizations, social media platforms and other sources of information such as newspapers.

Түлхүүр үгс: OSINT- нээлттэй эх сурвалж, гэмт хэрэгтэй тэмцэх, кибер орчноос мэдээлэл цуглуулах

Keywords: OSINT- open source intelligence, crime fighting, intelligence gathering from the cyber environment

Оршил: OSINT-буюу нээлттэй эх сурвалжаас мэдээлэл цуглуулах аргыг хууль сахиулах байгууллагаас кибер орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргийг илрүүлэх, мөн кибер аюулгүй байдлын мэргэжилтнүүд итгэлцэл, аюулгүй байдал эрсдэлийн менежмент хийхэд ашигладаг. Үүнээс гадна хүний нөөцийн болон бизнесийн менежерүүд ажилчид эсвэл түншүүдээ сайтар судлахын тулд OSINT-ийн хэрэгслийг ашигладаг байна. Кибер орчинд нээлттэй эх сурвалж \OSINT\ ашиглан мэдээлэл ямар мэдээлэл цуглуулах боломжтой талаар тоймлон харуулав. Жишээлбэл

- Хувь хүмүүсийн физик байршил
- Олон нийтийн мэдээллийн платформууд дээрх мэдээлэл
- Хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагын нэр дээр бүртгэлтэй домэйн нэр, сервер, цахим шуудангийн хаягууд
- Төрийн байгууллагын ил тод байдлын мэдээллийн сангууд, зөрчлийн бүртгэл, эзэмшиж буй лиценз гэх мэт. Эдгээр мэдээллийг албан ёсны мэдээллийн сан дээрх мэдээлэл, мэргэжлийн байгууллагаас өгсөн хувийн мэдээлэл гэж ангилдаг.
- Блог, сэтгүүлийн нийтлэл, мэдээний нийтлэл, хурлын материал
- Гар утасны мэдээллүүд болох утасны дугаар, төхөөрөмжийн төрөл, ашиглагдаж буй программууд гэх мэт.

Олон улсад хууль сахиулах байгуулга гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор ашиглаж болох мэдээ мэдээллийг үндсэн гурван эх сурвалжаас цуглуулдаг байна. Нэгдүгээрт: нээлттэй эх сурвалжийн ашиглах (OSINT- open-source intelligence), хоёрдугаарт: кибер

орчинд мэдээлэл цуглуулах (CYBINT), гуравдугаарт: хүн эх сурвалж ашиглан мэдээлэл цуглуулах (HUMINT)¹. Үүнээс бид OSINT буюу олон нийтэд ил байдаг нээлттэй эх сурвалжаас (интернет болон бусад нээлттэй эх сурвалж) мэдээлэл цуглуулах тэр дундаа кибер орчинд нээлттэй эх сурвалжаас мэдээлэл цуглуулах үйл явцын талаар дэлгэрэнгүй авч үзье.

OSINT ХЭРЭГСЛҮҮД

Нээлттэй эх сурвалжаас \OSINT\ мэдээлэл цуглуулах зорилгоор дараах хэрэгслүүдийг ашиглах боломжтой. Эдгээр хэрэгслүүд ямар чиглэлээр мэргэшсэн, юугаараа өвөрмөц, ялгаатай болохыг доор харуулав.

Maltego: Малtego нь хүмүүс, компаниуд, домэйн болон интернэт дэх олон нийтэд нээлттэй мэдээлэл хоорондын харилцааг илрүүлэх чиглэлээр мэргэшсэн мэдээллийн сайт юм. Дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.maltego.com/> хаягаар нэвтэрч судлаарай.

Mitaka: Та өөрийн ашиглаж байгаа интернэт хөтөч болох Chrome эсвэл Firefox дээр нэмэлтээр Mitaka-г үнэгүй суулгаснаар олон төрлийн хайлтын системээс IP хаяг, домэйн нэрийн бүртгэл, URL, хэш, биткойн түрийвчний хаяг гэх мэт төрөл бүрийн мэдээллийг өөрийн вэб хөтчөөсөө хайх боломжийг олгоно.

Хэрэгслийг <https://github.com/ninoseki/mitaka> хаягаар нэвтэрч суулгаарай.

Spiderfoot: нь IP хаяг, домэйн болон дэд домайн, имэйл хаяг, утасны дугаар, хэрэглэгчийн нэр, BTC хаяг мэт мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийх боломжтой олон төрлийн мэдээллийн эх сурвалжтай нэгтгэсэн үнэгүй OSINT хайгуулын хэрэгсэл юм. Та Spiderfoot программыг GitHub дээрээс татаж суулгах боломжтой.

Хэрэгслийг <https://github.com/smicallef/spiderfoot> хаягаар нэвтэрч суулгаарай.

BuiltWith: BuiltWith сан нь таны сонирхсон вэбсайтууд юугаар бүтээгдсэнийг олох боломжийг танд олгоно. Вэбсайтууд нь янз бүрийн технологийн арга, платформууд өөр өөр сайтуудыг ажиллуулж байдаг.

<https://builtwith.com/> хаягаар орж туршиж үзээрэй.

Intelligence X: программ нь вэб хуудаснуудын түүхэн хувилбаруудыг төдийгүй агуулгын үл нийцэх шинж чанар эсвэл хууль эрх зүйн шалтгааны улмаас вэбээс устгагдсан мэдээллийн багцыг бүхэлд нь хадгалж байдаг архивын үйлчилгээг агуулсан хайлтын систем юм.

<https://intelx.io/> хаягаар орж туршиж үзээрэй.

Grep.app: Та интернэтээр өөрт хэрэгтэй программчлалын эх кодыг хэрхэн хайх вэ? Мэдээжийн хэрэг GitHub, GitLab эсвэл BitBucket-ийн санал болгож буй хайлтын талбаруудыг та ашиглаж болно.

<https://grep.app/> хаягаар орж туршиж үзээрэй.

Вэбсайтаас мэдээлэл цуглуулах: Албан байгууллага хувь хүний талаарх мэдээллүүдийг вэбсайтаас олох боломжтой байдаг. Дараах мэдээллийг цуглуулах боломжтой. Үүнд:


- Тэд юу хийдэг;
- Тэдний үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ;
- Хаяг байршил;
- Нээлттэй ажлын байрууд;
- Холбоо барих утасны дугаарууд;

¹ <https://www.crowdstrike.com>

- Захирлууд эсвэл ажилчдын талаарх мэдээлэл, намтар;
- Хамтран ажилдаг албан байгуулга;
- И-мэйл хаяг;
- Холбоо барих утасны дугаар гэх мэт.

Цагдаагийн байгууллагын мөрдөгч гэмт этгээдийн талаар олон нийтийн мэдээллийн сайтуудаас /нээлттэй эх сурвалж/ төрөл бүрийн мэдээлэл цуглуулах боломжтой, тэд өөрсдийн зураг, байшин, тээврийн хэрэгсэл, ажил гэх мэт амьдралынхаа бараг бүх нарийн ширийн зүйлийг кибер орчинд нийтлэх тохиолдол их байдаг. Ихэнх тохиолдолд нэг газар хамт ажилладаг хүмүүс олон нийтийн мэдээллийн сайтууд дээр нэг бүлэг болж холбогдсон байдаг. Хэрэв мөрдөгч LinkedIn эсвэл Facebook дээр нэг ажилтан олсон бол түүгээр дамжуулан бусад бүх ажилчдыг тодорхойлох боломжтой. Ихэнх хүмүүс өөрсдийн ажил албан тушаалын талаар олон нийтийн мэдээллийг хэрэгсэлд оруулсан байдаг. Энэ мэдээллүүд нь мөрдөгчид тухай албан байгууллагын талаарх мэдээлэл, дотоод бүтэц, хэлтэст хэдэн хүн ажилладаг болох гэх мэт мэдээллүүдийг тодорхойлоход тусална.


Хайлтын систем ашиглан мэдээлэл цуглуулах: Веб сайт дээр нийтлэгдээгүй мэдээллийг олохын тулд дэвшилтэт хайлтын операторуудыг ашиглан хайлтын системээс мэдээлэл олох боломжтой. Энэ аргыг Google dork буюу dork гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл google dorking буюу Google-ийг хакердах арга нь энгийн хайлтын асуултаар олоход хэцүү мэдээллийг тусгай компьютерын хэл \query\ ашиглан олох юм. Жишээлбэл: site:news.mn filetype:pdf гэж бичин хайлт хийвэл www.news.mn домэйн дээрх PDF өргөтгөлтэй нийтийн хүртээл болгоход зориулаагүй файлуудын жагсаалтыг гаргаж ирдэг.



Зураг дээр google dorking ашиглах аргыг харуулав

Өөрт хэрэгтэй мэдээллийг цуглуулахын тулд хайлтын нэр томъёог мэддэг байх хэрэгтэй. Ямар нэг мэдээллийг хайхдаа filetype:pdf, filetype:doc, filetype:xls, filetype:txt гэж хайдаг зуршилтай болох. Энэ нь бидэнд DAT, CFG эсвэл бусад мэдээллийн сан эсвэл сервер дээрээ тухайн байгууллагын ажилчдын нээлттэй орхисон, хуулаад мартсан файлуудыг авах боломжийг өгдөг. www.googleguide.com/advanced_operators.html гэх холбоосоор илүү дэлгэрэнгүй мэдээллийг авч бие даан суралцах боломжтой.

Whois сангаас мэдээлэл цуглуулах: Whois гэдэг нь интернет үйлчилгээ үзүүлэгч компани, домэйн нэр эзэмшигчдийн талаарх мэдээллийг агуулсан мэдээллийн сангийн юм. Whois мэдээллийн сан нь зарим тохиолдолд веб сайтын администраторуудын талаарх бүрэн мэдээллийг агуулж байдаг асар том мэдээллийн сан юм.



Whois санг харуулав.

Мөн Whois мэдээллийн сан нь тодорхой IP хаягуудын мэдээллийг агуулж байдаг. Мөрдөгч Whois мэдээллийн санг ашиглан тухайн IP хаяг бүртгэлтэй интернэтийн үйлчилгээ үзүүлэгч компанийг тогтоож, тус компанид хандсанаар тухай IP хаягийг ямар байгууллага, компани, хувь хүн ашиглаж байсан талаарх мэдээллийг тогтоох боломжтой.

Мөн whois санг ашиглан домейн нэрийн бүртгэлийн мэдээллийг олох боломжтой. Жишээ нь www.news.mn веб хуудасны домейн нэрийг шалгаж үзэхэд:

 **DomainTools** PROFILE CONNECT MONITOR SUPPORT

Whois Lookup

```
Domain Name: news.mn
Registry Domain ID: 766ef55a524a42c8b329ed89b9dbf947-DONUTS
Registrar WHOIS Server: whois.nic.mn
Registrar URL: https://datacom.mn/
Updated Date: 2023-07-17T03:40:31Z
Creation Date: 2007-07-18T19:22:53Z
Registry Expiry Date: 2024-07-18T19:22:53Z
Registrar: Datacom Co., Ltd.
Registrar IANA ID: 800036
Registrar Abuse Contact Email: abuse@datacom.mn
Registrar Abuse Contact Phone: +976.11311411
Domain Status: clientTransferProhibited https://icann.org/epp#clientTransferProhibited
Registry Registrant ID: 46e14408d685461980dd98efd60f440f-DONUTS
Registrant Name: ANARHUU Ganbat
Registrant Organization: N/A
Registrant Street: 59 bair, 21 toot, narnii zam gudam 5 horoolol 5-r horoo
Registrant City: Ulaanbaatar
Registrant State/Province: Ulaanbaatar
Registrant Postal Code: 11000
Registrant Country: MN
Registrant Phone: +976.93337777
Registrant Phone Ext:
Registrant Fax:
Registrant Fax Ext:
Registrant Email: temuulen\_mgl@yahoo.com
Registry Admin ID: 3ad286b8526c4e3abf23c67648347403-DONUTS
Admin Name: ANARHUU Ganbat
Admin Organization: N/A
Admin Street: 59 bair, 21 toot, narnii zam gudam 5 horoolol 5-r horoo
Admin City: Ulaanbaatar
```

- Серверийн IP хаяг нь 43.231.115.241, Монгол улс, Улаанбаатар хот, Itools ХХК-дээр байршилтай ба эзэмшигчийн нэр, холбогдох утасны дугаар, имэйл хаяг гарч ирж байна.

Иймд www.whois.com, www.who.is, www.whois.domaintools.com гэх мэт санг ашиглан эзэмшигчийн мэйл хаяг, утасны дугаар, DNS серверийн IP хаягийн талаарх мэдээллийг олох боломжтой юм.

Практикт веб сайт эрхлэгчдийн мэдээлэл, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан IP хаяг бүртгэлтэй интернэтийн үйлчилгээ үзүүлэгч компанийн мэдээлэл зэргийг авахын тулд мөрдөгч албан бичиг төлөвлөн холбогдох байгууллага руу илгээж цаг алдах тохиолдол их байдаг. Үүний оронд мөрдөгч өөрийн интернэт холболттой гар утас, нотебүүк эсвэл компьютерыг ашиглан Whios мэдээллийн санд нэвтэрч дээрх мэдээллийг түргэн хугацаанд олж авах боломжтой юм. Мөн Whois мэдээллийн сан нь сонирхож буй компанийн танилцуулга, серверийнх нь талаарх дэлгэрэнгүй мэдээллийг авахад их тустай байдаг. Энэ аргыг ашиглан нэмэлт бусад мэдээллийг цуглуулах боломжтой.

Олон нийтийн сүлжээ сайт ашиглан мэдээлэл цуглуулах: Иргэд албан байгууллагууд олон нийтийн сүлжээг өргөн ашиглах болсон. Энэ бол олон тооны боломжит худалдан авагчдыг нэг дор хамруулсан маркетингийн үр дүнтэй хямд арга юм. Нөгөө талаас хувь хүн албан байгууллын талаарх мэдээллийг агуулсан маш том мэдээллийн урсгал юм. Албан байгууллага нь өөрийн үйл ажиллагаа, байгууллагын талаарх мэдээ, шинэ бүтээгдэхүүн, хэвлэлийн мэдээ, гэх мэт одоогийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нийтлэн, түүх үүсгэн хадгалагдсан байдаг. Сүүлийн үед Twitter, Instagram, Facebook, LinkedIn, Tiktok, Youtube болон бусад сайтуудын тусламжтайгаар хангалттай их мэдээллийг олж авах боломжтой.

Дүгнэлт: Дээрх жишээнүүд дээр хэлэх гэсэн гол нь санаа бол мэдээллийг хэрхэн ашиглах биш харин нээлттэй эх сурвалжаас мэдээллийг яаж цуглуулахад гол учир нь байгаа юм. Мэдээлэл цуглуулахад ашиглаж болох эх сурвалжууд, ашиглах арга тус бүр харилцан адилгүй. Мэдээлэл цуглуулах олон төрлийн эх сурвалжууд байдаг гэж өмнө дурдсан. Цагдаагийн эрүүгийн мөрдөгч бүх төрлийн эх сурвалжийг чадварлагаар ашиглан, тэдгээрийн давуу болон сул талуудыг судлан гэмт хэрэгтэй тэмцэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой мэдээллийг бие даан цуглуулах боломжтой юм.

Ашигласан материал:

1. Эрүүгийн мөрдөгч: гарын авлага төсөл 2023 он
2. <https://www.kaspersky.com>
3. <https://www.cisco.com>
4. <https://www.crowdstrike.com>
5. <https://www.csoonline.com>

**ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ БА ХОХИРОГЧИД
ИЛРЭХ СЭТГЭЦИЙН ГЭМТЛИЙН НИЙТЛЭГ ШИНЖ ТЭМДЭГ
TRAUMA-INFORMED COMMUNICATION WITH CHILD VICTIMS OF
TRAFFICKING IN PERSONS**

Дотоод хэргийн их сургуулийн ЦС-ийн

ЭПЭЗТ-ийн ахлах багш,

цагдаагийн хошууч Б.Батзаяа

[\(bbatzaya5181@gmail.com\)](mailto:bbatzaya5181@gmail.com)

Batzaya.B (Police Major)

Senior Teacher, Criminal Procedure Law Department,

School of Police, University of Internal Affairs

Хураангуй: Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь гэмт хэргийн улмаас бий болсон сэтгэцийн гэмтэл болон хууль хяналтын байгууллагаас түүнд зохих ёсны хамгаалалтыг аваагүйгээс үүдэн бусдын дарамт шахалт, ятгалга, заналхийлэл, хууран мэхлэлт зэрэг аливаа хэлбэрээр нөлөөлөлд автаж, гэмт хэргийн талаар зөрүүтэй мэдүүлэг өгөх, өөрийг нь хохироосон гэмт хэрэгтнийг өмөөрсөн мэдүүлэг өгөх, болсон явдал өөрт нь бус бусдад тохиолдсон мэтээр ярих зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндрэл учруулах тохиолдол ч цөөнгүй гардаг. Энэ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт буюу тасралтгүй, хурдан шуурхай хэргийг илрүүлэх боломжийг алдагдуулахаас гадна хохирогч сэтгэл зүйн хувьд дахин хохирох үндэслэл болдог байна.

Иймд сэтгэцийн гэмтэлд суурилсан арга барилаар буюу хохирогч төвтэй хандлагаар ярилцлага хийж, мэдүүлэг авах нь хохирогчийн сэтгэцийн гэмтэл, цочролыг дахин гэмтээхээс сэргийлэхээс гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тустай юм.

Abstract: Although victims are provided with certain protections and safeguards stipulated in the Criminal Procedure Code and the Law on Witness and Victim Protection during investigation, measures for psychological protection are often disregarded by law enforcement and a pursuit for obtaining evidences only for prosecution is prioritized. This situation leaves victims without sufficient assistance and support for recovery and reintegration.

Moreover, there are many cases where victims are interfered by pressure, persuasion, threats, or deception of the perpetrators and cause troubles in criminal investigation by giving misleading and inconsistent testimonies, defending the perpetrator or pretending the incident has occurred to others due to trauma caused by the crime and absence of appropriate protection from the law enforcement.

It not only undermines the main objective of criminal procedures to promptly detect crimes, but also causes re-traumatization to the victim. Thus, interview based on trauma-informed and victim-centered approaches prevent re-traumatization and benefits the criminal proceedings.

Түлхүүр үг: Сэтгэл зүйн гэмтэл, Мөрдөн шалгах ажиллагаа, Хүний эрх

Key words: trauma-informed Investigating and prosecuting, Human rights

1.1. Сэтгэцийн гэмтэл ба комплекс гэмтлийн дараах стрессийн тухай ерөнхий ойлголт

Хүн сэтгэцийн гэмтэлд өртсөн тохиолдолд энэ нь түүний тархины лимбийн системийн үйл ажиллагаанд бүхий л амьдралынх нь турш сөргөөр нөлөөлдөг байна.

Тиймээс тухайн хүн сэтгэцийн гэмтлийг насан туршдаа даван туулах шаардлагатай болдог гэж үздэг. Гэхдээ таагүй үйл явдал болгон сэтгэцийн гэмтэл үүсгэхгүй бөгөөд ижил үйл явдал нэг хүнд сэтгэцийн гэмтэл учруулж байхад, өөр хэн нэгэнд тийм үр дагавар үүсгэхгүй байж болох юм. Тиймээс судлаачид тухайн үйл явдлын туршлага (сэтгэцийн гэмтлийн шинжтэй эсэх) нь хүн бүрд харилцан адилгүй байх тул “гэмтэл үүсгэж болзошгүй үйл явдал” гэсэн нэр томъёог түгээмэл ашигладаг.²

Сэтгэцийн гэмтэл нь дараах шалтгааны улмаас үүсэж болно. үүнд:

- Хүн хоорондын харилцаанаас үүдэлтэй зарим таагүй тохиолдлууд;
- Хүчирхийллийн шинжтэй үйлдэл (бэлгийн, бие махбод, сэтгэл санаа, нийгэм, эдийн засаг);
- Хүүхэд насанд тохиолдсон хүчирхийллийн үйлдэл, ойр дотны хүнээс хагацсан байдал;
- Дам сэтгэцийн гэмтэл буюу хоёрдогч сэтгэцийн гэмтэл;
- Амь нас, эрүүл мэндэд эрсдэл учруулж болохуйц осол, түүнээс үүдэлтэй гэмтэл;
- Дайн, зэвсэгт мөргөлдөөн;
- Байгалийн гамшиг гэх мэт.

Дээрх нийтлэг шалтгаанууд нь тухайн хүний онцлог, даван туулах чадвар, амьдралын туршлагаас шалтгаалан сэтгэцийн гэмтэл үүсгэх боломжтой байдаг.

СЭТГЭЦИЙН ГЭМТЛИЙН ТӨРЛҮҮД		
Цочмог хурц буюу нэг удаа болоод өнгөрсөн үйл явдлаас үүссэн гэмтэл	Архаг ужиг буюу олон удаагийн давтагдсан үйл явдлаас үүссэн гэмтэл	Комплекс гэмтэл
Зам тээврийн осолд орох, хулгай, дээрэм гэх мэт гэмт хэргийн халдлагад өртөх, бие махбод болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртөх, түүнийг гэрчлэх гэх мэт таагүй үйл явдлаас хойш нэг сар хүртэлх хугацаанд илэрч болно.	Дайн, зэвсэгт мөргөлдөөн, гэр бүлийн хүчирхийлэл, архаг хууч өвчний үр дагавар, хүнд хэлбэрийн мэс ажилбар, орон гэргүй удаан хугацаанд байх гэх мэт харилцаанаас үүдэлтэй гэмтэл.	Ихэнхдээ итгэл даасан, асран хамгаалдаг байсан хэн нэгний зүгээс хохирогчид давтан, удаан хугацааны туршид бэлгийн, бие махбодь болон сэтгэл санааны хүчирхийлэл үзүүлэх, бие махбодын ноцтой гэмтэл, эмчилгээний үйл явцаас үүсэх сэтгэцийн гэмтэл, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч/даван туулагч болох гэх мэт.

² Trauma Super Conference. (2020). Conscious Life.

Үндсэн шинж	Палермогийн протокол
Гэмт үйлдэл (аль нь ч байж болно) – Ямар үйлдлийг хүн худалдаалах гэмт хэрэгт тооцох вэ?	Хүнийг элсүүлэх, тээвэрлэх, орогнуулах, дамжуулах, хүлээн авах
Үйлдлийн арга (аль нь ч байж болно) – Хэрхэн үйлддэг вэ?	Хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, залилах, эрх мэдлээ урвуулах, эмзэг байдлыг нь далимдуулан ашиглах, эсхүл бусдыг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах
Зорилго (аль нь ч байж болно) – Ямар зорилгоор үйлддэг вэ?	Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох буюу түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд эрхтнийг нь авах
Дээрх аргын аль нэгийг ашигласан тохиолдолд хохирогч өөрийг нь дээрх үйлдлийн аргаар хохироож байгааг өөрөө зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан хүн худалдаалах гэмт хэрэгт тооцно. Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энд заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.	

Хүн худалдаалах гэмт хэрэг НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол (цаашид “Палермогийн протокол” гэх)-ыг 2000 онд батлан гаргаснаар “Хүн худалдаалах гэмт хэрэг” хэмээх нэр томъёо олон улсын түвшинд анхлан тодорхойлогджээ. Энэхүү протокол нь олон улсын гэрээ бөгөөд гэрээнд нэгдэн орж, гарын үсэг зурсан бүх улс орон дагаж мөрдөх үүрэгтэй.

Палермогийн протоколын 3 дугаар зүйл: (а) “Хүн худалдаалах” гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, залилах, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл бусдыг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ.

Хүнийг мөлжих гэдэгт биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох буюу түүнтэй төстэй нөхцөлд байлгах, эд эрхтнийг нь авах үйлдлийг ойлгоно.

(б) Дээрх аргуудын аль нэгийг ашигласан тохиолдолд хохирогч өөрийг нь (а) хэсэгт заасан байдлаар мөлжих гэж байгааг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.(в) Мөлжих зорилгоор хүүхдийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авсан аливаа үйлдэл нь (а) хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй хүн худалдаалах гэмт хэрэгт тооцогдоно.(г) Хүүхэд гэж 18 нас хүрээгүй хүнийг хэлнэ.

Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13.1 дүгээр зүйлд хүн худалдаалах гэмт хэргийг хуульчлахдаа НҮБ-ийн Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт Палермогийн протокол, Хүн худалдаалахтай тэмцэх тухай Монгол Улсын хуулийн агуулгад нийцүүлж, 2002 оны Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай 2008 оны Улсын дээд шүүхийн 12 дугаар тогтоол, Эрүүгийн хуульд заасан хууль тогтоогчийн тайлбарыг тус тус гэмт хэргийн объектив талын шинжид багтаан дараах байдлаар хуульчилсан.

Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах 1.Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж;

2.2.хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж;

2.3.Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг:

3.1.байнга тогтвортой;

3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.

-Энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход хохирогч өөрийг нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хохироож байгааг өөрөө зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.

Хүн худалдаалах гэмт хэрэг нь хүний хувийн эрх, эрх чөлөө, халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халддаг, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл бөгөөд олон улсын шинжтэй гэмт хэрэгт тооцогддог.³

2.1 Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч/даван туулагч гэж хэн бэ?

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1985 оны 40/34 дүгээр шийдвэрээр баталсан “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирсон хохирогчдын шударга ёсыг тогтоох үндсэн зарчмын тухай тунхаглал”-д гэмт хэргийн хохирогчийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. **“Хохирогч”** гэж ганцаараа эсхүл олуулаа бие махбод, сэтгэл санаа, эдийн засгийн хувьд хохирол амсаж, тунхаглалд нэгдэн орсон улс орнуудын Эрүүгийн хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас үндсэн эрх нь зөрчигдсөн хүнийг хэлнэ. Энэхүү тунхаглал ёсоор буруутай этгээдийг тогтоосон, баривчилсан, гэм бурууг нь илчилсэн эсэх болон хохирогч, буруутай этгээд хоёр хоорондоо цусан төрлийн холбоотой эсэхээс үл хамааран тухайн хүнийг “хохирогч” гэж үзэж болно. Шаардлагатай гэж үзвэл хохирогчийг гэмт хэргийн золиос болгуулахгүйн тулд өмгөөлж, хамгаалж байсан гэр бүлийн гишүүд, хохирогчоос хамааралтай байдаг хүмүүсийг “хохирогч” гэх нэр томъёонд оруулж болно.

Монгол Улсын хуулиудад хохирогчийг дараах байдлаар тодорхойлдог.

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд заасны дагуу Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг **“хохирогч”** гэнэ.
- Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дугаар зүйлд заасны дагуу “Эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг **“хохирогч”** гэж тус тус заасан.

Бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүмүүсийг “даван туулагч” эсвэл “хохирогч” гэж нэрийдэх талаар салбарын эрдэмтэд, хүний эрхийн идэвхтнүүд өнөөг хүртэл мэтгэлцэж байна. Тухайлбал, судлаач Данн ”Аливаа төрлийн хүчирхийлэлд өртсөн хүнийг хохирогч гэж нэрлэснээр аргагүй байдалд орсон, гарцгүй, тусламж авч чадаагүй, сул дорой, идэвхгүй гэдэг санааг илтгэдэг бол эсрэгээрээ “даван

³ С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй /тусгай анги/, сурах бичиг, УБ., 2020, 62 дахь тал.

туулагч” гэх нь сонголт хийж байгааг, өөрөөр хэлбэл эерэг чанарууд, хүчирхийллийг даван туулах хүч, илаарьших зэрэг агуулгыг илтгэдэг”⁴ гэжээ. Харин судлаач Томпсон “Нэг талаараа хохирогч гэдэг нэршил “гэм зэмгүй” гэдэг утгатай учраас бодит байдлыг онож илтгэж байгаа ч нөгөө талаараа “хохирогч” гэдэг бас “сул дорой, эмзэг, өөрийнхөө төлөө үйлдэл хийх чадал дутмаг” гэдэг утга агуулж байна.⁵ Энэ утгаараа “хохирогч” гэх үг нь хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн өөрийн үнэлэмж, өөрийгөө тодорхойлоход сөргөөр нөлөөлөх талтай юм. Учир нь гэр бүлийн хүчирхийлэлд байсан ихэнх эмэгтэйчүүд хохирогч гэхээс илүү өөрсдийгөө “даван туулагч” гэж тодорхойлох хүсэлтэй байдаг талаар олон судалгаанд дурджээ. Жишээлбэл, Мак Картин судалгаанд өөрийгөө “хохирогч” гэж тодорхойлсон эмэгтэйчүүд бэлгийн хүчирхийллийг өөрийнх нь амьдралыг “шийдсэн”, өөрийн үнэлэмжийг нь удирдан чиглүүлж, ноёлох үйл явдал гэж үзэж байжээ⁶. Харин Томпсон “даван туулагч” гэдэг нэршил хүчирхийллээс үүдсэн шархыг илаарьшуулах, эргэн сэргэх, тэсвэр тэвчээр гэсэнтэй утга нийцдэг гэж үзсэн нь үндэслэлтэй юм. Зарим тохиолдолд шүүхийн үйл ажиллагаанд “хохирогч” гэдэг нэршил нь үйлчлүүлэгчийн гэм зэмгүй, хүч дорой байдлыг илтгэж байгаагаараа оновчтой. Харин Келли “сэтгэл зүйн хувьд илаарьших, даван туулах, өөрийн үнэлэмжээ эергээр шинээр тодорхойлоход “даван туулагч” гэх нэр томъёог ашиглах нь зүйтэй гэжээ.⁷

Дебра Паттерсон нарын судалгаагаар илүү чадавхажсан, өөрийгөө “даван туулагч” гэж мэдэрсэн үйлчлүүлэгчид хүчиндэх гэмт хэргийн талаар хууль сахиулах болон шүүхэд мэдүүлж, шийдүүлэх хандлагатай байдаг гэж дүгнэжээ. Даван туулагч гэдэг нь өөрийгөө хүчирхийлэлтэй харилцаанаас гаргасан, хүчирхийллийн харилцаагаа даван туулж байгаа, илаарьших үйл явц эхэлсэн хүмүүсийг хэлнэ гэж тодорхойлж болно.⁸

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч/даван туулагчдад

1. Гэмт хэргийн золиос болохоос өмнө үүссэн сэтгэл зүйн асуудал;
2. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч/даван туулагч болсон үеийн бие махбодын хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, сэтгэл санааны хүчирхийлэл;
3. Өртсөний дараах үр дагавар буюу хүн худалдаалах гэмт хэргээс суллагдсаны дараа илэрсэн шинж тэмдгүүд зэрэг холимог шинж тэмдгүүд илэрч болно.

Үүний зэрэгцээ гэмтлийн шинж тэмдгийг нарийн төвөгтэй болгож буй бас нэгэн хүчин зүйл нь хохирогч/даван туулагчдаар хүсээгүй үйлдлийг нь хийлгэж, үүнийхээ дараа тэдэнд тодорхой хэмжээний төлбөр өгсөн байх явдал юм. Нэг ёсондоо энэ нь хохирогч/даван туулагчдад төөрөгдөл үүсгэдэг бөгөөд тэдний өмнө нь баримталдаг байсан зарчимтай нь зөрчил үүсгэдэг. Үүнтэй холбоотойгоор хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид маш их ичгүүр, өөрийгөө буруутгах мэдрэмж авдаг⁹.

Тухайн хийсэн үйлдлээсээ ичих, мэхлэгдсэндээ, “зөвшөөрөл” өгсөндөө, өөрийн хяналтаас үл хамаарах нөхцөл байдалд хууртан орсондоо өөрийгөө ихээр буруутгадаг. Мөн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч/даван туулагчдад зарим үед тухайн үеийнхээ олон чухал зүйлсийг мартаж, өөрөөсөө “тусгаарлагдах” /диссоциаци/ шинж тэмдэг илэрдэг¹⁰.

⁴ Dunn, J. L. (2005). “Victims” and “Survivors”: Emerging Vocabularies of Motive for “Battered Women Who Stay”.

⁵ Tompson, Monica (2000). Life after rape: A chance to speak? Sexual and Relationship Therapy.

⁶ .BW, McCarthy (1986). A cognitive behavioral approach to understanding and treating sexual assault victims.

⁷ Kelly, L. (1988). Surviving Sexual Violence.

⁸ Debra Patterson, R. C. (2010). Why Rape Survivors Participate in the Criminal Justice System.

⁹ Clawson, H. J. (2008). National symposium on the health needs of human trafficking: Background document.

¹⁰ Zimmerman, C., Watts, C. (2003). World Health Organization ethical and safety guidelines for interviewing trafficked women.

Нөгөөтээгүүр бэлгийн хүчирхийлэлд өртсөн насанд хүрээгүй хохирогч/даван туулагч, цөөн тооны насанд хүрсэн хохирогч/даван туулагчдад хүчирхийллээс заримдаа таашаал авч байсан мэтээр алдаатай мэдрэмж төрүүлж, сэтгэцийн гэмтлийг улам ярвигтай болох нөхцөл үүсгэж байдаг.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч/даван туулагчдын дунд мансууруулах бодист донтох эмгэгүүд түгээмэл байдаг ч ийм эмгэг үүсэх цаг хугацаа нь хохирогч/даван туулагч бүрд харилцан адилгүй байдаг. Хохирогч/даван туулагчид хүн худалдаалах гэмт хэргийн золиос болсон дурсамжаа даван туулахын тулд хүчирхийлэгчид хүчээр мансууруулах бодис хэрэглүүлдэг болохыг онцлон анхаарах хэрэгтэй.¹¹

Хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгийн хохирогч/даван туулагчдад илэрдэг сэтгэцийн гэмтлийн үр дагаврууд:

- Амархан итгэл алдрах;
- Шийдэмгий бус болох;
- Сэтгэл гутралтай, идэвхгүй болох;
- Паник аттак / Сандрах дайралт;
- Хэт их сэтгэл хөдлөлд автах зэрэг шинж тэмдгүүд нийтлэгээр илэрдэг байна.

Дээрх сэтгэцийн гэмтлийн шинж тэмдэг, үр дагаврууд нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч/даван туулагч бүрд өөр өөр хэлбэрээр илэрч болно. Хохирогч/даван туулагчтай харилцаж буй мэргэжилтний хувьд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч/даван туулагчийн үзүүлэх хариу үйлдлийг урьдаас таамаглах боломжгүй бөгөөд хохирогч/даван туулагч тус бүрийг тусдаа бие даасан хувь хүн, өөрийн онцлогтой гэдгийг анхаарах хэрэгтэй¹².

2.2 Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд илрэх шинж

Хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүд гэмт этгээд, ажил олгогч, зуучлагч, эмсийн хүрээлэнгийн эзэд болон үйлчлүүлэгчдэд байнга зодуулах, тэдний сүрдүүлэг, дарамт, хууран мэхлэлтэд өртөх зэрэг сэтгэл зүйн болон бие махбодын хүчирхийллийн харилцаанд байж, түүний цар хүрээ тасралтгүй даамжирсаар сэтгэцийн гэмтэл үүсгэдэг.

Тухайлбал, урт хугацааны турш бие махбод, сэтгэл санаа болон бэлгийн хүчирхийлэлд өртөх нь хүүхдүүдийн нийгэмтэй харилцах, сэтгэл хөдлөлөө зохицуулах, дасан зохицох чадвар, зан төлөв, танин мэдэхүйн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, өөрийгөө тусгаарлагдах (диссоциаци) улмаар өөрийн үзэл бодол, зан авирын өөрчлөлтөд өртөх өндөр эрсдэлтэй байдаг.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд илрэх шинж нь бие махбод, сэтгэцийн эрүүл мэнд, түүний зан үйлд гарч буй өөрчлөлт болон боловсролын хоцрогдол зэрэг нийгмийн харилцааны шинжтэй асуудлаар илрэн гарч болно.

Олон удаа сэтгэцийн гэмтэлд өртсөн хүмүүсийн сэтгэцийн гэмтлийн шинж тэмдэг нь нэг удаа өртсөн хүмүүстэй харьцуулахад илүү хүнд байх нь олон тул дахин гэмтэл авах нь ихээхэн санаа зовоосон асуудал юм. Олон удаа сэтгэцийн гэмтэл авсан хүмүүсийн сэтгэл засалд хамрагдах хүсэл эрмэлзэл буурсан байдаг. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгийн аль ч төрлүүд нь сэтгэцийн гэмтэлтэй болгож үлдээх эрсдэл дагуулдаг тул гэмт үйлдлийг нэг нь

¹¹НҮБ-ын Мансууруулах бодис гэмт хэрэгтэй тэмцэх алба. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага. 2009 он.

¹² НҮБ-ын Мансууруулах бодис гэмт хэрэгтэй тэмцэх алба, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага. 2009 он.

нөгөөгөөсөө хүнд эсхүл хөнгөн гэж ялгаж болохгүй юм. Харин сэтгэцийн гэмтлийг даван туулах нь тухайн хүний сэтгэл зүйн байдал, дэмжлэг бүхий гэр бүл, хамт олон, орчин байгаа эсэх зэргээс хамаардаг.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч/даван туулагчийг аврах, чөлөөлөх, эрхийг нь хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тодорхой хугацаанд болдог ба энэ үйл ажиллагааг сэтгэцийн гэмтэлд суурилсан зарчмаар хэрэгжүүлбэл хохирогч/даван туулагчийг нөхөн сэргээх, илаарьшуулахад сайн үр нөлөөг бий болгодог. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч/даван туулагч өөрсдийгөө эдгээх гэж оролдохдоо асар их дотоод зөрчилтэй тулгардаг бөгөөд нөхөн сэргээх үйл явцын янз бүрийн үе шатанд өөр, өөр хэрэгцээ, шаардлага үүсдэг. Нэн тэргүүнд хохирогчид аюулгүй байдал, хувцас, орон байр, хямралын үеийн сэтгэл засал шаардлагатай болдог¹³. Богино хугацаанд хохирогч/даван туулагчдад бие махбод болон сэтгэцийн эрүүл мэндийн эмчилгээ шаардлагатай бөгөөд хууль сахиулах байгууллагын ажилтнууд хохирогч/даван туулагчийн эдгээр хэрэгцээг мэдэрч, зохицуулах шаардлага үүсдэг.

Хохирогч/даван туулагчтай ажилладаг мэргэжилтнүүд хоёрдогч сэтгэцийн гэмтэлд өртөх магадлалтай байдаг. Энэ нь хохирогч/даван туулагчийн туулсан үйл явдлыг мэдсэний дараа үйлчлүүлэгчийн нөхцөл байдлыг өөр дээрээ тусгаж, мэдэрсний улмаас үүсэж болох стресст хариу үйлдэл юм. Байгууллагын удирдлага, ажилтнууд нь бүхий л түвшинд хоёрдогч сэтгэцийн гэмтлийн үр дагаврыг таних, тохирсон хариу үйлчилгээг ажилчдад үзүүлэх, ажилчдыг дэмжих, тэдний даван туулах чадварыг нэмэгдүүлэх орчныг ажлын байран дээр бий болгох шаардлагатай.

Хоёрдогч сэтгэцийн гэмтэл нь гуниг, бухимдал, түгшүүр, гэмшил, итгэл алдрах, сэтгэл гутрал, санаа зовнил зэрэг шинж тэмдгүүдээр илэрч мэргэжилтний ажлын гүйцэтгэл болон хувийн амьдралд ч сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай. Мөн үйлчилгээ үзүүлэх явцад гэрч, хохирогч/даван туулагчид, гэр бүлтэй нь тааламжгүй харилцаа үүсгэх, ажлаас халшрах, ажлаа тасалдуулах, эрүүл мэндийн асуудал тулгарах, ажлаас гарах зэрэг асуудлууд үүсэх боломжтой.

Тиймээс байгууллага нь дараах зүйлүүдийг хэрэгжүүлбэл зохино. Үүнд: Ажилтан, алба хаагчдыг хоёрдогч сэтгэцийн гэмтлийн тухай мэдлэгтэй болгох. Ингэснээр тэд 1) өөрт нь болон тэдний хамтран ажиллагсад эсвэл удирдах ажилтанд нь хоёрдогч сэтгэцийн гэмтэл тохиолдож байгаа эсэхийг тодорхойлох, 2) хоёрдогч сэтгэцийн гэмтэл нь энгийн хариу үйлдэл гэж хүлээн зөвшөөрөх, 3) хариу арга хэмжээ авахын тулд үр дүнтэй даван туулах стратеги ашиглах боломжоор хангах;

Дүгнэлт:

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч/даван туулагчийг аврах, чөлөөлөх, эрхийг нь хамгаалах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа тодорхой хугацаанд болдог ба энэ үйл ажиллагааг сэтгэцийн гэмтэлд суурилсан зарчмаар хэрэгжүүлбэл хохирогч/даван туулагчийг нөхөн сэргээх, илаарьшуулахад сайн үр нөлөөг бий болгодог. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч/даван туулагч өөрсдийгөө эдгээх гэж оролдохдоо асар их дотоод зөрчилтэй тулгардаг бөгөөд нөхөн сэргээх үйл явцын янз бүрийн үе шатанд өөр, өөр хэрэгцээ, шаардлага үүсдэг. Нэн тэргүүнд хохирогчид аюулгүй байдал, хувцас, орон байр,

¹³ Zimmerman, C., Watts, C. (2003). World Health Organization ethical and safety guidelines for interviewing trafficked women.

хямралын үеийн сэтгэл засал шаардлагатай болдог¹⁴. Богино хугацаанд хохирогч/даван туулагчдад бие махбод болон сэтгэцийн эрүүл мэндийн эмчилгээ шаардлагатай бөгөөд хууль сахиулах байгууллагын ажилтнууд хохирогч/даван туулагчийн эдгээр хэрэгцээг мэдэрч, зохицуулах шаардлага үүсдэг.

Хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгийн хохирогч/даван туулагч дахин сэтгэцийн гэмтэлд өртөх магадлалтай тул сэтгэцийн гэмтэлд суурилсан үйлчилгээ үзүүлэх нь чухал юм. Тиймээс хохирогч/даван туулагчтай уулзалт хийж байх үедээ уулзалт, үнэлгээний зорилгоо ямагт санах хэрэгтэй ба зорилгоосоо хазайж болохгүй. Эмнэлгийн үйлчилгээ болон хууль зүйн туслалцаа үзүүлэх явцад хохирогч дахин сэтгэцийн гэмтэлд өртөх магадлал илүү өндөр байдаг. Тухайлбал, эрүүл мэндийн үзлэг, оношилгоо хийх, хууль зүйн туслалцаа үзүүлэх болон бусад төрлийн үйлчилгээний явцад тухайн хүний биед хүрэх, эмзэг асуулт асуух, тохиромжгүй орчин нөхцөлд байлгах зэрэг нь дахин гэмтэх нөхцөлийг бүрдүүлдэг.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ч тухайн алба хаагч/мэргэжилтэн сэтгэцийн гэмтэл сэдрээхээс сэргийлэн харилцах ёстой. Тиймээс хохирогч/даван туулагчтай ажиллаж буй бүхий л мэргэжилтнүүд нийгмийн ажлын зорилго, загварыг мэдэж байвал зохилтой ба тэр дундаа тухайн үйлчлүүлэгчийн нийгмийн харилцаа, дотоод сэтгэл зүйн үйл явц хэрхэн явагдаж болох нөхцөл байдлыг анхаарч анзаарах шаардлагатай юм. Үйлчлүүлэгчтэй итгэлцэл бий болгох нь хамгаас чухал бөгөөд таны асууж буй асуулт дахин сэтгэцийн гэмтэлд оруулж болзошгүйг ямагт анхаарах хэрэгтэй

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж, тушаал шийдвэр

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992.
2. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль. 2012.
3. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль,
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017.
5. Улсын Дээд шүүхийн 2008 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар “Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн зарим заалтыг тайлбарлах тухай” тогтоол.
6. Улсын ерөнхий прокурорын 2017 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн А/57 дугаар тушаалын хавсралт “Мэдүүлэг авах өрөөнд тавигдах шаардлага”

Монгол хэл дээрх материал

1. Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: “Цагдаагийн байгууллагад хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зөвлөмж”, 2022.
2. Улсын ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 06 дугаартай зөвлөмж.
3. Улсын ерөнхий прокурорын газраас “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлт, шүүхээс оногдуулсан ял, гэмт хэрэг үйлдэгдэж буй шалтгаан нөхцөлийг 2021 он, 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд судалсан” дүн.
4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд хохирогч төвтэй хандлагыг хэрэгжүүлэх нь”, хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны гарын авлага.

¹⁴ Zimmerman, C., Watts, C. (2003). World Health Organization ethical and safety guidelines for interviewing trafficked women.

5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны гарын авлага. УБ., 2017.
6. “Вьетнам улсын хууль хэрэгжүүлэх, шүүх байгууллагын чадварыг нэмэгдүүлснээр ГБХ-ийн эсрэг авах арга хэмжээ, урьдчилсан сэргийлэх үр дүнг нь нэмэгдүүлэх” сургагч багшийн гарын авлага, 2010.
7. НҮБ-ын Хүн амын сан. Дотно хамтрагчийн зүгээс үйлдсэн хүчирхийллийн эдийн засгийн өртөг зардлын тооцоо” судалгааны тайлан. УБ., 2021.
8. НҮБ-ын Мансууруулах бодис гэмт хэрэгтэй тэмцэх алба. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх гарын авлага. 2009.
9. С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй /тусгай анги/, сурах бичиг, УБ., 2020.

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ХУУЛЬ БУСААР МОД БЭЛТГЭХ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ ABOUT THE CRIME OF ILLEGAL TREE CUTTING HISTORICAL TRADITIONS AND REFORMS OF CRIMINAL LAW

*Дотоод хэргийн их сургуулийн магистрант,
цагдаагийн ахлах дэслэгч Б.Энхцогт
Master's student of the University of internal affairs,
police senior lieutenant B.Enkhtsgot*

Хураангуй: Монгол орны ойн санд хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн үзүүлж буй хор уршиг гол хүчин зүйлийн талаар болон хууль, цаазын түүхэн сурвалж бичигт хэрхэн хуульчлан тусгаж өгч байсан, байгаль экологид учруулж буй хор хөнөөлийн талаар тусгаж өгсөн болно.

Abstract: Conclusions and suggestions have been made about the main factors of the forest fund of Mongolia, Illegal logging crime, how it has been legalized in the historical records of law and execution, and the harm it causes to nature and ecology.

Түлхүүр үгс: Хууль бусаар мод бэлгэх гэмт хэрэг, Эрүүгийн хуулиар ой модыг хамгаалж ирсэн түүхэн уламжлал, шинэчлэл, мөн чанар.

Key words: The crime of illegal logging, Historical tradition, reforms and quality of protecting forest trees through criminal law.

Үндсэн хэсэг. Хүн байгаль орчинтойгоо зүй бусаар харьцаж эдийн засгийн хөгжлийг гол болгож ирсэний улмаас экологийн тэнцвэрт байдал алдагдан ойн баялаг болох модыг устгаснаар ган, цөлжилт, усны үер, хүчтэй салхи шуурга зэрэг байгалийн гамшгийн цар хүрээ, давтамж урд өмнөхөөс эрс ихсэж дэлхий даяараа дулаарал, озоны давхаргын нимгэрэл, уур амьсгалын өөрчлөлтүүд зэрэг хурц асуудлуудтай тулгараад байна. Эдгээр гамшгийн дотроос дэлхийн олон улс оронд асар их түгшүүр төрүүлж, нөлөө үзүүлж буй нь байгалийн гол хүчин зүйл болсон модыг хууль бусаар бэлтгэн устгаж буй явдал юм.

Манай орны Ойн сан бүхий газар **2020 онд 11.8** хувь байсан бол **2022 оны байдлаар 14256.6 мянган.га** буюу нийт нутаг дэвсгэрийн **9.1** хувийг л эзэлж байна.

Ойн сан бүхий газарт ойгоор бүрхэгдсэн газар 12108.9 мянган га буюу 84.9 хувийг, ой модыг нь огтолсон газар 133.0 мянган га буюу 0.9 хувийг, мод үржүүлгийн газар 63.3 мянган га буюу 0.4 хувийг, ой тэлэн ургах нөөц газар 719.0 мянган га буюу 5.0 хувийг, ойн сангийн бусад газар 1232.4 мянган га буюу 8.6 хувийг тус тус эзэлж байна.¹⁵

Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 76,9 хувь нь цөлжилтөд өртсөн бөгөөд энэ эрчим хэвээр байвал 2080 он гэхэд манай улсын 80 хувь нь элсэн цөл болон хувирах дүр зурагтай байна.

Байгалийн баялгийг зүй зохистой ашиглахад зохицсон аж ахуйн уламжлалт болон орчин үеийн нийтлэг хэвшлийг хослуулан хөгжүүлэх замаар байгалийн баялгийг нөхөн сэргээж, төрх байдлыг нь хамгаалж, иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бий болгоход төрөөс экологийн талаар баримтлах бодлого чиглэгдэх явдал юм.

Байгаль орчны бодлого нь байгалийн төрх, байдлыг хадгалах, байгалийн болон болон түүх соёлын үнэт зүйлсийг хамгаалах экологийн даацад нийцүүлэн нөөц баялгийг иж бүрэн, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үр өгөөжийг нь ард иргэдэд адил тэнцүү хүртээх нөхцөлийг бүрдүүлэх замаар улс орны эдийн засгийн тогтвортой өсөлтийг тэтгэн, амьдрах орчныг сайжруулах зорилгод нийцсэн байна.

Байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэхдээ нөхөн сэргээгдэх байгалийн нөөцийн хүрээнд амьдралын хэрэгцээг бүрэн хангах, үл нөхөгдөх буюу удаан сэргэдэг нөөцийг гагцхүү улс орны хөгжлийн нэмэлт хүчин зүйл болгон зохистой ашиглах замаар экологийн аюулгүй байдлыг хангах явдлыг чухалчилна.¹⁶

Тухайлбал, Ойн нөөцийн талаар:

- Ойн экологи, эдийн засгийн түгээмэл ач холбогдлыг чухалчлан монгол орны газар нутгийг ойжуулах арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэн, ойн тархалтын хүрээг тэлж, модны чанарыг сайжруулах замаар ойн нөөцийг зохистой түвшин, хэмжээнд тогтвортой өсгөн, хэмнэлттэй ашиглах бодлого явуулах;

¹⁵ <https://www.gazar.gov.mn/p/527-108>

¹⁶ Төрөөс экологийн талаар баримтлах бодлого. 1997 он. Төрийн мэдээлэл сэтгүүл. 1998 он, №01

- Ой хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх цогцолбор баримтлалын үндсэн дээр ойн нөөцийн үнэлгээ, төлөвлөлтийн чадварыг дээшлүүлж, ой модыг тогтмол ашиглагчдад гэрээгээр эзэмшүүлэн хамгаалуулах, модны дотоодын хэрэглэгчдийн хэрэгцээг хангахад түлхүү анхаарах;

- Олон талын ач холбогдлыг нь харгалзан ойг хамгаалах, нөхөн ургуулах, хязгаартай ашиглах бүс нутгийг тогтоож тэдгээрт тохирсон ой зохион байгуулалтыг бүрдүүлэх, модыг сорчлон бэлтгэх, экспортлохыг хязгаарлах, модон материалын импортыг дэмжих, ойн байгалийн нөхөн үржилтийг тэтгэх, сайн чанарын үрийн аж ахуйг эрчимжүүлж модлог ургамал тариалах хэмжээ, хүрээг өргөтгөх, ой модыг өвчин, хортон шавьж, гал түймрээс урьдчилан сэргийлэх чадавхийг бэхжүүлэх явдлыг байгаль хамгаалах үйл ажиллагааны гол чиглэл болгон гэжээ.

Монголчууд эрт дээр үеэс амьдарч буй орон нутгийнхаа байгалийн зүй тогтлыг танин мэдэж байгаль орчноо хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээхэд үлэмж анхаарч зан үйл, ёс заншил, шашин шүтлэгээрээ зохицуулж ирсэнээс гадна төрийн бодлогоор хууль цааз тогтоож ирсэн уламжлалтай.

Бидний өвөг дээдэс маань мөн чанар, дотоод шалтгааныг гүнзгий танин мэдсэн учраас байгаль дэлхийгээ тахин шүтэх олон шүтлэгийг бий болгож үзэсгэлэн төгс нутаг орныхоо онцлог хэсгийг дархлан хамгаалж иржээ.¹⁷

Монголчууд байгаль хамгаалах хууль цаазаа хэлбэрэлтгүй мөрдөж зөрчсөн этгээдийг ноён, харц гэж ялгалгүй тохирсон шийтгэлийг хүлээлгэж байсан нь Улаан хацарт хэмээх номонд “...Төр Гэрэлтийн 28 дугаар оны /1848 он/ 7 сард Шадивлангийн ойр газраас яргай мод огтолсон хиа Гомбыг бага хөлөөр баалж шийтгэв”, мөн онд Чингэлтэй уулнаас түлээ мод огтолж авсан лам Ишдоржийг нэгэн есөөр торгов хэмээн тэмдэглэжээ.¹⁸

Монгол орон байгалийн унаган төрхөө алдаагүй, түүний баялаг бүрэн бүтнээр бидний үед өвлөгдөн ирэхэд монгол түмний үе үеийн мэргэдийн боловсруулан мөрдөж ирсэн хууль цаазын бичиг, зарлиг нь онцгой үүрэг гүйцэтгэсэн.

Монголчууд байгаль орчноо хайрлан хамгаалах баялаг уламжлалтай ард түмэн бөгөөд өнөөдөр бидэнд өвлөгдөн ирсэн хөндөгдөөгүй шахам байгаль бол өвөг дээдсийн нөр их хөдөлмөр, хатуу хууль, төрийн зөв бодлого, уламжлалт зан заншлын хэм хэмжээтэй шууд холбоотой бөгөөд байгаль дэлхийгээ эзэнтэй, хамаагүй хөндвөл эзэн хилэгнэнэ, лус савдагийн хорлол болно гэх зэргээр хамгаалж ирсэн түүхэн уламжлалыг бидний үеийнхэн мартах учиргүй.

Чингис хааны “Их засаг” хууль. Судлаачдын бүтээлээс үзэхэд “Их засаг” хуулийн агуулгыг төр засах цааз, иргэний аж байдлын цааз, эрүүгийн бодлого гэсэн гол асуудлуудад төвлөрүүлэн зангидаж тайлбарласан¹⁹ ба байгаль орчныг хамгаалахтай холбоотой заалтууд нь ихэвчлэн зан заншил, аж ахуй, онгон шүтлэгтэй холбоотой байв.

“Их засаг” хуульд байгалийн унаган төрхийг хадгалах, нутаг бэлчээрийг зүй зохистой ашиглах, газар шороо, хөрс усыг цэвэр ариун байлгах, ой модыг түймрээс хамгаалах зэрэг заалтууд тусгагджээ.

“Их засаг” хуулийн 28 дугаар зүйлд “...гал алдаж ой хээрийн түймэр гаргаваас гэр орноор нь цаазаар авсугай” гэсэн заалтаас харахад ой хээрийн түймрээс сэрэмжлэх, түймэр тавигчдад хатуу шийтгэл оногдуулж байсныг харж болно.

³ Амархүү.О. “Монголын орчин цагийн экологийн эрх зүй”. Уб., 2009 он 56 дахь тал.

¹⁸ Авирмэд.Э., Дашцэдэн.Д., Совд.Г., “Монгол хууль”. Уб., 1997 он 15 дахь тал.

¹⁹ Болдбаатар.Ж., Лүндээжанцан.Д. “Монгол Улсын төр эрх зүйн түүхэн уламжлал”, Уб.,1997. 71-73 дахь тал.

Их Юан гүрний “Нэвтэрхий хууль” нь нийгэм улс төр, эдийн засаг, ахуй амьдралын бүхий л хэв шинжийг агуулсан, “Их засаг” хуулийн нөлөө, Монгол зан заншил ихээр тусгагдсаны дотор байгаль хамгаалахтай холбоотой олон зүйл заалтууд орсон, өмнөх хууль, зарлигуудын эмхтгэл байсан бөгөөд 60 бүлэг, 2391 зүйлтэй байжээ.

Хубилай хааны зарлигт их замын дагуу 2 алхмын зайтай мод тарихыг зарлигдсаны дагуу говь цөл, хээр тал хангай, гол мөрөн, нуур цөөрмийн зах хөвөөнд мод тарьж ойжуулах асуудлыг тусгаж газрын хөрсийг хамгаалах, бэлчээр, ой мод, хадлангийн талбайг тариалангийн талбайн адил хамгаалах хууль эрх зүйн үндсийг бий болгожээ.²⁰

Алтан хааны цааз бичиг нь ХҮГ зууны Монголын томоохон цааз бичгүүдийн нэг бөгөөд оршил буюу айлтгал үгийн хамт 12 хэсэг, 117 зүйлээс бүрддэг.²¹ Алтан хааны цааз бичгийн 95 дугаар зүйлд “...ой модыг их хэмжээгээр огтлох, хулгайлбал 2 есөөр торгох” ялыг хэрэглэхээр заажээ.

Монгол-Ойрадын хууль буюу “Дөчин дөрвөн хоёрын цааз” хуулийг 1640 онд Халх, Ойрадын бүх ноёдыг төлөөлсөн чуулганаар баталсан. 186 зүйлээс бүрддэг ба “...ой хээрийн түймэр тавих зорилгогүйгээр ой модыг гэмтээсэн, огтолсон буруутанг тэмээ тэргүүтэй 9 малаар торгож байх, ой мод бэлчээр ургамлыг хамгаалах” талаар нийтээр мөрдөх эрх зүйн хэм хэмжээг зөрчвөөс 5 мориор торгохоор заажээ.

Монгол цаазын бичигт Монголын үзэсгэлэнт байгалийг дархлан хамгаалж, онголон тахиx, хамгаалах тухай заалт, хэм хэмжээ арвин бөгөөд байгаль орчныг сүйтгэсэн үйлдлүүдийг 3 ангилан хуваасан байна.

- газар эдэлбэрийн тогтоосон хэм хэмжээ зөрчих;
- ой хээрийн түймэр тавих;
- хууль бусаар ан хийх, ховор ургамал түүх, **ой модыг огтлох;**

Нүүдэлчин Монголчуудын хувьд нутаг бэлчээр, ой модыг хамгаалах түүнийг зөв зохистой ашиглаж малаа адгуулан маллах нь эртнээс улбаатай бөгөөд түймэр алдаж ой бэлчээр устгасан, ой модыг үлэмж хэмжээтэй огтолсон, гэмтээсэн, энэ хэргийн улмаас хүний амь хохирсон буюу өөр хүнд хор уршиг учруулсан бол хүндээр шийтгэхээр заажээ.

Халх журам хуульд байгаль хамгаалах асуудал тодорхой байр суурь эзлэж байсан ба өмнөх хуулиудын уламжлалыг баяжуулан бататгаж ой мод, ан амьтан, усыг хамгаалах, ой хээрийн түймрээс сэргийлэх асуудлыг нарийвчлан тодруулжээ.

Халх журам хуулийн 126 дугаар зүйлд “...хүрээ зассан газарт мод огтлохгүй, хүрээний гадагш нойтон мод огтлохыг хориглоод хэн хүн зөрчиж мод огтолбол багаж болон биедээ авч яваа эд юмсыг бүгдийг хураан авна”²², нойтон мөчир бол нойтон модны ёсоор, хуурай мөчир хуурай модны ёсоор цаазтай гэжээ. Энд заасан нэгэн шинэлэг зүйл нь “гурван этгээдээс элч гарган” ажиллуулж тухайн хориглосон үйлдлийг зөрчиж буй эсэхийг шалгаж, эргэж үзэж байх хэм хэмжээг анх тогтоосон явдал юм.

Гурван этгээдээс гэдэг нь хүрээний захирагч, шашин сүм хийд болон хүрээнд оршин суугч энгийн ардуудаас тус бүр нэг төлөөлөгч байхыг хэлж байсан бөгөөд элч гэдэг нь өнөөгийн байгаль хамгаалагчтай ижил зиндааны алба хариуцагчийг хэлж байсан бололтой.

Элч нь эргэж шалгахын зэрэгцээ гаднаас хүрээнд ирсэн ноёд, зочдод мод, мөчир огтлохыг хориглосон тухай таниулж, хуулиа сурталчлан ойлгуулж байх үүрэгтэйг хуульчилсан байв. Хүрээнд болон түүний ойролцоо газарт ой модыг хамгаалах журам

²⁰ Амархүү.О. “Монголын орчин цагийн экологийн эрх зүй”. Уб.,2009. 84-85 дахь тал.

²¹ Авирмэд.Э., Дашцэдэн.Д., Совд.Г. “Монгол хууль”. Уб.,1997. 15-18 тал.

²² Жалан-Аажив.С. “Халх журам”. Уб.,1995. 15 дахь тал.

тогтоохдоо “хуурай модыг огтолсон нь нойтон модыг хуга дайрсан бол сүхийг ав” гэсэн нь зулзаган модыг хамгаалах чухал ач холбогдол бүхий заалт байжээ.

Богд хаант Монгол Улсын хууль цаазын гол эх сурвалж нь “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль цаазын бичиг” бөгөөд байгаль хамгаалах асуудлыг өргөн хүрээтэй авч үзжээ.

Байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах асуудлыг нутгийн удирдлагад үүрэг болгож, хариуцлагад нь шингээж өгсөн; газар нутгийг онголон дархалж, уул овоо тахиx уламжлалт зан үйлийг хуульчилж тусгай хамгаалалтанд авсан, дархан цаазат газар нутагт ан гөрөө хийх, зөвшөөрөлгүйгээр ойд мод огтлохыг хориглон хуульчилсан зэргийг дурьдаж болно.²³

Ардын хувьсгалын эхэн үеийн байгаль хамгаалах хууль тогтоомж

БНМАУ-ын анхны Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд “...улсын хязгаарын доторхи газар, уурхай, ой мод, ус зэрэг баялаг нь эрт цагаас нааш ард нийтийн өмч байсаар ирсэн бөгөөд хувийн өмчид байж болохгүй”²⁴ гэжээ.

1926 оны Шүүх цаазын бичиг- Уг хуулийн 15 дугаар бүлгийн 103 дугаар зүйлд “...байгалийн баялгийг ашиглах тухай дүрэм зөрчигсдийг 3 сар хүртэл хорино”; 110 дугаар зүйлд “...ой модыг хамгаалах дүрэм зөрчсөн, цааз бүхий газраас нойтон мод огтолвоос 6 сар хүртэл хорино”; 116 дугаар зүйлд “...гал түймэр гарсныг үзсээр сөнөөхөөр эс очвоос 2 сар хүртэл хорино”; 117 дугаар зүйлд “...аливаа малтсан газрыг эс таглаж тэгшилвээс 1 сар гяндлан хорино” гэжээ.

1924 оны улсын анхдугаар хурлаас баталсан Үндсэн хуульд эх орны ойн баялаг бол улсын өмч мөн гэж заагаад ойг хамгаалан хямгадах асуудал бол хоршооллын байгууллага, иргэдийн үүрэг гээд тэр ондоо анхны “Ой модны дүрэм”, 1925 онд шинэчлэн “Монгол Улсын хязгаарын доторх ой мод газрыг захирах дүрэм” болгон өөрчилжээ.²⁵

1931 онд баталсан Ойн хууль нь ойн ашиглалт, хамгаалалтын тухай анхны төрөлжсөн хууль бөгөөд манай орны нутаг дэвсгэр дэх бүх ой улсын өмч, ойн нэгдсэн сан болохыг хуульчлан тогтоосон юм. Бүх ойг улсын, орон нутгийн чанартай гэсэн 2 ангилалд хувааж, үргэлжилсэн ойгоос бусад хэсэг ойг орон нутгийн эзэмшил, мэдэлд байлгахаар зааж, улсын мэдлийн ойн ашиглалт, хамгаалалтыг Мал тариалангийн яамнаас, орон нутгийнхыг аймаг, сумын захиргаанаас тус тус эрхлэн хариуцаж байхаар шийдвэрлэжээ.

Улсын чанартай ойгоос жилд олгох модны хэмжээг түүний нэг жилийн өсөлтөөс хэтрүүлэхгүйгээр тогтоох, ургаа нойтон модыг үнэлэх, жижиг залуу мод огтлохыг хориглох, мод бэлтгэсэн байгууллага, хүмүүс тухайн талбайг цэвэрлэх, хэрэв цэвэрлээгүй бол огтолсон модны үнийн 15-25 хувийг улсад төлж байх журам тогтоосон байна.²⁶

Ойг нөхөн сэргээх эрх зүйн үндэс мөн л энэ хуулиар эхлэн тавигдаж, мод тарьж суулгах ажлыг ойн ангиуд хариуцан гүйцэтгэх, ой цэвэрлэх, тарьж ургуулахад зориулсан татварыг мод бэлтгэгчдээс хурааж байх, хуулиар хориглосон журам зөрчигчдийг эрүүгийн хариуцлагад татах, хууль бусаар огтолсон модны үнийг 3 нугалан төлүүлж байх, ойн цагдаа хууль бус үйл ажиллагааг шууд таслан зогсоох, огтолсон модыг хураах, гал түймэр гарахад дайчилгаа явуулах эрх эдлэхээр заасан байна.

²³ Амархүү.О. “Монголын орчин цагийн экологийн эрх зүй”. Уб., 2009. 85 дахь тал.

²⁴ БНМАУ-ын их, бага хурлын тогтоол, Үндсэн хууль, тунхагууд. Уб., 1956. 30 дахь тал.

²⁵ Эрдэнэбаяр.М. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийг илрүүлэх шалгахад анхаарах зарим асуудал. Уб., 2010. 67 дахь тал.

²⁶ Амархүү.О. “Монголын орчин цагийн экологийн эрх зүй”. Уб., 2009. 106 дахь тал.

Энэ хугацаанд ой модыг үйлдвэрлэл бүтээн байгуулалтад өргөн ашиглаж уг асуудлыг хариуцсан Аж ахуйн яамны бүтцэд “Ой модны хэлтэс” байгуулжээ. Ойн ангиудыг байгуулж хот орчмын ой, амьтны нөөцийн ашиглалт, хамгаалалтанд хяналт тавьж журамлах асуудлыг хариуцуулж байсан, 1933 онд “модны тэмдэгт бичиг авч 11 сарын 01-нээс дараа оны 4-р сарын 01 хүртэл модыг огтолно” гэсэн нь зөвшөөрлийн системийн үндэс болжээ.

1942 оны Эрүүгийн хуульд байгаль орчны эсрэг гэмт хэргийн талаар тусдаа бүлэг байхгүй ч 9 дүгээр бүлэгт байгаль орчны эсрэг гэмт хэргийн талаар цөөн заалт оруулсан. 188 дугаар зүйлд “...худаг, булаг зэрэг усыг гэмтээж хүний уух ба малыг услахад хэрэглэж болохгүй болговол 1 жил хүртэл хорино”, 190 дүгээр зүйлд “...ой мод, хадлан бэлчээрийг гал алдаж шатааваас 2 жил хүртэл хорино” гэжээ. Харин 1940 онд БНМАУ-ын Ойн хуулийг шинэчлэн баталсан бөгөөд уг хуулиар:

- ойн ашиглалт, хамгаалалтад тавих төрийн хяналтыг хүчтэй болгох;
- мод бэлтгэх зөвшөөрлийг гагцхүү ойн ангиас тус тусын хариуцсан нутаг дэвсгэрийн дотор олгож байх;
- нойтон модыг зөвхөн зам гүүр, улсыг батлан хамгаалах хэрэгцээнд СНЗ-ийн зөвшөөрлөөр, бусад албан газар, байгууллага, ард иргэдийн хэрэгцээнд хатсан буюу өмхөрсөн, түймэрт нэрвэгдсэн мод бэлтгэх;
- мод бэлтгэсний гоожингийн үнэ дээр ой цэвэрлэх, ойг бүртгэн тооцоолоход зориулан 15 хувийн нэмэгдэл хурааж байх журам тогтоожээ.

Мөн хуулиар хот суурины ногоон бүсийн хэмжээ заагийг тодотгож, Богд уул ба УБ хотоос зүг бүр 50 км хэмжээний газарт ургаа, нойтон мод огтлохыг хориглож, тэрхүү бүсийн дотор зөвхөн ойн арчилгаа, цэвэрлэгээний ашиглалт хийхийг зөвшөөрчээ.

1961 оны Эрүүгийн хууль: Уг хуулийн 123 дугаар зүйлд “...ой модыг хууль бусаар огтолсон, устгасан буюу гэмтээснээс болж учирсан хохирол нь захиргааны арга хэмжээнээс хэтэрсэн байвал 1 жил хорино”, 190 дүгээр зүйлд “ой хээрийн түймэр тавих” гэмт хэргүүдийг хуульчилж оногдуулах ялын төрөл хэмжээг тогтоожээ.²⁷

БНМАУ-ын Ойн хуулийг 1974 онд шинэчлэн баталсанаар ойн ашиглалт, хамгаалалт нь нэгдсэн бодлого, зохион байгуулалттай болсон. Мод ашигласаны төлбөр хураамж авч байх талаар төрөөс зохих арга хэмжээ авч байсны илрэл нь БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1974 оны 556 дугаар тогтоолоор гоожингийн хураамжийг батлаж уг тогтоолд “...ойгоос мод бэлтгэх гоожингийн хураамж бол ой модыг зөв зохистой ашиглах, хамгаалахад идэвхтэй үйлчлэх үүрэг бүхий ойн нөхөн үйлдвэрлэлийг хангахад шаардагдах нийгмийн зардлыг багтаасан үнийн систем мөн” гэж тодорхойлсон нь ойгоос мод ашиглагч нь байгалийн баялгийг ашигласаны төлбөр хураамж заавал төлж байхыг баталгаажуулсан хэрэг болжээ.

1986 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль: “Байгаль орчин, түүний баялгийг хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг” гэсэн 7 дугаар бүлэгт²⁸ ус, газар, түүний хэвлий, агаар зэрэг байгалийн гол төрөл зүйлүүдийг шинээр Эрүүгийн хуулийн хамгаалалтанд авчээ.

1990-1992 онд Монгол улсад төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг болон ойн аж ахуй задарч, зах зээлийн эдийн засагт шилжсэнээр ой модыг хууль бусаар огтлох гэмт хэрэг, зөрчил түгээмэл гарах болсон ч эрүүгийн хариуцлага тооцож чадахгүй байсан шалтгаан нь

²⁷ БНМАУ-ын хуулиудын эмхтгэл. Уб., 1960. 123 дахь тал.

²⁸ БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар. Уб., 1989. 227 дахь тал.

1986 оны Эрүүгийн хуулийн 187 дугаар зүйлд “...ойг хууль бусаар огтолсон, гэмтээсний улмаас их хэмжээний хор уршиг учирсан бол” гэмт хэрэгт тооцохоор заасанд байв.

1993 онд Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан боловч их хэмжээний хор уршиг гэдгийг өөрчлөлгүй 2002 он хүртэл үйлчилсэн.

Тухайн үед хохирлын хэмжээг УДШ-ийн тогтоолоор тайлбарладаг байсан бөгөөд 1995 онд 1,5 сая төгрөг болон түүнээс дээш хэмжээний хохирлыг их хэмжээнд тооцохоор заасан, 1995-2002 онд нэг шоо метр модны экологи-эдийн засгийн үнэлгээ нь 12000 төгрөг байсантай холбоотойгоор /тайлбар: Зил-130 машинд дунджаар 10 м³ мод ачигдана, машин модны үнэлгээ 120,000 төгрөг, 13-14 машин мод огтолж байж их хэмжээний хохиролд хүрнэ/ эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй шахам байсаар 2002 он хүрчээ.

2002 оны Эрүүгийн хуулийн 211 дүгээр зүйлд “...зохих зөвшөөрөлгүйгээр ойд үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэсэн, онцгой бүсийн болон ногоон бүсийн ой, хориотой зурвасын ойд хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсаны улмаас үлэмж хэмжээний хохирол учруулсан бол” гэж объектив талыг тодорхойлсон нь өмнөх хуулийн заалтыг бүр дордуулсан.

Тухайлбал, гэмт хэргийн объектив талыг “үйлдвэрлэлийн зориулалттай мод бэлтгэсэн бол” гэж тодорхойлсон, амьдрал дээр хууль зөрчигчид ихэвчлэн 1-2 машин мод тээвэрлэж яваад баригддаг, уг модоо ахуйн хэрэгцээндээ бэлтгэсэн гэхэд л эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй болж байв.

Түүнчлэн үлэмж хэмжээний хохиролд хүрэхийн тулд доод тал нь 15 машин мод огтолж байж эрүүгийн хэрэг үүсдэг байсан учир жилд 10 хүрэхгүй гэмт хэрэг бүртгэгдэж эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломж багассан, захиргааны хэлбэрийн төдий торгууль нь хууль зөрчигчдийг улам өөгшүүлсэн.

Социализмын үед Улаанбаатар болон Булган, Сэлэнгэ зэрэг аймагт мод боловсруулах үйлдвэрүүд ажиллаж ойн нөөцийг төлөвлөгөөтэй ашиглаж байсан ч үйлдвэрүүд нь тайрсан модныхоо тоогоор нөхөн сэргээлт хийдэг, ойн аж ахуй хөгжсөн, бүх үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу явагддаг, хууль бусаар мод бэлтгэх нь зөвхөн ахуйн зориулалттай буюу байшин барих, түлшинд хэрэглэдэг байв. Монгол Улсын тухайд уламжлалт нүүдлийн соёл иргэншлээ төгөлдөржүүлэх замаар тогтвортой хөгжлийн байгаль орчны зорилтуудыг шийдвэрлэх боломжтой.

Нүүдлийн соёл иргэншлийн тулгуур үзэл баримтлал нь **Хүн- Байгаль-Амьтан** гэсэн цагираг хэлхээс үүсгэдэг нь өнөөгийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд бүрэн нийцэж байна.

Тогтвортой хөгжил гэдэг нь: эдийн засгийн үр ашигтай, нийгэм нь шударга хариуцлагатай, байгаль орчинд зохистой хөгжлийн хандлага²⁹ бөгөөд тогтвортой хөгжлийн үндсэн шаардлага нь байгаль орчин, эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтуудыг нэгийг нь нөгөөгөөс салгахгүйгээр, ээлж дараалал тогтоохгүйгээр хамтад нь шийдвэрлэж байх явдал гэж хөгжлийн зарчмыг тодорхойлсон.

Ойн аж ахуйн нэгжүүд 1990-1992 онд хувьчлагдаж ойн ашиглалтын талаарх нэгдсэн бодлого алдагдсанаар хууль бус дураар мод бэлтгэх, амьдрал ядуу, бизнес эрхэлж байгаа нэрийн дор замбараагүй ашиглалт явуулж хот суурингийн орчмын ногоон бүсийн ой ихээр өртсөн түүхтэй.

²⁹ 1992 оны Рио-Де-Жанейрогийн чуулга уулзалтаас гаргасан Хүрээлэн буй орчин ба хөгжлийн талаарх тунхаглал. Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөлийн гарын авлага. УБ., 2010. 9-10 дахь тал.

1990-1992 онд Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэн, ойн аж ахуй дампуурч мод, модон материалын эрэлт, хэрэгцээг хангаж чадахгүйд хүрсэн учир Хууль бусаар мод бэлтгэх явдал газар авч зөвхөн ахуйн хэрэгцээг хангах төдий бус, экспортлох, бусдад худалдах, мод модон материал үйлдвэрлэх болсонтой холбоотойгоор ойн гэмт хэргийн гаралт эрс нэмэгдсэн.

2015 оны Эрүүгийн хууль 24.6 дугаар зүйл. Хууль бусаар мод бэлтгэх: “Зөвшөөрөлгүйгээр ойд мод бэлтгэсэн, гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан бол”, Хүндрүүлэх бүрэлдэхүүнд “байнга тогтвортой, бүлэглэж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ойд, төрийн албан хаагч үйлдсэн бол...,хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол” гэж тусгайлан заан тодорхойлсон ч, өнөөгийн нөхцөлд оногдуулж буй ялын бодлого, санкц нь бага, энэ төрлийн гэмт хэрэг буурахгүй жил ирэх тусам ихсэж байгаа цаашид ч нэмэгдэх хандлага байсаар байна.

ДҮГНЭЛТ

Монгол орны өвөг дээдэс маань уламжлалт бөө мөргөл, бурханы шашин, христийн шашин аль нь ч эх болсон байгаль дэлхий, ой модыг хайрлан хамгаалахыг сургадаг учир уламжлалт зан үйлийг шинжлэх ухаантай хослуулах, дэлгэрүүлж хэвшүүлэх болон шашны зан үйлийг ашиглах замаар ой хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах нь үр нөлөөтэй учир өсвөр насны хүүхэд, багачуудад байгаль орчноо хайрлаж сурахад шашин шүтлэгийн нөлөө их бөгөөд манай өвөг дээдэс байгаль дэлхий, уул усаа жил бүр тахиж, модыг хууль бусаар бэлтгэхийг хориглож байсан тэр уламжлал, шашны зан үйлийг сэргээж, ойн хууль тогтоомж зөрчих гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ашиглах шаардлагатай.

Монголчууд ойн баялгийг бурхантай, ээжтэйгээ зүйрлэн хайрлан хамгаалхаас гадна ахуйн зорилгоор зөв ашиглаж чаддаг өнө эртний сайхан уламжлал нь монгол хүний экологийн мэдлэг, соёл, ухаарал арвин байсны илрэл бөгөөд цаг хугацаа өнгөрөхийн хэрээр хумигдаж арилж байгаа нь маш том гарз³⁰ бөгөөд уламжлалыг сэргээж, баяжуулах, хүн бүрт байгалиа хайрлан хамгаалах мэдлэгийг түгээн дэлгэрүүлж, мэдээлэл хүргэх, байгальд хандах нийгмийн соёлыг дээшлүүлэх нь нэг гол арга болно.

САНАЛ

Дээрх дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- ❖ Одоо мөрдөгдөж буй Эрүүгийн хуульд Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулж буй мөнгөн торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх.
- ❖ Байгаль, Хүрээлэн буй орчинд учруулсан Экологи-эдийн засгийн үнэлгээг шинжээч томилон, гэмт хэрэг үйлдсэн этгээдээс гаргуулах заалтыг эрүүгийн хуульд тусгаж өгөх.
- ❖ Хүрээлэн буй орчинд хохирол, хор уршиг учруулж буй гол хүчин зүйл нь хүн учир өвөг дээдэс маань хэрхэн байгаль эх, хүрээлэн буй орчноо хамгаалдаг байсан ёс уламжлал, түүхтэй ард түмэн байсныг сэргээн сануулж нөлөөллийн арга хэмжээ болох сошиал мэдээ, мэдээлэл бэлтгэн иргэд, олон нийтэд түгээх ажлыг төрөөс бодлого гарган явуулах, сургалтыг хөтөлбөр боловсруулж Ерөнхий боловсролын сургуулиудад хичээл орох нь үр дүнтэй, ач холбогдолтой гэж үзэж байна.

³⁰ Амархүү.О. “Монголын орчин цагийн экологийн эрх зүй”. Уб., 2009. 27 дахь тал.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. <https://www.gazar.gov.mn/p/527-108>
2. Төрөөс экологийн талаар баримтлах бодлого. 1997 он. Төрийн мэдээлэл сэтгүүл.
3. Амархүү.О. “Монголын орчин цагийн экологийн эрх зүй”. УБ., 2009 он.
4. Авирмэд.Э., Дашцэдэн.Д., Совд.Г., “Монгол хууль”. УБ., 1997 он.
5. Болдбаатар.Ж., Лүндээжанцан.Д. “Монгол Улсын төр эрх зүйн түүхэн уламжлал”. УБ., 1997 он.
6. Жалан-Аажив.С. “Халх журам”. УБ., 1995 он.
7. БНМАУ-ын их, бага хурлын тогтоол, Үндсэн хууль, тунхагууд. УБ., 1956 он.
8. Эрдэнэбаяр.М. “Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийг илрүүлэх шалгахад анхаарах зарим асуудал”. УБ., 2010 он.
9. БНМАУ-ын хуулиудын эмхтгэл. УБ., 1960 он.
10. БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ., 1989 он.
11. 1992 оны Рио-Де-Жанейрогийн чуулга уулзалтаас гаргасан Хүрээлэн буй орчин ба хөгжлийн талаарх тунхаглал. Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөлийн гарын авлага. УБ., 2010 он.

ГЭМ БУРУУГИЙН АНДУУРАЛ БА ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА GUILT CONFUSION AND INTERNATIONAL EXPERIENCE

Б.Баярболд

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн
багш, цагдаагийн ахлах дэслэгч
/хууль зүйн магистр/*

Bayarbold B.

*Police school at University of Internal Affairs,
Department of criminal law and criminology,
lecturer, police senior lieutenant
/master of law/*

Хураангуй: Өөрийн орны эрүүгийн хуулийг боловсронгуй болгохын тулд гадаад улс орны туршлагыг судалж, эх орондоо хэрэгжүүлэх боломж бололцоог эрэлхийлэх шаардлага цаг үе бүрт байсаар ирсэн билээ. Энэхүү өгүүллээр гэм буруугийн андуурлын талаарх онолын ойлголт, мөн практик хэрэглээнд тулгамдаж буй асуудлыг олон улсын эрүүгийн эрх зүйн гэм буруугийн ойлголттой харьцуулах замаар судлахыг зорьсон.

Abstract: In order to improve the criminal law of one's country, there has always been a need to study the experience of foreign countries and look for opportunities to implement it in the country. This article aims to explore the theoretical understanding of the mistake of guilt, as well as the problems in its practical application, by comparing it with the concept of guilt in international criminal law.

Түлхүүр үг: Гэм буруу, андуурал, субъект, гэмт хэргийн бүрэлдэхүүн, олон улсын туршлага

Keywords: Guilt, confusion, subjectivity, composition of crime, international experience

Үндсэн хэсэг. Гэм буруугийн андуурлын түүхийн уламжлалыг авч үзэхдээ Монголын төдийгүй гадаад улсуудын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд андуурлыг хэрхэн тодорхойлж ирсэн талаар судлах нь зүй ёсны хэрэг юм. Аливаа эрх зүйг боловсронгуй болгоход, өөрийн орны нөхцөл байдалтай уялдуулан гадаад улсын эрх зүйн зохицуулалтын сайн туршлагыг судалгаа шинжилгээний үндсэн дээр туршин, хэрэгжүүлснээр шинэчлэлт, шинэлэг байдал бий болж, салбарын хөгжилд томоохон дэвшил болдог.

Гэм буруугийн “андуурал” гэх ойлголт нь англи хэлээр “mistake”, орос хэлний “ошибка” хэмээн орчуулагддаг байна. Манай улсын эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хөгжилд гадаадын улс орнуудын эрүүгийн эрх зүйн онолын үзэл баримтлал ихээхэн түлхэц болсон бөгөөд үүнд хамгийн их чухал үүрэг гүйцэтгэсэн нь ОХУ-ийн эрүүгийн эрх зүйн онол, үзэл баримтлал билээ.

ОХУ-ийн эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд гэм буруугийн андуурлыг хэд хэдэн байр суурьнаас судалж, боловсронгуй болгосоор ирсэн байна.

Нэгдүгээрт: Гэм буруугийн андуурал нь гэмт этгээдийн өөрийн үйлдлийн улмаас учрах аюулыг урьдчилан мэдээгүй байдал юм.

ОХУ-ийн хувьд гэм буруугийн андуурлын улмаас гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг үнэн зөв тогтоох, түүний үйлдлийг зөв зүйлчлэх, талаар маш олон эрдэмтэн судлаачид судалгаа шинжилгээ явуулсаны анхдагчдын нэг бол И.З.Геллер юм. Тэрээр 1910 онд анх гэм буруугийн андуурлыг “бодит объектуудын талаарх эсхүл объектууд хоорондын зүй тогтлын холбооны талаарх хүний буруу төсөөлөл, бодлууд” хэмээн тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл тэрээр “Үйлдэл нь өөрөө аюултай ч тийм байхад нөхцөлдхгүй. Энэ нь гэмт хэргийн улмаас үүдсэн үр дагавар нь төгссөн гэмт хэрэгт тооцогдохгүй, урьдчилан харалгүйгээр гэмт хэргийн үр дагаварыг гаргасан тохиолдолд уг үйлдлийг болоогүй гэж үзэх учиртай. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдэл өөрөө хэдий аюултай байсан ч тийм үр дагаварт хүргээгүй, харин тухайн үр дагаварт жинхэнээсээ хүргэсэн, хожуу гарч ирсэн этгээдийн үйлдлийн улмаас учирч болох боловч анхны үйлдэл хийсэн этгээд нь өөрөө гэмт хэрэг үйлдсэн хэмээн андуурч болох боломжтой. Ийм байдлаар гэмт хэргийн субъектын гэмт санаа бодол болон шалтгаант холбоо хоорондоо зөрчилдөх боломжтой хэмээн

тодорхойлсон байдаг. Энэ нь ОХУ-ийн эрүүгийн эрх зүй дэх өнөөгийн шалтгаант холбооны андуурлын эх үндэс нь болсон юм.

Харин Н.Д. Сергиевским гэх тухайн үеийн эрдэмтэн нь уг санааг маш товч, ерөнхий байдлаар тодорхойлсон ба тэрээр үзэхдээ “ хэрэв гэмт хэрэг үйлдсэн гэх этгээд нь хэдийгээр нийгэмд аюултай үйлдлийг бодож төлөвлөсөн ч гэсэн өөрийнх нь урьдчилан хараагүй, харах боломжгүй байсан үр дагавар учирсан бол тухайн этгээдийг буруутгаж болохгүй”³¹ хэмээн тодорхойлсон байна. “Ошибка в уголовном праве” буюу монгол хэлнээ шууд орчуулвал “гэм буруугийн алдаа” хэмээн орчуулдаг бөгөөд хүний ухамсарлан, ухамсарлах боломжгүй байсан нөхцөл байдлын үед, эсхүл гэмт үйл ажиллагааны хөгжлийг алдаатай тодорхойлсон тохиолдолд анхны гэмт санааг агуулсан агуулгын хүрээнд хариуцлага хүлээлгэх нь зөв хэмээн зарим судлаачид үздэг байсан байна.

Хоёрдугаарт: Гэм буруугийн андуурал нь төөрөгдөл юм.

Хэрэв нэгдүгээр хэсэгт авч үзсэн гэм буруугийн андуурлын ойлголтыг нэгдүгээр үе шатаас эргэн харвал гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын үндсэн шинжүүдийг бүхэлд нь хангасан ойлголт байсныг анзаарах боломжтой юм. Өөрөөр хэлбэл нэгдүгээр хэсэгт үзэж байсан эрдэмтийн үзэл баримтлалыг материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэргэгт тооцох боломжтой юм.

Харин ОХУ-ийн эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд гэм буруугийн андуурлыг илүү боловсронгуй болгож, судалж байсан эрдэмтэд бол П.П. Пусторослев, Н.С. Таганцев, А.Ф. Кистяковский нарын тэргүүрэй судлаачид юм. Тэд үзэхдээ гэм буруугийн андуурлыг 2 төрөлд буюу зүйлчлэлийн андуурал буюу хууль цаазын андуурал болон бодит байдлын андуурал, ашиггүй завдалт хэмээн ойлголтуудыг анх гаргаж ирж байсан юм.

Эдгээр судлаачдын үзэл санаа өнөөгийн ОХУ-ийн эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны онолын хүрээд үнэтэй байр суурийг эзэлсээр байгаа хэдий ч Оросын эрүүгийн хууль тогтоомжид гэм буруугийн андуурлыг манай улстай нэгэн адил нарийвчлан хуульчилж, тодорхойлоогүй байна.

Монгол Улсын орчин үеийн эрүүгийн хууль тогтоомжид аливаа этгээд нь хууль зүйн андуурал гаргсаны улмаас нийгэмд аюултай, үйлдэл, эс үйлдэл хийж, тулгарсан аюулыг арилгах, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх эсхүл эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх тухай шууд заасан заалд байхгүй билээ. Гэвч практикт манай улсын иргэдийн гэмт хэрэгт холбогдох, гэмт хэрэг үйлдэхэд хүргэж шалтгаануудын нэг нь яахын аргагүй нийгэмд аюултай үйлдлийг хийхдээ удаа дараа дээрх андуурал, алдааг гаргаж, улмаар эрүүгийн эрх зүйн харилцааны субъект болох тохиолдлууд цөөнгүй байна. Тухайн иргэний андуурч хийсэн алдаатай үйлдэл, эс үйлдэхүй нь субьектийн зүгээс гаргаж буй зүйлчлэлийн андуурал хэмээх онолын ойлголт даган гарч ирэх юм. Хууль мэдэхгүй нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхгүй байх зарчимын дагуу хууль зүйн андуурал нь эрүүгийн хариуцлагыг бий болгодог.

Харин хүн бодит байдлыг андуурч, буруугаар төсөөлөн нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл хийсэн тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх тухай шууд заасан заалт одоогийн эрүүгийн хуульд тусгагдсан ба энэ нь гэм буруугийн андуурлыг хуульд шууд тусгаж өгсөн, дэвшил боловч хэт ерөнхий зохицуулалт болсон учир дутагдалтай юм. Эрүүгийн эрх зүйн салбар хөгжихийн хэрээр, практикт тулгамдсан гэм буруугийн андууралтай холбоотой зохицуулагдаагүй харилцаа бүрийн онцлогоос хамаарч цаашид энэхүү заалд илүү боловсронгуй болох боломжтой юм.

³¹ Гаухман Л. Д. Квалификация преступлений: закон, теория, практика. Москва, 2011. 446 дахь тал.

Гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын хувьд хууль зүйн эсхүл бодит байдлын андууралын улмаас, түүнд хандаж буй сэтгэхүйн харьцаа, учруулсан хохирол, хор уршиг, нийгмийн аюулаас нь шалтгаалан шудрага ёсны зарчмыг удиртгал болгон ялыг ялгамжтай, тохирсон байлаар оногдуулах зохицуулалт шаардлагатай юм. Мэдээж гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр үйлдэгддэг, тэр тусмаа андуурч үйлдэгдэх боломжгүй гэмт хэргүүдэд (өмчлөх эрхийн эсрэг, авлига албан тушаалын гэмт хэргүүдэд хамаарах гэмт хэргүүд г.м) хууль зүйн андуурлыг хэрэглэхгүй байхаар нарийвчигдсан зохицуулалт шаардлагатай юм.

Манай орны хувьд гэм буруугийн андууралтай холбоотой хэд хэдэн түүхийн эх сурвалжууд байдаг ч энэ нь зөвхөн бодит байдлын андууралтай холбогдож байна. Тухайлбал 1926 онд баталсан БНМАУ-ын шүүх цаазын бичгийн ерөнхий ангийн товчооны 3 дугаар бүлгийн /Ял үл хэлэлцэх/ 20 дугаар зүйлд зааснаар “Аливаа гэмт явдлыг үйлдэхдээ зориуд санаагүй эндэгдэн ташаарсан буюу, эцэстээ гэм гарахыг үл мэдсэн ба мэдсээр боловч зогсоохыг завдаж чадсангүй учир илэрвээс санаатайгаар үйлдсэн ёсоор яллаж үл болно. Хэрэв хууль цаазад тусгай заасан зүйл бий аваас түүнийг баримталж шийтгэвэл зохионо” гэж заасан байна³². Энэ нь гэмт хэрэг үйлдсэн этгээд хэргийн нөхцөл байдлыг буруугаар төсөөлсөнийг “эгнэгдэн ташаарсан” хэмээн үгсээр тодорхойлсон ба андуурч хийсэн үйлдлийг гэм буруугийн санаалтай хэлбэрээс ангид байлгаж, зөвхөн болгоомжгүй гэмт хэрэгт хамааруулсан байгаагаараа онцогтой байна.

Харин 1929 онд баталсан БНМАУ-ын шүүх цаазны бичгийн ерөнхий ангийн товчооны 3 дугаар бүлгийн /Ял үл хэлэлцэх/ 21 дүгээр зүйлд зааснаар “аливаа гэмт явдал үйлдэхээр зориуд санаагүй адагтаа ташаарсан буюу эцэстээ гэм гарахыг үл мэдсэн ба мэдсэн боловч зогсоохыг завдаж чадаагүй учир илэрвээс санаатайгаар үйлдсэн ёсоор яллаж үл болмой. Хэрэв хууль цаазад тусгай заасан зүйл буй аваас түүнийг баримталж шийтгэвээс зохимой” хэмээн заасан байна. Энэ нь өөрөө гэм буруугийн болгоомжгүй хэлбэрийг хуульчилсан мэт боловч угтаа “Гэм буруугийн андуурлын” ойлголтыг агуулж байна гэж үзэж болох юм. Учир нь андуурал гэх үгийн утга нь өөрөө эндүү, ташаарал³³ гэх утгатай ба энэхүү заалт дээр “...гэмт явдал үйлдэхээр зориуд санаагүй адагтаа ташаарсан...” гэх утга нь андуурлын ойлголтыг илэрхийлж байгаа юм³⁴. Хариуцлагын талаар уг заалтад санаатайгаар “...гэмт явдал үйлдсэн ёсоор яллаж үл болмой...” “Хэрэв хууль цаазад тусгай заасан зүйл буй аваас түүнийг баримталж шийтгэвээс зохимой” гэж заасан нь хариуцлагаас чөлөөлөх, хөнгөрүүлэх нөхцөлийг үүсгэж байна гэж үзэж болох юм.

1934 онд баталсан БНМАУ-ын Эрүүгийн хуульд гэм буруугийн санаатай болон болгоомжгүй хэлбэрийг тусгайлан зааж өгч гагцхүү уг хоёр хэлбэрээр үйлдсэн этгээдүүдэд ял хэлэлцэнэ гэж заасан ба 1942 он, 1961 он, 1986 онуудад мөн адил заасан байна³⁵. Үүнээс үзэхэд тухайн эрүүгийн хуулиудад гэм буруугийн андуурлыг гэм буруугийн болгоомжгүй хэлбэрт нэр мөр хамааруулан ойлгож, хуульчилж ирсэнийг анзаарч болохоор байна.

Нийгэм, цаг үе өөрчлөгдөхийн хэрээр манай орны эрүүгийн эрх зүйн зохицуулах харилцаа улам тэлж, практикт тулгарч буй тохиолдол, асуудлуудыг илүү нарийн зохицуулах шаардлага бий болсоор байгаа билээ. Үүний нэг илрэл нь 2002, 2015 оны эрүүгийн хуулийн шинэчлэлүүд юм.

³² Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. Уб., 2011. 284 дэх тал.

³³ [Монгол хэлний их тайлбар толь \(mongoltoli.mn\)](http://mongoltoli.mn)

³⁴ Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. Уб., 2011. 314 дэх тал.

³⁵ Мөн тэнд. 467 дахь тал.

2002 онд баталсан Монгол Улсын эрүүгийн хуульд “Гэм буруу”-гийн ойлголтыг тусдаа бүлэг болгож, хор уршиг гэм буруугүйгээр учруулах турхай шинэ ойлголтыг тусгасан нь практикаас үүссэн дэвшилтэд зохицуулалт байсан юм. Гэвч гэм буруугийн андуурлын талаарх ойлголтыг мөн тодорхойлон зааж өгөөгүй байсан юм.

Харин 2015 онд батлагдаж, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Эрүүгийн хуульд “Гэм буруугийн андуурал”-ын ойлголтыг тусгайлан зааж өгөөгүй. Гэвч Эрүүгийн хуулийн 6.5 дугаар зүйл буюу “Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал”-ын 1.6 дахь хэсэгт “Нөхцөл байдлыг буруугаар төсөөлж, андуурсны улмаас гэмт хэрэг үйлдсэн” гэх заалтыг шинээр нэмж оруулсан нь гэм буруугийн бодит байдлын андуурлыг илэрхийлсэн дэвшилт болсон юм. Гэвч уг заалт нь “нөхцөл байдал” гэх ойлголтоор хязгаарласан байгаа нь угтаа гэм буруугийн андуурлын ойлголтыг бүрэн гүйцэт илэрхийлж чадахгүй байгаа явдал юм.

Нөхцөл байдал гэдгийг Монгол хэлний их тайлбар тольд “тухайн юм, үйлийн үүсэх, хөгжих, оршин байх үеийн төлөв” гэж заасан байна. Мөн нөхцөл байдал гэх ойлголтод гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын нэмэгдэл шинж болох гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал хамаарах юм.

Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал гэж гэмт хэрэг үйлдсэн цаг үеийг тодорхойлох объектив нөхцөл байдал юм. Тухайлбал, дайны цаг буюу дайн бүхий байдал, онцгой байдал зарласан үед гэмт хэрэг үйлдэх, нийтэд учирсан гамшигт байдлыг далимдуулан гэмт хэрэг үйлдэх зэргийг ойлгоно³⁶.

Үүнээс үзвэл гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал нь гэмт этгээд тодорхой цаг хугацаанд өөрийн үйлдэж буй гэмт хэргийн бодит байдлын мөн чанар, нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг буруугаар ойлгон төсөөлж үйлдсэн явдлаас ялимгүй ялгагдаж байна. Учир нь гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд хүн аливаа нөхцөл байдлыг далимдуулж гэмт хэрэг үйлдэх тухай ойлголт хамаарна. Энэ нь гэмт этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулыг, мөн, түүний улмаас учрах хохирол, хор уршигийг ухамсарлан, ойлгосон атлаа түүнийг хүсч үйлдсэн байхыг илэрхийлэх бөгөөд тухайн үйлдлээ хийхдээ гагцхүү нөхцөл байдлыг л гэмт хэрэг үйлдэхэд тохиромжтой нөхцөл болгон ашигладаг онцлогтой.

Харин эрүүгийн хуульд тусгагдсан “Нөхцөл байдлыг буруугаар төсөөлж, андуурсны улмаас гэмт хэрэг үйлдсэн” тухай заалтын агуулга дахь “нөхцөл байдал” гэх ойлголт нь гэм буруугийн андуурлын нэг төрөл болох бодит байдлын андуурлыг буюу субъектийн гэмт хэрэг үйлдэж эхлэхийн өмнөх шатанд бий болж буй нөхцөл байдлыг буруугаар төсөөлөн андуурч, улмаар гэмт хэрэг үйлдсэн тухай илэрхийлж байгааг тусгасан ойлголт болохоор байна.

Гэм буруугийн андуурлын асуудлыг манай Эрүүгийн хуульд хараахан хуульчилж өгөөгүй, эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд онолын үүднээс тодорхойлж судалдаг бол зарим гадаад орнуудын Эрүүгийн хуульд хуульчилж өгсөн байна. Тухайлбал, АНУ-ын Нью-Йорк муж улсын Эрүүгийн хууль /15.205/, Франц улсын Эрүүгийн хууль /122.3§/, Герман улсын Эрүүгийн хууль /16-17§/, Испани улсын Эрүүгийн хууль /14§/, Беларусь улсын эрүүгийн хууль, ОХУ-ийн эрүүгийн хууль, Итали улсын Эрүүгийн хууль зэргийг дурдаж болно.

³⁶ Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги. УБ., 2020. 227 дахь тал.

Францын эрүүгийн хуульд зөвхөн хууль цаазны андуурлыг хуульчилсан бол Германы Эрүүгийн хуульд гэм буруугийн андуурлын хоёр төрөл болох бодит байдлын болон хууль цаазны андуурлыг тусад нь хуульчилж өгчээ.

Дээрх орнуудын Эрүүгийн хуульд гэм буруугийн андуурлыг хуульчилсан хэм хэмжээг судалж үзэхэд андуурсан бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх буюу оногдуулах ялыг хөнгөрүүлэхээр заасан байна.

Францын Эрүүгийн хуулийн 122.3-р зүйлд "Субъект үйлдэж байгаа хэргийнхээ хууль цаазны шинжийн талаар төөрөлдсөн, энэ хэргийг үйлдэх нь хуульд харш биш гэж бодсон бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө" хэмээн хуульчилсан нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн үйлдлийг хууль цаазын андуурал гаргаснаар хариуцлагаас боломжийг олгосон байна. Энэ нь маш ерөнхий зохицуулалт байх ба хуулийн урвуу байдлаар, өөрт ашигтайгаар шийдвэрлүүлэх, ял завших боломжийг олгох боломжтой юм.

Болгар улсын Эрүүгийн хуулийн 14-р зүйлд "Субъект гэмт хэргийн бүрэлдэхүүний элементүүдийн талаар мэдээгүй бол гэм буруугүйд тооцогдоно" гэж заасан байна. Болгар улсын эрүүгийн эрх зүй нь ОХУ-ийн эрүүгийн эрх зүйтэй төсөөтэй бөгөөд энэ нь Зөвлөлт холбоот улсын бүрэлдэхүүнд багтдаг байсан нь судалгаа шинжилгээний эх сурвалж ижил байсантай холбоотой юм. Гэвч өнөөгийн ОХУ-ийн эрүүгийн хуулиас ялгагдах нэг зохицуулалт бол гэм буруугийн андуурлын талаарх зохицуулалт хэрэгжиж буй явдал юм. Өөрөөр хэлбэл гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив, эсхүл субъектив шинжүүдийн аль нэг шинжийг л мэдээгүй байсан нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болох нөхцөлийг ерөнхийлөн хуульчилсан байна.

1995 оны Испани улсын эрүүгийн хуульд хууль зүйн болон бодит байдлын андуурлын улмаас хийсэн үйлдлийг тусгайлан хуульчлах бус чухамхүү "Гэмт хэргийг үйгүйсгэх нөхцөл байдал"-д хамааруулан зохицуулалт болгон тусгасан байна. "...Эрүүгийн эрх зүйн зөрчлийг бүрдүүлж буй үйлдэлд хамаарах арилгах боломжгүй алдаа нь тухайн хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно. Хэрэв гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлын хувьд алдааг арилгах боломжтой байсан тохиолдолд гэмт хэргийг болгоомжгүйгээр үйлдсэнд тооцож хариуцлага хүлээлгэнэ" хэмээн заасан байна.

Хүчин төгөлдөр үйлчилж буй Италийн Эрүүгийн хуульд мөн гэм буруугийн андуурлыг гэмт хэргийг үггүйсгэх нөхцөл байдалд хэрэглэх байдлаар хуульчилсан байна. Тухайлбал, 59 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт гэмт "...Хэрэв хүн ял оногдуулахгүй байх нөхцөл байдал бий болсон хэмээн андуурч, нийгэмд аюултай үйлдэл хийсэн бол тухайн нөхцөл байдлыг үргэлж түүний талд ашигтайгаар шийдвэрлэнэ. Хэрэв хүн хайхрамжгүй байдлын улмаас алдаа гаргасан бол тухайн үйлдсэн үйлдлийг болгоомжгүйгээр үйлдсэн хэмээн үзэх бөгөөд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй" хэмээн заасан байна. Үүнээс үзэхэд гэмт хэргийг үггүйсгэх нөхцөл байдлын үед хүн бодит байдлыг андуурч гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхөөр байна.

Харин Бүгд найрамдах Беларусь улсын эрүүгийн хуульд гэмт хэргийг үггүйсгэх нөхцөл байдлын үед гаргасан гэм буруугийн андуурлыг шууд хуульчилж өгсөн байна. Тухайлбал 37-р зүйлд гэм буруугийн андуурлыг гэмт хэргийг үггүйсгэх нөхцөл байдалтай уялдуулан хуульчилахдаа "...хүн өөрийгөө аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд хохирол учруулах, баривчлах таслан зогсоох зорилгоор халдах нөхцөл байдалд байна хэмээн төөрөгдөлд орж, хохирол учруулах бодит нөхцөл байдал байхгүйг мэдэх ёсгүй, мэдэх боломжгүй байсны улмаас гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй "

хэмээн хуульчилсан байна. Энэхүү зохицуулалтыг ОХУ-ийн эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд онолын хувьд хүлээн зөвшөөрсөн байдаг.

Английн эрх зүйн сургаальд хэрэв субъект хууль бус зүйлийг хийхдээ бодит нөхцөл байдлыг мэдээгүйн, эсхүл түүний талаарх алдаатай төсөөллийн улмаас хийж буй зүйлээ хууль бус болохыг нь мэдээгүй тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн хэмээн хариуцлага хүлээлгэхгүй хэмээн тодорхойлсон байдаг. Учир нь энэ тохиолдолд хүсэл зориг болон үйлдлийн байх ёстой нэгдэл байхгүй; хүсэл зоригийн гэмт үр дагаварт хандах харилцаа саармаг болж үлдэнэ” хэмээн үздэг. АНУ-ийн эрх зүй нь Английн эрх зүйгээс эх сурвалжтай бөгөөд АНУ-ийн 1962 оны Эрүүгийн хууль 2.04 заалтад эрх зүйн болон бодит байдлын андуурлын тухай асуудлыг анх хуульчилж байсан юм. Үүний агуулга нь “ Хэрэв хүн аливаа гэмт хэргийн шинжтэй үйлдлийг хийхдээ бодит байдал, хууль зүйн андуурлын улмаас гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө, гэхдээ халдлагын заавал байх элемент болох гэм буруу байхгүй байхыг шаардана. Харин аргагүй хамгаалалтын хувьд тухайн хамгаалалтыг хийх үеийн хамгаалалт хийсэн хүний сэтгэл санааны байдлыг харгалзаж хариуцлагаас чөлөөлөх эсэхийг шийдвэрлэнэ” хэмээн хуульчилсан байна.

ОХУ-ийн эрүүгийн хуульд мөн гэм буруугийн андуурлын талаарх нарийвчилсан зохицуулалт байхгүй байна. Гэвч 1995 онд боловсруулагдсан ОХУ-ын Эрүүгийн хуулийн төслийн 29-р зүйлд андууралтай шууд холбогдох "Хэрэв субъект өөрийн хийх гэж байгаа болон хийж буй үйлдэл /эс үйлдэхүй/ нь ялын сүрдүүлэг дор эрүүгийн хуулиар хориглосон гэдгийг ухамсарлаагүй, хэрэг үйлдэх үеийн нөхцөл байдлаас шалтгаалж ингэж ухамсарлах /мэдэх/ боломжгүй байсан нь тогтоогдвол гэм буруугүй гэж үзэх бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээхгүй" гэсэн хэм хэмжээ хэлэлцэгдэж байсан боловч хууль тогтоогчдын дэмжлэг авч чадаагүй юм. Энэ нь агуулгаараа андуурлын тухай биш гэм буруугүйгээр хохирол учруулахтай холбоотой байсан нь харагдаж байна.

Гэвч зарим улсад, тухайлбал, Германы эрүүгийн хуульд андуурлын хоёр төрөл болох хууль зүйн болон хэргийн нөхцөл бодит байдлын андуурлыг тусад нь хоёр бие даасан хэм хэмжээнд хуульчилсан нь сонирхол татаж байна. Германы Эрүүгийн хууль 16, 17-р зүйл "Хэрэв субъект хэрэг үйлдэх үеийн нөхцөл байдлын улмаас өөрийн хийж буй үйлдэл, гэмт хэрэг мөн эсэхийг мэдээгүй, мэдэх боломжгүй бол эрүүгийн хариуцлага хүлээхгүй", "Хэрэв субъект өөрийн үйлдлийг /эс үйлдэхүй/ гэмт хэрэг гэж бодсон боловч тэр нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг биш бол эрүүгийн хариуцлага хүлээхгүй", "Хэрэв субъект Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдэх үедээ гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний обьектив болон субъектив шинжүүд, хүндрүүлэх болон онц хүндрүүлэх нөхцөл байдлуудын талаар ташаарсан /андуурал/ бол андуурсан төсөөллийн хүрээнд андуурлын шинж, агуулга, хүрээ зэргийг тал бүрээс нь харгалзан эрүүгийн хариуцлагын асуудлыг шийдвэрлэнэ" хэмээн хуульчилсан байна.

Харин Монгол Улсын Эрүүгийн хуульд “Гэм буруугийн андуурал”-ын тухай ойлголтыг тусгайлан зааж өгөөгүй бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн 6.5 дугаар зүйл буюу “Эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдал”-д гэм буруугийн андуурлыг “Нөхцөл байдлыг буруугаар төсөөлж, андуурсны улмаас гэмт хэрэг үйлдсэн” хэмээн зөвхөн гэм буруугийн бодит байдлын андуурлыг тусгасан юм.

Гэвч уг заалт нь “нөхцөл байдал” гэх ойлголтоор хязгаарласан байгаа нь угтаа гэм буруугийн андуурлын ойлголтыг бүрэн гүйцэт илэрхийлж чадахгүй байгаа явдал юм. Учир нь “Нөхцөл байдлыг буруугаар төсөөлж, андуурсны улмаас гэмт хэрэг үйлдсэн” гэх

заалтын байгаа “нөхцөл байдал” гэх ойлголт нь гэм буруугийн андуурлын нэг төрөл болох бодит байдлын андуурлыг буюу субъектийн гэмт хэрэг үйлдэж эхлэхийн өмнөх шатанд бий болсон, улмаар буруу төсөөлөл, андуурлын улмаас гэмт хэрэг үйлдэх ойлголт бөгөөд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх үндэслэл юм.

Дүгнэлт. Дээрээс үзэхэд улс орон бүр гэм буруугийн андуурлыг өөр өөрсдийн байр сууринаас, практикт үндэслэн тайлбарлаж, хуульчилсан байна. Зарим улс орнуудад гэм буруугийн андуурлыг гэм буруу гэх институцийн бүрэлдэхүүнд хамааруулан судалж, хуульчилсан байхад, зарим нь гэм буруугийн андуурлыг гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдалд хамаатуулан зохицуулж байгаа бөгөөд эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх эсхүл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх бие даасан үндэслэл болгон хуульчилсан онцлогууд ажиглагдаж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Совд, Г. БНМАУ-ын эрүүгийн эрх зүйн курс. Ерөнхий анги. УБ., 1973 он
2. Нарангэрэл, С. Монгол улсын эрүүгийн эрх зүй Ерөнхий анги., УБ 1999 он
3. Жанцан, С. Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол., УБ 2009 он
4. Гантөмөр, Г. Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол. УБ., 2011 он
5. Золбоо, Т. Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги гэмт хэргийн бүтэц. УБ., 2018 он
6. Доржпалам, Х. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй ерөнхий онол. УБ., 2019 он
7. Амарбаясгалан, Б. Тойм лекц. УБ., 2019 он
8. Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги. УБ., 2020 он
9. Гаухман Л. Д. Квалификация преступлений: закон, теория, практика. Москва, 2011 он

ӨСВӨР НАСНЫ ХҮНЭЭС ХҮЧИНГИЙН ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭЖ БУЙ ШАЛТГААН НӨХЦӨЛ YOUNG CHILDREN COMMIT CRIMES CAUSE CONDITIONS

*Дотоод хэргийн их сургуулийн магистрант,
цагдаагийн хошууч М.Болор
Graduate student of the university
of internal affairs, police captain M. Bolor*

Хураангуй: Энэхүү өгүүлэлээр өсвөр насны хүний зүгээс үйлдэгдэж хүчиндэх гэмт хэргийн өнөөгийн байдал, урьдчилан сэргийлэх арга зүйг тодорхойлж үнэлэлт дүгнэлт өгч шалтгаан нөхцлийг тайлбарласан.

Abstract: In this article, the current situation and methods of prevention of rape committed by teenagers are determined and evaluated, and the causes and conditions are explained.

Түлхүүр үг: Гэр бүл, боловсрол, хүмүүжил, хараа хяналт, үл хайхрах, хууль, эрх зүй.

Key words: family, education, supervision, law and justice.

Үндсэн хэсэг. Монголчууд эрт цагаас хүнээр хүн хийж, хүүхдийг бага наснаас нь зөв төлөвшилтэй, бие хүн болгохоор ардын аман зохиол, үлгэр домог, тууль, зүйр цэцэн үг, оньсого, таавар, ахуй, аж амьдралаараа хүмүүжүүлсээр ирсэн хүүхэд хүмүүжлийн баялаг өв уламжлал түүхтэй улс билээ.

Хүүхэд бүрийн төрлөх араншин өөр өөр байдгаас шалтгаалан хүүхэд хүмүүжлийн олон арга, сурган хүмүүжүүлэх дадлтай байсан нь түүх, шастирт тэмдэглэгдэн үлдсэн байдаг.

Омог хурц, ширүүн төлөвтэй хүүхдийг: Омогтой хүнийг дарлаваас хорсох тул нэр цолоор баясга, атаач хүнд нүүр эс өгвөөс гомдох тул сайхан загна, дээрэнгүй хүнийг хөгжөөвөөс хэрэг гарах тул битгий хэрэгс, ууртай хүнд ширүүн хэлбэл аюул болох тул ухуул гэх мэт хүүхэд бүрийн зан араншинд нийцүүлэн нарийн харьцах аргатай байсан бол мөн хүүхдийг өсөж томрох хэрээр үлгэр дуурайлалтай, бие хүн болгон төлөвшүүлэх зорилгоор хүүхдийг:

-Гашуунаар бүү тэтгэ;

-Амтганаар бүү тэтгэ;

-Өнгөнд бүү шунуул;

-Мөнгөнд бүү шунуул;

-Улай бүү үзүүл;

-Нойронд бүү автуул гэж сурган Гурав настанг хаан мэт дээдэл, таван настанг хатан мэт хайрла, таван наснаас дээш насны хүүхэдтэй харцын ёсоор харьц, арван гурван наснаас дээш хүүхэдтэй найзын ёсоор харьц хэмээн хүүхдийн нас насны онцлогт тохируулан сурган хүмүүжүүлэх ухаанаар харьцаж байсан.

Монголчууд “Хүн болох багаасаа, хүлэг болох унаганаасаа”, “Буруу эрхэлсэн хүүхэд бухын хүзүүнээс ч хатуу” гэж сурган, хүүхдэд багаас нь энэрэл, хайр, халамж тавьж, амьдралын зөв дадал, хэвшилтэй болгож хүмүүжүүлэхийг ардын аман зохиол, зүйр цэцэн үгээр илэрхийлсэн ирсэн. Хүүхдийг зөв биет хүн болгон хүмүүжүүлж, амьдралын зөв дадал зуршилтай болгох нь бүх хүүхэдтэй эцэг эхчүүдийн хуулийн өмнө хүлээсэн үүрэг билээ. 2016 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байгаа “Хүүхдийн эрхийн тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлд “Хүүхдийн хүмүүжил төлөвшил”-ийн тухай, 10 дугаар зүйлд “Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг хариуцлага”-ын тухай тодорхой тусгасан байдаг.

Хувьсан өөрчлөгдөж буй нийгэм, мөнгөний хамаарлаас шалтгаалан цаг үеэ даган хүүхэд хүмүүжүүлэх сургаалт үг, сурган хүмүүжүүлэх арга барил орхигдож, мэддээлийн хэт задгай хэрэглээ, эцэг эхийн хайхрамжгүй байдлаас шалтгаалан зөвхөн эд зүйл, хэрэглээг ханган хүүхдээ үл хайрхалт дунд орхиж, хүүхдээс хүссэн эд зүйлээр ханган орхиж

байгаагаас хараа хяналтаас гарсан өсвөр насны хүүхдийн гэмт хэрэг үйлдэх болж нийгмийн хөндүүр сэдэв болсоор байна.

Насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн сэтгэл зүйн шалтгаан нөхцөл олон төрөл байдаг боловч тухайн өсвөр насны сэжигтэн яллагдагч, шүүгдэгчид гэмт хэрэг, зөрчил үйлдэх үеийн сэтгэл зүйд ар гэрийн амьдрах орчин, эцэг эхгүй хүмүүжих, хайр халамжгүй, хүүхэд наснаас үлдсэн дурасамж, харгис хэрцгий эцэг эхтэй байх нь нөлөөлсөн эсэхийг судлах явдал юм.

Өнөөгийн нөхцөл байдал

Өсвөр насны хүний зүгээс үйлдэгдэж буй гэмт хэрэг жил ирэх тусам хэрцгий, хүнлэг бус болж, энэ хэрээр хүчиндэх гэмт хэрэг үйлдэж буй өсвөр насны хүний хэргийн гаралт жил ирэх тусам өсөн нэмэгдэж байна.

Эцэг эх, асран хамгаалагчийн зүгээс үл хайхрах, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг шалтгаан, нөхцөлөөс болж хараа хяналтаас холд оршиж, сургууль завсардаж, өөрийн үнэмлэмж буурч, амьдралын бодитой зорилго төлөвлөгөөгүй, ихэнх цагаа гудамжид өнгөрөөх, мөн мэдээллийн хэт задгай хэрэглээ нь өсвөр насны хүнийг бэлгийн эрт харилцаанд татаж байгааг үгүйсгэхгүй бөгөөд өсвөр насны хүний зүгээс үйлдсэн хүчингийн гэмт хэрэг үйлдсэн орчин, цаг хугацаа, шалтгаан нөхцөл нь дийлэнхдээ ар гэрийн хараа хяналт сул, гэр бүлийн хүчирхийлэл дунд өссөн, хэт задгай хүмүүжилтэй зэргээс шалтгаалж байна.

Дээрх хүчин зүйлээс шалтгаалан хүүхэд хэсэг бүлгээрээ нийгмийн сөрөг зан үйлд суралцан, харилцан гэмт зан үйл халдаах байдалд автдаг.

2021 онд насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэргийн 599 буюу 81.7 хувийг хөнгөн, 134 буюу 18.3 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж, 68.9 хувь нь Улаанбаатар хот, 31.1 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна. Үүнээс хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн 7,

2022 оны 8 дугаар сар хүртэлх хугацаанд насанд хүрээгүй хүнээс үйлдсэн гэмт хэргийн 744 буюу 85.8 хувь нь хөнгөн, 123 буюу 14.2 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж, 73.9 хувь Улаанбаатар хотод, 26.1 хувь орон нутагт үйлдэгдэн бүртгэгдсэн бол хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн 8 тохиолдол бүртгэгджээ.

Хорих ялаар шийтгүүлж, хорих ангид хоригдож буй хүүхдүүдийн 80 хувь огт сургуульд суралцаагүйгээс гадна бичиг үсгийн анхан шатны мэдлэгийг дөнгөж эзмшсэн байсан бол 90 хувь нь гэмт хэрэг үйлдэхээс өмнө ямар нэгэн байдлаар сургалт, сургуульд суралцаж байгаагүй.

Судалгаанаас авч үзвэл гэмт хэрэг үйлдсэн хүүхдийн 37 буюу 12.3 хувь сургуульд суралцаагүй, 89 буюу 29.6 хувь бага боловсролтой, 118 буюу 39.3 хувь нь бүрэн бус дунд боловсролтой байлаа.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2023 оны эхний 1 сард 3900 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оноос 96 хэргээр буюу 2.4 хувиар буурч, насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэрэг 34 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 1 хэргээр буюу 3.0 хувиар өсч, нийт хэргийн 0.9 хувийг эзэлж байна.

Насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэргийн 28 буюу 82.4 хувийг хөнгөн, 6 буюу 17.6 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж, 44.1 хувь нь нийслэлд, 55.9 хувь нь орон нутагт бүртгэгдсэн.

Гэмт хэргийн өнгөөр нь авч үзвэл: 9 буюу 26.5 хувь нь хулгайлах, 17 буюу 50.0 хувь нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 4 буюу 11.8 хувь нь залилах,

2 буюу 5.9 хувь нь дээрэмдэх, **1 буюу 2.9 хувь нь хүчиндэх**, 1 буюу 2.9 хувь нь бусад төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан байна³⁷.

Хүчиндэх гэмт хэрэгт холбогдсон бага насны хүүхдийн талаар Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн ерөнхий газраас 2017-2022 оны байдлаар судалгааг хийсэн байх бөгөөд уг судалгаанд зөвхөн хүчиндэх гэмт хэргийн хохирогчоор Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт хандсан судалгаа юм³⁸. Уг судалгаанд:

Газар орон	2017	2018	2019	2020	2021	2022
Улаанбаатар хот	86	137	81	101	140	141
Орон нутаг	109	173	116	112	205	228

Гэвч хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүүхдийн талаар судалгааг тэр бүрийд судлаагүй байх бөгөөд энэ төрлийн гэмт хэрэг гэр бүлийн хүрээнд үйлдэгдэн гэр бүлийн гишүүд дарах, нуух байдлаар өнгөрүүлдэгтэй холбоотой байх магадлал өндөр байгаа юм.

Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага 411 дүгээр хорих ангид хорих ял эдэлж буй хоригдол хүүхдүүдтэй ярилцлагын аргаар асуулга явуулахад:

15 настай Б: 5 настай бага настай байхдаа хамаатны ахдаа хүчирхийлүүлж байсан бөгөөд энэ үйл явдал нь тухайн хүүхдийн сэтгэл зүйд толбо болон үлдэж, энэ явдал удаан хугацаанд үргэлжилж, улмаар бага насанд үзэж туулсан бүхнээ өөрийгөө хамгаалах чадваргүй хүнд үзүүлэх, үүнээсээ таашаал авах хүслийг түрүүлэх болсон;

15 настай Б: Зуны амралтаар хөдөө төрөл садны хамаарал бүхий айлд амрахаар очсон, шөнийн цагаар насанд хүрсэн хүмүүсийн дотно харилцааг харснаар тухайн айлын бага насны хүүхдэд бэлгийн хүчирхийлэл үзүүлсэн;

15 настай С: Хойт эцгийн дарамтад бага насаа өнгөрүүлсэн, хойт эцэгтээ зодуулсан, үүнээс үүдэн хонзон авах зорилгоор төрсөн дүүдээ бэлгийн хүчирхийлэл үзүүлсэн;

13 настай Т: Асрах газарт хүмүүжиж байхдаа хамт асрах газар хүмүүжиж байсан хөвгүүдтэй бэлгийн харилцаанд орсон, цэвэр өөрсдийн сонирхлоор орсон гэх;

14 настай Б: Насанд хүрсэн эрэгтэй найзуудын ятгалгаар, тэдний санал болгосноор үеийн охинтой бэлгийн харилцаанд хоорондоо тохиролцоод орсон гэх³⁹;

Мөн хүчиндэх гэмт хэрэг үйлдэж буй өсвөр насны этгээдийн бага насанд авсан сэтгэл зүйн гэмтэл нь нөлөөлөх шалтгаан болдог нь олон олон бодит үйл явдлаас харагдаж байна.

Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүүхдийн сэтгэл зүйн байдлыг судлан үзэхэд эцэг эхийн болон гэр бүлийн хамаарал бүхий хүмүүсийн амьдралын хэв маяг, өдөр тутмын үйл явдал, зан үйлээс шалтгаант байдлаас үүссэн байх магадлал тун өндөр байна.

Өсвөр насны хүний сэтгэл зүйн байдалд нөлөөлөх хүчин зүйл

Бага наснаас сэтгэл, санаандаа тод авсан үзэгдлээс шалтгаалан мөн туршин үзэх хүсэл, сонирхолд хөтлөгдөн энэ төрлийн гэмт үйлдлийг хийж үзэх хүсэлд автах, донтох байдал бий болж байна.

³⁷ Цагдаагийн ерөнхий газрын судалгаа

³⁸ Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн ерөнхий газрын 2017-2022 оны судалгаа

³⁹ Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага 411 дүгээр хорих ангид хорих ял эдлэж байгаа хүүхдүүдээс авсан судалгаа

Өсвөр насанд буюу аливаа зүйлийг олон талаас танин мэдэх насанд үзсэн, мэдэрсэн зүйл сэтгэлд тод үлддэг бөгөөд сэтгэл зүйн хувьд айдас эсвэл, дахин мэдрэх хүслийг төрүүлдэг тухай сэтгэл зүйн онолуудад дурьдсан байдаг.

Жишээлбэл:

Хүүхэд оюун санаа, сэтгэл зүй, бие махбодийн хувьд тодорхой өсөлтийн үе шатуудтай байх бөгөөд тухайн насандаа тохирсон сэтгэл зүйн онцлогтой, хүүхдийн тархи 20 нас хүртэл хөгждөг, үе шатлалтай хүүхдийн хөгжилтэй холбоотойгоор сэтгэл зүй ч мөн хөгжиж байдаг.

Хүүхдийг бүрдүүлж,нөлөөлж, бие хүн болоход гээр бүл, эцэг эхийн хүмүүжил, орчин маш чухал нөлөөтэйг дурддаг бөгөөд хүүхдийн сэтгэцийн хөгжлийн үе шатыг:

I үе шат: Хөдөлгөөний /1 нас/

II үе шат: Мэдрэхүйн хөдөлгөөний /1-3 нас/

III үе шат: Сэтгэл хөдлөлийн /3-12 нас/

IV үе шат: Сэтгэхүйн /10-12 нас/

Сэтгэцийн эмгэг, өөрчлөлтүүдийн ихэнх нь хүүхэд насанд үүсдэг. Тиймээс эцэг эхчүүд хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхдээ дараах чадвар, мэдрэмжүүдийг нь хөгжүүлж, суулгаж өгөх нь чухал юм.

Сургуулийн насны үе 6-12 нас: Хүүхэд өмнөө тавьсан санаачлагч эсвэл захирагдсан зан төлөвтэй болох эсэх нь үргэлжлэн хөгжиж байдаг. Идэвх, санаачлагатай байх нь хөдөлмөрч зан чанараар илэрч, ажил хийх дур сонирхол, хүсэл эмэлзэлтэй, тууштай, цөхрөлтгүй оролдлого хийдэг эерэг чанарууд үүсэж төлөвшихөд нөлөөлдөг;

Өсвөр буюу идэр насны үе 12-20 нас: Амьдралын мөчлөгийн бүх үе шатууд дотроос хамгийн чухал үе нь юм. Энэ үе нь ижилсүүлэлт, тодорхойгүй байдал хоёрын аль нэг нь л бүрэлдэн тогтдог. Өсвөр насны хүүхэд “Би хэн бэ, хэнийг дуурайх вэ” гэдэгт хариулт хайдаг. Хэн нэгэн таалагддаг, хүндэлдэг хүнээ үлгэрлэн дуурайж, түүн шиг биеэ авч явах, түүн шиг хувцаслах, бүр түүн шиг ярих гэх мэтээр өөртөө бие хүний тодорхой байдлыг төлөвшүүлдэг.

Харин ижилсүүлэлтийг шийдвэрлэж чадаагүй, үлгэр, дуурайлал авах хүнгүй бол бие хүний тодорхойгүй байдал төлөвшдөг аж. Тодорхойгүй байдалд орсон хүүхэд:

- Нийгэм, сэтгэл зүйн дараагийн ххөгжлийн үе шатуудад шилжихэд саад тотгортой учрах;
- Сэтгэцийн гажуудал үүсэх;
- Сэтгэл зүйн хөгжлийн өмнөх шат руу ухрах зэрэг сөрөг талтай⁴⁰;

Хүүхдийн хүмүүжил, зан чанар, сэтгэл зүйн хувьд эрүүл байх, эсвэл асуудалтай байх гол эх үүсвэр нь эцэг эх юм.

Гэр бүлийн орчин нь хүүхдэдээ “Би чамтай хамт”, “би чиний талд шүү” гэдгийг мэдрүүлэх нь маш чухал бөгөөд хүүхдээ сонсож, ойлгох хэрэгтэй. Хүүхдийнхээ хэрэгцээг зөв тодорхойлж, зөвхөн эдлэл, хэрэглэл, хоол, хүнсээр хангах бус сэтгэл зүйн хувьд хэн болон төлөвшихөд нь анхаарах хэрэгтэй юм.

Дүгнэлт. Өсвөр насны хүний зүгээс үйлдэгдэж буй гэмт хэрэг жил ирэх тусам өсөх гэмт хэргийн хөдөлгөөн ажиглагдаж байна. Өсвөр насны хүнээс үйлдэж байгаа хүчиндэх гэмт хэрэг гаралт гэмт хэргийн хөдөлгөөнөө дагаж жил ирэх тусам өсөн нэмэгдэж байна.

Хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүүхдийн сэтгэл зүйн байдлыг судлан үзэхэд эцэг эхийн болон гэр бүлийн хамаарал бүхий хүмүүсийн амьдралын хэв маяг, өдөр тутмын үйл явдал, зан үйлээс шалтгаант байдлаас үүссэн байх магадлал тун өндөр байна. Өсвөр буюу идэр насны үе 12-20 насанд өсвөр насны хүний төлөвшлийн хамгийн чухал үе юм.

Энэ үе өсвөр насны хүүхэд “Би хэн бэ, хэнийг дуурайх вэ” гэдэгт хариулт хайдаг бөгөөд тухайн үед нь эцэг эх, гэр бүлийн гишүүд, сурч байгаа сургуулийн зүгээс хамтарсан хяналтын, мөн урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийн хэрэгжүүлснээр энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн хөдөлгөөн, гаралтыг саармагжуулах бүрэн боломжтой гэж дүгнэж болохоор байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Цагдаагийн ерөнхий газрын статистик мэдээлэл <https://police.gov.mn/as/article/3>
2. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн ерөнхий газрын 2017-2022 оны судалгаа
3. Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллага 411 дүгээр хорих ангид хорих ял эдлэж байгаа хүүхдүүдээс авсан судалгаа

**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГ,
ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ**
CRIMES OF DOMESTIC VIOLENCE,
SOME PROBLEMS OF ITS LEGAL REGULATION

Б.Наргулан
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн ахлах багш,
цагдаагийн дэд хурандаа
B.Nargulan
Senior teacher of police Law department,
Police school of University of Internal Affairs

Хураангуй: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг гэдэг нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдал, гэр бүлийн ашиг сонирхолд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл хэлнэ.

Энэхүү өгүүлэлд гэр бүлийн хүчирхийллийн тухайн ойлголт, түүний бүрэлдэхүүний шинж, гэмт хэргийн гаралтын өнөөгийн байдал, түүний шалтгааны талаар товч авч үзсэн болно.

Abstract: The crime of domestic violence is defined as a criminal act that is legally defined in Article 11.7 of the Criminal Code and is punishable by criminal liability.

This article briefly discusses the concept of domestic violence, its components, the current state of crime, and its causes.

Түлхүүр үг: Гэр бүл, бэлгийн хүчирхийлэл, бие махбодь, эдийн засаг, сэтгэл зүй, гэмт хэрэг, үйлдэл, эрх, хууль, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн,

Keywords: Family, sexual violence, physical, economic, psychological, crime, action, right, law, family related relationship

Оршил хэсэг. Хүний жам ёсны эрхийг зөрчиж байгаа хамгийн түгээмэл үйлдэл нь аливаа хэлбэрийн хүчирхийлэл бөгөөд түүний дотор гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүсийн хооронд үйлдэгддэг гэр бүлийн хүчирхийлэл хамгийн ихээр гарч байна. Монгол Улс төдийгүй бусад улс орнуудын анхаарлын төвд байгаа туйлын харш үзэгдэл бол эмэгтэйчүүдийг хүчирхийлэх явдал юм. Өнөөдөр Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэл нь нийгмийн тулгамдсан асуудлууд дотор хохирол, хор уршигаараа мэдэгдэхүйц аюул дагуулсан үзэгдлийн хэмжээнд хүрээд байна.⁴¹

Монгол Улсад гэр бүлийн хүчирхийллийн бүх хэлбэр бүртгэгдэж түүнд эрэгтэй, эмэгтэй, хүүхэд, хөгшид аль аль нь өртөж байна. Гэхдээ эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн хэлбэр дийлэнх болохыг судалгаа харуулж байгаа бөгөөд үүнээс үүдэн “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл” хэмээх нэр томъёо бий болж, эл үзэгдлийг орчин үеийн боолчлолын нэг хэлбэр гэж тодорхойлох болов.⁴² Монгол Улсын Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдорж хэлэхдээ “Боолчлол гэр бүлийн хүрээнд үлджээ. Охидоо хамгаалж чадахгүй, хүнээ хамгаалж чадахгүй бол хүнлэг нийгэм ээ хамгаалж чадахгүй”⁴³ гэж хэлснээс үзэхэд нийгмийн энэ сөрөг үзэгдэл үндэсний аюулгүй байдалд аюул занал учруулах хэмжээнд хүрч, анхаарал татах асуудал болсоныг харуулж байна. Иймээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн шинж, тулгамдаж байгаа асуудал болон улсын хэмжээнд хэрхэн

⁴¹ Цагдаагийн Ерөнхий Газрын МТ-ийн төв. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн улмаас хохирсон иргэний судалгаа. УБ хот. 2015 он., Хавсралт №3

⁴² П.Цэцгээ. Гэр бүл, ахуйн хүрээн дэхь хүчирхийлэл, түүний эрх зүйн зохицуулалт. УБ., 2015 он., 36 дахь тал

⁴³ www.president.mn

хэрэгжиж байгаа мөн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүмүүсийн өнөөгийн нөхцөл байдал, түүнтэй тэмцэх арга зам түүний эрх зүйн зохицуулалтын талаар гүнзгийрүүлэн судлахад оршино.

Үндсэн хэсэг: Монгол Улсын Үндсэн хуулийн 16.11-д ..“Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ⁴⁴... гэж заасан байдаг. Гэвч өнөөдөр Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэл ихээр үйлдэгдэх болж нөхөр нь эхнэр, хүүхэд ээ зодсон, хүчирхийлсэн, сэтгэл санааны дарамтад оруулсан зэрэг нийгмийн сөрөг үзэгдэл гарах болж Монгол Улсын Үндсэн хуулинд заасан гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй гэсэн заалтыг зөрчиж гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүмүүс бие биенээ сэтгэл санаа, эдийн засаг, бие махбодь, бэлгийн зэрэг төрөл бүрийн хүчирхийлэлд оруулж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд: Гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд /эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр,.../ энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодьд халдсан үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ⁴⁵ гэсэн бол судлаач Г.Бямбадорж: Гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нь аль нэг этгээд нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан эсвэл учруулахаар заналхийлсэн үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ гэсэн байна⁴⁶. Бидний үзэж байгаагаар гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн хэн нэгний эрх, хууль ёсны ашиг сонирхолын эсрэг сэтгэл санаанд нь дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодид халдаж хохирол, хор уршиг учруулсан үйлдлийг хэлнэ гэж үзэж байна.

Дээрх тодорхойлолтоос үзэхэд гэр бүлийн хүчирхийлэл нь гэмт хэргийн шинжийг агуулж байгаа нь харагдаж байна. Учир нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.5-р зүйлд гэмт хэргийн хохирол, хор уршиг хуульчилж⁴⁷ өгсөн бөгөөд тухайн хохирол хор уршигийг учруулахдаа нэг удаагийн эсхүл үргэлжилсэн үйлдлээр хохирол, хор уршигт санаатай учруулдаг. Тиймээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг эрүүгийн эрх зүйн талаас нь дэлгэрүүлэн авч үзэх шаардлага үүнээс үүдэн гарч байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7-р зүйлд “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийг хуульчилсан бөгөөд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан үйлдэлүүд хамаардаг.⁴⁸

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг гэдэг нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдал, гэр бүлийн ашиг сонирхолд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл юм⁴⁹ гэж тодорхойлсон байна.

⁴⁴ Төрийн мэдээлэл. 1993. №1. Монгол Улсын Үндсэн хууль.

⁴⁵ Төрийн мэдээлэл. 2017. №5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

⁴⁶ Г.Бямбадорж. Гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал. УБ., 2014. 35 дахь тал

⁴⁷ Гэмт хэргийн хохирол, хор уршиг нь эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

⁴⁸ Төрийн мэдээлэл. 2016. №7. Эрүүгийн хууль

⁴⁹ С.Гантулга., Б.Энхболд. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. УБ. 2018 он., 47 дахь тал

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг нь Эрүүгийн хуульд зайлшгүй байвал зохих нийгэмд аюултай үйлдэл эс үйлдэхүй, хор уршиг учруулдаг үйлдэл, эс үйлдэхүй байх шинжээрээ гэмт хэргийн шинжийг агуулж байгаа юм. 2015 онд батлагдсан Монгол Улсын эрүүгийн хуулийн 11.7-р зүйлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх үйлдлийг гэмт хэрэгт тооцож гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш байх эрхийг эрүүгийн хууль тогтоомжоороо хамгаалсан юм.

Тэгвэл гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн шинжээр нь авч үзвэл дараах үндсэн шинжтэй. Үүнд:

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн **объект нь** хүний эрүүл мэндийн халдашгүй байдал, гэр бүлийн ашиг сонирхол байна. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдал, гэр бүлийн ашиг сонирхолыг Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3 дугаар зүйлд: “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй⁵⁰,” Үндсэн хуулийн 16-р зүйлийн 13-д Халдашгүй чөлөөтэй байх., 11-д Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхолыг төр хамгаална,⁵¹ гэж тус тус гэр бүлийн хамаарал бүхий хүний эрх, ашиг сонирхолыг баталгаажуулж өгсөн.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн **объектив тал нь** гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон, байнга харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан, байнга хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах, эрхэд халдсан идэвхтэй үйлдэл байна⁵².

Объектив талын үндсэн шинж нь **байнга** гэсэн шинжийг агуулж байх ёстой бөгөөд Эрүүгийн хуулинд байнга гэдгийг хэдэн удаагаар ойлгохыг тайлбарласан эрүүгийн хуулиар зохицуулсан ойлголт байхгүй байна. Практикт байнга гэдгийг өмнөх 2002 оны Эрүүгийн хуулийн 100-р зүйлд “Тарчлаах” гэмт хэргийн тайлбараар ойлгож хэрэглэж байна. Өмнөх хуулийн тайлбарт “байнга” гэдгийг 3 буюу түүнээс дээш удаа үйлдсэн тохиолдлыг ойлгож байсан. Харин 2015 оны Эрүүгийн хуульд тийм зохицуулалт байхгүй байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг нь **халдлагад өртөгч /хохирогч/-ийн** эрүүл мэндэд хохирол учирсан байхыг шаардахгүй, гэр бүлийн хүчирхийлэл байнга үйлдсэнээр төгсдөг хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг юм.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн **нэр томьёоны хувьд авч үзвэл:** Байнга зодсон гэж гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний бие махбодид 3 ба түүнээс дээш удаа халдсан байхыг ойлгоно. Хохирогчийн бие махбодид халдах үйлдэл нь алгадах, цохих, түлхэх, өшиглөх, зэрэг хэлбэртэй байж болно.⁵³ Байнга хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан гэж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3-д заасан үйлдлийг 3 ба түүнээс дээш удаа хийснийг ойлгоно. Тухайлбал хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүй хийсэн⁵⁴, хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх, эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгих, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэх зэргийг ойлгоно.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн **нэр томьёоны тайлбарын** хувьд албан ёсны Дээд шүүхийн тайлбар гараагүй байгаа учир эрдэмтэн, судлаачид янз бүрийн

⁵⁰ Хүний эрхийн түгээмэл тунхаглал., 3-р зүйл

⁵¹ Төрийн мэдээлэл. 1993. №1. Монгол Улсын Үндсэн хуулийн 16.13, 16.11 дэх хэсэг

⁵² С.Гантулга., Б.Энхболд. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Уб., 2018 он., 48 дах тал

⁵³ Мөн бүтээл. 48 дахь тал

⁵⁴ Төрийн мэдээлэл. 2017. №5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6.2-р зүйл

утгаар ойлгох, тайлбарлах тохиолдол гараад байна.Тиймээс албан ёсны дээд шүүхийн тайлбарыг гаргах шаардлагатай байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн **субъектив тал нь** гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдсэн хүн өөрийн үйлдлийн нийгэмд аюултай шинж чанарыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн⁵⁵ байна. Субъектив талын нэмэгдэл шинж болох гэмт хэрэг үйлдсэн сэдэлт, зорилго, гэмт хэрэг үйлдэх үеийн сэтгэл санааны байдлыг Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хуульчлаагүй тул гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй. Энэ төрлийн гэмт хэрэг ямар ч сэдэлт, зорилгоор үйлдэгдэж болох юм.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн **субъект нь** Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн байна. Хэрэв гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн субъект нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн биш танихгүй хүн хүчирхийлэл үйлдвэл гэмт хэргийн субъект үгүйсгэдэг нь тиймээс энэ төрлийн гэмт хэргийг зүйлчлэх, нотлоход гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай эсэхийг анхаарах хэрэгтэй. Харин 11.7 дугаар зүйлийн 2 дах хэсэгт таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн тохиолдолд хүндрүүлэх шинжээр хуульчилсан.

Гэр бүлийн хүчирхийлэл нь гэр бүлийн харилцаан дахь дарамт, шахалт үзүүлэх, зодох занчих, айлгах зэрэг хэлбэрээр үйлдэгдэж буй хүчирхийлэл нь хүний өөрийн үнэлэмжийг бууруулж, улмаар хүчирхийлэлд өртөгч хүчирхийллийн шалтгааныг өөрөөсөө хайн эцэст нь амьдралынх нь хэвийн үзэгдэл болтлоо дасан зохицдог байна. Тухайлбал гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нь хүчирхийлэл үйлдэгчээс хэт болгоомжлох, аргадах, уучлах, айж ичсэний улмаас тухайн нөхцөл байдлыг хууль хяналтын байгууллагад мэдээлэхгүй байх нь олонтоо байдаг. Гэр бүлийн хүчирхийлэл нь хэдэн хэдэн төрөл байх бөгөөд түүнийг судлаачид сэтгэл санааны, бие махбодийн, бэлгийн, эдийн засгийн гэсэн дөрвөн төрөлд хуваан авч үзсэн.

Сэтгэл санааны хүчирхийлэл гэдэг нь хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгих заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэсэнийг хэлнэ.

Бие махбодийн хүчирхийлэл гэдэг нь хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан, эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.⁵⁶

Эдийн засгийн хүчирхийлэл гэдэг нь хүнийг цалин хөлс,тэтгэвэр, тэтгэмж,тэдгээртэй адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах , тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан эсхүл эд хөрөнгийн хохирол учруулсаныг хэлнэ.

Бэлгийн хүчирхийлэл гэдэг нь хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг хэлдэг.

Дээрх гэр бүлийн хүчирхийллийн төрөлд өртсөн хохирогчид өөрт учирсан хохиролоо нөхөн төлүүлж чадахгүй байх тохиолдол гардаг. Тухайлбал сэтгэл санааны удаан хугацааны дарамтад байсаны улмаас сэтгэл санаанд учирсан хохиролоо нөхөн төлүүлж чадахгүй байх тохиолдол гарч байна.

⁵⁵ Төрийн мэдээлэл. 2016. №7. Эрүүгийн хуулийн 2.3-р зүйлийн 2 дах хэсэг

⁵⁶ Төрийн мэдээлэл. 2017. №5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6-р зүйл

Харин Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар бүлгийн 8.1-р зүйлд **хохирогч гэж** гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд **хөрөнгийн бус хохирол** хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хэлнэ гэж заасан байна.⁵⁷ Эд хөрөнгийн бус хохирол нь (материаллаг бус) нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан, сэтгэл санааны хүчтэй дарамтанд байлгасаны улмаас сэтгэл санааны зовиур шаналал үүсэх зэрэг эд хөрөнгийн шинжгүй мөнгөөр илэрхийлдэггүй сэтгэл санааны үр дагаврыг ойлгоно.⁵⁸

Нэр төр, алдар хүнд, сэтгэл санаа, нь эдийн засгийн эргэлтэд арилжааны зүйл болдоггүй ба эдийн бус хохиролд хамаарна. Энэ хохиролын хэмжээг хэрхэн яаж тооцож, барагдуулах талаар эрх зүйн зохицуулалт дутмаг байгаагаас гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн улмаас хохирсон иргэд өөрт учирсан хохиролоо бодитой, бүрэн дүүрэн төлүүлэх эрхээ эдэлж чадахгүй, хохирсоор байна.

Шүүхийн практикт гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэхдээ зөвхөн нотлох баримтад тулгуурлаж байгаа тул эмчилгээний зардал, оршуулгын зардал, тээврийн зардалын баримт, түүнчлэн аймаг дүүргийн засаг даргын тамгын газрын санхүүгийн хэлтэсийн үнэлгээний комиссын үнэлгээ зэргийг харгалзан хохиролыг тогтоож, нөхөн төлүүлэх шийдвэрийг гаргаж байна. Өөрөөр хэлбэл энэхүү зардалд эд хөрөнгийн хохирол хамаарах бөгөөд эдийн бус хохирол тооцогдохгүй орхигддог.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8 дугаар бүлгийн 8.2-р зүйлд хохирогч нь гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх эрхтэй гэж заасан байдаг. Гэтэл хохирогч энэхүү эрхээ эдэлж чадахгүй байгаа нь эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгаагийн илэрхийлэл юм.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн бүртгэгдсэн статистик судалгаанаас үзвэл. Монгол Улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2018 онд 210, 2019 онд 260, 2020 онд 110, 2021 онд 118 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.⁵⁹

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн холбогдогчийг 2017-2021 оны нийт насны ангилалаар авч үзвэл. Хувиараа хөдөлмөр эрхлэгч-287, малчин-150, хувийн хэвшлийн байгууллагын ажилтан-102, төрийн алба хаагч-63 гэх мэт холбогдсон бол 46.3 хувь нь бүрэн дунд, 21.0 хувь нь суурь, 18.3 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. Насны ангилалын хувьд авч үзвэл 30-34 насны 262, 35-39 насны 251, 25-29 насны 244 хүн гэр бүлийн хүчирхийлэл хамгийн их үйлдсэн байна.⁶⁰

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 117 үйлчлүүлэгчид нөхцөл байдлын үнэлгээ хийхэд эрсдэл аюултай буюу өндөр 47 буюу 40 хувь, эрсдэл дунд 49 буюу 42 хувь, эрсдлийн түвшин бага 21 буюу 18 хувийг эзэлдэг⁶¹. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 86,6 хувь нь эмэгтэйчүүд байдаг нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчийн хувьд эмэгтэйчүүд илүү өртдөг нь харагдаж байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэр бүл салалт, түүнээс улбаалан хүүхдийн өнчрөлт, хараа хяналтгүй хүүхдийн тоо олшрох зэрэг нийгэмд сөрөг үр дагавар бий болж байна.

⁵⁷ Төрийн мэдээлэл. 2017. №5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дэхь заалт

⁵⁸ Х.Доржпалам. Иргэний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. УБ., 2012. 117 дахь тал

⁵⁹ <http://police.gov.mn/resource/policegovmn/File/2019/02/02/ye2861uzdg8yvbxbh/2019.01%>

⁶⁰ Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн өнөөгийн байдал. УБ., 2018. 185 дахь тал

⁶¹ Нийслэлийн цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх хэлтэсийн, түр хамгаалах байрнаас 2018 онд хийсэн ажлын тайлан. УБ хот. 2018 он.

Үүнээс үзвэл гэр бүлийн хүчирхийлэл гарч байгаа нийтлэг шалтгаан нь архидалт, ядуурал, ажилгүйдэл, хууран мэхлэлт зэрэг шалтгаанаас үүдэлтэй. Тухайлбал архидалтын улмаас 42%, ядуурлын улмаас 30%, ажилгүйдэлийн улмаас 20%, хууран мэхлэлт, хардалтын улмаас 8% нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг гарса байна. Гэр бүлийн хүчирхийллийн учир шалтгааныг иргэд “Хүчирхийлэгч” этгээд өөрийнхөө зан, ааш авирыг хянаж чадаагүйд, оршдог гэж буруугаар ойлгодог нь элбэг. Баримтаас үзэхэд, гэр бүлийн хүчирхийлэгч этгээд нь бусдыг эрхшээлдээ оруулах хүсэлдээ автсан байдаг нь илт байдаг. Хүчирхийлэлд өртсөн хохирогч нарт сэтгэл зүйн болон эмнэлэгийн анхан шатны тусламжийг үзүүлж, иргэнийг хэвийн амьдралд нь оруулж, сэтгэл зүйн, бие бялдрын хувьд эрүүл, өөртөө итгэлтэй, дахин ажиллаж амьдрах итгэлтэй болгох шаардлагатай байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг нь Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааны хувьд гэмт хэргийн шинж болох объект, объектив тал, субъект, субъектив тал зэрэг 4 шинжийг агуулсан нийгэмд аюултай, хор уршиг учруулдаг үйлдэл юм. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн шинжийн объектив талын шинжид байнга гэдгийг тайлбарласан албан ёсны тодорхойлолт байхгүй учраас практикт хүндрэл тохиолдож байгаа нь энэхүү судалгаагаар ажиглагдсан.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч нар сэтгэл зүйн, бие махбодь, эдийн засгийн зэрэг хохиролд өртөж байна. Бие махбодийн болон эдийн засаг хохиролд өртсөн тохиолдолд эд зүйлийн үнэлгээ болон гэмтлийн зэрэг тогтоолгож өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх боломжтой бөгөөд харин сэтгэл санааны хохиролд өртсөн тохиолдолд түүнийгээ нөхөн төлүүлж чадахгүй байгаа нь харагдаж байна. Учир Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2-р зүйлд хохирогч нь гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх эрхтэй гэж заасан байдаг. Харин сэтгэл санааны хохиролд өртсөн тохиолдолд энэхүү эрхээ эдэлж чадахгүй байна.

Дүгнэлт: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүдийн насны ангилалын хувьд авч үзвэл 25-45 насны, бүрэн дунд боловсролтой хүмүүс их үйлдэж байна. Эдгээр нь ажилгүйдэл, ядуурал, архидалт зэрэг нийтлэг шалтгаанаас үүдэн бий болж байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг нь хулгайлах, дээрэмдэх, хүнийг алах, хүний эрүүл мэндэд хөнгөн, хүндэвтэр, хохирол учруулах зэрэг гэмт хэргийн дараагаар орж байгаа бөгөөд эдгээр ихээр үйлдэгдэж буй гэмт хэргийг бууруулах чиглэлээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн төсөвөө илүү анхааруулж ажиллах шаардлагатай байна.

Монгол Улсад гэр бүлийн хүчирхийллийн талаар олон нийт мэдээд удаагүй байгаа тул мэдлэг боловсрол мэдээлэл хомс байгаа хүмүүс өөрсдийгөө хүчирхийлэлд өртөж байгаагаа ч мэдэхгүй тохиолдол үүсч байна. Эдийн засгийн болон сэтгэл зүйн хувьд хүчирхийлэлд өртсөн хохирогч нар манай улсад их байгаа тэр тусмаа мэдээлэл бага хүрдэг зарим хөдөө орон нутгийн иргэд хүчирхийлэлд өртдөгч хандах газар байдаггүй байна. Иймээс хөдөө орон нутгийг ханд хүчирхийллийн эсрэг мэдээ мэдээлэл өгч ард иргэдийг үргэлж мэдээллээр хангаж ажилласанаар хүчирхийлэгч нар багасах мөн энэ төрлийн мэдээлэл авсан хохирогч өөрийгөө эндээс олж харан тусламж авч хүчирхийллээс ангид байж болох юм.

Санал:

1. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7-р зүйлийн тайлбар хэсэгт Байнга гэдгийг шинээр тайлбарлаж оруулах. Учир нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан гэдгийг яг хэдэн удаа үйлдсэн бол байнга үйлдсэнд тооцож байгааг тайлбарласан хуулийн

зохицуулалт байхгүй байна. Практикт өмнөх Эрүүгийн тусгай ангийн 100-р зүйлд заасан Тарчлаах гэмт хэргийн тайлбарт зааснаар “3 буюу түүнээс дээш удаа үйлдсэн тохиолдолд” байнга гэдгийг тайлбарласан байна. Тиймээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7-р зүйлийн тайлбар хэсэгт **Байнга гэж** 3 буюу түүнээс дээш удаа үйлдсэнийг ойлгоно гэж

2. Гэр бүлийн хүчирхийлэл өртсөн хохирогчдын Олон улсын өвчний Х ангилалыг баримтлан гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан сэтгэл зүйн /эдийн бус/ хохирлын хэмжээг тогтоох аргачлалыг бий болгох талаар “Шүүхийн Шинжилгээний тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэхь хэсэгт “Шинжилгээ хийх журмыг шинжилгээний төрлөөс хамааран хууль зүйн, эрүүл мэндийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэснийг үндэслэн хохирогчийн эдийн бус /сэтгэл зүйн/ хохирлыг тогтоох талаар аргачлалыг боловсруулах. Эдийн бус хохирлыг тогтоох аргачлалд дараах зүйлсийг тусгах. Үүнд:

- Гэм хор учруулагчийн гэм буруугийн хэмжээ,
- Хохирол учирсан этгээдийн хувийн онцлогтой холбоотой бие махбодийн болоод сэтгэл санааны зовлон, зовиур, шаналалын /гэм хорын/ хэмжээ,
- Бодит нөхцөл байдал болон хохирогчийн хувийн онцлогийг тусгасан бие махбодийн болоод сэтгэл санааны зовлон, зовиур, шаналалын /гэм хорын/ шинж чанар, шударга ёсны шаардлага зэргийг тусгах.

3. Гэмт хэргийг индекс болон индекс бус гэмт хэрэг гэж 2 ангилан бүртгэж, улмаар гэмт хэрэгтэй тэмцэх стратеги, төсөвөө тодорхойлох. Индекс гэмт хэрэгт нь түгээмэл үйлдэгддэг хүнийг алах, бие махбодид хохирол учруулах, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, хулгайлах, дээрэмдэх, хүчиндэх, эд хөрөнгө устгах гэх мэт гэмт хэргүүдийг хамааруулах.

Харин индекс бус гэмт хэрэг гэдэгт түгээмэл биш боловч нийгмийн хор аюул ихтэй бусад төрлийн гэмт хэрэг хэргүүд тухайлбал хүн амын эрүүл мэнд, байгаль орны эсрэг гэмт хэргүүд гэх мэт 2 хувааж гэмт хэрэгтэй тэмцэх стратеги ээ зөв тодорхойлж чадах болно. Энэхүү аргачлалыг хэрэгжүүлснээр түгээмэл үйлдэгддэг гэмт хэргийн гаралтыг бууруулах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж чадна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол Улсын хууль

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
3. Эрүүгийн хууль
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

Ном бүтээл:

5. С.Гантулга., Б.Энхболд. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. УБ. 2018 он
6. Хүний эрхийн түгээмэл тунхаглал
7. Монгол Улсын Үндсэн хууль. УБ. 1992 он
8. П.Цэцгээ. Гэр бүл, ахуйн хүрээн дэхь хүчирхийлэл, түүний эрх зүйн зохицуулалт. УБ хот. 2015 он
9. Г.Бямбадорж. Гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудал. УБ хот. 2014 он
10. Х.Доржпалам. Иргэний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал. УБ. 2012 он

Тайлан мэдээ, судалгаа:

11. Цагдаагийн Ерөнхий Газрын МТ-ийн төв. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэргийн улмаас хохирсон иргэний судалгаа. УБ хот. 2015 он
12. Нийслэлийн цагдаагийн газрын урьдчилан сэргийлэх хэлтэсийн, түр хамгаалах байрнаас 2018 онд хийсэн ажлын тайлан. УБ хот. 2018 он.
13. Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн өнөөгийн байдал. УБ хот. 2018 он

Цахим эх сурвалж:

14. <http://police.gov.mn>
15. <http://www.president.mn>
16. <http://www.mn-nhrc.org>
17. <http://www.ikon.mn>

**МОНГОЛ УЛСЫН МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫГ
ХУУЛЬ БУСААР АШИГЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ,
ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ
THE CURRENT CRIME SITUATION OF ILLEGAL USE OF NARCOTIC DRUGS AND
PSYCHOTROPIC SUBSTANCES IN MONGOLIA PREVENTS IT**

Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн ахлах багш,
цагдаагийн хурандаа
А.Баасанцэрэн
Police school of Police Law
Senior Lecturer,
Colonel of police
A. Baasantseren
baaskaa0522@gmail.com

Хураангуй: Монгол улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар эргэлтэд хяналт тавих, үйлдэгдэж байгаа гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, түүнээс урьдчилан сэргийлэх арга замыг судлаж үзэх болно.

Abstract: We will examine the current situation and Prevention of drug and Psychotropic trafficking in Mongolia.

Түлхүүр үг: мансууруулах эм бэлдмэл, хар тамхи, сэтгэцэд нөлөөлөх бодис, мансуурал бодис, түүхий эд, урьдчилан сэргийлэх.

Keyword: Drugs, Psych otropic Substances, narcotic substances, raw materials, prevention

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хууль бусаар ашиглах гэмт хэргийн түүхэн уламжлал.

Судлаачдын үзэж байгаагаар хүн төрөлхтөн мансууруулах бодисыг эртнээс таньж, хамгийн анх намуу цэцгийг Месопатамчууд манай тооллын өмнөх 340 жилийн тэртээ хэрэглэж байсан нь эртний булш, бунханаас олдсон эд өлгийн зүйл, хадны сүг зураг зэргээс ажиглагддаг тухай тэмдэглэсэн байна. 1839-1842, 1858 онд Манж Чин улс, Англи улстай хийсэн “хар тамхины I, II дайн”-д ялагдсанаар дайны төлбөрт нийт 25 сая доллар төлөх болжээ. Иймд торго, цай зэрэг дотоодын бүтээгдэхүүнээ гадаадад гаргаж оронд нь хар тамхи оруулж, хэрэглэх явдлыг өөрийн эзэмшлийн орнуудад чөлөөтэй болгожээ. Тухайн үед зөвхөн Хятадад хар тамхийг 1 сая хүн хэрэглэдэг байсан бол XX зууны эхэн үе гэхэд хэрэглэгчийн тоо даруй 100 саяд хүрсэн байна.

Энэ байдал нь Манжийн колони байсан Монгол оронд шууд нөлөөлж Манжийн төрийн бодлогын оролцоотойгоор эхэлсэн ба Монголд цагаачлан ирсэн хятад иргэд Манжийн хятадчилагдсан төрөөс явуулсан Шинэ засгийн бодлогоор хятад иргэдийг Ар монголд суурьшуулах шийдвэр гаргаж байсан нь байдлыг улам дэвэргэж, ядуу буурай монголын нийгэмд бодитой аюул занал учруулж эхэлсэн байна

Монгол Улсын Засгийн газраас 2017 онд 4 жилийн хугацаатай хэрэгжүүлэх “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлж байгаа ба мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгаас урьдчилан сэргийлэх, хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, иргэдийг соён гэгээрүүлэх гол зорилгыг агуулсан байна.

Өнөөгийн Монгол улсад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, энэ төрлийн бодисын хор хөнөөлөөс хүн амын эрүүл мэнд, удмын санг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь тулгамдсан асуудал болоод байна. Сүүлийн жилүүдэд энэ төрлийн гэмт хэрэг зөрчил байнгын өсөлттэй байгаа нь нийгмийн сэтгэл зүйг нөлөөлж тулгамдсан асуудал бол 2022 оны байдлаар 238 хүн холбогдсон 14-35 насны 195 хүн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж гэмт хэрэгт холбогдсон байна. Ийм хүүхэд залуучуудыг энэ төрлийн гэмт хэрэг, зөрчөөс урьдчилан сэргийлэх ажил нэн тэргүүнд тавигдаж байна.

“Хар тамхи гэдэг нь хүний уураг тархи мэдрэлийн системд нөлөөлөх ургамалын болон химийн гаралтай мансууруулах бодис юм”⁶²

Монгол улсын Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд томьёолсоноор “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэж донтуулах болон сэтгэцэд бусад хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, “Мансууруулах эмийн тухай” 1961 оны НҮБ-ын Конвенци, “Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай” 1971 оны НҮБ-ын Конвенцийн жагсаалтад заасан, хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад хяналтад байлгавал зохих эм, байгалийн болон нийлэгжүүлсэн бэлдмэлийг;

“мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлт” гэж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг бэлтгэх, хуваарилах, худалдах, хэрэглэх, тээвэрлэх, хадгалах, устгах, Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, тус улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрүүлэх талаар энэ хууль, бусад хууль тогтоомжоор тогтоосон үйл ажиллагааг;

“мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис үйлдвэрлэх” гэж байгальд ургадаг мансууруулах үйлчилгээ бүхий ургамлыг түүж цуглуулах, тарьж ургуулах, хураан авах, цэвэршүүлэх, дахин боловсруулж хувирган өөрчлөх, бэлэн бүтээгдэхүүн, түүхий эдийн хэлбэрээр гаргаж авахыг;

“мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын түүхий эд” гэж хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан, тус улсад хяналтад байлгавал зохих мансууруулах үйлчилгээ бүхий ургамал болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг үйлдвэрлэх, дахин боловсруулахад хэрэглэгддэг бодисыг;⁶³

Монгол улсад сүүлийн 5 жил энэ төрлийн 1263 гэмт хэрэг бүртгэгдсэнээс цагдаагийн байгууллагын хэмжээнд 2022 онд 229 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 42 буюу 22.5 хувиар, нийслэлийн хэмжээнд 204 бүртгэгдсэн нь 59 буюу 40.7 хувиар тус тус өсч, орон нутгийн хэмжээнд 25 бүртгэгдсэн нь 17 буюу 40.5 хувиар өссөн байна⁶⁴

⁶² Prezi.com.

⁶³ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 3-р зүйл 2002 он

⁶⁴ “Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал” ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба 2023 он 199, 200 тал.

	Хэргийн тоо		Өсөлт Бууралт	Нийт хэргийн эзлэх хувь	
	2021 он	2022 он		2021 он	2022 он
Улсын хэмжээнд	187	229	22.5	0.7	0.6
Нийслэлд	145	204	40.7	0.9	0.8
Орон нутагт	42	25	-40.5	0.5	0.2

Гэмт хэрэг үйлдэгдсэн газар. Гэмт хэрэг бүртгэгдсэн газрыг авч үзвэл бүртгэгдсэн гэмт хэргийн 97 буюу 42.4 хувь нь гэр, орон сууцанд, 76 буюу 33.2 хувь нь гудамж талбайд, 24 буюу 10.5 хувь нь олон нийтийн газарт, 2 буюу 0.9 хувь нь нийтийн тээвэрт, 1 буюу 0.4 хувь нь төрийн байгууллагад, 1 буюу 0.4 хувь нь төрийн бус байгууллагад, 4 буюу 1.7 хувь нь аж ахуйн нэгжид, 4 буюу 1.7 хувь нь автозамд, 20 буюу 8.7 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Гэмт хэрэгт холбогдсон хүн. Нийт 238 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28 буюу 13.3 хувиар өссөн. Холбогдогчдын 25 буюу 10.5 хувь нь эмэгтэй, 213 буюу 89.5 хувь нь эрэгтэй, 6 буюу 2.5 хувь нь 14-17 насны хүүхэд байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй хүн 9.8 хувиар, эмэгтэй хүн 92.3 хувиар тус тус өсч, хүүхэд 14.3 хувиар буурсан байна.

№	Гэмт хэрэгт холбогдсон хүн	Эрэгтэй		Эмэгтэй		Хүүхэд	
	238	213	89.5%	25	10.5%	6	9.8%

Гэмт хэрэгт холбогдогчдын нас, хүйс, нийгмийн байдал. Ажилгүй 121, Хувиараа хөдөлмөр эрхлэгч 61, Хувийн хэвшилд ажилдаг 27, Оюутан 23, Сурагч 5 бусад 1,

Сүүлийн жилүүдэд хар тамхины асуудал манай улсад улам их газар авах боллоо. Тухайлбал 100 мянган хүн ам тутмын 2700 нь мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм бодис хэрэглэдэг. Харин хэрэглэх санал ирсэн 21800 хүн байна гэсэн судалгааны тоо мэдээ байгаа юм. Гэтэл олон улсад хар тамхи хэрэглэгч нэг хүний цаана дөрвөн хүн байдаг гэж үзвэл манай улсад ойролцоо-гоор 40-70 мянган хэрэглэгч байж болзошгүй гэх судалгаа ч байдаг. Гэтэл энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож байгаа хүмүүсийн дийлэнх нь 14-35 насныхан байдаг нь хамгийн харамсалтай юм.

Ийнхүү хар тамхины асуудал аюулын харанга дэлдээд эхэлчихсэн байхад урьдчилан сэргийлэх ажил бараг хийгдэхгүй байгаад байгаа нь хачин. Учир нь 2012-2022 онд нийтдээ 1518 гэмт хэрэгт 551 хүн хар тамхины хэргээр шалгагдсан. Тухайлбал, 2022 онд энэ төрлийн 229 гэмт хэрэгт 238 хүн холбогдон шалгагдсан. Эдгээрийн хүмүүсийн 80 хувийг 14-35 насны залуус эзэлсэн байна.

Хамгийн гол нь хар тамхи мансууруулах бодистой холбоотой хэрэгт ихэвчлэн томчуудын хүүхдүүд, нэр нөлөө бүхий эрхмүүдийн залгамж халаа болсон залуус холбогдож байгааг албаныхан хэлж буй. Тухайлбал, 2022 онд гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдийн 121 буюу 50 хувийг ажилгүй залуус эзэлсэн байгаа юм.

Уг нь Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлдөг бодисын эргэлт, түүнд тавих хяналт хуулийн 14.5-д “урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын зохисгүй хэрэглээг бууруулах, эргэлтэд хяналт тавих, эрх зүйн орчныг бүрдүүлэх, олон улсын харилцааг хөгжүүлэх чиг үүрэгтэй Үндэсний хороо ажиллах бөгөөд уул Үндэсний хороо орон тооны ажлын албатай байна” гэж заасан байдаг.

Гэтэл энэхүү Үндэсний хороо нь одоог болтол байгуулагдаагүй л байгаа. Үндэсний хороо байгуулагдах гэж “дунших” зуур бурхангүй газрын бумба галзуурна гэгчээр томчуудын хүүхдүүд дураараа дургисаар байгаа нь харамсалтай. Тэд нэр, нөлөө бүхий эцэг,

эхийнхээ албан тушаалд эрдэж, хуулиас дээгүүр авирлаж байгааг хэн таслан, зогсоох үүрэгтэй вэ. Үүний тулд Үндэсний хороог нэн даруй байгуулж, хар тамхины хэргийг “хүрээлэлд” нь дарж авахгүй бол хожмын хор хөнөөл нь хэний ч санаанд оромгүй байдлаар илэрнэ. Тиймээс харанга дэлдэж байгаа хар тамхины хор хөнөөлийн асуудалд холбогдох албаныхан анхаарлаа хандуулах цаг нь болжээ.

Судалгаанаас харахад гол төлөв 18-35 насны залуучууд хар тамхи, мансууруулах бодис хэрэглэж, донтогч болж байгаа тоо баримт байдаг. Учир нь өсвөр насны хүүхэд, залуучуудын сэтгэл зүйн онцлогоос шалтгаалан бусадтай нийлэх, бусдад уруу татагдах, сониуч зандаа хөтлөгдөх болон хар тамхины хор уршгийн талаар мэдээлэл дутмаг байдлаасаа болж хэрэглэж эхэлдэг⁶⁵.

Хүний их тархи ойролцоогоор 25-27 насанд бүрэн гүйцэд хөгжиж дуусдаг. Иймээс хүүхэд, залуучууд аливаа асуудалд шийдвэр гаргахдаа эрсдлийг бүрэн гүйцэд ухамсарладаггүй, хөнгөн хийсвэрээр ханддаг байдлаас болж хорт муу зуршилд уруу татагдах нь элбэг байдаг. Өсвөр насны хүүхэд, залуучууд сурч боловсрох болон ажиллаж хөдөлмөрлөх насандаа хар тамхи, мансууруулах бодис хэрэглэж, цаашлаад донтогч болж байгаа нь үнэхээр харамсалтай.

Хар тамхи, мансууруулах бодис хэрэглэснээр хүний бие, эрүүл мэнд, сэтгэл зүйд ямар өөрчлөлт: Хүний биеийн эд эс, эрхтэн тогтолцоо дахиж сэргээгдэхгүйгээр гэмтдэг. Хар тамхи хэрэглэгч нь уушгины хорт хавдар, БЗХӨ, элэгний өвчлөл, арьсны өвчлөл гэх мэт өвчин тусах тохиолдол их байдаг. Мөн тархины эд эсийг гэмтээн анхаарал төвлөрөлт болон ой тогтоолт муудаж мартамхай болж эхэлдэг.

Эрүүл мэндийн болон цагдаагийн байгууллагаас хар тамхинаас донтогч хэрэглэгчийг гаргахын тулд хичээл зүтгэл гарган ажилладаг боловч нэгэнт бие болон сэтгэцийн хувьд аль хэдийн хамааралтай болсон хүн өөрийгөө удирдах чадвараа алдаж, бусдаас ирэх тусламжийг үл ойшоож, өөртөө болон нийгэмд аюултай үйлдэл хийдэг.

Хар тамхи нь тухайн хэрэглэгч, донтогчийн гэр бүл, ойр дотны хүмүүст хэрхэн нөлөөлөл: Хар тамхи, мансууруулах бодис хэрэглэснээр тухайн хэрэглэгч гэлтгүй, эргэн тойрны гэр бүлийн гишүүд, найз нөхөд бүгд сэтгэл санааны байнгын айдас, түгшүүрт байдалд байдаг. Тухайн хэрэглэгчийн зан авир эрс өөрчлөгдсөнөөр өөрт болон бусдад бие махбодийн болон сэтгэл санааны бодит аюул учруулж эхэлдэг.

Мөн тухайн гэр бүлийн эдийн засаг, санхүүгийн байдал ч хүндэрч эхэлдэг. Ингэснээр найз нөхөд, гэр бүлийн гишүүд тухайн хэрэглэгчээс зайгаа барихаас өөр аргагүй байдалд ордог.

Харин тухайн хэрэглэгч хэнд хандах, хэрхэн даван туулах учраа олохгүй, өөрт итгэх итгэл найдвараа алдан, улам ихээр донтож, эцэст нь амь насаа алддаг. Хар тамхи хэрэглэсэн үед хий юм харах, сонсох, үйлдлээ хянах чадваргүй болох зэрэг шинж тэмдэг илэрдэг. Тухайн бодисоо хэрэглэсэн үедээ өөр төрлийн гэмт хэрэг үйлдэх тохиолдол маш их гардаг.

Жишээ нь мансууруулах бодис олж авахын тулд бусдын эд зүйлийг хулгайлах гэмт хэрэг үйлдэх болон биеэ үнэлэх, халдварт өвчин авах эрсдэл бий болж байдаг.

Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь:

⁶⁵ “Хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, хор уршиг, хэрхэн урьдчилан сэргийлэх нь” клиникийн сэтгэл судлаач Х.Сайнсанаатай ярилцлага 2018 он

Олон улсын жишгээс харахад хар тамхи мансууруулах бодисын хэрэглээнээс урьдчилан сэргийлэх ажил их чухал байдаг. Хар тамхи болон түүний хор уршгийн талаар насны ангиллаар нь зорилтот бүлэгт чиглэсэн зөв мэдээлэл өгөх нь илүү үр дүнтэй юм. Өсвөр үеийн хүүхэд, залуучуудад насны онцлогт тохируулан боловсролын байгууллагаас хор уршгийн талаарх мэдээлэл болон өөрийгөө хэрхэн хамгаалах тухай бодит практик дээр суурилсан сургалтын стандарт, арга зүйтэй болох зайлшгүй шаардлагатай.

Мөн эцэг эхчүүдэд зориулсан хар тамхи хэрэглэсэн үеийн шинж тэмдэг болон хэрхэн хүүхэдтэйгээ нээлттэй ярилцах тухай мэргэжлийн байгууллагаас зөвлөмж мэдээллийг тасралтгүй олгох ёстой. Мэргэжлийн байгууллагууд олон улсын хар тамхитай тэмцэх байгууллагуудтай хамтран Монгол хүний сэтгэл зүйн онцлог дээр суурилсан урьдчилан сэргийлэх хөтөлбөртэй болох нь чухал юм.

Жишээлбэл, Японд хар тамхины тухай мэдээллийг олон нийтэд хязгаарлагдмал байдалтай тараадаг бол Канадад бага ангиас нь эхлэн хичээлийн хөтөлбөрт нь тусгасан байдаг. Аливаа улс орны хүн амын онцлогийг сайн судалж, тохирсон арга хэмжээ авах хэрэгтэй. Манай улсын хувьд энэ төрлийн донтолтыг эмчлэх нарийн мэргэжилтэн болон эмнэлгийн хангамж дутмаг байгаа учир урьдчилан сэргийлэх ажлыг хангалттай гүйцэтгэж чадвал маш олон залуучууд энэ аймшигт хорт зуршил руу орохоос сэргийлж чадна.

Нэгэнт хар тамхинд донтсон тохиолдолд эмчилгээнд давтан хамрагдсан ч дахин хар тамхийг хэрэглэх тохиолдол их байдаг учир анхнаасаа л өөрийгөө болон бусдыг хамгаалж сурах нь чухал юм.

Хэрэв та болон таны танил хар тамхины хэрэглээтэй болсон бол нууж хэрхэвч болохгүй бөгөөд мэргэжлийн байгууллага, сэтгэл зүйчид эртхэн хандахыг зөвлөж байна. Хар тамхи сэтгэцэд нөлөөт бодис нь найрлага, бодисын агууламж, гаргаж авсан аргаасаа хамаараад хүний бие, сэтгэцэд нөлөөлөх богино хугацааны болон урт хугацааны хор уршиг нь өөр өөр байдаг.

Энэ бол Улс үндэстэн дамжиж үйлдэгддэг гэмт хэрэг. Бусад төрлийн гэмт хэргийг бодвол нууц далд аргаар үйлдэгддэг. Хохирогчгүй гэмт хэрэг гэж үздэг. Хэргийн 55 хувьд нь Монголд ургаж байгаа өвс ургамал хэрэглэсэн, татсан, тээвэрлэсэн байдал гарч байна.

Монгол Улсын 21 аймгийн тодорхой бүс нутагт мансууруулах үйлчилгээтэй каннабис өвс ургамал ургадаг. Түүнийг түүж бэлтгэх, зарж борлуулах, хэрэглэх, тээвэрлэхтэй холбоотой гэмт хэрэг ихэвчлэн гардаг. Үлдсэн 45 хувийг манай улсад үйлдвэрлэдэггүй химийн аргаар гаргаж авдаг бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх тээвэрлэх гэмт хэрэг бүрдүүлж байна.

Ялангуяа, Зүүн өмнөд чиглэлийн азийн орнуудаас манай улсад орж ирдэг. Тухайн бодисыг улсын хилээр орж ирэхээс өмнө хил гаалийн байгууллага илрүүлэх ёстой. Сүүлийн жилүүдэд хил гаалийн байгууллага энэ төрлийн гэмт хэрэг илрүүлэх нь нэмэгдэж байна. Нэн ялангуяа, шуудан илгээмжээр орж ирж байгаа мансууруулах бодисыг хамтын ажиллагааны хүчинд илрүүлэх нь ихэссэн.

ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газраас мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээг хумих, урьдчилан сэргийлэх зорилгоор “Хасах-25” аян өрнүүлж буй юм. Энэ хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдаас мансууруулах бодисын талаарх ойлголт, хэрэглээний тархалт тодруулах судалгаа авах юм байна.

Судалгаанд 10000 орчим сурагч хамруулахаар төлөвлөжээ. Мөн НҮБ-аас гаргасан стандартын дагуу 211 сургуулийн 1079 бүлгийн 29 мянган сурагчид “Мансууруулах

бодисын хор хөнөөл” сэдвээр сургалт явуулах ажээ. Нийт 91 мянга гаруй сурагчийн ар гэрийнхэн, асран хамгаалагч нарт энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах юм байна. Мөн аяны хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн багш, нийгмийн ажилтнуудад ч энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээлэл олгох ажээ.

Манай улсад хар тамхи хэрэглэсэн нь тогтоогдсон хүмүүсийн 88 хувь нь 35 насныхан бөгөөд түүний 5.7 хувь нь сурагч байна. Эцэг, эхчүүд хүүхдээ хар тамхи хэрэглэдгийг цагдаагийнхнаас сонсоод ихэд цочирддог ажээ. Тиймээс Хар тамхитай тэмцэх газрынхан мэргэшсэн сэтгэлзүйчтэй болж, эцэг эх болон сурагчдад ганцаарчилсан зөвлөгөө өгч байна.

ДҮГНЭЛТ:

1. Монгол Улсад 2012-2022 онд нийтдээ 1518 гэмт хэрэгт 551 хүн хар тамхины хэргээр шалгагдсан. Тухайлбал, 2022 онд энэ төрлийн 229 гэмт хэрэгт 238 хүн холбогдон шалгагдсан. Эдгээрийн хүмүүсийн 80 хувийг 14-35 насны залуус эзэлсэн байгаа нь сүүлийн жилүүдэд тогтмол өсөлттэй байгаа тул энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

2. Энэ төрлийн гэмт хэрэгтэй дан ганц цагдаагийн байгууллага тэмцээд үр дүн багатай байгаа тул бусад /Гааль, эмнэлэг, боловсрол, бусад төрийн болон төрийн бус байгууллагууд/-тай хамтран хөтөлбөр төлөвлөгөө гаргаж улс үндэстний авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3. Монгол улсын засгийн газраас 2000 онд батлагдсан “Хар тамхи, мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулж цаг үетэй нийцүүлэн батлан гаргаж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах, олон улсын жишгээр ажил арга хэмжээ зохион байгуулах

5. Монгол Улсын эрүүгийн хуулийн 20.7, 20.8, 20.9, 20.10, Зөрчлийн хуулийн 5.1 зүйлийн 3 дахь заалт тогтоомжид энэ төрлийн гэмт хэрэгт холбогдогчдын ял, шийтгэлийн бодлогоор чангатгаж өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль 2002 он
2. Монгол Улсын эрүүгийн хууль 2017 он
3. Монгол Улсын зөрчлийн тухай хууль 2017 он
4. “Хар тамхи, мансууралтай тэмцэх үндэсний хөтөлбөр” Засгийн газрын 2000 оны 34 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт
5. “Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал” ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба 2023 он 199, 200 тал.
6. Хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, хор уршиг, хэрхэн урьдчилан сэргийлэх нь” клиникийн сэтгэл судлаач Х.Сайнсанаатай ярилцлага 2018 он
7. Prezi.com.

**ГАЛТ ЗЭВСГИЙН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТИЙН
ТУХАЙ ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ, ХЭЛБЭР
ILLEGAL CIRCULATION OF FIREARMS
CONCEPTS, TYPES AND FORMS OF**

*Ц.Очгэрэл
ДХИС-ийн докторант
Ts. Ochgerel,
a doctoral student of the university
of internal affairs*

Хураангуй. Галт зэвсгийн хууль бус эргэлтийн ойлголтыг нээн гаргахын тулд эхлээд тухайн зэвсгийн хууль ёсны эргэлтийн тухай ойлголтыг тодорхой болгох нь зүйтэй юм. Галт зэвсгийн эргэлт, түүнчлэн түүний хууль бус эргэлт, тэдгээрийн ойлголтыг тодорхойлсон хэм хэмжээнүүд гадаадын олон орны хууль тогтоомжид тусгалаа олсон байдаг бол Монгол Улсын хууль тогтоомжид энэ тухай заалт алга байна.

Энэхүү өгүүлэлд галт зэвсгийн хууль бус эргэлтийн тухай ойлголт, түүний төрөл, хэлбэрийн талаар судлаачийн хувьд өөрийн үзэл бодлоо товч өгүүлсэн болно.

Abstract:. In order to clarify the concept of illegal circulation of firearms, it is necessary to first clarify the concept of legal circulation of the firearm. The circulation of firearms, as well as its illegal circulation and the norms defining their concept are reflected in the laws of many foreign countries, but there is no provision for this in the laws of Mongolia.

In this article, the concept of illegal circulation of firearms, its types and forms is briefly described as a researcher's opinion.

Түлхүүр үг. Галт зэвсэг, хууль бус эргэлт, эрх зүйн зохицуулалт
Key word. Firearms, Illegal Traffic, Legal Regulation

Үндсэн хэсэг. Монгол Улсын Галт зэвсгийн тухай хуулийн 1.1.-д «Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг хангах, галт зэвсэг, сумны эргэлтэд хяналт тавьж, аюулгүй ажиллагааг мөрдүүлэхэд оршино»⁶⁶ гэснээс үзэхэд энэ хуулийн нэг зорилт нь галт зэвсгийн эргэлтэд хяналт тавих явдал болох нь харагдаж байна.

Хууль тогтоогч «галт зэвсэг, сумны эргэлт» хэмээх ухагдахууныг хуулинд ийнхүү хэрэглэсэн атлаа түүний хуульчилсан тодорхойлолтыг өгөөгүй байх тул бид энэ ойлголтыг

⁶⁶ Монгол Улсын Галт зэвсгийн тухай хууль (Шинэчилсэн найруулга) (2015). //Төрийн мэдээлэл, 2015. №31.

нээн гаргах, ямар ямар эрх зүйн харилцаа уг ойлголтыг бүрдүүлж байгаа болох, түүний мөн чанар юу болохыг тодорхойлох оролдлогыг энэ судалгааны хүрээнд хийсэн болно.

Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар тольд «эргэлт» гэдэг нь «орчих, тойрох, урвах, хөлбөрөх, буцах, өөрчлөхийг илэрхийлэх агаад хүрдний эргэлт, үсний эргэлт, усны эргэлт, цагийн эргэлт» гэж тайлбарласан байна. Үүнээс аливаа зүйл, юмс, үйл явц эргэлдэх хөдөлгөөнд байж, тойрон, үргэлжлэн, өөрчлөгдөн байдаг үйлдэл, үйл ажиллагаа гэж ойлгож болохоор байна.

Үг зүйн дээрх утгаас ургуулан бодож үзвэл «галт зэвсгийн эргэлт» гэдэг нь галт зэвсэгтэй холбоо бүхий тодорхой үйлдэл, үйл ажиллагааны илрэлүүд, тэдгээрийн ээлжлэн өрнөх үйл явц, хөдөлгөөн, өөрөөр хэлбэл, галт зэвсэгтэй хамааралтай үүсэж буй эрх зүйн харилцаанууд, тэдгээрийн хувьсан өөрчлөгдөх хэлбэр байж болох нь харагдаж байна.

Монгол Улсын Галт зэвсгийн тухай хууль тогтоомжид галт зэвсэгтэй холбоотой эрх зүйн хэд хэдэн харилцаа тусгалаа олсон байх бөгөөд эдгээр нь дараах хэлбэрүүдтэй байна:

Галт зэвсгийн тухай хуулийн Гуравдугаар бүлэгт Галт зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглах, бүртгүүлэх, хадгалах, хязгаарлах эрх зүйн харилцааг зохицуулсан байна.

Галт зэвсгийн тухай хуулийн дээр дурдсан зөвшөөрөгдсөн хэм хэмжээнүүдийг зөрчсөн тохиолдолд энэ нь хууль бус эргэлтийн (гэмт) шинжтэй үйлдэл болж хувирна. Уг хуулийн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, түүнээс үүдсэн үр дагавар зэргийг харгалзан зарим тохиолдолд сахилгын болон зөрчлийн шийтгэл оногдуулах, түүнчлэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байна.

Галт зэвсгийн тухай хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ (25.1), уг хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль⁶⁷, эсхүл Зөрчлийн тухай хуульд⁶⁸ заасан хариуцлага хүлээлгэхээр (25.2) зохицуулжээ.

Галт зэвсгийн тухай хуульд галт зэвсэг, сум хэрэглэлийг үйлдвэрлэх харилцааг зохицуулсан заалт алга байгаа нь Монгол Улс галт зэвсгийг зөвхөн импортолж ирсэнтэй холбоотой байх магадлалтай боловч Зөвшөөрлийн тухай хуульд сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгохоор заасан байна.

Гэтэл зарим орны зэвсгийн тухай хууль тогтоомжид, тухайлбал, «Зэвсгийн тухай»⁶⁹ Холбооны хуулинд (ОХУ) зэвсэг үйлдвэрлэх харилцааг тусгайлан зохицуулжээ. Уг хуулиар зэвсэг үйлдвэрлэх гэж зэвсэг, хэрэгсэл, сум, тэдгээрийн бүрдэл хэсгийг судлах, зохион бүтээх, турших, бэлтгэх, түүнчлэн уран сайхны аргаар чимэглэх, засварлах үйлдлийг ойлгодог байна. Дээрх хуульд зэвсгийг цуглуулах, дэлгэн үзүүлэх харилцааг мөн зохицуулжээ.

Монгол Улсын Галт зэвсгийн тухай хуулийн дээр дурдсан хэм хэмжээнүүдээс галт зэвсгийн хориглоогүй, зөвшөөрөгдсөн, өөрөөр хэлбэл, хууль ёсны эргэлтийг дараах байдлаар тодорхойлж болохоор байна: Галт зэвсгийн (хууль ёсны) эргэлт гэдэг нь төрөл бүрийн зориулалт, хэлбэр, загварын галт зэвсэг, сум хэрэгслийг хууль тогтоомжид заасан дүрэм, журам, хязгаарлалтын дагуу хил нэвтрүүлэхээс эхлэн тэдгээрийг худалдах, өмчлөх, эзэмших, ашиглах, бүртгүүлэх, хадгалах, биедээ авч явах, тээвэрлэх, өвлүүлэх, бэлэглэх, тоолох, хураан авах, устгах хүртлэх үйлдлүүд, тэдгээртэй холбоотой хөдөлгөөн гэж ойлгож болохоор байна. Нөгөө талаас, галт зэвсгийн хууль ёсны эргэлтийг галт зэвсэгтэй

⁶⁷ Монгол Улсын Эрүүгийн хууль (Шинэчилсэн найруулга) (2015). //Төрийн мэдээлэл, 2016. №7.

⁶⁸ Монгол Улсын Зөрчлийн тухай хууль (Шинэчилсэн найруулга) (2017). //Төрийн мэдээлэл, 2017. №24.

⁶⁹ Федеральный закон РФ «Об оружии» от 13.12.1996. №150-ФЗ.

хамааралтай үүсэж буй эрх зүйн зөвшөөрөгдсөн, хориглоогүй олон талт харилцаануудын илрэх хэлбэр гэж үзэж болохоор байдаг.

Галт зэвсгийн хууль ёсны харилцааг Монгол Улсын хууль тогтоомжоор цагдаагийн байгууллага хяналтандаа байлгах аар хуульчилсан байна.

Галт зэвсгийн хууль бус эргэлтийг нэг талаас гэмт (криминал) үйл ажиллагааны нэг төрөл гэж үзэж болох тул энэ нь криминологийн шинжлэх ухааны ойлголт, нөгөө талаас эрх зүйн ойлголт мөн байдаг. Учир нь эрүүгийн хууль тогтоомжид тусгалаа олсон галт зэвсэгтэй холбоотой гэмт хэргүүд нь эрүүгийн эрх зүйн, галт зэвсгийн болон зөрчлийн тухай хууль тогтоомжид тусгалаа олсон зөвшөөрөгдсөн хэм хэмжээнүүд зөрчигдсөн тохиолдолд гол төлөв захиргааны эрх зүйн ойлголтын хүрээнд шийдвэрлэгдэнэ.

Галт зэвсгийн хууль бус эргэлтийг эрх зүйн үүднээс авч үзвэл дээр дурдсаны дагуу хоёр төрлийн эргэлт байж болохоор байна.

Нэгдүгээрт, Захиргааны хэм хэмжээний акт зөрчсөн үйлдлүүд, тухайлбал, Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн «Хууль бусаар зэвсэг эзэмших» (5.6) зүйлд заасан «хууль бусаар тусгай хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, агсамжийг биедээ авч явсан», «иргэний, эсхүл харуул хамгаалалтын зориулалттайгаас өөр төрлийн галт зэвсэг өмчилсөн, эсхүл эзэмшсэн», «хуульд зааснаас өөр зориулалтаар галт зэвсэг өмчилсөн», «хуульд заасны дагуу сургалтад сууж гэрчилгээ аваагүй, хуульд заасан өмчлөх эрхгүй этгээд галт зэвсэг олж авсан, эзэмшсэн, ашигласан», «галт зэвсэг бүртгүүлэх, хадгалах, ашиглах, эзэмших, худалдан авах журам зөрчсөн», «галт зэвсэг эзэмшүүлэх гэрээг хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй», «тусгай зөвшөөрөлгүйгээр галт зэвсэг, сум импортолсон, худалдсан», «галт зэвсэг, сумыг худалдан авагч иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хуульд заасны дагуу цахим бүртгэлд хадгалаагүй», «галт зэвсэг, сумыг улсын хилээр нэвтрүүлэх журам зөрчсөн», «спорт-сургалт, ан агнуурын зориулалтаар галт зэвсэг улсын хилээр нэвтрүүлэх журам зөрчсөн», «галт зэвсэг авч явах, эсхүл тээвэрлэх журам зөрчсөн, эсхүл хуульд заасан хугацаанд галт зэвсгийн тооллогод хамрагдаагүй» үйлдлүүд. Дээр дурдсан зөрчлийг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуулиар шийтгэнэ.

Хоёрдугаарт, Эрүүгийн хуулийн заалтуудыг зөрчсөн үйлдлүүд. Галт зэвсгийн энэ төрлийн эргэлт нь Монгол Улсын Эрүүгийн хуулинд тусгасан гэмт хэргийн бүрэлдэхүүнүүдтэй холбоотой байх тул эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг.

Монгол Улсын Эрүүгийн хуулинд галт зэвсэгтэй холбоотой дараах хоёр бүлэг гэмт хэргийг тусгасан байдаг:

а) галт зэвсгийг гэмт үр дүнд хүрэх зэвсэг болгон ашигласан гэмт хэргүүд, тухайлбал, хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (11.1), заналхийлэх (13.5), дээрэмдэх (17.2), зэвсэгт үймээн дэгдээх (19.5), хорлон сүйтгэх ажиллагаанд бэлтгэх (19.7), зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулах, түүнд элсэх (20.3), олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах (20.16), хууль сахиулагчийг эсэргүүцэх (23.1), бие биедээ захирагдахгүй цэргийн алба хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчих (28.4);

Галт зэвсгийг зэвсэг болгон ашигласан дээрх гэмт хэргүүдийг зарим судлаач «зэвсэглэсэн гэмт хэрэг» гэж нэрлэх санал гаргасан байдаг.

б) галт зэвсэг нь гэмт халдлагын зүйл болсон гэмт хэргүүд, өөрөөр хэлбэл, гэм буруутны үйлдэл нь зэвсгийн эргэлтийн журам зөрчсөн гэмт хэргүүд, тухайлбал, Эрүүгийн хуулийн Тусгай ангийн «Эдийн засгийн гэмт хэрэг» гэсэн 18 дугаар бүлэгт тусгалаа олсон: улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх (18.5), «Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг» гэсэн 20 дугаар бүлэгт тусгалаа олсон: галт зэвсэг, галт

хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших (20.4), галт зэвсэг хууль бусаар бэлтгэх (20.5), галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хамгаалахад хайнга хандах (20.6), «Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг» гэсэн 28 дугаар бүлэгт тусгалаа олсон: цэргийн эд хөрөнгө, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг зарах, үрэгдүүлэх, завших (28.7), цэргийн эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх (28.8), байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих (28.9), «Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг» гэсэн 29 дүгээр бүлэгт тусгалаа олсон: террорист үйлдэл хийх (29.8), террорист үйлдэлд бэлтгэх (29.9);

Эрүүгийн хуулийн дээр дурдсан хэм хэмжээнүүд нь галт зэвсэг ашиглан гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэм буруутныг гэмт санаагаа хэрэгжүүлж эхлэх үе шатанд үйлдлийг нь таслан зогсоох, түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх чухал үүрэгтэй байдаг. Эдгээр гэмт хэргүүд нь галт зэвсэг ашиглан гэмт хэрэг үйлдэх урьдач нөхцөл нь болж өгдөгөөрөө олон нийтийн аюулгүй байдалд заналхийлэх, иргэн, хүний хууль ёсны ашиг сонирхолд төдийгүй, өргөн хүрээтэй нийгмийн харилцаанд бүхэлд нь бодитой хохирол учруулах эрсдэлийг дагуулж байдаг.

Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисын хууль бус эргэлттэй холбоотой олон нийтийн аюулгүй байдлын эрүүгийн эрх зүйн хамгаалалтын онцлог нь эдгээр зэвсэг, хэрэгсэл, бодисын аюултай шинж чанар, мөн эдгээрийг нийтийн ашиг сонирхолд гэм хор учруулж болох байдлаар ашиглах боломжтой зэргийг харгалзан эрүүгийн эрх зүйн харилцаа заавал бодитой хохирол учирсанаар, түүний уршгаар аюултай байдал бий болсоноор үүсдэггүй.

Харин галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хамгаалахад хайнга хандах (20.6) гэмт үйлдлийн тухайд заавал «их хэмжээний хохирол» учруулсан байхыг, цэргийн эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх (28.8) гэмт үйлдлийн тухайд эд хөрөнгө, галт зэвсэгт бодитой хохирол учирсан байхыг шаарддаг.

Эрүүгийн хууль зөрчсөн гэмт хэргийн бүрэлдэхүүнүүдийг дэлгэрэнгүй авч үзвэл:

Эрүүгийн хуулийн 18 дугаар бүлэг (Эдийн засгийн гэмт хэрэг)-т тусгасан:

Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх (18.5.).

1. Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу хориглосон бараа, эрдэнэс, эрдсийг Монгол Улсын хилээр, гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг:

2.1. албан тушаалынхаа байдлыг ашиглаж;

2.2. байлдааны галт зэвсэг, галт хэрэгсэл, цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, тэсэрч дэлбэрэх бодисыг улсын хилээр хууль бус нэвтрүүлж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулийн 20 дугаар бүлэг (Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг)-т тусгасан. Тухайлбал:

Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших (20.4.).

1. Байлдааны, хууль сахиулах зориулалттай галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэлэгч төхөөрөмжийг хууль бусаар олж авсан, шилжүүлсэн,

борлуулсан, тээвэрлэсэн, хадгалсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчир эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих яв шийтгэнэ.

Галт зэвсэг хууль бусаар бэлтгэх (20.5).

1. Галт зэвсэг, түүний бүрдэл хэсгийг хууль бусаар бэлтгэсэн, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэлэгч төхөөрөмжийг хууль бусаар бэлтгэсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хамгаалахад хайнга хандах (20.6).

1. Байлдааны, хууль сахиулах зориулалттай галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэлэгч төхөөрөмжийг хадгалах, хамгаалах үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас их хэмжээний хохирол учруулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хохирол учирсан, хохирогч нас барсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулийн 28 дугаар бүлэг (Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг)-т тусгасан. Үүнд :

Цэргийн эд хөрөнгө, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг зарах, үрэгдүүлэх, завших (28.7).

1. Цэргийн алба хаагч өөрт нь хэрэглүүлэхээр тавьж олгосон цэргийн хувцас, хэрэгсэл, эд зүйлийг бусдад худалдаж, арилжиж, бэлэглэж, барьцаанд өгч завшсан, тэдгээрийг арчилж хамгаалах, хэрэглэх үүргээ биелүүлээгүй бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Цэргийн алба хаагч өөрт нь итгэмжлэн хариуцуулсан байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг завшсан, гээгдүүлсэн, эсхүл цэргийн техник, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, зөөвөрлөх хэрэгсэл, цэргийн эд хөрөнгийг харж хамгаалах үүргээ биелүүлээгүй бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ гэмт хэргийг дайны байдалд шилжсэн, эсхүл онц байдал зарласан үед үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Цэргийн эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх (28.8).

1. Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, зөөвөрлөх хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг санаатай устгасан, гэмтээсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг дайны байдалд шилжсэн, эсхүл онц байдал зарласан үед үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих (28.9).

1. Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэл, эд зүйл, цацраг идэвхт хаягдалтай харьцах журам зөрчсөнөөс хүний эрүүл мэндэд хүндэвтэр, эсхүл хүнд хохирол учруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулийн 29 дүгээр бүлэг (Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг)-г тусгасан:

Террорист үйлдэл хийх (29.8).

1. Төр, олон улсын байгууллагаас тодорхой шийдвэр гаргуулах, гаргасан шийдвэрийг өөрчлүүлэх, шийдвэр гаргахаас татгалзуулах зорилгоор галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, хими, биологийн хортой, аюултай бодис, кибер орчин, техник хэрэгсэл, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлийг ашиглаж, ашиглахаар заналхийлж хүн амыг айдаст автуулсан; галдан шатаасан, хүн, объект барьцаалсан, хүнийг алсан, эрүүл мэндэд хохирол учруулсан; зэвсэгт мөргөлдөөний нөхцөлд сөргөлдөгч аль нэг талд идэвхтэй оролцоогүй хүний амь бие, бие махбодид халдсан хүнийг арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.

Террорист үйлдэлд бэлтгэх (29.9).

1. Террорист үйл ажиллагаа явуулах зорилгоор зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулсан, бусдыг элсүүлсэн, татан оролцуулсан, бэлтгэсэн, сургасан, галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйлээр хангасан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг албадан татан буулгана.

Галт зэвсгийн энэ төрлийн эргэлтийг эрүүгийн хууль тогтоомж зөрчсөн, улмаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх үйлдэл тул үүнийг С.У.Дикаев⁷⁰ зөвхөн «хууль бус» төдийгүй, «гэмт» (криминальный) эргэлт гэж авч үзсэн байдаг. Тэрээр эрүүгийн эрх зүйн хүрээнд ийм төрлийн зэвсгийн эргэлтийн тухайд «хууль бус эргэлт» (незаконный оборот) гэсэн нэр томьёо төдийлөн оновчтой бус, харин «зэвсгийн гэмт эргэлт» (криминальный оборот оружия) гэж ярих нь илүү нийцтэй гэж үзсэнтэй бид санал нэгдэж байна.

С.У.Дикаевын үзэж байгаагаар зэвсгийн гэмт эргэлтийн бүтцэд хуулиар хориглосон, иргэний, албаны, байлдааны зэвсэгтэй хамааралтай үйлдлүүд, түүнээс гадна гэмт хэргийн зэвсэг (криминал зэвсэг), тухайлбал, гар хийцийн (самодельный), халхавчилсан (замаскированный), тодорхой төрөлд хамаарахгүй (атипичный) зэвсгүүд, тэдгээртэй холбоотой үйлдлүүд багтаж байна.

Ийм тул галт зэвсгийн хууль бус эргэлт нь зэвсгийн гэмт эргэлт төдийгүй, зэвсгийн хууль ёсны эргэлтийн дүрмийг ноцтойгоор зөрчин, улмаар хяналтаас бүрэн гарч гэмт хүрээлэл рүү татагдан орох нөхцлийг үүсгэдэг онцлогтой.

Монгол Улсын Галт зэвсгийн тухай хуулийн 9.1-д заасны дагуу «21 нас хүрсэн, иргэний эрх зүйн бүрэн чадамжтай, галт зэвсэг ашиглаж гэмт хэрэг санаатай үйлдэж байгаагүй, галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан Монгол Улсын иргэн иргэний зориулалттай галт зэвсэг өмчилж болно» гэж заасан.

Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн дагуу хэрэв иргэн, тухайлбал, дээр дурдсан «Хууль бусаар зэвсэг эзэмших» (5.6) зүйлд заасан «хууль бусаар тусгай хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, агсамжийг биедээ авч явсан», «иргэний, эсхүл харуул

⁷⁰ Дикаев, С.У. Устранение коллизий в законодательстве, как фактор успешной борьбы с криминальным оборотом оружия (Актуальные проблемы борьбы с незаконным оборотом оружия в условиях переходного периода). – М., 1998. С.19.

хамгаалалтын зориулалттайгаас өөр төрлийн галт зэвсэг өмчилсөн, эсхүл эзэмшсэн», «хуульд зааснаас өөр зориулалтаар галт зэвсэг өмчилсөн», «хуульд заасны дагуу сургалтад сууж гэрчилгээ аваагүй, хуульд заасан өмчлөх эрхгүй этгээд галт зэвсэг олж авсан, эзэмшсэн, ашигласан», «галт зэвсэг бүртгүүлэх, хадгалах, ашиглах, эзэмших, худалдан авах журам зөрчсөн», «галт зэвсэг эзэмшүүлэх гэрээг хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй», «тусгай зөвшөөрөлгүйгээр галт зэвсэг, сум импортолсон, худалдсан», «галт зэвсэг, сумыг худалдан авагч иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хуульд заасны дагуу цахим бүртгэлд хадгалаагүй», «галт зэвсэг, сумыг улсын хилээр нэвтрүүлэх журам зөрчсөн», «спорт-сургалт, ан агнуурын зориулалтаар галт зэвсэг улсын хилээр нэвтрүүлэх журам зөрчсөн», «галт зэвсэг авч явах, эсхүл тээвэрлэх журам зөрчсөн, эсхүл хуульд заасан хугацаанд галт зэвсгийн тооллогод хамрагдаагүй» үйлдлүүд нь хориг зөрчсөн үйлдэл буюу хууль бус эргэлтийг үүсгэнэ.

Хэв журмын албаны практикаас үзэхэд хамгийн их тархсан тохиолдол нь галт зэвсэг эзэмших эрхийг цагдаагийн байгууллагад бүртгүүлэх, сунгуулахтай холбоотой үүсдэг зөрчлүүд байдаг. Эзэмшигч нь галт зэвсгийг бүртгүүлэх, сунгуулах хугацааг хэтрүүлсэн бол энэ мөчөөс эхлэн уг үйлдэл нь хууль бус эргэлтийн ангилалд шилжинэ гэсэн үг юм. Энэ тохиолдолд хууль бус эргэлтийн дуусах хугацааг тодорхойлох, гэмт (криминал) эргэлтийн эхлэх хугацааг тогтоох шаардлагатай байдаг. «Зэвсгийн тухай» Холбооны хуулийн дагуу ангын зориулалттай галт зэвсгийг хадгалах, биедээ авч явах эрхийг иргэнд 5 жилийн хугацаатай олгодог. Галт зэвсэг хадгалах, биедээ авч явах эрхээ сунгуулах хүсэлтийг лицензийн хугацаа дуусахаас 3 сарын өмнө хүргүүлсэн байхаар заажээ.

Галт зэвсэг эзэмших лиценз дууссан өдрийн дараагийн өдрөөс эхлэн галт зэвсгийн гэмт эргэлт эхэлж байна гэж үзэх бөгөөд энэ нь эцэс төгсгөлгүй үргэлжилж болох, эсвэл тухайн галт зэвсгийг хураан авах, устгах хүртэл үргэлжлэнэ.

Галт зэвсэг хууль бусаар олж авсан (Эрүүгийн хуулийн 20.4.) үйлдлийг хуульд заасан өмчлөх эрхгүй этгээд галт зэвсэг олж авсан (Зөрчлийн тухай хуулийн 5.6.) үйлдлээс ялгаж зааглах хэрэгтэй байдаг. Сүүлийн тохиолдолд журам зөрчсөн иргэнд эрүүгийн хариуцлага оногдуулдаггүй.

Хэрэв галт зэвсэг эзэмших эрхгүй этгээд галт зэвсэг олж авсан, эсхүл эзэмших эрхтэй боловч зөвшөөрөлгүйгээр эзэмшсэн, мөн зөвшөөрлийн нөхцөл нь зөрчилтэй бол шаардлага хангаагүй этгээд галт зэвсэг олж авсан хууль бус үйлдэл болно.

Журмын дагуу олж авсан галт зэвсгийг цагдаагийн байгууллагад бүртгүүлээгүй бол галт зэвсэг олж авах журам зөрчсөн гэж үзнэ.

Галт зэвсгийг хууль бусаар олж авсан бол энэ мөчөөс эхлэн тухайн галт зэвсэгтэй холбоотой, тухайлбал, хадгалах, биедээ авч явах г.м. үйлдэл бүр нь хууль бус байна. Галт зэвсэг эзэмших гэрчилгээ авсан бол энэ нь хадгалах, биедээ авах (ан агнах зориулалтаар биедээ авч явах) эрх нь мөн нээгдсэн гэж ойлгож болно.

Дүгнэлт. Галт зэвсгийн хууль бус эргэлтийн ойлголт нь ийнхүү Эрүүгийн хуульд заасан хууль бус эргэлтийн хэлбэрүүдээс илүү өргөн хүрээтэй болох нь бидний судалгаанаас харагдаж байна. Галт зэвсгийн хууль бус эргэлтийн эрүүгийн эрх зүйн хэлбэрүүдээс гадна Галт зэвсгийн тухай болон Зөрчлийн тухай хуульд заасан захиргааны хэм хэмжээний акт зөрчсөн өргөн хүрээтэй үйлдлүүд байгаа болохыг дээр дурдсан билээ. Түүнчлэн иргэний эрх зүйн журмаар эд зүйлийг (галт зэвсэг) гаргуулан авах иргэний эрх зүйн хариуцлагын асуудал ч хөндөгдөж болохоор байдаг.

Дээр дурдсанд дүгнэлт хийж үзэхэд галт зэвсгийн хууль бус эргэлт нь хоёр төрөлтэй (хоригийг зөрчих, үүргээ үл биелүүлэх) байх бөгөөд учруулж буй нийгмийн хор аюулын

шинж чанараас хамааран «хоригийг зөрчсөн» бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр, «үүргээ биелүүлээгүй» бол захиргааны, сахилга батын, эсвэл иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэхээр байна.

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЧИНД ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ IN THE POLICE OPERATIONAL ENVIRONMENT IMPACT ANALYSIS DONE

Б.Одбаатар

*Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн
Цагдаагийн удирдлага, стратегийн тэнхимийн
профессор, хууль зүйн доктор (Ph.D),
дэд профессор, цагдаагийн хурандаа.*

Odbaatar.B

*Professor, Department of Police Strategy
Management, Executive Management Academy,
University of Internal Affairs, Mongolia,
doctor of law (Ph.D), Associate Professor, police colonel.*

Хураангуй: Энэхүү нийтлэлээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны орчинд шинжилгээ хийж гадаад, дотоод орчны зүгээс эерэг болон сөрөг байдлаар нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодорхойлон дүгнэхийг зорилоо.

Abstract: In this article, we aim to analyze the operational environment of the police organization and determine the factors that affect it in a positive and negative way from the external and internal environment.

Түлхүүр үгс: цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны шинжилгээ, хүчин зүйлийн нөлөөлөл.

Keywords: analysis of the activities of the police organization, external and internal environment, and the influence of factors.

Үндсэн хэсэг. Аливаа байгууллагын аюулгүй байдал, өрсөлдөх чадвар, нийгэмд эзлэх байр суурь зэргийг тал бүрээс нь тодорхойлон үнэлэлт, дүгнэлт өгөхөд гадаад, дотоод орчны хүчин зүйлийн давуу болон сул тал, түүнчлэн үйл ажиллагааг сайжруулах боломж, учирч болох саад бэрхшээлийг тодорхойлох дөрвөн хэмжүүрт судалгааны арга буюу SWOT шинжилгээг өргөн ашиглаж ирсэн.

Түүний нэг адил цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд гадаад болон дотоод орчны зүгээс нөлөөлж байгаа хүчин зүйлийн харилцан хамааралд хийсэн SWOT⁷¹ шинжилгээгээр дараах нөхцөл байдал тогтоогдож байна.

Хүснэгт 1.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хийсэн SWOT шинжилгээ

Давуу тал ➤ Цагдаагийн албаны тухай хууль батлагдан хэрэгжиж байгаа. ➤ Нэгдсэн төвлөрсөн удирдлагатай тул хүний нөөцийн бодлогыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангадаг. ➤ Удирдлагын чадавхи тодорхой хэмжээнд бүрдсэн. ➤ Үйл ажиллагааны төсөв, санхүүгийн эх үүсвэр хуулийн хүрээнд шийдвэрлэгдсэн. ➤ Алба хаагчдын аюулгүй байдлыг хангахад анхаарч ая тухай орчинд ажиллах талаар нэлээдгүй ажил хийсэн. ➤ Компьютер, техник, тоног төхөөрөмж, программ хангамжаар боломжийн түвшинд хангагдсан.	Сул тал ✗ Алба хаагчийг сонгон шалгаруулах өнөөгийн зохицуулалт боловсронгуй бус. ✗ Зарим томилгоонд субъектив хандлага давамгайлдаг. ✗ Дунд шатны удирдлагын менежмент сул, ур чадвар дутагдалтай. ✗ Захиргааны үйл ажиллагааны цахим хэлбэр жигдэрч төлөвшөөгүй. ✗ Алба хаагчдыг ур чадварыг төсвийн санхүүжилтээр бүрэн шийдвэрлэх боломжгүй. ✗ Алба хаагчдын шилжилт, албанаас гарах (тэтгэвэр) хөдөлгөөн өндөр. ✗ Захиалгаар суралцуулсан алба хаагчдыг тогтвортой ажиллуулах механизм зарим талаар алдагдсан
Боломж ✓ Байгууллагын орчинг аюулгүй байдалтай уялдуулан боловсронгуй болгох. ✓ Мэдээллийн технологийн орчин үеийн ололтыг нэвтрүүлэх замаар үйл ажиллагаагаа шуурхай, хүртээмжтэй болгох, алба хаагчдыг мэдээ, мэдээлэл, арга зүйн удирдлагаар шуурхай хангаж, тэдний үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх. ✓ Алба хаагчийг зөв байршуулах, алба тушаал дэвших карьерын тогтолцоо төлөвших. ✓ Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх.	Эрсдэл ✚ Байгууллагын үйл ажиллагааны зорилго, зорилтууд бодлогын түвшинд шийдвэрлэгдэхгүй байх. ✚ Сургаж, мэргэшүүлсэн алба хаагчдаа тогтвортой ажиллуулж чадахгүй, бусад байгууллагад шилжүүлэх, албанаас чөлөөлөх /алдах/. ✚ Аюулгүй байдлыг хангахад шаардлагатай хөрөнгө, санхүү дутагдах. ✚ Улс төрийн /гадаад/ нөхцөл байдлаас шалтгаалж, алба хаагчдын тогтвортой ажиллах, мэргэшсэн байх зарчим алдагдах. ✚ цалин хангалтгүй, илүү цагаар ажилласан ажлын хөлс олгогдодгүй байдлаас алба хаагчид авилгалд өртөх.

Өнөөдөр SWOT судалгааны аргыг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн өсөлт, бууралт, хүн амын нийгэм-соёлын төлөвшилт, улс төрийн болон гадаад, дотоод орчны нөлөөллийн цар хүрээ, хууль эрх зүйн зохицуулалтын орчин, түүнчлэн учирч болох аюул, эрсдлийн бодит хүчин зүйлийг бүрэн дүүрэн тодорхойлоход төдийлөн хангалттай биш гэж үзэх болсон.

Иймд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд уламжлалт буюу SWOT шинжилгээний аргаас гадна төрийн болон хувийн хэвшлийн аль ч байгууллагын үйл

⁷¹ Байгууллагын гадаад, дотоод орчны хүчин зүйлийн нөлөөллийг судлахад энэхүү аргыг хэрэглэдэг. Энэ нь байгууллага өөрийн давуу ба сул тал, боломж ба аюул занал гэж үзэж болох ямар асуудал байна, түүний нөлөөлөл нь ямар байгааг шинжлэн судалсны үндсэн дээр эрхэм зорилго, стратегия тодорхойлж хэрэгжүүлэх боломж нөхцлийг бүрдүүлж өгдөг судалгааны арга. SWOT гэдэг нь: Strength – давуу тал, Weakness – сул тал, Opportunity – боломж, Threat – аюул занал гэсэн англи үгнүүдийн эхний үсгийн товчлол.

ажиллагаа, хүний нөөцийн бодлого, алба хаагчийн аюулгүй байдал болон хөгжлийн алсын хараа, стратеги зорилтыг тодорхойлоход өргөн ашиглаж байгаа PESTLE⁷² шинжилгээний аргыг цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд гадаад, дотоод орчны зүгээс эерэг болон сөрөг байдлаар нөлөөлөх хүчин зүйлийг дараах хэлбэрээр тодорхойлон авч үзвэл:

Зураг 1.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлс



Political force буюу улс төрийн орчин. Өнөөгийн нийгмийн амьдралын хэв маягыг дүгнэн авч үзвэл улс төр, бизнесийн бүлэглэлийн нэгдэл улс төрийн нам, эвсэл, холбооны хүрээнд бий болж, эрх мэдлийн төлөө өрсөлдөх болсон, Засгийн газрын хэмжээнд явагддаг улс төрийн томилгоо нь хуулийн байгууллагын удирдлагыг хамарснаар дээрхи байгууллагуудын бие даасан, хараат бус байдал алдагдах эрсдлийг үүсгэж байна.

Төрийн албаны тухай хуульд мерит зарчмыг тусгаж, улс төрийн албан тушаал, төрийн албыг заагласнаас хойшхи арваад жилийн туршлагаас харахад улстөрчид, эрх баригчид үргэлж энэ хуулийн эсрэг алхмыг хийж иржээ. УИХ-ын ээлжит сонгуулийн дараа Төрийн албаны тухай хуулийг зөрчсөн, төрийн албан хаагчдыг үндэслэлгүйгээр халсан талаарх гомдол, маргаан хууль хяналтын байгууллагад олноор ирдэгийг шүүхийн байгууллагын статистик тоо баримт нотлож байна. 2022 оны байдлаар Монгол Улсад 225205 төрийн албан хаагч байгаагийн дөнгөж 1,7 хувь буюу 3759 нь төрийн улс төрийн албан тушаалтан байна⁷³. Төрийн албаны тухай хуулийг нэг мөр хэрэгжүүлэн шударга, зарчимтай байх юм бол нийт төрийн албан хаагчдын хоёр хувь нь л сонгуулийн үр дүн, улс төрийн намуудын эрх мэдлийн хуваарилалтаас хамаарч томилогдохоор байна.

Харин үлдсэн 98,4 хувь сонгууль болон улстөрчдөөс хараат бусаар тогтвор, суурьшилтай ажиллах ёстой боловч сонгуулийн үр дүнгээс шалтгаалан төрийн албан хаагчдын 20-30 хувь нь халагдаж, солигддог жишиг тогтоод удаж байна. Энэ гажуудал дутагдал цагдаагийн байгууллагад оршсоор байгаа нь гадаад орчны зүгээс нөлөөлж байгаа сөрөг хүчин зүйлийн нэг байсаар байна.

⁷² Байгууллагын ажиллагаанд эерэг болон сөрөг байдлаар нөлөөлөх хүчин зүйлсийг судлан шинжлэх аргын нэг нь PESTLE. Энэ нь дараах үгнүүдийн эхний үсгийн нийлбэр. Political force – улс төрийн орчин, Economic force – эдийн засгийн орчин, Sociocultural force – нийгэм-соёлын орчин, Technological force – техник-технологийн орчин, Legal force – хууль эрх зүйн орчин, Environmental force – хүрээлэн буй орчин. Байгууллагын гадаад орчин дотоод үйл ажиллагаанд нөлөөлөлж болох чиг хандлагыг тогтооход ашигладаг.

⁷³ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. <https://www2.1212.mn/>

Өнөөдөр төрийн тусгай чиг үүрэгтэй аль ч байгууллагад шат шатны удирдах ажилтныг сонгон шалгаруулалтад хүний нөөцийн бодлого алдагдах, удирдах албан тушаал дэвших сонгон шалгаруулалт гэхээсээ илүү үзэмжээр хандах явдал ажиглагдах болсон. Түүгээр ч барахгүй удирдлага солигдох бүрт шат шатны удирдах ажилтан солигдох ёстой мэт сөрөг үзэгдэл бий болж, зарим тохиолдолд энэ нь байх ёстой, хэвийн үзэгдэл мэт ойлгогдох хэмжээнд хүрсэн нь Төрийн албаны тухай хууль болон төрийн албанд сонгон шалгаруулах журам бусад хууль, эрх зүйн актын заалт, шаардлага тууштай, нэг мөр хангагдахгүй байгаагийн тод жишээ юм.

Economic force буюу эдийн засгийн орчин. Монгол орны эдийн засаг дахь баялаг бүтээх, нийгмийн амьдралыг тэтгэх чадварын түвшин, өсөлт нь дэлхийн болон бүс нутгийн түвшнээс доогуур байх, ядуурал, баялгийн тэгш бус хуваарилалт нь гэмт хэрэг, зөрчил өсөх, цаашлаад нийгмийн хурц зөрчил, сөргөлдөөнийг үүсгэх ч аюултай. Уул уурхайн түүхий эдэд түшиглэсэн, эдийн засаг нь тогтворгүй, худалдан авагчаас хараат байдалд оруулдаг, банкны систем, улсын өр, гадаадын хөрөнгө оруулалтыг татах буруу зохицуулалт зэрэг нь хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх боломжийг сулруулах, үндэстэн дамнасан компаниудын үйл ажиллагааны талбар болгож төр, нийгмийг хагаралд хүргэх, түүнчлэн улс орныг дампууралд хүргэж болзошгүй.

Улс оронд тулгарах орчин үеийн бүхий л аюул, занал, сорил, оюун санааны хүрээнд бий болсон сөрөг өөрчлөлтийг даван туулах чадамж бүхий аюулгүй байдлын тогтолцоо бэхжээгүй. Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг, шинэ төрлийн террорист үйлдэл, түүний дотор кибертерроризм үйлдэгдэх, хууль бус үйл ажиллагаа, түүнчлэн дэлхий нийтийг хамарсан аймшигт өвчин буюу цар тахал (COVID-19 зэрэг)-ын аюул байна. Техник, технологийн дэвшлийг эдийн засгийн хувьд бэхжсэн, чадамжтай гэмт хэрэгтнүүд өргөн ашиглаж, харин төсвийн санхүүжилттэй цагдаа хүчгүйдэх, хоцрогдох нөхцөл бүрдэж байна. Цөлжилт, уур амьсгалын огцом өөрчлөлт, гэнэтийн үзэгдэл нь асар их хохирол учруулж, хөдөөгийн амьдралыг хүндрүүлэн гэмт хэргийн нөхцөл байдлыг хүндрүүлэх эрсдэлтэй байна.

Цагдаагийн алба хаагчийн цалин, хангамж амжиргааны энгийн хэрэглээнний зардалд хүрэлцэхгүй, үйл ажиллагааны төсөв хомсдолтой байгаа нь зэрэг нь алба хаагчийн ажил гүйцэтгэх сэтгэл ханамж, цаашлаад тогтвор суурьшилтай ажиллах урам зори, итгэл үнэмшилд нөлөөлөх болсон. Энэ алба хаагчийн ар гэрийн зүгээс ч албанд хандах хандлагад сөргөөр нөлөөлөх нэг шалтгаан болж байна. Түүнчлэн цагдаагийн алба хаагчдын 90 гаруй хувь нь цалин, орон сууцны зээлтэй, цалингийн хэмжээ хангалтгүй, илүү цагаар ажилласан ажлын хөлс олгогддоггүй байгаа нь эдийн засгийн нөлөөнд автах, алба хаагчид авилгад өртөх эрсдэл өндөр байгаа явдал гадаад орчны зүгээс хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байна.

Sociocultural force буюу нийгэм-соёлын орчин. Хүн амын соёлын түвшин, аливаа асуудалд хандах байр суурь, төлөвшил эрс өөрлөгдөж байгаа өнөөгийн нөхцөлд олон нийтийн зүгээс өгч байгаа үнэлэмж, үнэлгээгээр цагдаагийн байгууллагын нэр хүнд, соёл, харилцааны ур чадварыг бүрэн дүүрэн тодорхойлоход хэцүү. Тухайлбал, өөрийн хүсэл сонирхол, эрх ашиг хүссэн хэмжээнд нь хангагдаагүй эсвэл хүсэн хүлээсэн байдлаар асуудал шийдвэрлэгдээгүй л бол цагдаагийн нэр хүндийг гутаах, нэр хүндэд халдах, олон нийтэд социал ертөнцөөр дамжуулан өөрийн үзэл бодлоо бусдад түгээж бусдаар хүлээн зөвшөөрүүлэх хандлага бий болсон нь цагдаагийн байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлж байна.

Нөгөө талаар цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн болон харилцааны ур чадварын жижиг алдаанаас ч олон нийтэд албаны нэр хүнд унах эрсдэл байна.

Түүнчлэн дараах төрлийн эрсдэл бий болох дамтамж, магадлал байнга өндөр хэмжээнд байгаа тул цагдаагийн байгууллагын нэр хүнд, хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаа гол хүчин зүйлийн нэг болж байна. Үүнд:

- Алба хаагчдын ажлын хариуцлага, сахилга ёс зүй байдал, харилцааны соёл иргэдийн хүсэн хүлээсэн шаардлагын хэмжээнд хүрэхгүй байгаагаас албаны нэр хүнд унах;
- Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгаж шийдвэрлэх ажиллагаа хуулийн хугацаанд хийгдэхгүй, хариуг иргэдэд нэн даруй өгөхгүй байгаа нь цагдаагийн байгууллагын нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлэх;
- Алба хаагчдаас иргэдтэй харьцахдаа хүндэтгэлтэй бус харьцах, мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэт өгч чадахгүй байгаа явдал иргэдийг бухимдуулах, цагдаагийн байгууллагын нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлэх;
- Хүний нөөцийн бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны журмыг баримталж томилгоо хийгдэхгүй байгаагаас алба хаагчид тогтвор суурьшилгүй ажиллах, албанаас халагдах;
- Цагдаагийн байгууллагын болон удирдах албан тушаалтнуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр зохион байгуулалттайгаар гүтгэх;
- Цагдаагийн байгууллагын хэвлэл, мэдээллийн төвөөс олон нийтэд өгч байгаа мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангаагүйгээс дотоод аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг үүсгэж байна.

Нийгмийн хөгжлөөс шалтгаалан цагдаагийн нийт алба хаагчдын санаа бодолд гарсан өөрчлөлт, хэрэглэгчийн үнэлгээний судалгаагаар цагдаагийн алба хаагчдын 46 хувь нь эрхэлсэн ажилдаа хандах сэтгэл ханамж дундуур, ажлын ачаалал, алба хаагчийн ажилласан хугацааны турш хуримтлагдсан стресс, түүнээс үүдэлтэй зан авирын өөрчлөлт, нэг ёсны мэргэжлийн өвчинтэй болж, иргэдтэй харьцах харьцаанд муугаар нөлөөлдөг, карьерын болон хариуцлагын шударга тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай⁷⁴, цагдаагийн алба хаагчийн ачаалал их, 100 мянган хүн амд ноогдох цагдаагийн ажилтны тоо дэлхийн дундаж үзүүлэлтээс 83,1 хувиар бага⁷⁵ гэжээ.

Нөгөө талаас нийгмийн ёс суртахууны үнэлэмж үлэмж доройтсон өнөө үед иргэдээс цагдаагийн алба хаагчдыг дорд үзэх, гүтгэх, доромжлох нь ердийн үзэгдэл болсон нь мөн л аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд сөрөг нөлөөллийг байнга бий болгож байна.

Technological force буюу техник-технологийн орчин. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд шинжлэх ухааны агууламж бүхий дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, өргөн ашиглах замаар мэдээллийн хангамжийг сайжруулан, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, халуун мөрөөр нь илрүүлэх, нотлох ажиллагааг мэргэжлийн түвшинд хүргэн эрчимжүүлэх шаардлагатай байна. Мөн цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэхэд эрх зүйн зохицуулалтын орчин боловсронгуй бус байгаагаас гадны өндөр хөгжилтэй улс орны техник, технологийг нэвтрүүлэхэд хүндрэлтэй байдлыг үүсгэж байна.

Түүнчлэн өндөр технологи нэвтрүүлэлт ба цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт шууд шугаман хамааралтай боловч шаардлагын түвшинд

⁷⁴ Цагдаагийн ерөнхий газар. Цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг, зөрчил, харилцаа, ёс зүйн өнөөгийн байдал. судалгааны тайлан. – УБ., 2021.

⁷⁵ Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр. Засгийн газрын 2020 оны 04 сарын 22 ны өдрийн 141 дүгээр тогтоолын хавсралт.

хүрээгүй зэрэг цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаа талаар эрсдлийн үнэлгээний жил бүрийн тайланд тусгасан байна.

Дээрхи нөхцөл байдал нь цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах, орчин үеийн техник, өндөр технологийг нэвтрүүлж шуурхай, найдвартай ажиллах таатай орчин нөхцлийг бүрдүүлэх, дотоод аюулгүй байдлыг хангах нэг хэлбэр болох мэдээллийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

Legal force буюу хууль, эрх зүйн орчин. Цагдаагийн албаны тухай хууль батлагдан 2017 оны 02 дугаар сарын 09-ны өдрөөс мөрдөгдөж эхэлсэн нь цагдаагийн байгууллагын үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх болон албан хаагчийн эрх зүйн баталгаа, аюулгүй байдал, эрх ашгийг хамгаалах гол үндэс болжээ.

Цагдаагийн байгууллагын хүний, санхүүгийн, техникийн нөөцийг үр дүнтэй хуваарилах, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, зорилт, чиг үүргийг тасралтгүй хэрэгжүүлж чадах нөөцийг төлөвлөж, аюул, эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллана. Энэ хүрээнд:

- Хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг алба хаагчдад сурталчилна;
- Алба хаагчдыг сэлгэн, шилжүүлэн ажиллуулж ажлын байранд хөрвөх чадварыг бий болгоно;
- Холбогдох хууль, дүрэм, журмын талаар болон бусад шаардлагатай сургалтыг тухай бүр зохион байгуулж, алба хаагчдыг мэдээ, мэдээллээр хангана;
- Алба хаагчдад чиглэсэн цалин нэмэгдэл болон бусад эдийн засгийн хөшүүргийг дэмжинэ;
- Улс орны эдийн засгийн өсөлт, хүн амын төвлөрлийг тооцоолсон бодит судалгааг хүний нөөцийн бодлого төлөвлөлтөд ашиглана;
- Ажил, чиг үүргийн давхардал, ажлын ачааллын талаар судалгаа хийж, судалгааны үр дүнг үндэслэн тэнцвэржүүлэх арга хэмжээ авна;
- Алслагдсан сум, сууринд ажиллаж байгаа алба хаагчдыг мэдээллийн технологи /Online/ ашиглах замаар зардал багатайгаар сургалтад хамруулах, тодорхой тохиолдлуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх, мэдээ, мэдээллээр хангах, энэ чиглэлийн техник, технологийн болон санхүүгийн асуудлыг шийдвэрлэнэ;
- Тэтгэвэрт гарах алба хаагчид, орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, тооцоо судалгааг жил бүр үндэслэлтэйгээр гаргаж, тэдэнд олгох тэтгэмжийг төсөв, санхүүтэй уялдуулна;
- Төв байгууллага, харьяа нэгж, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын орон тоо, төсвийг тогтоох, төсөвт тодотгол хийхдээ тухайн орон нутгийн онцлог, алслагдсан байдал, гэмт хэргийн гаралтын түвшин, хэв журмын нөхцөл байдал, хүн амын нягтралыг судалж, харгалзан, холбогдох албанд санал хүргүүлж, шийдвэрлүүлнэ;
- Алба хаагчдыг гэмт хэрэгт холбогдон шалгагдах, ял шийтгүүлсэн алба хаагчдын нэгдсэн судалгаа хийж, тэднийг гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэх, эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлыг системтэйгээр зохион байгуулна гэж тодорхойлсон байна.

Эрх зүйн зохицуулалтын орчинд хийсэн дүгнэлтээс харахад Монгол Улсад төрийн алба мэргэшсэн, чадварлаг, тогтвортой байх суурь зарчимд тулгуурлан аливаа албан тушаалд ур чадварын шалгуураар томилох “Merit” тогтолцоо давамгайлах нь чухал байна. Төрийн албанд оршиж байгаа томилгооны тогтолцооны гажуудлыг засах, шинэчлэлт хийж шинэ шатанд гаргах талаар ярьж, шүүмжилдэг ч зохих үр дүнд хүрэхгүй байна. Түүгээр ч барахгүй энэ гажуудал төрийн, тэр дундаа салбарын шат, шатны удирдах албан тушаалд

дэвшүүлэх, томилоход ажиглагдаж байгаа нь төрийн тусгай албаны уламжлал, төлөвшил, ёс зүй, мөн чанар, нэр хүндийг ч сулруулахад хүргэж байна.

Environmental force буюу хүрээлэн буй орчин. Иргэдээс авсан тандалт судалгаагаар⁷⁶ цагдаагийн газар болон цагдаагийн имиж, дүр төрхийг “цагдаа төрийн хүн төдийгүй шударга, итгэж болох хүн” гэж 80 хувь онцолсон, “цагдаагийн үүргийг та юу гэж бодож байна?” гэсэн асуултанд 50 гаруй хувь “гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх” гэж хариулсан нь иргэд цагдаагийн байгууллагад ямар нэгэн хэмжээгээр итгэдэг бөгөөд цагдаагийн үйл ажиллагааны талаар хэвшиж тогтсон ойлголт, итгэл үнэмшил бий болсон байдгийг харуулж байна. Харин цагдаагийн алба хаагчдын 40 хувь өөрийн мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх шаардлагатай болохыг онцлоод, эрхэлж буй ажилдаа хандах сэтгэл ханамжийн түвшингээ “дунд” гэж үнэлжээ⁷⁷. Цагдаагийн байгууллагын гадаад, дотоод харилцаа өргөжин тэлж, дэлхийн улс орнуудын адил чиг үүрэгтэй мэргэжлийн байгууллагуудтай харилцан, хамтран ажиллаж байгаа төдийгүй Нэгдсэн үндэстний байгууллагын мандаттай энхийг дэмжих ажиллагаанд цагдаа, дотоодын цэргийн алба хаагчид оролцож, үүрэг гүйцэтгэж байна.

Нийгмийн хөгжилтэй уялдан цагдаад итгэж, хүндэтгэлтэй хандаж ирсэн уламжлалт гэж болох нийгмийн сэтгэл зүй өөрчлөгдсөн, алба хаагчийн нийгмийн болон бусад баталгаа бэхжээгүй, цагдаа, дотоодын цэргийн алба мэргэшлийн болж хөгжиж чадахгүй байгаа, албанаас олон хүн чөлөөлөгдөж, институцийн хувьд чадавхи буурч байгаа явдал анхаарал татаж байна.

Түүнчлэн улс төрийн нөлөөлөл ихэссэнээр байгууллагын бие даасан, хараат бус байдал алдагдсан зэрэг эрсдлүүд бий болсоор байгууллагын үйл ажиллагаа, томилгоонд нөлөөлж байна. Бусад өндөр хөгжилтэй улс орны цагдаагийн байгууллагын хөгжлийн загвараас суралцах, тэдний туршлагыг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Цагдаагийн байгууллагын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөх гол хүчин зүйлийн нэг нь алба хаагчийн ажлын хариуцлага, ажилд хандах хандлага, тэдний сахилга, ёс зүйн төлөвшил байдаг. Энэ нь цагдаагийн байгууллагын нэр хүнд, олон түмний итгэл хүндлэл, цаашлаад аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгааг үнэлэх хэмжүүр болдог. “Байгууллагын удирдлагын зүгээс ажлын хариуцлага, сахилга ёс зүйг дээшлүүлэх, гэмт хэрэгт холбогдох, сахилга, ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр оновчтой ажил, арга хэмжээг авч чадаж байна уу?” гэсэн санал асуулгад 1979 алба хаагч оролцсоноос 1322 буюу 66.8 хувь нь “хангалттай”, 600 буюу 30.3 хувь нь “дунд зэрэг”, 57 буюу 2.9 хувь нь “хангалтгүй” гэж хариулсан байна⁷⁸. Түүнчлэн ажлын хариуцлагыг дээшлүүлэх гэмт хэрэг, ёс зүйн зөрчил, дутагдлаас урьдчилан сэргийлэх, бууруулах ажил, арга хэмжээний талаар 1152 буюу 58.3 хувь нь “үр дүнтэй, алба хаагч бүрт хүрч чадаж байна”, 711 буюу 36 хувь нь “дунд зэрэг”, 112 буюу 5.7 хувь нь “хангалтгүй” гэж үнэлжээ.

Алба хаагчдын зүгээс бие даан, хараат бус байдлаар хуулийн хүрээнд албаны нэр хүндийг дээдэлж, ялгаварлан гадуурхалгүй, шударга, шуурхай байдаар ажиллах боломж нөхцөл хангагдсан эсэх талаар 1170 буюу 57.1 хувь нь “хангалттай”, 692 алба хаагч буюу 33.8 хувь нь “дундад зэрэг”, 187 алба хаагч буюу 9.1 хувь нь “хангалтгүй” гэж үнэлсэн

⁷⁶ Цагдаагийн ерөнхий газар. Судалгааны АРИГҮ Медиа ХХК. Богино хугацааны мэдээлэл, харилцааны стратеги. судалгааны ажлын тайлан. – УБ., 2014.

⁷⁷ мөн тэнд.

⁷⁸ Цагдаагийн ерөнхий газар. Дотоод хяналт, аюулгүй байдлын газар. Судалгаа, дүн шинжилгээний төв. “Цагдаагийн алба хаагчаас үйлдсэн гэмт хэрэг, зөрчил, харилцаа, ёс зүйн өнөөгийн байдал” судалгааны ажлын тайлан. 2020.

бөгөөд “дунд” буюу “хангалтгүй” гэж үнэлсэн алба хаагчид дараах шалтгаантай холбон тайлбарлажээ. Үүнд:

➤ Удирдлага, дээд шатны байгууллага, эрх бүхий хүмүүсээс хөндлөнгийн нөлөөлөл их байдаг гэж 206 буюу 20.5 хувь (*нийт судалгаанд хамрагдсан алба хаагчдын 10 хувь*);

➤ Хуулийн хугацаа богино учир анхны хугацаанд нь шийдвэрлэхэд хүндрэл гардаг гэж 316 буюу 31.5 хувь (*нийт судалгаанд хамрагдсан алба хаагчдын 15.4 хувь*).

➤ Нэг алба хаагчид ноогдох ажлын ачаалал нэмэгдсэнтэй холбоотой гэж 469 буюу 46.7 хувь (*нийт судалгаанд хамрагдсан алба хаагчдын 22.9 хувь*) үзжээ.

Цагдаагийн байгууллагын алба хаагчдаас 2021 онд 1217 зөрчилд 1244 алба хаагч холбогдон шалгагдсанаас 812 буюу 65.2 хувийг офицер, 428 буюу 34.4 хувийг ахлагч, 4 буюу 0.3 хувийг энгийн ажилтан эзэлж байна. Үүнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад сахилгын зөрчил 51 нэгж буюу 4.0, алба хаагч 17 нэгж буюу 2.6 хувиар тус тус буурсан хэдий ч ажлын хариуцлага алдсан, архидан согтуурсан, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль зөрчсөн, цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм зөрчсөн, ёс зүйн дүрэм зөрчсөн, хээл хахууль, шан харамж авсан зөрчил таслан зогсохгүй байгаа явдал анхаарал татсаар байна.

Дээрхи санал асуулгын судалгааны дүнгээс үзэхэд цагдаагийн төв байгууллага, удирдлагын зүгээс алба хаагчийн ажлын гүйцэтгэл, сахилга, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулж, түүний гүйцэтгэл, үр дүнг тогтмол тооцож хэвшлүүлэх талаар үр дүнтэй ажил зохион байгуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Дүгнэлт. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа зөвхөн гадны хүчин зүйл, түүний сөрөг нөлөөлөл, үр дагавраас хамааралтай гэж ойлгох нь ташаа бөгөөд энэ нь алба хаагчийн мэдлэг, боловсрол, ур чадвар, соёл, зан харьцаа, ажилдаа хандах хандлагаас мөн хамаарах учиртай. Үүний тулд цагдаагийн алба хаагч төрийн өмнө хүлээсэн албан үүргээ нэр төртэй гүйцэтгэхэд дараах үндсэн шаардлага зүй ёсоор тавигдана гэж үзлээ. Үүнд:

- Төрийн албаны ёс суртахууны хэм хэмжээг чанд мөрдөж, төрийн болон албаны, мөн ажил хэргийн шугамаар олж авсан хувь хүний нууцыг чанд хадгалах;

- Төрийн алба, түүний мөн чанарыг гүнзгий мэдэрч хууль, тогтоол, шийдвэрийг байнга судалж, ажил хэрэг болгон үйл ажиллагаандаа удирдлага болгон ашиглах;

- Мэргэжлийн өндөр ур чадвартай, зэвсэг, техник, технологийг чадамгай эзэмшсэн байх;

- Гадаад хэлний мэдлэг боловсролтой, харьцааны өндөр соёлтой бусдыг ямагт хүндэлдэг хүнлэг сэтгэлтэй байх;

- Биеэ дайчлан хөгжүүлэх, сэтгэл зүйн тэвчээр, хатуужилтэй байх;

- Гадны нөлөөнд автахгүй байх, албан тушаалаа хувийн ашиг сонирхолд ашиглах, шан харамж авах, бусдыг доромжлох, нэр төрийг нь гутааж басамжлахыг цээрлэн ёс зүйтэй байх;

- Бүтээлч, санаачлагатай байж өөрт ноогдсон үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарлаж, ажлаа хугацаанд нь гүйцэтгэж, хариуцлагаас тойрох, түүнээс эмээх зэрэг сул талын илрэл гаргахгүй байх;

- Хууль, эрх зүйн төдийгүй нийгэмд өрнөж буй улс төр, эдийн засаг, санхүүгийн үйл явц өрнөлд дүн шинжилгээ хийх өөрөөр хэлбэл аливаа асуудалд хөндлөнгийн зөв дүгнэлт хийх чадвартай байх зэрэг олон ур чадвар, мэдлэгийг эзэмшсэн байхыг тэднээс шаардаж байна.

Цагдаагийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн дээрхи шалгуурууд нь хэдийгээр цагдаагийн алба хаагчид тавигдах ажлын байрны зайлшгүй шалгуур үзүүлэлт, шаардлага биш ч гэлээ төрийн албан хаагчийнхаа хувьд баримтлах, цаашид өөрийн аюулгүй байдлаа хангах, бусдын нөлөө, халдлагад өртөхгүй байх нөхцлийг өөрөө бүрдүүлэх тэдний зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар гэж үзэж болно.

Санал. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд орчны шинжилгээ хийсэн энэхүү судалгаанд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн алба хаагчаас үйлдэгдэх сахилга, ёс зүйн зөрчил буурахгүй байгаад дүгнэлт хийж тэдний мэдлэг, ур чадвар, харилцааны соёлыг дээшлүүлэхэд чиглэсэн үр дүнтэй ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

2. Цагдаагийн байгууллагын бүтцийн нэгжийн анхан болон дунд шатны удирдах албан тушаалтны манлайлалыг хөгжүүлэх тэднээр дамжуулан цагдаагийн байгууллагын хөгжлийг шинэ шатанд гаргахад чиглэсэн бодлого, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Ашигласан эх сурвалж.

1. Цагдаагийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017 он. №8.
2. Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр. Засгийн газрын 2020 оны 04 сарын 22 ны өдрийн 141 дүгээр тогтоолын хавсралт.
3. Цагдаагийн ерөнхий газар. Цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг, зөрчил, харилцаа, ёс зүйн өнөөгийн байдал. судалгааны тайлан. – УБ., 2021.
4. Цагдаагийн ерөнхий газар. Судалгааны АРИГҮ Медиа ХХК. Богино хугацааны мэдээлэл, харилцааны стратеги. судалгааны ажлын тайлан. – УБ., 2014.
5. Цагдаагийн ерөнхий газар. Дотоод хяналт, аюулгүй байдлын газар. Судалгаа, дүн шинжилгээний төв. “Цагдаагийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг, зөрчил, харилцаа, ёс зүйн өнөөгийн байдал” судалгааны ажлын тайлан. 2020.
6. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 6/169 тушаал. Хүний нөөцийн бодлогын баримт бичиг.
7. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. <https://www2.1212.mn/>

**ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН НИЙТТЭЙ
ХАРИЛЦАХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ**
**THE ROLES AND POSITION OF POLICE-PUBLIC PARTNERSHIPS
IN THE FUNCTIONS OF THE POLICE ORGANIZATIONS**

М.Эрдэнэбилэг

ДХИС-ийн харьяа Ахлагчийн мэргэжлийн сургалт-
үйлдвэрлэлийн төвийн тактикийн тэнхимийн эрхлэгч,
доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа

Erdenebileg.M

University of internal affairs, Mongolia. Elder vocational
training center, Tactical department, police lieutenant colonel

Товч агуулга: Цагдаагийн албаны тухай хуульд зааснаар цагдаа нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж, дэмжлэг авах, тэдэнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах талаар хуульд заасан үйлчилгээ үзүүлж, хамтарч ажиллах талаар тусгасан нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ нийгэмд үйлчлэх төрийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг баримтлах үзэл санаа оршиж байна.

Abstract: According to the Law on Police Service, the police must respect human rights and freedoms, be transparent and open, strictly maintain confidentiality, receive public trust and support, fight crime, protect public order, and ensure public safety. providing services and working together as stipulated in the law, there is an idea of adhering to the main direction of government activities to serve the society in the implementation of its main functions.

Түлхүүр үгс: Олон нийт, харилцаа, хамтын ажиллагаа, цагдаагийн байгууллага.

Key words: the public, relationship, cooperation, police organization

Үндсэн хэсэг. Цагдаагийн албаны тухай хуулийн хоёрдугаар бүлэгт зааснаар цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, захиргааны хяналт тавих⁷⁹ үндсэн гол чиг үүрэгтэй.

“Чиг үүрэг” (functio-биелүүлэх гэсэн утгатай латин гаралтай үг) гэсэн ойлголт, нэр томъёо нь хууль зүйн шинжлэх ухаанд эрх зүй ба төрийн учир холбогдлын шинжийг тодорхойлоход хэрэглэгдэнэ. Эрх зүйт төрийн чиг үүрэг нь эрх зүйн хүрээнд нийгмийн харилцааг зохицуулах, хамгаалах бэхжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг мөн. Иймд эрх зүйт төрийн чиг үүрэг нь эрх зүйн чиг үүргээр тодорхойлогдоно. Францын хуульч Жан-

⁷⁹ Цагдаагийн байгууллагын тухай хууль. // Төрийн мэдээлэл эмхэтгэл. УБ., 2017. №8

Луй Бержель эрх зүйн чиг үүргийг: шударга ёс; зохистой зан үйл; хүнд үйлчлэх; нийгэмд үйлчлэх гэсэн дөрвөн төрөлд ангилжээ⁸⁰.

Академич С.Нарангэрэл эрх зүйн чиг үүргийг: маргааныг хянан шийдвэрлэх; нийгмийн дэг журмыг сахиулах; эсрэг тэсрэг ашиг сонирхлыг зохицуулах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах чиг үүрэг⁸¹ гэж нийгмийн хандлагаар ангилан авч үзсэн байна.

Доктор, профессор Ч.Нямсүрэн эрх зүйн чиг үүргийг эрх зүйн харилцааг зохицуулах, хамгаалах, бэхжүүлэх, үйлчлэх гэж ангилан авч үзсэн байна⁸².

Иймд цагдаагийн байгууллагын чиг үүрэг нь хууль дээдлэх хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, олон нийтийн итгэл хүлээж, дэмжлэг авах, улс төрөөс ангид байх, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг баримтлан гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах талаарх нийгэмд үйлчлэх төрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл мөн гэж тодорхойлж болохоор байна.

Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нь хуульд заасан үндсэн үүрэг боловч энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхэд дан ганц цагдаагийн байгууллагын хүч хэрэгслээр бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд учир дутагдалтайг хуульч эрдэмтэд, цагдаагийн ажилтнууд цөөнгүй тэмдэглэж байгааг өмнө хийсэн судалгааны ажлын үр дүнд харагдаж байна. Энэ талаар ч олон эрдэмтэн, судлаачид байр сууриа өөр өөрийн өнцгөөс илэрхийлж байгаагаас харагдаж байна. Түүхэн уламжлалаас харахад цагдаагийн байгууллага, алба хаагч нь төрийн болон төрийн бус байгууллага, ард иргэдийн оролцоонд түшиглэсэн олон ажил, арга хэмжээг бодлогын түвшинд авч хэрэгжүүлж ирсэн туршлагатай.

Цагдаагийн албаны тухай хуульд зааснаар цагдаа нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, ил тод, нээлттэй байх, нууцыг чанд хадгалах, олон нийтийн итгэл хүлээж, дэмжлэг авах, тэдэнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах талаар хуульд заасан үйлчилгээ үзүүлж, хамтарч ажиллана гэжээ. Чиг үүргүүдээс авч үзвэл:

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд:

1) гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг тогтоох;

2) гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай мэдээ, мэдээллийг төлбөртэй авахад иргэд, төрийн ба төр бус байгууллага, аж ахуйн нэгж, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагатай шууд болон мэдээлэл солилцох хүрээнд хамтран ажиллана.

Нийтийн хэв журам хамгаалах хүрээнд:

1) зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, хуулиар харьяалуулсан зөрчлийг шалгаж шийдвэрлэх, байгууллага, алба хаагчийг мэдээллээр хангах;

2) гудамж, талбай болон нийтийн эзэмшлийн бусад газарт эргүүл хийх;

3) замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

4) насанд хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

5) гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

⁸⁰ Жан-Луй Бержель. Общая теория права. Москва. NOTA BENE., 2000. С. 57.

⁸¹ Дэлгэрүүлж үзнэ үү.: С.Нарангэрэл. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. Уб., 2001. 60-73 дахь тал.

⁸² Нямсүрэн, Ч. Эрх зүйн ерөнхий онол. Уб., 2023. 86 дахь тал.

6) гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдэд шаардлага, сэрэмжлүүлэг өгөх, биелэлтийг нь хангуулах;

7) олон нийтийн цагдааг мэргэжил, арга зүйгээр хангах зэрэг чиг үүрэг гүйцэтгэнэ.

8) Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байх зарчмын хүрээнд цагдаагийн алба хаагчийн ёс зүй, сахилга, хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арилгуулахад олон нийттэй хамтарч ажиллана.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах хүрээнд:

1. нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх бүх талын арга хэмжээ авах;

2. нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал, цуглааны үеийн хамгаалалт хийх;

3. байгууллага, алба хаагч, ажилтны аюулгүй байдлыг хангах, тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад олон нийттэй хамтарч ажиллана.

Захиргааны хяналт тавих хүрээнд:

1) эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хараа хяналтгүй болсон хүүхдийн асуудлыг судалж шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх;

2) эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгаснаар сураггүй алга болсон хүн, гээгдэл эд хөрөнгийг эрэн сурвалжлах, хэн болох нь тогтоогдоогүй цогцсыг таниулах ажиллагаа явуулах;

3) гээгдэл эд хөрөнгө, мөнгийг бүртгэх, шаардлагатай бол хадгалах, хууль ёсны эзэмшигчид нь олгох, хэрэв хууль ёсны эзэмшигч олдохгүй бол төрийн, эсхүл орон нутгийн холбогдох байгууллагад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэхэд олон нийттэй хамтран ажиллаж тэдний дэмжлэг туслалцааг авна.

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 22 дугаар зүйлд зааснаар цагдаагийн байгууллага, алба хаагч нь олон нийттэй харилцах, хамтарч ажиллахдаа дараахь зарчмын нийтлэг шаардлагыг дагаж мөрдөнө:

1) хуулийг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй.

2) цагдаагийн алба хаагч үүргээ хэрэгжүүлэхдээ өөрийн албан тушаал, цол, нэрийг хэлж, шаардсанаар өөрийн албаны үнэмлэхийг үзүүлнэ.

3) хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, эсхүл албадлагын арга хэмжээ авсан тохиолдолд арга хэмжээ авах болсон үндэслэл, шалтгааныг тухайн этгээдэд мэдэгдэж, авсан арга хэмжээтэй холбогдон хүн, хуулийн этгээдэд үүсэх эрх, үүрэг, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, өөрийнхөө эсрэг тайлбар, мэдүүлэг өгөхгүй байх эрхийг тайлбарлаж өгөх үүрэгтэй.

4) цагдаагийн алба хаагч бусдад эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлохыг хориглоно.

5) цагдаагийн алба хаагч, үүргээ гүйцэтгэхдээ бусадтай хүндэтгэлтэй харьцаж, бусдыг үл тоосон, заналхийлсэн, доромжилсон үг хэллэг, үйл хөдлөл хэрэглэхгүй байж, өөрийн шаардлагыг үндэслэлтэй, ойлгомжтой хэлбэрээр илэрхийлэх үүрэгтэй.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээг олон нийтэд түшиглэсэн, тэдний дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх нь үр дүнтэй бөгөөд төрөөс дээрх үйл ажиллагааг бодлогоор болон санхүүжилтээр дэмжих нь үр нөлөөтэй юм. Бодит байдалд цагдаагийн байгууллагад

урьдчилсан сэргийлэх, олон нийттэй харилцах чиглэлээр төсөвт төдийлөн санхүүжилт төсөвлөгдөхгүй байгаа нь дээрх ажлын үр нөлөө буурах нь зүйн хэрэг юм.

Цагдаагийн байгууллагын олон нийттэй харилцах чиг үүргийг хэрэгжүүлж буй нэгж нь мөрдөн байцаах алба, эрүүгийн цагдаагийн алба, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба гэх зэрэг цагдаагийн төрөл мэргэжлийн албадуудын үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах гүүр нь болж ажилладаг байна. Дээрх албадууд нь хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ иргэний эрх, эрх чөлөө, эд хөрөнгийг битүүмжлэх, мөрдөн шалгах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, сэжигтнийг баривчлах зэрэг нь нийгмийн эсэргүүцэлтэй тулгардаг тул цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, ойлгуулах, эрх хэмжээг таниулах, цагдаа иргэдийн харилцаанд онцгой үүргийг хүлээж ажилладаг.

Цагдаагийн олон нийттэй харилцах алба юуны өмнө нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагын зохиож байгаа гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах, тухайн арга хэмжээг тогтмолжуулан үр нөлөөг дээшлүүлэх зэргээр мэргэжлийн удирдлагаар хангах үйл ажиллагаа явуулна.

Цагдаагийн байгууллага нь эрх бүхий албан хаагч өөрийн үүрэгт хамаарах аль чухал ач холбогдолтой асуудлаар хэвлэлийн бага хурал, товч зөвлөгөөн, ярилцлага хийх, цагдаагийн удирдлагатай хэвлэлийн төлөөлөгчийг уулзуулах, тусгай мэдээ бэлтгэж нийтлүүлэх зэргээр холбоо тогтоож хамтын ажиллагааны илүү үр нөлөөтэй арга хэлбэрийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд ашиглана. Цагдаагийн ажлын практикт нийтийн сонирхол татсан асуудлаарх цагдаагийн удирдлагын байр суурийг илэрхийлэх, тодорхой хугацааны үйл явдал байгууллагын ажил шийдвэр шаардсан асуудлын тухай мэдээлэл өгөх зорилготой товч уулзалт хийх, хэвлэл мэдээллийн ажилтнуудад цагдаагийн байгууллагаас зориуд бэлтгэсэн тусгай мэдээлэл материал өгч нийтлүүлэх зэргээр хамтран ажиллах нь бас бий⁸³ гэсэн байна.

Цагдаагийн байгууллагаас үзүүлж буй аливаа үйлчилгээ иргэдийн таашаалд нийцэх, эс нийцэх явдал нь нийгмийн хүрээнд цагдаагийн байгууллагын нэр хүндэд шууд нөлөөлж байдаг. Энэ үүднээс бид “цагдаа-олон нийтийн харилцаа” гэдгийг цагдаагийн байгууллага өөрийн үйл ажиллагаагаа олон нийтэд таниулан сурталчлах мөн үүргээ гүйцэтгэх үедээ олон нийттэй үүсгэж буй харилцаа гэж томъёолох нь зүйтэй юм⁸⁴.

Энэ байдлаас дүгнэж үзвэл цагдаа олон нийтийн хамтын ажиллагаа нь цагдаагийн албаны чиг үүргийн шинжээс гадна түүний үйлчлэх орон зайгаар нь *нэгдүгээрт, хариуцсан нутаг дэвсгэр дээрх цагдаагийн анхан шатны байгууллага, алба хаагчдын (нүүр тулан уулзах) бодит хамтын ажиллагаа; хоёрдугаарт, виртуал орчин буюу сошиал, ОНМХ-ээр дамжуулан харилцах хамтын ажиллагаа* гэж хоёр үндсэн хэсэгт ангилан авч үзэж болно.

Цагдаагийн байгууллагын олон нийттэй харилцах үйл ажиллагааны хэрэгжүүлэх явцын цөм нь анхан шатанд ажиллаж байгаа алба хаагч нар бөгөөд тэр дундаа төв, орон нутгийн хэмжээнд хэсгийн төлөөлөгч, хэсгийн байцаагч, ахлагч бүрэлдэхүүн байдаг.

Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, байцаагч нь цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагаанд онцгой байр эзэлнэ. Тэдгээр нь хүн ам, олон түмэнтэй хамгийн ойр дөт байж, сум, дүүрэг, баг хороо зэрэг захиргааны нэгж, тодорхой объект хариуцан ажилладаг. Оршин суугчид, хэсгийн төлөөлөгч, байцаагчийн ажлаар цагдаагийн байгууллагын

⁸³ Долгорсүрэн, Ж. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. Уб., 2004. 271 дэх тал.

⁸⁴ Отгонсүх, А. Цагдаа-олон нийтийн харилцаа. Уб., 2009. 42, 43 дахь тал.

захиргааны үйл ажиллагааг бүхэлд нь үнэлж дүгнэх нь цөөнгүй, нөгөө талаар тэдгээр нь хүн ам, хамт олон, иргэдийг цагдаагийн байгууллагатай холбогч албан тушаалтан юм⁸⁵.

Зохих хэмжээний мэдээлэлтэй ард түмэн шийдвэр гаргах үед иргэд өөр хоорондоо ямар ч харилцаа холбоогүй ч олон тооны ялихгүй зөрүүтэй саналын үр дүнгээс бүх нийтийн хүсэл зориг бий болдог бөгөөд гаргасан шийдвэр нь ямагт зөв байдаг⁸⁶. Цагдаагийн байгууллага нэг талаас төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй нягт хамтран ажиллахад, нөгөө талаас гэмт хэрэг, нийгмийн хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион явуулахад эрх зүйн бус хэлбэрийг өргөн ашигладаг онцлогтой⁸⁷.

Засгийн газар ба иргэний нийгмийн зохицол гэж бас бий. Ямар Засгийн газартай болохыг иргэний нийгэм сонирхоно. Яагаад гэвэл өөртөө үйлчлүүлэх гэж тэр. Тэгвэл олонх, цөөнх хоёр нь нэгдчихвэл (үнэн хэрэгтээ нэг эвсэл буюу нам болчихвол) улс төрийн битүү цагариг үүсэж хөндлөнгийн хяналтгүй, иргэний нийгэм түүнд нэвтрэх аргагүй болно. Өөрөөр хэлбэл, иргэний нийгэм чинь цөөнхөд тусалж, олонхын дур зоргын ажиллагааг хянаж хязгаарлаж байх ёстой⁸⁸.

Цагдаагийн байгууллагаас олон нийттэй харилцах ажлын үр нөлөөг ярихад зайлшгүй урьдчилан сэргийлэх ажил арга, хэмжээ давхар яригдаж байна. Эрх зүйн дэг журмыг хангах ажлын үр нөлөө нь цагдаагийн албадаас иргэн, байгууллага, аж ахуйн нэгж, нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй нийгмийн хэв журам хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх талаар хамтран ажиллахаас ихээхэн хамаарна.

Цагдаагийн албан хаагч хөдөлмөрийн хамт олны дотор болон хүн амын дунд биеэрээ, эсхүл нийтийн мэдээллийн хэрэгслээр эрх зүйн дэг журам, нийгмийн хэв журам, улс орны аюулгүй байдлыг хангах, өмч хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах асуудлаар хууль, хууль тогтоомжийг тайлбарлан таниулах, сурталчлах ажлыг зохион байгуулна⁸⁹.

Цагдаагийн байгууллагаас олон нийттэй харилцах үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд авч хэрэгжүүлэх нь удирдлагын дэмжлэгээс шууд хамааралтай зүйл юм.

Удирдлагын арга барил, бодлого, шийдвэр нь энэхүү ажлын үр нөлөөнд шууд нөлөөлөх хүчин зүйл тул тогтвортой мэргэшсэн бүтцийг цагдаагийн байгууллагын хэмжээнд байгуулж хэрэгжүүлэх нь үр дүнтэй гэж харж байна.

Мэдээллийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд зорилтод бүлэгт чиглэсэн арга хэмжээг судалгааны үр дүнд авч хэрэгжүүлэх, анхаарлыг татсан контент бүтээх, нийгмийн сүлжээг өргөнөөр ашиглахдаа дээрх зөвлөмжийг мөрдөх нь зүйтэй.

Нийгмийн хөгжлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан цагдаагийн байгууллага цаашдын чиг хандлагаа тодорхойлон үйл ажиллагаагаа үүнд чиглүүлэх нь хамгаас чухал. Мөн үйл ажиллагааны төвлөрлийг саармагжуулах алба хаагч иргэддээ илүү ойр харилцах тийм бололцоо нөхцөлийг бүрдүүлэх, мэдээллийн урсгалыг зөв ашиглах зэргээс ажлын бүтээмж нэмэгдэх, нийгмийн хүлээлтэд хүрэх юм.

Нөгөө талаас цагдаагийн байгууллагын талаарх олон нийтийн ойлголт ямар ажил үүрэг гүйцэтгэж байгаагаас биш харин алба хаагчдын хандлагаас хамаарч бий болдог гэж авч үзэж болно. Алба хаагчдын харилцаа, хандлага хэдий чинээ эерэг түвшинд байна төдий чинээ үйл ажиллагаагаа олон нийтэд ойлгуулах, хүлээн зөвшөөрүүлэх үйл явц хөнгөрнө гэж харж болохоор байна. Сэтгэлгээний өөрчлөлтийг байгууллагын соёлын түвшинд бий

⁸⁵ Долгорсүрэн, Ж. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. Уб., 2004. 110 дахь тал.

⁸⁶ Жан Жак Руссо. Нийгмийн гэрээ. (орчуулгын бүтээл) Уб., 2016. 49 дэх тал.

⁸⁷ Таванжин, Д. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. Уб., 2006. 165 дахь тал.

⁸⁸ Чимид, Б. Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал. Уб., 2008. 235, 236 дахь тал.

⁸⁹ Долгорсүрэн, Ж. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. Уб., 2004. 270 дахь тал.

болгох үйл явцыг үе шаттай авч хэрэгжүүлэх хэрэгцээ өнөөгийн нийгэмд бий болсон асуудал. Албаараа бахархах сэтгэлгээг төлөвшүүлэх, үнэн ч шударга, хуулийн хүрээнд ажил үйлчилгээгээ шуурхай үзүүлэх нь иргэдийн итгэлийг олж авах, цаашлаад төр засгийн зүгээс нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд түлхэц болно.

Орчин үеийн цагдаагийн үйл ажиллагааны шинэ үзэл бодлын гол асуудлууд:

- Гэмт хэрэгтэй тэмцэх шаардлагатайг ард иргэд бүрэн дүүрэн ойлгон ухамсарладаг байх. Ард иргэд болон цагдаагийн ажилтнууд хамтран гэмт хэрэгтэй тэмцэнэ.

- Цагдаагийн байгууллага үйл ажиллагаагаа хэтийн хараатай, өргөн цар хүрээтэй явуулна⁹⁰ гэжээ.

Орчин үеийн цагдаагийн байгууллагын үзэл хандлага ойлголтыг өнөөгийн нийгмийн хөгжилд нийцүүлэн олон нийттэй харилцах үйл ажиллагааны онол, практикт түшиглэн хэрэгжүүлэх нь байгууллагын үнэт зүйлийг бүтээхэд нэлээдгүй нөлөөг үзүүлэхээр байна.

Орчин үеийн цагдаагийн үйл ажиллагааны загварт цагдаа ард иргэд нэг нэгэндээ ойр дөт болдог. Цагдаа ард иргэдийн хоорондын харилцаа шууд харилцан ярилцлагаар тодорхойлогддог. Энд дайсан гэх дүр зураг байхгүй, харин хамтарч ажиллах түншүүдийн уур амьсгал аль алинд нь бий болно.

Гэмт хэргийг бууруулах олон нийтэд тулгуурласан үүсэл санаачилгыг хөгжүүлэхэд шинэ эрч хүч өгөх боловч сайн санаа өвөрлөсөн, итгэл үнэмшилтэй хүмүүс байлаа ч гэсэн шаардагдах хөрөнгө мөнгө байхгүй бол амжилтад хүрч чадахгүй юм. Ийм учраас нутаг дэвсгэрийн цагдаагийн ажилтан болон иргэд, олон нийт өөрсдийн тогтолцоог өргөжүүлэн, дэмжлэг үзүүлэхийн тулд урьдчилан арга хэмжээ авч, шинэ санаа оноог дэвшүүлэх хэрэгтэй юм. Байж болох бүхий л шийдлүүдийг авч үзэх шаардлагатай болно.

Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нь хуульд заасан үндсэн үүрэг боловч энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхэд дан ганц цагдаагийн байгууллагаас бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд учир дутагдалтай юм. Гэмт хэрэг үйлдсэн түүнийг илрүүлэхэд чиглэсэн арга хэмжээ нь урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээс илүү их цаг хугацаа, хүн хүч, зардлыг дагуулдаг.

Цагдаа, олон нийтийн хамтын ажиллагаа нь цагдаагийн албаны чиг үүргийн шинжээс гадна түүний үйлчлэх орон зайгаар нь *нэгдүгээрт*, хариуцсан нутаг дэвсгэр дээрх цагдаагийн анхан шатны байгууллага, алба хаагчдын (нүүр тулан уулзах) бодит хамтын ажиллагаа; *хоёрдугаарт*, виртуал орчин буюу сошиал, ОНМХ-ээр дамжуулан харилцах хамтын ажиллагаа гэж хоёр үндсэн хэсэгт ангилан авч үзэж болохоор байна.

Дүгнэлт. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг олон нийтэд түшиглэсэн, тэдний дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх нь үр дүнтэй бөгөөд төрөөс дээрх үйл ажиллагааг бодлогоор болон мөн төрийн төсөв, мөн гадаад улс орны туршлагаар олон нийт, хувийн хэвшлийн санхүүжилтээр дэмжих нь үр нөлөөтэй юм. Бодит байдал дээр цагдаагийн байгууллагад урьдчилсан сэргийлэх, олон нийттэй харилцах чиглэлээр төсөвт төдийлөн санхүүжилт төсөвлөгдөхгүй байгаа нь дээрх ажлын үр нөлөө буурах нэг үндсэн шалтгаан болж байна гэж үзэж байна.

Ардчилсан төрийн гол шинж нь ил тод, нээлттэй, үнэн зөв мэдээллээр иргэдийг хангах байдаг бол төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага, тэр дундаа цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ олон

⁹⁰ Хоролсүрэн, М. “Орчин үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа”. Орчуулгын бүтээл. Уб., 2010. 23 дахь тал.

нийтгэй харилцах, олон нийтийн дэмжлэгт түшиглэсэн орчин үеийн цагдаагийн байгууллагын төлөвшлийг бий болгох асуудал зүй ёсоор тулгарч байна. Тиймээс цагдаагийн байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ иргэдийн оролцоог хангаж ирсэн түүхэн уламжлал, өнөөгийн эрх зүйн орчинд нийцүүлэн оновчтой PR харилцааг авч хэрэгжүүлэх нь нийгмийн хүлээлт, шаардлага юм байна.

**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ШИНЖТЭЙ ЗӨРЧЛИЙГ ШАЛГАН
ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ**
SOME ISSUES TO BE CONSIDERED IN THE TRIAL
RESOLUTION OF DOMESTIC VIOLENCE VIOLENCES

Д.Нямдорж

ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн
тэнхимийн багш, цагдаагийн хошууч

D. Nyamdorj

Teacher of police Law department, Police school
of University of Internal Affairs, Police maj

Хураангуй. Сүүлийн жилүүдэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдын хамаарал бүхий ойр дотны хүмүүсээс ятгах, үгсэн тохиролцох, дарамтлах зэргээр нөлөөсний улмаас тухайн хүчирхийллийн үнэн бодит байдлыг тогтоох, хүчирхийлэл үйлдэгч этгээдэд хуульд заасан тохирсон шийтгэлийг хүлээлгэхтэй холбоотой зөрчлийг цагдаагийн эрх бүхий албан тушаалтнаас шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудал бий болсоор байна.

Энэхүү илтгэлд гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, түүнийг шалган шийдвэрлэх ажиллагааны өнөөгийн байдал, тулгарч байгаа хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэх арга замын талаар тусгасан болно.

Abstract: En los últimos años, debido a la persuasión, la connivencia y la presión de familiares cercanos de las víctimas de violencia doméstica, ha surgido el problema de investigar y resolver violaciones por parte de agentes de policía autorizados para establecer la verdad de la violencia e imponer el castigo apropiado prescrito. por ley sobre los autores de actos de violencia.

Este informe describe el concepto de violencia doméstica, el estado actual de la investigación, las dificultades enfrentadas y las formas de solucionarla.

Түлхүүр үг: Гэр бүлийн хүчирхийлэл, хохирогч, холбогдогч, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, шуурхай байдлыг хангах, мэргэшсэн алба хаагчийг бэлтгэх, мэргэжлийн удирдлага, шалтгаан нөхцөл.

Key word: Domestic violence, victims, contacts, Violation investigation, promptness, training of qualified officers, professional management, causes.

Үндсэн хэсэг: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхийн тулд хууль түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг түргэн шуурхай шалган шийдвэрлэх ажиллагааг өнөөгийн дэлхийн нийтийн жишиг хандлагад хүргэхийн тулд Монгол Улс түүнийг зохицуулах эрх зүйн шинэтгэлийг эрчимтэй хийсээр байна.

Үүнтэй холбогдуулж зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ямар нэгэн байдлаар алдаа дутагдал гаргахгүй байх, цаашлаад хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, зөрчлийг шалгаж буй эрх бүхий албан тушаалтан үүрэгт ажлаа хуулийн хүрээнд бүрэн дүүрэн хэрэгжүүлэх, орчин үеийн техник технологийн хөгжлөөс хоцролгүй хөл нийлүүлэн ажиллах нь өнөөгийн цагдаагийн байгууллагын анхаарах асуудлын нэг болоод байна.

Цагдаагийн байгууллагад ирүүлсэн гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гомдол мэдээллийг эрх бүхий албан тушаалтан хүлээн авч хэрхэн шалган шийдвэрлэх тухай авч үзэхийн өмнө “Гэр бүлийн талаарх хуулийн ойлголтыг авч үзье.

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуульд:

- “Гэрлэлт” гэж хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёр, сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг;

- “Гэр бүл” гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг;

- “Гэрлэгчид” гэж гэрлэлтээр холбогдсон харилцан тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээх нөхөр, эхнэрийг,

- “Гэр бүлийн гишүүн” гэж гэрлэгчид, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садны хүнийг;

- “Төрлийн хүн” гэж гэрлэгчийн эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, ач хүү, ач охин, зээ хүү, зээ охин, тэдгээрийн хүүхдийг;

- “Садангийн хүн” гэж гэрлэгчийн төрсөн ах, эгч, дүү, авга, нагац, тэдгээрийн хүүхдийг, “Овог” гэж нэг өвөг дээдсээс гаралтай эцгийн талын холбоо бүхий бүлэг хүмүүсийн дунд үе уламжлан хэрэглэгддэг нэрийг;⁹¹ гэж, мөн

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд:

- гэр бүлийн харилцаанд эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд; тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү, Гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд нэгэн адил хамаарна⁹² гэж тус тус томъёолсон байна.

Гэр бүлийн хүндээ гар хүрэх, хүүхээ зодож бие мах бодид гэмтэл учруулах зэргийг л хүчирхийлэл хэмээн нийтлэг үзэх нь саяхныг хүртэл байсан. Гэр бүлийн хүчирхийлэл үнэн хэрэгтээ олон хэлбэрээр үйлдэгддэг аж. Тухайлбал, бие мах бодийн, эдийн засгийн, оюун санааны болон бэлгийн хүчирхийлэл зэрэг хэлбэрүүд байдаг.

Монгол Улс 2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль баталж, 2017 оноос хэрэгжүүлж эхэлснээр энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээлэл ихсэж, илрүүлэлт, шийдвэрлэлт өсжээ. Гэвч гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид дахин ийм зүйл болохгүй хэмээн найдаж, гэр бүлийн харилцаагаа бүтэн авч үлдэхийг хүсэх, үр

⁹¹ Төрийн мэдээлэл. 1999. №30. Гэр бүлийн тухай хууль

⁹² Төрийн мэдээлэл. 2017. №5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

хүүхдээ өнчрүүлэхгүй байх зэрэг шалтгаанаар ихэнх тохиолдолд хүчирхийлэлд өртөж буйгаа нууцалдаг аж⁹³. Хүчирхийлэлд өртсөнөө нууж, тэвчсээр цаг хугацаа өнгөрөх тусам энэ төрлийн гэмт хэрэг зөрчил улам бүр ноцтой болж, улмаар хохирогч амиа алдахад хүрдэг байна. Энэ онд л гэхэд цоожтой хаалганы цаана үйлдсэн гэр бүлийн хүчирхийллийн улмаас найман хүн амиа насаа алджээ.⁹⁴

Сүүлийн жилүүдэд нийгэмд сошиал мэдээллийн хурд нэмэгдэж, төрийн болон төрийн бус байгууллагаас гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр багагүй ажлууд хийсний дунд иргэдийн ойлголт, мэдлэг, хандлага өөрчлөгдөж байна⁹⁵. Энэ хэрээр цагдаагийн байгууллагаас тусламж үйлчилгээ авах хүсэлт болон тухайн төрлийн зөрчлийн талаарх мэдээлэл цагдаагийн байгууллагад тасралтгүй ирсээр байна.

Орон сууц, гэр хороолол хосолсон Чингэлтэй дүүргийг сонгон авч Цагдаагийн байгууллагын Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн “102” тусгай дугаараар дамжуулан ирүүлсэн гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага мэдээллийг сүүлийн 3 жилээр судлан авч үзлээ⁹⁶ Үүнд цагдаагийн эрх бүхий алба хаагчид тухайн дуудлага мэдээллийг газар нь очиж шалгаад шийдвэрлэсэн байдлыг хүснэгтээр авч үзэв.

Огноо	Цагдаагийн 102 тусгай дугаарт хүлээс авсан ГБХ шинжтэй дуудлага мэдээлэл	Давхардсан, гэмт хэрэг зөрчлийн шинжгүй, өөр төрлийн зөрчил байсан тул газар дээр нь торгож шийдвэрлэсэн гомдол	Гомдол мэдээллийн бүртгэлд авч эрх бүхий албан тушаалтан шилжүүлсэн
2021.01.01-нээс 2021.10.25-ны өдрийн хооронд	3827	1152 /30.1%	2675 /69.8%
2022.01.01-нээс 2022.10.25-ны өдрийн хооронд	3426	766 /22.3%	2660 /77.6%
2023.01.01-нээс 2023.10.25-ны өдрийн хооронд	2816	453 /16%	2363 /83.9%
Нийт	10069	2371 /23.5%	7698 /76.4%

Дээрх тоон судалгаанаас авч үзвэл цагдаагийн байгууллагын гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд авч шалгасан нь жил ирэх тусам буурсан эерэг үзүүлэлтийг харуулж байна.

Нийт дуудлага, мэдээллээс гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гомдлыг авч шийдвэрлэсэн байдлыг задлан авч үзвэл⁹⁷

Огноо	Нийт гомдол мэдээлэл	Хүлээн авахаас тагталзаж шийдвэрлэсэн	Өөр төрлийн зөрчил гэж үзэн хялбаршуулсан журмаар торгож шийдвэрлэсэн	Зөрчлийн хэрэг нээсэн	Зөрчлийн хэрэгт шүүхээс баривчлах шийтгэл оногдуулсан байдал	шүүхээс нэмэлт ажиллагаанд буцсан, хэрэгсэхгүй болгосон.
2021.01.01-нээс 2021.10.25-ны өдрийн хооронд	1400	408 /29.1%	853 /60.9%	308 /22%	282 / 20.4%	26 /1.8%

⁹³ Баянмөнх, Б. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа. –Уб., 2018. 22 дахь тал

⁹⁴ [Police.gov.mn.](https://police.gov.mn/) //Татаж үзсэн: 22.11.2023.

⁹⁵ Бямбадорж, Г. Хүчирхийлэл. –Уб., 2014. 22 дахь тал

⁹⁶ Цагдаагийн байгууллагын дуудлага мэдээлэл хүлээн авах ECS программ

⁹⁷ Цагдаагийн байгууллагын мэдээллийн Од программ

2022.01.01-нээс 2022.10.25-ны өдрийн хооронд	1223	412 /33.6%	564 /46.2%	565 /46.1%	518 /42.3%	47 /3.4%
2023.01.01-нээс 2023.10.25-ны өдрийн хооронд	1253	586 /47.7%	344 /27.4%	394 /31.4%	288 /22.9%	106 /8.4%
Нийт	3876	1406 /36.7%	1761 /45.3%	1267 /32.6%	1088 /28%	179 /4.6%

Судалгаанаас харвал:⁹⁸

1. Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гэж өгсөн 10069 дуудлага мэдээлэлд анх очиж газар дээр нь шалгасан авто эргүүлийн алба хаагчид түүний 3876 буюу 38,5%-ийг “Гэр бүлийн хүчирхийлэл” гэсэн ангилалд оруулан, цаашид Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан шийдвэрлэх үндэслэлтэй гэж үзсэн байна.

2. Гэр бүлийн хүчирхийлэл гэж үзсэн 3876 гомдол мэдээллийг эрх бүхий албан тушаалтан хүлээн авч цаашид хуульд заасан хугацаанд Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж 1406 буюу 36,7 хувийг татгалзаж шийдвэрлэсэн нь мөн анхаарал татаж байна. Учир нь анхны мэдээлэлд очсон алба хаагчид “Гэр бүлийн хүчирхийлэл” мөн гэж үзээд цаашид шалгуулахаар шилжүүлсэн байтал “Зөрчлийн шинжгүй гэсэн үндэслэлээр татгалзсан байна.

3. Мөн Гэр бүлийн хүчирхийлэл мөн гэж үзсэн гомдлыг шалгаад 1761 буюу 45,3 хувийг хялбаршуулсан журмаар торгож шийдвэрлэсэн нь мөн анхаарал татаж байна. Учир нь Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн холбогдогчид зөвхөн баривчлах шийтгэлтэй байдаг.

4. Шүүхийн шатанд 179 буюу 4,6 хувийг нэмэлт хэрэг бүртгэлт хийлгэхээр буцаах болох хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Энэ нь мөн нотолбол зохих ажиллагааг бүрэн дүүрэн хийгээгүй байгааг илэрхийлж байна.

Үүний шалтгаан нөхцөлийг тодруулахаар гомдлыг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн материалыг түүврийн аргаар сонгон авч танилцахад, хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд бүрдүүлсэн нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа хангалтгүй, аюулын зэргийн үнэлгээг үнэн зөв гүйцэт бичээгүй, түүнийг нотлох баримтын зэрэгт үнэлүүлэх талаар дурдаагүй зэрэг нийтлэг дутагдалтай байлаа.

Мөн шүүхийн шатанд хэрэгсэхгүй болсон шүүгчийн захирамжтай танилцахад нотлох, цагаатгах баримтыг бүрэн дүүрэн хийгээгүй, гэрч, хохирогч нарт эрх, үүргийг тайлбарлаагүй зэрэг процессын зөрчилтэй байлаа.

Дүгнэлт. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэхэд шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын ажилтнууд нэгдсэн ойлголтгүй, тэдний зан үйл, сэтгэл зүйн онцлогт тохирсон, хэрэгцээнд нь суурилсан арга хэмжээ авахад энэ талын мэдлэг, арга зүй дутмаг байна. Энэ байдал нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа, түүний гаралтад нөлөөлөхөөс гадна хохирогч шаардлагатай тусламж үйлчилгээ авч чадахгүй үлдэх нөхцөл байдлыг үүсгэж байна.

Хүчирхийллийн хохирогч нь бие махбод болон сэтгэл зүйн хувьд ихээхэн хохирол амссанаас шалтгаалан тухайн нөхцөлд өвөрмөц зан үйл, сэтгэл зүйн төлөв байдалтай байдаг нь нарийн мэдрэмжтэй харилцааг шаардаж байна. Иймд тэдэнтэй харилцах, хамгаалах, тусламж үзүүлэх эрх бүхий албан тушаалтан тодорхой мэдлэг, ойлголт, ур чадвар олгох хэрэгцээ бий болж буй юм. Мөн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйл, сэтгэл зүйн онцлогийг

танин мэдэх нь зөвхөн тухайн хүчирхийлэгчтэй ажиллах арга, тактикаа боловсруулахад шаардлагатай байна.

Санал. Дээрх дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага мэдээлэлд анх очсон цагдаагийн алба хаагч нэн түрүүнд гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах буюу бусдын нөлөөнд автахааргүй орчин нөхцөлийг бүрдүүлсний үндсэн дээр гэрч, хохирогч нараас болсон үйл явдлын талаар дэс дараалан мэдүүлгийг тухай орчин нөхцөлд цааргалж хойшлуулалгүй авах.

2. Дуу дүрсний бичлэгээр тухайн нөхцөл байдал орчныг харуулан гэрч, хохирогч, холбогдогч нарын яриа, үйл хөдлөл, мэдүүлэг зэргийг тасралтгүй байдлаар бичиж авч хэргийн материалд хавсаргах.

3. Аюулын зэргийн үнэлгээг бүрэн дүүрэн хийж цаашид авах арга хэмжээ болон ямар нөхцөл байдалтай байсныг дэлгэрэнгүй бичиж үнэлж дүгнэх зэрэг хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд эрх бүхий албан тушаалтан хийгдвэл зохих ажиллагааг хуульд заасан үндэслэл журмын дагуу бүрэн дүүрэн хийж гүйцэтгэсэн тохиолдолд зөрчлийн хэрэг бүртгэлтийн шатанд гэрч, хохирогч нарт бусдын зүгээс нөлөөлөх боломжгүй болно мөн шүүхийн шатанд мэдүүлгээс буцах, аливаа эрх үүргийг нь тайлбарлаж хэрэгжүүлээгүй зэрэг процессын зөрчил дутагдал гарахгүй болсноор хэрэг маргааныг бүрэн шийдвэрлэх боломжтой болно.

Ашигласан материал:

Монгол Улсын хууль

1. Монгол Улсын үндсэн хууль, 1992 он
2. Гэр бүлийн тухай хууль, 1999 он
3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 2016 он
4. Зөрчлийн тухай хууль, 2017 он
5. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017 он
6. Эрүүгийн хууль, 2017 он
7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он
8. Цагдаагийн албаны тухай хууль, 2017 он

Ном, сурах бичиг, гарын авлага

9. Бямбадорж, Г. Хүчирхийлэл, 2014 он
10. Баянмөнх, Б. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа. 2018 он

Цахим эх сурвалж:

1. (police.gov.mn)
2. Цагдаагийн байгууллагын дуудлага мэдээлэл хүлээн авах ECS программ
3. Цагдаагийн байгууллагын мэдээллийн Од программ

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД
ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ
(PROBLEMS IN CONFLICT INVESTIGATING
AND METHODS OF RESOLUTION)**

Б.Батбаяр

*Дотоод хэргийн их сургуулийн ЭЗНУС-ийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш,
цагдаагийн ахлах дэслэгч*

B.Batbayar

*Teacher of the Public Law Department of the
Law School of the University of the Interior,
Senior Police Lieutenant*

Хураангуй: Энэхүү өгүүллээр зөрчлийн тухай хуультай холбогдон үүсэж буй хуулийн хийдэл болон түүнд хяналт тавих хэрэгжүүлэх үүрэгтэй цагдаагийн байгууллагын оролцоо, улмаар ахлагч бүрэлдэхүүн тэдгээрт тулгамдаж буй асуудлын талаар практикт үндэслэн судалгаа хийх, тулгамдаж буй асуудалд үнэлэлт дүгнэлт хийж санал дэвшүүлэхэд оршино.

Abstract: This article aims to examine the legal framework and enforcement mechanisms pertaining to the prevention of corruption, as well as the roles of governmental institutions involved in addressing and resolving issues related to corruption. It necessitates conducting empirical research to substantiate practical implications and conducting evaluations and assessments to provide recommendations for addressing and mitigating the issues at hand."

Түлхүүр үг: Зөрчил, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа

Keywords: Conflict and conflict investigating

Оршил. Зөрчлийн тухай хуулийн дутагдалтай талаас харгалзан авч үзвэл хөөн хэлэлцэх хугацаа богино байгаа нь зарим хөнгөн зөрчил дээр хариуцлага тооцогдохгүй өнгөрөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Түүнчлэн түүнийг хэрэгжүүлэгч гол хууль сахиулах чиг үүрэг бүхий субъект болох цагдаагийн алба хаагчдын зөрчил шалган шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал төдийгүй тэднийг хуульд тусгаагүй хэдий ч практик дээр шийтгэх хуудсаар төгсгөж болох зөрчил дээр ч заавал тэмдэглэл бичихийг шаардах нь хүн хүч дутмаг цагдаагийн алба хаагчдын цаг зав болон олон хүнд хүртээмжтэй ажиллахад саад учруулж байгаа нь учир дутагдалтай байна.


Эдгээр олон шат дамжлагаас үүдэлтэйгээр ард иргэдийн дундах цагдаагийн байгууллага ажлаа хийж чаддаггүй, хүнд сурталтай, ажил хойш татдаг зэрэг сөрөг сэтгэгдлүүд хэдийнээ бидний эчнээ танил үгс болсон нь биднийг хүндлэх хүндлэлийг унтрааж байна гэж үзэж байна.

Судалгааны арга: Судалгааг контент анализ ба асуулгын аргыг ашиглан, дедуктив судалгааны аргын үндсэн дээр суурилж боловсруулсан. Алба хаагчдаас авсан асуулгын судалгааг Google forms ашиглан авсан болно.

Зорилго нь: Алба хаагчдаас ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотой нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Үндсэн хэсэг. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль 2017 онд батлагдах хүртэл зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг БНМАУ-ын АИХ-ын зарлиг, МАХН-ын төв хороо, СнЗ-ийн хамтарсан тогтоол, мөн СнЗ-ийн тогтоол, АДХ, түүний гүйцэтгэх захиргааны шийдвэр⁹⁹, Захиргааны хариуцлагын тухай хууль гэсэн хэм хэмжээний олон актад тусгах байдлаар захиргааны зөрчлийг шийдвэрлэж ирсэн байна

Тухайлбал: Монгол Улсад зөрчил шалган шийдвэрлэх чиг үүргийг цагдаа, хилийн цэрэг, гааль, татвар, монгол банк, санхүүгийн зохицуулах хороо зэрэг олон салбар байгууллага хэрэгжүүлдэг бөгөөд өнөөг хүртэл тэдгээрийн үйл ажиллагааны үндэслэл, журмыг Захиргааны хариуцлагын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Өрсөлдөөний тухай, Гаалийн тухай болон Татварын ерөнхий хууль зэрэг салбарын хуулиар зохицуулан процессын төрөлжсөн хууль байгаагүй нь дээрх баримтаас харагдаж байгаа юм. Гэвч эдгээр төрөлжсөн хуулиудад салбарын хүрээнд үйлдэгддэг зөрчлийг тодорхойлж, улмаар шалган тогтоох, хянан шийдвэрлэх журмыг тухайн салбарын асуудлыг зохицуулсан хуулиар буюу өөр өөр байдлаар хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг төрийн хяналт шалгалтаас ялгаатай байдлаар зохицуулаагүйгээс салбарын онцлог нэрийн дор салбар бүрд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны өөр өөр стандартыг тогтоон хэрэгжүүлж байсныг өөрчлөх зайлшгүй шаардлагыг харгалзан үзжээ.



Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны журам нь салбарын болон байгууллагын эрх хэмжээний хүрээнд батлагдсан журмаар өөр өөр байдлаар зохицуулагдаж байна.

Зөрчлийн хуулийн тухай

⁹⁹ 1923 оны 06 сарын 26-ны өдрийн Засгийн Газрын 18-р хурлаар “Цагдан цээрлүүлснийг зөрчигсдийг яллах хууль” -аар Цагдан сэргийлэх байгууллагад гэмт хэрэг, зөрчилд тохируулан ялгавартайгаар 1-15 төгрөгөөр торгох, мөн 1-15 хоногоор хорих шийтгэл ногдуулах эрх олгож байжээ. Энэ хуулийн “Нийтийн хууль” хэмээх 12 зүйлтэй 1-р бүлэгт зөрчил гаргагчдад ногдуулах 7-н зүйлийн торгууль тогтоож, аливаа хорих шийтгэлийг цагдан сэргийлэх хорооны газарт даалгаад, зөрчил гаргагчидыг хөнгөтгөн үзвэл донгодон шийтгэх тухай болон ялыг хэрхэн гүйцэтгэх зэрэг хуулийг хэрэглэх нийтлэг зүйлийг тухайлан тогтоожээ.

1932 онд “Аливаа торгууль ногдуулах дүрэм”-г баталсан бөгөөд уг дүрмэд урьдах хуулийг бодвол торгууль ногдуулах зөрчил бүхий хэргийг тодруулан зааж, торгуулийн хэмжээг нэмэгдүүлж 40 хүртэл төгрөгөөр торгох болсон байна. Уг дүрмийн нэг онцлог нь торгох шийтгэлийг хэрхэн яаж ногдуулах, түүнийг хэрхэн гүйцэтгэх гэх мэт асуудлыг багтааж байв.

1940 оноос салбарын харилцааг зохицуулсан хуулиудад захиргааны хариуцлага хүлээлгэхээр зааж байв.

/www.google.com/

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдөр УИХ-ийн нэгдсэн хуралдаанаар батлан 2017 оны 07 сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэн. Шинэчлэн найруулсан буюу 2022 оны 04 сарын 13-нд баталсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль нь зөрчил шалгах ажиллагааг салбарын хууль болон байгууллагын эрх хэмжээний хүрээнд батлагдсан журмаар өөр өөр байдлаар хэрэгжүүлж байсныг халж, нэгдсэн стандартаар хэрэгжүүлэх журмыг хуульчилсан, шалган шийдвэрлэх ажиллагааны оролцогч хэн байхыг тодорхойлон зааж тэдгээрийн эрхийг хангах нөхцөлийг бий болгосон зэрэг дэвшилттэй сайн тал байгаа хэдий ч практикт нэгдсэн ойлголт арга зүйд хүрээгүйн улмаас уг хуулийг буруу хэрэглэхээс гадна хуулийн хийдэлтэй¹⁰⁰ байдлыг ашиглан зөрчилд холбогдсон этгээд хууль зүйн хариуцлагаас мултарч байгаа нь судалгааны явцад харагдаж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа гэдэг нь: “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнаас хуульд тогтоосон хугацаанд, зохих журмын дагуу хянан үзэж, шийдвэр гаргах дэс дараалсан үйл ажиллагааг ойлгоно”.

Дэлхийн улс орнуудын практикаас харахад хууль сахиулах үйл ажиллагаа нь нэлээд өргөн хүрээг хамарсан ойлголт бөгөөд үүнийг нийт иргэдэд шууд мэдрэгдэх хууль сахиулах, аюулгүй байдлыг хосолсон шинжтэй үйлчилгээг цагдаагийн байгууллага гүйцэтгэдэг¹⁰¹ байна. Өөрөөр хэлбэл цагдаагийн байгууллагын зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь хууль сахиулах ажиллагааны нэг хэлбэр юм.

Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан дотор хамгийн олон зөрчил өдөр тутам шалган шийдвэрлэдэг цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан онцлох байр эзэлнэ. Гэтэл цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч¹⁰² гэдэгт цагдаагийн чухам ямар албан тушаалтан хамаарах тухай хууль, эрх зүйн актуудад нарийвчлан тусгагдаагүй байгаа нь цагдаагийн алба хаагч бүр зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулж болохоор ойлгогдож байна.

Зөрчил шалгах ажиллагааг зогсоох, түдгэлзүүлэх талаар зохицуулалт байхгүй, хэрэг бүртгэлийн үед холбогдогч оргон зайлах, эрх бүхий албан тушаалтны дуудсан цагт хүрэлцэн ирэхгүй байх тохиолдолд зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацаа дуусахад тухайн зөрчил хэрэгсэхгүй болж гэм буруутай этгээдэд хууль зүйн хариуцлага ногдуулж чадахгүйд хүрч буй асуудал судалгаагаар¹⁰³ харагдаж байна.

График 1. Нийслэлийн хэмжээнд 2023 оны I улиралд бүртгэгдсэн зөрчил, түүний шийдвэрлэлтийн талаар:

¹⁰⁰ Эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдвал зохих нийгмийн зарим харилцааг зохицуулах хэм хэмжээ дутагдахыг хэлнэ.

¹⁰¹ Оюунболд.Г “Хууль сахиулах үйл ажиллагааны шинэтгэл” ” Хууль сахиулахуй” улирал тутмын сэтгүүл УБ., 2014 он №1. 10 дахь тал.

¹⁰² Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйл. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал

6.Дараахь эрх бүхий албан тушаалтан доор дурдсан харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ: 6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, дахь хэсэгт заасан зөрчил;

¹⁰³ Нийслэлийн хэмжээнд нийт 27859-н зөрчил бүртгэгдсэнээс 25007-н зөрчилд торгууль ногдуулсан, 125-н зөрчилд эрх хасч торгосон, 614-н зөрчилд баривчлах шийтгэл оногдуулсан, 2113 зөрчлийг хэрэгсэхгүй болгосон байна. /www.google.com/





График 2. Зөрчлийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрлэлтийн задаргааны талаар:



Хуулийн байгууллагын ачааллыг багасгах зорилгоор зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа өөрийн гэсэн онцлогтойгоор хялбаршуулсан журмаар явагддаг.

Энэхүү ажиллагааг дан ганц бие даасан хуулиар “Беларусь, Польш улс” эсхүл захиргааны зөрчлийн тухай хуулийн нэг хэсэг болон “ХБНГУ, Швейцар, Австри улс болон ОХУ” хуульчилсан байдаг. Харин манай улс эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль батлагдаж 2017 оны 07 сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэх хүртэл Захиргааны хариуцлагын тухай хуулийн¹⁰⁴ нэг хэсэг болгон хуульчилж саяхныг хүртэл уг хуулийн дагуу зөрчлийг шийдвэрлэх процессын үйл ажиллагааг зохицуулж байсан байна.

Асуудал дэвшүүлэх нь

Хууль болон практик хоёрын зөрчилдөөн

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлд зөрчил үйлдэгдсэн нь ил тодорхой, зөрчил, учирсан хохирлыг нотлох талаар зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах шаардлагагүй бол, зөрчил үйлдэгдсэн, учруулсан хохирол нь нотлох баримтаар тогтоогдож холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн бол, зөрчил үйлдсэн болох нь стандартаар баталгаажсан хэмжилт-хяналтын төхөөрөмжөөр нотлогдсон тохиолдолд эрх бүхий албан тушаалтан зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэнэ¹⁰⁵ гэж заасан.

¹⁰⁴ Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хууль. //Төрийн мэдээлэл. 1992 №10

¹⁰⁵ Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль., УБ 2017 он., //Төрийн мэдээлэл №24

Гэтэл практикт хэрэглэхдээ замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлөөс бусад зөрчлүүдэд зөвхөн шийтгэл оногдуулахдаа шийтгэлийн хуудсаар асуудлыг шийдвэрлэх боломж байсаар атал давхар тэмдэглэл хөтөлж байгаа нь нэг талаасаа зөрчил шалган шийдвэрлэх процессын үйл ажиллагааг тодорхой харуулах зорилгыг агуулж байгаа боловч утга нь давхацсан, шат дамжлага шаардсан бланкуудыг¹⁰⁶ бөглөж байгаа нь иргэдэд хүнд суртал үүсгэж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа болхи, алба хаагчдын ур чадвар муу байгаа мэт сэтгэгдэл төрүүлэн хуулийн бодлого, ойлголтыг алдагдуулахад хүргэж байна.


Хуулийн зохицуулалт дутмаг үүднээс хийдэл үүсэх нь

1.Зөрчлийн тухай хуулиар “зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах, Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах”¹⁰⁷ албадлагын арга хэмжээний төрлийг нэмж, зөрчил үйлдсэн этгээд зөрчлийг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой байлгах зорилгоор зохицуулалтыг нарийвчлан тусгасан боловч уг хуулийн тусгай ангид заагаагүй тохиолдолд зөрчил үйлдэх үед хэрэглэгдэж байгаа бараа бүтээгдэхүүн, амьтан, ургамлыг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байгаа нь хуулийн үйлчлэлийг хүчгүйдүүлж байна хэмээн үзэж байна. Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн **7.3 дугаар зүйл**¹⁰⁸ “Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйл тэдгээрийн гаралтай эд зүйлийг зохих зөвшөөрөлгүйгээр улсын хилээр нэвтрүүлсэн тохиолдолд торгоод л өнгөрөхөөс биш тухай зөрчил үйлдэхэд ашиглагдаж буй амьтан ба ургамлыг хураах боломжгүй байна.

2.Түдгэлзүүлэх агуулга бүхий зохицуулалт байхгүйн улмаас зөрчил гаргагч хуулийн байгууллага шалгаж эхэлсэн өдрөөс хойш оргон зайлж зөрчил шалгах хамгийн сүүлийн хугацаа болох 61 хоног өнгөрсний дараа гарч ирэхэд процессын үйл ажиллагаа явуулах боломжгүйн улмаас шийтгэлээс мултрах боломжтой болж байна.

Энэхүү судалгааны үндсэн дээр бид Нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар Багануур гэсэн 4 дүүргүүдийн алба хаагч нарыг дараах судалгаанд хамруулсан.

График 3. Зөрчил шалган шийдвэрлэх явцад дараах тулгардаг талаар:



¹⁰⁶ Улсын Ерөнхий прокурорын 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/54 дугаар тушаалын хавсрал.

¹⁰⁷ Төрийн мэдээлэл. 2017. №24. Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйл.Хөрөнгө, орлогыг хураах, шилжүүлэх, 4.2 дугаар зүйл.Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах

¹⁰⁸ 7.3 дугаар зүйл “Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль зөрчих 1.Монгол Улсын хуулиар ховор, нэн ховор амьтны жагсаалтад ороогүй боловч Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, эсхүл тэдгээрийн гаралтай эд зүйлийг зохих зөвшөөрөлгүйгээр улсын хилээр нэвтрүүлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Судалгааны үндсэн дээр Замын цагдаагийн алба хаагчдын үүрэг гүйцэтгэх үед ашиглаж буй торгуулийн төхөөрөмжөөс хэвлэгдэн гарч буй шийтгэлийн хуудсыг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 194 дугаар тогтоолоор батлагдсан шийтгэлийн хуудасны маягтын загварт нийцүүлэн өөрчлөх. Мөн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацаанд шаардлагатай тохиолдолд тухайн ажиллагааг зогсоодог, түдгэлзүүлдэг байх агуулга бүхий заалтыг нэмж оруулах шаардлагатай гэж үзэж байна.

Дүгнэлт. Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зөвхөн хуульд заасан үндэслэл, журам, арга хэрэгслээр хэрэгжүүлэх, тус ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн эрх зөрчигдөхөөс хамгаалах зорилгоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Өнөөдөр үйлчилж байгаа хуулийн хүрээнд зөрчил шалгах ажиллагааны явцад хүний эрхэнд хязгаарлалт тогтоох ажиллагааг хяналтгүй хэрэгжүүлдэг, иргэдээс зөрчил шалгах ажиллагаанд оролцох, гомдол гаргах журам тодорхойгүй зэрэг олон бэрхшээл үүсдэг байна.

Хуулийн оновчгүй зохицуулалтаас үүдэлтэй дээрх бэрхшээлийг арилгах зорилгоор оновчтой шийдлийг сонгон ерөнхий агуулга, зарчмын хүрээнд “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх үндэслэл, журмыг нэгтгэн тогтоож, хүний эрхийг хууль бусаар хязгаарлахаас хамгаалах хяналтыг өндөржүүлэх, иргэн, хуулийн этгээдээс зөрчигдсөн эрхээ сэргээлэх үр дүнтэй механизмыг тогтоох” зорилгоор хуулийн зохицуулалтыг шинэчлэх шаардлагатай гэж дүгнэж байна.

Санал

1. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацаанд шаардлагатай тохиолдолд тухайн ажиллагааг зогсоодог, түдгэлзүүлдэг байх агуулга бүхий заалтыг нэмж оруулах. /Хугацааг зогсоох/

2. Замын цагдаагийн алба хаагчдын үүрэг гүйцэтгэх үед ашиглаж буй торгуулийн төхөөрөмжөөс хэвлэгдэн гарч буй шийтгэлийн хуудсыг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 194 дугаар тогтоолоор батлагдсан шийтгэлийн хуудасны маягтын загварт нийцүүлэн өөрчлөх.

3. Зөрчлийг газар дээр нь, эсхүл гомдол, мэдээллийг шалгах явцад хялбаршуулсан журмаар шийдвэрлэх үндэслэлийг ялган зохицуулж, хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд тавигдах нөхцөлийг тодорхой болгох. Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа тохиолдолд заавал тэмдэглэл үйлдэхгүйгээр шийтгэлийн хуудсаар асуудлыг шийдвэрлэдэг байх шаардлагатай байна. Хэдийгээр хуульд заавал тэмдэглэл хөтөл гэж заагаагүй ч процедур нь тодорхой бус байгаа нь практикт харилцан адилгүй хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж байна. Ингэснээр ачаалал ихтэй үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн албан хаагчийн¹⁰⁹ нэг хүнд ногдох ажлын ачаалал багасах, шуурхай ажиллах бололцоог бүрдүүлэх нэг үндэс болж болох юм.

4. Зөрчлийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулж байгаа ялгаатай стандартыг өөрчилж, шүүхээр зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааны нэгдсэн журмыг хуульчлан тогтоох

¹⁰⁹ “Цагдаа судлалын төвийн 2013 оны судалгааны тайлан” УБ 2014 он., Эмхэтгэл №1. /судалгаанаас тодорхой харагана/

5. Төрийн алба хаагчийн болон хууль сахиулагчийн шаардлагыг эсэргүүцсэн тохиолдолд зөвхөн торгох бус баривчлах санкцаас сонгож болдог байхаар тусгах

6. Зөрчлийн тухай хуулийн¹¹⁰ “зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хураах, Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах”¹¹¹ гэсэн албадлагын арга хэмжээний агуулгад эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэх үед ашиглагдаж байгаа бүхий л эд зүйл, амьтан, ургамлыг хурааж болохоор өөрчилж өгөх. Эсвэл тусгай ангийн агуулгад байж болох тохиолдол бүрийг хийдэл цоорхойгүйгээр тусгаж өгөх.

Ашигласан материал.

Хууль, эрх зүйн акт

1. “Монгол Улсын Үндсэн хууль”. //Төрийн мэдээлэл №01. 1993.
2. “Захиргааны хариуцлагын тухай хууль”. //Төрийн мэдээлэл №4-5. УБ., 1992.
3. “Монгол Улсын Эрүүгийн хууль”. //Төрийн мэдээлэл №5. УБ., 2002.
4. “Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль”. //Төрийн мэдээлэл №6. УБ., 2002.
5. “Зөрчлийн тухай хууль”. //Төрийн мэдээлэл №24. УБ., 2017.
6. “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”. //Төрийн мэдээлэл №24. УБ., 2017.

Ном, сурах бичиг

1. “Цагдаа судлалын төвийн 2013 оны судалгааны тайлан” УБ 2014 он., Эмхэтгэл №1.
2. Оюунболд.Г “Хууль сахиулах үйл ажиллагааны шинэтгэл” ” Хууль сахиулахуй” улирал тутмын сэтгүүл УБ., 2014 он №1. 10 дахь тал.
3. Даваажав.Б., Эрдэнээ.Х Цагдаагийн байгууллагаас захиргааны зөрчилтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (гарын авлага). УБ., 2015.

Бусад

1. “Цагдаа” (ЦЕГ-ын нийтлэл сургалтын арга зүйн сэтгүүл). №04. УБ., 1992.
2. www.google.com
3. www.legalinfo.mn
4. www.parliament.mn
5. www.moj.gov.mn

¹¹⁰ Төрийн мэдээлэл №24. УБ., 2017 он.

¹¹¹ Монгол Улсын Зөрчлийн тухай хууль. 2017 он.


4.1 дүгээр зүйл.Хөрөнгө, орлогыг хураах, шилжүүлэх

4.2 дугаар зүйл.Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах


Хавсралт

Цагдаагийн алба хаагчаас зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал шийдвэрлэх арга замыг тодорхойлох судалгааны асуулга.


1. Алба хаагчийн ажиллаж байгаа дүүрэг: Баянзүрх дүүрэг болон Чингэлтэй дүүрэг Багануур дүүргийн цагдаагийн хэлтсүүдээс судалгаанд хамрагдсан болно.




2. Та хэдэн настай вэ?




3. Та ахлагч бүрэлдэхүүнд ажиллаад хэдэн жил болж байна вэ?




4. Ажил үүргээ гүйцэтгэж байх хугацаанд дараах бэрхшээлүүдээс аль нь түгээмэл тохиолдож байна вэ?




5. Зөрчил шалган шийдвэрлэх явцад дараах асуудлаас аль нь их тохиолддог вэ?



6. Дараах дуудлага, мэдээллүүдээс аль нь илүү их түгээмэл байна вэ?



7. Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа тохиолдолд заавал тэмдэглэл үйлдэхгүйгээр шийтгэлийн хуудсаар асуудлыг шийдвэрлэдэг байх шаардлагатай гэж та үзэж байна уу?



**ҮЕ ТЭНГИЙН ДЭЭРЭЛХЭЛТЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД
ЭЦЭГ ЭХ, АСРАН ХАМГААЛАГЧИЙН ҮҮРЭГ, ОРОЛЦОО**
**PREVENTING PEER BULLYING DUTIES AND
PARTICIPATION OF PARENTS AND GUARDIANS**

*Цагдаагийн сургуулийн Цагдаагийн
эрх зүйн тэнхимийн багш,
цагдаагийн ахлах дэслэгч
Д.Цэрэнлхам
teacher of the Department of Police
Law at the Police School Senior police
lieutenant D. Tserenlham,*

Хураангуй: Бид аливаа болохгүй асуудлын шалтгааныг ихэвчлэн гадны хүчин зүйлд хамааруулж байдаг. Насанд хүрэгчдийн зүгээс сургууль, гэр бүлийн орчинд хүүхдийг хичээл хийх ёстой, сайн сур гэдэг шаардлагыг маш өндөр тавьдаг боловч бусадтай зөв харилцах, үе тэнгийнхэнтэйгээ хэрхэн зүй зохистой харилцах, зөрчил маргааныг хэрхэн хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх арга замыг заах, эерэг зан байдлыг төлөвшүүлэх тал дээр учир дутагдалтай байдаг.

Хүүхэд наснаасаа найз нөхөд, үе тэнгийнхнээ ойлгож, хүлээн зөвшөөрч, хүндэлж сурах нь ирээдүйд бусадтай зүй зохистой харилцдаг, багаар ажиллах, бусадтай хамтрах чадвартай бие хүн болон төлөвших суурь хандлага нь болох юм. Тиймээс судлаач миний

бие энэхүү өгүүллээрээ дамжуулан үе тэнгийн дарамт, дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэхэд эцэг, эх, асран хамгаалагчдын үүрэг оролцоо чухал болох талаар товч авч үзсэн болно.

Abstract: We often attribute the cause of problems to external factors. Adults set very high requirements that children should study and study well in school and family environment, but they need to teach them how to communicate properly with others, how to communicate properly with peers, how to solve conflicts in a non-violent way, and how to cultivate positive behavior. lacks.

Learning to understand, accept, and respect friends and peers from childhood will become the basic attitude to develop into a person who can communicate appropriately with others, work in a team, and cooperate with others in the future. Therefore, through this article, the researcher has briefly discussed the importance of the role of parents and guardians in preventing peer pressure and bullying.

Түлхүүр үг: Дарамт, дээрэлхэлт, гэр бүл, үүрэг, хариуцлага, оролцоо

Keywords: Pressure, bullying, family, role, responsibility, participation

Үндсэн хэсэг: Боловсрол бол хүний үндсэн эрх төдийгүй бусад эрх, эрх чөлөөгөө эдлэх хамгийн чухал эх сурвалж гэж үздэг.

Боловсрол нь чадавхын эрх болохын хувьд нийгэм, эдийн засгийн хувьд хязгаарлагдмал хүүхдүүд, томчуудад ядуурлаас өөрсдийгөө гаргах, нийгмийн амьдралд бүрэн төгс оролцох арга замаа олох үндсэн хэрэгсэл нь болдог. Боловсрол нь иргэдийг чадавхжуулах, хүнд, хортой хөдөлмөр, бэлгийн мөлжлөгөөс хүүхдүүдийг хамгаалах болон хүний эрх, ардчиллыг хөхүүлэн дэмжих, хүрээлэн буй орчноо хамгаалах, хүн амын өсөлтийг хянахад нэн чухал үүрэгтэй¹¹².

Боловсрол нь төрийн санхүүгийн хөрөнгө оруулалтуудаас хийж болох хамгийн сайн хөрөнгө оруулалтын нэг хэмээн хүлээн зөвшөөрөгддөг. Гэвч боловсролын ач холбогдол нь зөвхөн практик зүйл биш. Чөлөөтэй, өргөн хүрээтэй сэтгэх чадвар бүхий сайн боловсрол эзэмшсэн, идэвхтэй санаа бодолтой хүн л хүн болж төрсний гавьяа, аз жаргалыг мэдэрдэг. Харамсалтай нь ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх мэдлэг, хандлага, ойлголт дутагдсанаар ялгаварлан гадуурхалт бий болж үүнээс үүдэлтэй саад бэрхшээлүүд хүүхдүүдийг амжилттай суралцах, өөртөө итгэлтэй хувь хүн болж төлөвшихөд саад болж цаашлаад сургууль завсардах нөхцөл болж байна. Боловсрол эвслийн хийсэн судалгаагаар¹¹³ жендэрт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, үе тэнгийнхэний дээрэлхэлт нь сургуулиас гарах үндсэн шалтгаануудын нэг болох нь харагдаж байна.

Боловсролын зорилгыг ЭЗНСЭтОУП-д тодорхойлсноор:

- хүүхдийг бие хүн болгон төлөвшүүлэх, авьяас билэг, оюуны болон биеийн чадавхыг бүрэн төгс хөгжүүлэх;
- хүний эрх, үндсэн эрх чөлөө болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэмд тунхагласан зарчмыг хүндэтгэх үзлээр хүмүүжүүлэх;
- эцэг эх, соёл, хэл, үнэт зүйлс, амьдарч байгаа улсынхаа болон төрсөн улс орныхоо үндэсний үнэт зүйлс болон өөрийнхөөсөө ялгаатай соёл иргэншлийг хүндэтгэх үзлийг төлөвшүүлэн хөгжүүлэх;

¹¹² “Бүх нийт боловсролын төлөө” иргэний нийгмийн үндэсний эвсэл., “Үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх аргачлал” УБ., 2020. 9 дэх тал.

¹¹³ “Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд” чанарын судалгаа УБ., 2020.

- харилцан ойлголцол, энхийг эрхэмлэх, хүлцэн тэвчих, эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдал, аливаа ард түмэн, угсаатны болон шашны бүлэг, нутгийн уугуул иргэдийг хүндэтгэх үзлийг хүүхдэд төлөвшүүлж чөлөөт нийгэмд хариуцлагатай амьдрахад бэлтгэх;

- байгаль орчныг хайрлан хүндэтгэх үзлээр хүмүүжүүлэх юм.

Тиймээс боловсролын орчин буюу сургууль айдас, ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс ангид байх ёстой. Нөгөө талаар Монгол улсын хууль тогтоомжид зааснаар боловсролын байгууллага, эцэг эх, асран хамгаалагч насанд хүрэгчид нь хүүхдийг дараах үйлдэл, эс үйлдлээс хамгаалах үүрэг хүлээсэн байдаг. Үүнд: аливаа төрлийн хүчирхийлэл, үл хайхрах, дарамт, мөлжлөг, эрсдэлт нөхцөл, гэмт хэрэг, зөрчил, бие махбодийн шийтгэл, хорт зуршилд өртөхгүй байх зэрэг багтана.

Ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх агуулга нь соёлын, нийгмийн, бие махбодын, эдийн засгийн, улс төрийн болон шашны эх сурвалжтай бөгөөд өөр бусдыг үл хүлцэх нь хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалтын гол эх болдог. Үүнээс урьдчилан сэргийлэхэд хүлээцтэй байдал тэр дундаа хүний эрх, эрхэм чанар, ялгаатай байдлыг хүндлэх, зөрчлийг хүчирхийллийн бус арга замаар шийдвэрлэх чадварыг төлөвшүүлэх цогц, ухаалаг арга зүйг нэвтрүүлэх нь боловсролын салбарын эн тэргүүний зорилт байх ёстой. Бидэнд нийтлэг байдаг ганцхан зүйл бол ялгаатай байдал юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон хүүхдүүдийг ялгаварладаг тогтолцоо нь хэн бүхнийг хүйс, нас, оршин буй газар, ядуурал, нийгмийн статус, үндэс угсаа, харьяалал, хэл, шашин, шилжин ирсэн эсвэл дүрвэсэн байдал, бэлгийн чиг баримжаа, жендэр, шоронд хоригдсон явдал төдийгүй итгэл үнэмшил мөн хандлагаас нь болж гадуурхаж байдаг¹¹⁴.

Энэхүү агуулгыг ТХЗ-ын 4.7-д “Бүх суралцагчдад тогтвортой хөгжил болон тогтвортой амьдралын хэв маягийн тухай боловсрол, хүний эрх, жендэрийн тэгш эрхийн боловсрол, энх тайвныг эрхэмлэх болон үл хүчирхийлэх соёл, дэлхийн иргэн байх болон соёлын олон янз ялгаатай байдлыг дээдлэх хандлагыг түгээх замаар тогтвортой хөгжлийг бий болгох мэдлэг, ур чадварыг эзэмшүүлсэн байна” хэмээн тодорхойлсон билээ.

Гэр бүлийн боловсрол: Үе тэнгийн дарамт дээрэлхэлт нь дан ганц сургууль анхаарал хандуулаад шийдэгддэг асуудал биш юм. Дээрэлхэлтэд өртсөн болон бусдыг дээрэлхэх сөрөг зан үйлтэй сурагчдын гэр бүл, асран хамгаалагчдыг татан оролцуулснаар уг асуудлыг амжилттай шийдвэрлэх боломжтой. Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтийн асуудлыг байх ёстой болон хүүхдийг сэтгэл зүйн хувьд хатуужуулна гэдэг хандлагыг эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс гаргах гээд байдаг. Тиймээс эцэг эх, асран хамгаалагч бүр хүүхдийнхээ сургуулийн амьдралын талаар мэдээлэлтэй байж, санаа тавин, хариуцлагатай хандах үүрэгтэй. Хувь хүн болон гэр бүлийн түвшинд эрсдлийг бий болгож буй хүчин зүйлсийг хүснэгтээр харуулбал: /эдгээр хүчин зүйлс нь дарамт, дээрэлхэлтийг шууд бий болгохгүй ч гэсэн түүнд өртөх магадлалыг нэмэгдүүлдэг байна/

Хүснэгт 1.,

Хувь хүний хүчин зүйлүүд	Гэр бүл, ойрын хүрээллийн хүчин зүйлүүд
- Өмнө нь хүчирхийллийн хохирогч байсан - Анхаарал төвлөрөл сул, хэт хөдөлгөөттэй, эсвэл суралцах идэвхгүй - Бага насандаа түрэмгий зан авир гаргаж байсан - Архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэдэг - Аливаа зүйлд дүн шинжилгээ хийх, үйлдэлдээ дүгнэлт өгөх, хянах чадвар султай - Сэтгэл гутралд орсон - Хүчирхийлэл, зөрчилтэй гэр бүл, орчинд амьдардаг - Нийгмийн хэв журам, эв нэгдлийн эсрэг итгэл үнэмшил, хандлагатай байх	- Гэр бүл нь хүмүүжлийн хатуу ширүүн, эсвэл хэт сул, эсвэл хааяа хатуу, хааяа зөөлөн зэргээр тууштай бус хандлага баримталдаг - Хүүхэд хүмүүжилд эцэг, эхийн оролцоо, анхаарал бага байх - Эцэг, эх асран хамгаалагчид сэтгэл зүйн хувьд хүүхэддээ хайхрамжгүй хандах - Эцэг, эх, асран хамгаалагч нь хүчирхийлэгч байх, гэр бүл доторх үүрэг хариуцлага сул, хүүхдээ харж хандах, зөвлөн дэмжихэд анхаарал бага байх

¹¹⁴ “Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд” чанарын судалгаа УБ., 2020.

- Үе тэнгийнхэний зөрчилдөөнийг шийдэж буй дарамтлуулах, дарамтлах байдлыг хэвийн зүйл гэж үзэх хандлага	- Гэр бүлийн салалт - Эцэг, эхийн хоорондын таарамжгүй харилцаа зэрэг
--	--

Хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах хүчин чармайлт, үйл ажиллагаанд гэр бүл, асран хамгаалагчдыг татан оролцуулах нь чухал.

Гэр бүл нь хүүхэд хамгаалалд гол үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тэд хэн нэгэн хүүхэдтэй зүй бус харьцахаас хамгийн сайн хамгаалах чадвартай. Судалгааны үр дүнгүүдээс харахад сургуулиуд эцэг эх, асран хамгаалагч нарт хүүхдийн хүчирхийлэл, үл хайхралтын талаар боловсрол олговол тэд хүүхдийг урьдчилан сэргийлэх, хамгаалахад хүлээх үүрэг хариуцлагаа бүрэн ухамсарлахад нь тусалж чадна гэдгийг илэрхийлсэн байдаг.

Гэр бүлийн хүмүүжлийн нөлөөгөөр хүүхэд хувийн хяналт сайтай болох боломжтой ба ингэх тусам зүй бус үйлдэл үйлдэх магадлал багасна¹¹⁵. Үүний тулд эцэг, эх, асран хамгаалагч бид үе тэнгийнхэний дундах хүчирхийллийн талаар хангалттай сайн ойлголттой байх шаардлага гарч ирж байна. Судалгааны хэсэг: Дараах судалгаанд нийт 33 эцэг, эх, асран хамгаалагч хамрагдсан байна.

График 1.,



График 2.,



График 1 болон 2-оос үзэхэд судалгаанд хамрагдсдын дийлэнх буюу 70 гаруй хувь нь бакалавр болоод магистрын түвшиний боловсролтой, мөн ажил эрхлэлтийн хувьд 61% нь төрийн албанд ажилладаг байна.

График 3.,






График 4.,



Дээрх судалгааны үр дүнг харахад нийт эцэг, эх асран хамгаалагчдын 50 гаруй хувь нь дарамт дээрлэхэлтийн талаарх ойлголт хангалтгүй, 76% нь дарамт дээрлэхэлтийн талаар заримдаа болон огт ярилцдаггүй гэсэн хариулт өгсөн нь энэ талаарх нөлөөлөл хангалтгүй байгаа нь харагдаж байна. Мөн энэ талаар огт ярилцдаггүй гэсэн 5 хүнээс шалтгааныг асуухад ойлголт байхгүй гэдэг хариулт өгч байгаа нь нөлөөлөл хангалтгүй гэдгийг баталж байна.


График 5.,



¹¹⁵ Осман Долу. Криминологийн онолууд. (Дашбалсрын уулсын бүтээл). УБ., 2022. 164 дэх тал.

Дээрх графикаас харахад судалгаанд оролцогчдын 45% нь мэдэхгүй, 18% нь тийм гэдэг хариултыг өгсөн нь 60 гаруй хувь нь ямар нэг байдлаар дарамт, дээрэлхэлтэд өртөж байгааг харуулж байна. Энэ асуултад тийм гэдэг хариулт өгсөн оролцогчдоос энэ талаар хаанаас мэдсэн талаар асуухад 83% нь хүүхдээс өөрөөс нь гэж хариулсан байна. Эндээс хүүхдүүд энэ талаарх ойлголт, мэдээллийг гэр бүлээсээ бус өөр эх сурвалжуудаас мэддэг, энэ тухай нууж болохгүй гэдэг ойлголтыг авч чадаж байгааг харж болохоор байна.

График 6.,



Хүчирхийлэл бол хувь хүний төрөлхийн шинж чанар гэхээс илүүтэй хувь хүн, гэр бүл, хүрээлэл, нийгмийн хүчин зүйлсийн нөлөөгөөр бий болдог, төлөвшдөг хандлага, зан үйл юм. Хэвшсэн зан үйлийг өөрчилж болохоос гадна сөрөг зан үйлийг хэвшихээс нь өмнө урьдчилан сэргийлэх боломжтой билээ.

Хүчирхийлэл гарахад нөлөөлж байгаа хүчин зүйлсийн нөлөөллөөс хамгаалах үйл ажиллагаа хэрэгжүүлснээр зан үйлийг өөрчилж, улмаар хүчирхийлэл гаргахаас нь өмнө урьдчилан сэргийлж болно. Сургуулийн орчинд гарч буй үе тэнгийнхэний хүчирхийлэлд сургуулийн зүгээс л сахилга, ёс зүйн хүрээнд хариу арга хэмжээ авч байгаа нь хангалтгүй байна. Учир нь сургуулийн зүгээс авч буй арга хэмжээг хүүхдүүд зөвхөн дэг журмын хүрээнд хүлээж авах хандлага илүү байдаг. Харин эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо нэмэгдүүлж дарамт, дээрэлхэлт нь хүчирхийлэл юм гэдгийг бага наснаас нь ойлгуулах, бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, бусдад хүндэтгэлтэй хандах зэргийг суулгаж өгөх нь хамгийн зөв урьдчилан сэргийлэлт болж чадах юм.

Үе тэнгийн дарамт, дээрэлхэлтийн асуудлыг байх ёстой болон хүүхдийг сэтгэл зүйн хувьд хатуужуулна гэдэг хандлага байж болохгүй юм. Тиймээс эцэг эх, асран хамгаалагч бүр хүүхдийнхээ сургуулийн амьдралын талаар мэдээлэлтэй байж, санаа тавин, хариуцлагатай хандах үүрэгтэй.

Дүгнэлт: Сургууль бол зөвхөн эрдэм мэдлэг олж авах, суралцах орчин биш бөгөөд хүүхдүүдийн амьдралын хамгийн чухал, нийгэмших, өөрийгөө илэрхийлэх, хөгжих, оролцох эрхүүдийн нийлбэр цогц юм. Сэтгэл зүй, үе тэнгийн дээрэлхэлттэй холбоотой ямар нэг асуудал үүсэхэд эцэг эх, хүүхэд, залуучуудын хэн нь ч сургуулийн аль ч багшид мэдэгдэж болох бөгөөд ийм нөхцөл бий болгоход идэвхтэй оролцоо чухал юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992
2. Хүүхэд хамгааллын тухай хууль 2016
3. Осман Долу. Криминологийн онолууд. (Дашгаадан.Э. Орчуулгын бүтээл). УБ. 2022
4. Г.Баттулга, Г.Буянтогтох, Д.Мөнхжаргал нар “Өсвөр насны хүүхэд, залуусын дундах дээрэлхэлт, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх модул сургалт” гарын авлага. УБ. 2022
5. “Бүх нийтийн боловсролын төлөө” иргэний нийгмийн үндэсний эвсэл., “Үе тэнгийн дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх аргачлал” гарын авлага УБ. 2020
6. Д.Мөнхцэцэг. “Хүний хөгжил ба сэтгэл зүйн зөвлөгөө” гарын авлага. УБ. 2023

ОЛОН НИЙТИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ОНОЛ ПРАКТИК

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧААС НЭГ БҮРИЙН ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ SOME ISSUES TO BE CONSIDERED WHEN USING SPECIAL TOOLS BY POLICE OFFICERS

Г.Төртүлга

*Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн
багш, цагдаагийн хошууч*

Turtulga Gantumur

*Lecturer of police Law department,
Police school of University
Of Internal Affairs, Police major*

Товч агуулга: Цагдаагийн байгууллагын алба хаагчаас хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нэг бүрийн тусгай хэрэгсэл буюу резинэн бороохой, гавыг хуулийн хүрээнд үндэслэл, журмын дагуу зөрчил, дутагдалгүй хэрэглэх ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарах зарим асуудлыг тусгасан.

Abstract: Some issues to be considered in order to increase the skills of each police officer to use special tools, such as rubber truncheons and handcuffs in accordance with the law, without violations or deficiencies, in the performance of the duties required by the law.

Түлхүүр үг: Цагдаагийн байгууллага, нэг бүрийн тусгай хэрэгсэл, бороохой, гав

Key words: Police organization, each special equipment, batons and handcuffs

Үндсэн хэсэг. Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг гүйцэтгэхдээ нэг бүрийн тусгай хэрэгслийг хууль тогтоомжид заасан үндэслэлийн дагуу албаны үйл ажиллагаандаа ашигладаг. Тодруулбал:¹¹⁶

-Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд:

1.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг гарсан шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгуулах;

2.гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа тухай мэдээллийг хүлээж авах, бүртгэх, олзлох, цуглуулах, олж авмагц таслан зогсоох, учирч болох хор хохирлыг гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээ авах, гэмт хэргийг илрүүлэх;

3.гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг хүлээн авмагц гэмт хэргийн газрыг хамгаалах, үзлэг хийх, нотлох баримт илрүүлэх, бэхжүүлэх, цуглуулах, гэмт этгээдийг олж тогтоох, эрэн сурвалжлах, баривчлах;

4.хуулиар харьяалуулсан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах;

5.хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх ажил явуулах;

6.гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий бусад байгууллагатай хамтран ажиллах;

7.хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, гэмт хэрэг үйлдсэнд сэрдэгдсэн хүнийг эрэн сурвалжлах, баривчлах;

8.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах;

9.шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах;

10.гэмт хэрэг, зөрчил, тэдгээрт шийтгүүлсэн этгээдийн нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, лавлагаа гаргах;

11.гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр судалгаа, шинжилгээний ажилд мэргэжлийн байгууллага, мэргэжилтний туслалцаа авах, татан оролцуулах;

-Нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийн хүрээнд:

1.Зөрчлийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, хуулиар харьяалуулсан зөрчлийг шалгаж шийдвэрлэх, байгууллага, алба хаагчийг мэдээллээр хангах;

2.гудамж, талбай болон нийтийн эзэмшлийн бусад газарт эргүүл хийх, байнгын болон түр ажиллагаатай хянаж-нэвтрүүлэх цэг ажиллуулах дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, бусад арга, техник хэрэгсэл ашиглан хяналт тавих;

3.замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

4.насанд хүрээгүй хүнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

5.гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

¹¹⁶ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухй хууль

6.гэрээт харуулын болон хувийн хамгаалалтын үйл ажиллагаанд хяналт тавих, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;

7.хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад илэрсэн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилгуулах, тэдгээрийг гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор иргэн, хуулийн этгээдэд шаардлага, сэрэмжлүүлэг өгөх, биелэлтийг нь хангуулах;

8.олон нийтийн цагдааг мэргэжил, арга зүйгээр хангах;

-Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд:

1.нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх бүх талын арга хэмжээ авах;

2.эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр жагсаал, цуглааныг албадан тараах ажиллагааг гүйцэтгэх;

3.гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон, аюул үүссэн үед хорио цээрийн дэглэмийг сахиулах, амь нас, эрүүл мэнд нь онц аюултай нөхцөлд байгаа хүнд тусламж үзүүлэх;

4.дипломат төлөөлөгчийн газрыг хамгаалах;

5.шаардлагатай тохиолдолд улсын онц чухал болон хүний амь нас, эрүүл мэнд, байгаль экологийн тэнцвэрт байдалд шууд хохирол учруулах эрсдэлтэй болон гэмт халдлагад өртөж болзошгүй бусад объект, ачаа тээшийг түр хугацаагаар хамгаалах;

6.төрийн тусгай хамгаалалтын хууль тогтоомжид заасан үүрэг гүйцэтгэх;

7.нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал, цуглааны үеийн хамгаалалт хийх;

8.яллагдагч, шүүгдэгч, ялтныг цагдан хорих байрнаас шүүх хуралдаанд, шүүх хуралдаанаас цагдан хорих байранд хуяглан хүргэх гэсэн олон талт үүргийг гүйцэтгэх үедээ цагдаагийн алба хаагч нь нэг бүрийн тусгай хэрэгсэл буюу резинэн бороохой, гавыг түлхүү өдөр тутам биедээ авч явж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Цагдаагийн алба хаагч нь дээрх үүргүүдийг гүйцэтгэх үедээ өдөр бүр бусдын аюул занал, тодорхой эрсдэлтэй учирч, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах нөхцөл байдалтай тулгардаг. Энэ үед цагдаагийн алба хаагч нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх зайлшгүй шаардлага гарч байна.

Цагдаагийн алба хаагч нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэрийг тухайн нөхцөл байдалд тохируулан бие даан гаргана.¹¹⁷

Нэг хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг нэг бүрийн тусгай хэрэгсэл гэнэ. Нэг бүрийн тусгай хэрэгсэлд дараах хэрэгсэл хамаарна гэжээ.¹¹⁸ Үүнд:

-Гав;

-Хүлэг, ороох цамц, хөдөлгөөн хязгаарлах бусад хэрэгсэл;

-Бороохой;

-Цахилгаан гүйдлээр цохигч;

-Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;

-Резин болон хуванцар сумтай буу;

-Нэг бүрийн бусад тусгай хэрэгсэл.

Цагдаагийн алба хаагч үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараах тохиолдолд нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэнэ.¹¹⁹

¹¹⁷ ХЗДХС, УЕП-ын хамтран баталсан 2017 оны А-224/А/102 тушаалын хавсралт “Цагдаагийн алба хаагчийн биений хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 3.3 дахь хэсэг

¹¹⁸ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухй хууль

¹¹⁹ Мөн тэнд

1.Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй халдлагыг таслан зогсоох;

2.Гэмт хэрэг, зөрчлийн үйлдлийг таслан зогсоох, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг баривчлах;

3.Зэвсэглэсэн болон зэвсэг хэрэглэн эсэргүүцэж болзошгүй хүнийг баривчлах;

4.Баривчлагдсан хүнийг эрүүл мэндийн болон холбогдох байгууллагад албадан хүргэх, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх;

5.Хяналтад байгаа хүн амиа хорлох, өөрийн бие махбодид гэмтэл учруулах, оргон зайлахаас урьдчилан сэргийлэх;

6.Сэтгэцийн эмгэг, сэтгэл санаа хүчтэй цочрон давчидсаны улмаас өөрийгөө удирдах чадваргүй, түүнчлэн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүн догшин, хэрцгий авирлаж бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх;

7.Албаны болон бусдын орон байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөнийг бүслэн хаасныг чөлөөлөх;

8.Олон нийтийн арга хэмжээний үед нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тавьсан цагдаагийн алба хаагчийн шаардлагыг биелүүлээгүй;

9.Нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчих, эсхүл нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хууль бус жагсаал, цуглааныг албадан тараах;

10.Тээврийн хэрэгслийг зогсоох эрх бүхий албан тушаалтны шаардлагыг үл биелүүлэн зугтаасан;

11.Хуульд галт зэвсэг хэрэглэхээр заасан бусад

Доор дурдсанаас бусад тохиолдолд жирэмсэн, насанд хүрээгүй, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай, гэмтэлтэй болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүнд нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэхийг хориглоно. Үүнд:

-Цагдаагийн алба хаагч болон бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар зэвсэг хэрэглэн довтолсон, бүлэглэн дайрсан.

-Галт зэвсэг, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох зүйлээр зэвсэглэсэн хүн зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлсэн, эсэргүүцсэн.

-Амиа хорлож болзошгүй бол.

Резинэн бороохой, гав ашиглах арга зүй, эрх зүйн зохицуулалт.

Цагдаагийн байгууллагын алба хаагч нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Цагдаагийн албаны тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтран баталсан 2017 оны А-224/А/102 тоот тушаал “Цагдаагийн алба хаагчийн биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг тус тус эрх зүйн зохицуулалтаа болгон нэг бүрийн тусгай хэрэгслийг ашиглана.

Цагдаагийн алба хаагч нь өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалахын тулд, эсхүл сэжигтэй этгээдийг аюул учруулахгүйгээр хяналтад авахад биеийн хүч хэрэглэх боломжгүй гэж үзсэн бол бие даан шийдвэр гаргаж резинэн бороохойг хэрэглэж болно.

Цагдаагийн байгууллагад дараах төрлийн резинэн бороохойг ашиглаж байна.¹²⁰
Үүнд:

- 80 см урттай хатуу шахмал резинэн бороохой
- 100 см урттай хатуу төмөр голтой резинэн бороохой
- Г хэлбэрийн бариултай шахмал резинэн бороохой
- 80 см урттай үзүүр хэсэгтэй булзуутай, пүрштэй шахмал резинэн бороохой.

Эргүүлийн болон бусад томилгоот үүрэг гүйцэтгэх үед цагдаагийн алба хаагч ихэвчлэн Г хэлбэрийн болон булзуутай резинэн бороохойг үйл ажиллагаандаа ашигладаг. Алба хаагч резинэн бороохойг ашиглахдаа дараах зүйлсийг анхаарвал зохино.

-Бороохойг хүний хувцастай болон нүцгэн биеийн яс, булчин дагуу чиглүүлж ороолгох, цохих, хатгах, бамбай, бусад эд зүйлд цохиж, дуу чимээ гаргах, зэвсгийн чанартай эд зүйлээр довтолсон тохиолдолд хамгаалах зэргээр хэрэглэх.¹²¹

-Бороохойг зайнаас биеийн хөдөлгөөнтэй хослуулан хэрэглэх бөгөөд хэт ойрын зайнаас довтолж буй тохиолдолд гар хөлийн цохилттой хослуулан хэрэглэх.

-Бороохойгоор нэг газарт олон удаа цохихгүй байх, аль болох гэмтэл учруулахгүй байхыг эрмэлзэх.

-Тусгай хэрэгсэл хэрэглэсний үр дүнд дахин тусгай хэрэгсэл хэрэглэх үндэслэл арилсан.

Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж, эсхүл цагдаагийн алба хаагчийн амь бие, эрүүл мэндэд хохирол учруулахаар довтолсноос бусад тохиолдолд хүний толгой, давсаг, бүсэлхий, бөөрний тус газарт цохихгүй байхыг эрмэлзэх.

Цагдаагийн алба хаагч резинэн бороохойг хүний биед хэрэглэхийг зөвшөөрсөн дараах хэсгүүд байна. Тухайлбал:

-Дав хавсарч цохих

-Гарын гурван толгойт булчин, хөлийн гуяны зузаан булчин, шилбэний ард талд байрлах эрээн булчингийн хэсэгт цохиход анхаарах хэрэгтэй. Гэвч дээрх хэсгүүдэд бороохойг хэрэглэхдээ дагууд нь гуядаж, ороолгох маягаар цохино. Харин хөндлөн цохивол хүний биеийн тухайн хэсэгт хүнд гэмтэл учрах магадлал их гэдгийг анхаарах хэрэгтэй.

Цагдаагийн алба хаагч үндсэн чиг үүргээ гүйцэтгэж сэжигтэй этгээдийн үйлдлийг биеийн хүч, тусгай хэрэгсэл ашиглаж амжилттай таслан зогсоосон тохиолдолд тухайн этгээд дахин сэжигтэй үйлдэл гаргахаас урьдчилан сэргийлж гав хэрэглэх шаардлага тулгардаг.

Цагдаагийн алба нь өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан дараах төрлийн гавыг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Үүнд:

- Гарын гав /Бугуй/
- Хөлийн гав /Хөлийн нарийн шилбээр эсхүл өвдөгний дээгүүр туших/
- Хурууны гав /Эрхий хуруу/
- Нэг удаагийн гав /Хуванцар/ тус тус багтана.

Алба хаагч гавыг өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол ашиглах нь элбэг байдаг тул тухайн тусгай хэрэгслийг ямар тохиолдолд хэрхэн хэрэглэх аргачлал болон дадлыг сайтар эзэмшсэн байвал зохино. Товчхондоо нэг талаас хууль дүрэм журамд заасан

¹²⁰ Ш.Чулуун. Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл. УБ.,2015.150 дахь тал

¹²¹ ХЗДХС, УЕП-ын хамтран баталсан 2017 оны А-224/А/102 тушаалын хавсралт “Цагдаагийн алба хаагчийн биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 3.13 дахь хэсэг

үндэслэлийн дагуу хэрэглэх нь чухал ч нөгөө талаас хэрхэн хэрэглэх арга барилд суралцах нь ач холбогдолтой байна.

Цагдаагийн алба хаагч нь ямар төрлийн гав ашиглаж байгаагаас хамаарч тухайн гавыг дараах аргаар хэрэглэсэн байвал зохистой юм.¹²² Үүнд:

-Хурууны гавыг эрхий хурууны 1-р үений хойд хэсгээр, хоёр эрхий хурууг хооронд нь буюу 2 хүний эрхий хурууг хооронд нь холбож биеийн урд нь ба ард нь гавлаж болно.

-Гарын гавыг 2 гарын бугуйн хэсгээр хооронд нь буюу өөр хүнтэй гавлаж болно. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг хуяглан хүргэх үед гарыг нь өөртэйгөө холбож гавлаж болох бөгөөд тээвэрлэх үед гар буюу хөлийг нь автомашины суудал, тэвш, бусад эд зүйлтэй холбож гавлаж болно.

-Хөлийн гавыг хөлийн нарийн шилбээр хөлийг хооронд нь буюу 2 хүний хөлийг холбон гавлаж болно. Мөн үл хөдлөх зүйлээс холбон гавлаж болно.

Гавыг хэрэглэхдээ алба хаагч зарим зүйлсийг анхаарах шаардлагатай байдаг. Гавыг хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учрахааргүй үл хөдлөх зүйлээс түр хугацаанд холбоно. Учир нь холбосон эд зүйлдээ эргэж дарагдах аюултай тул байнгын хараа хяналттай байлгавал зүйтэй. Мөн хүйтний улиралд гавыг гадна орчинд хэрэглэхдээ хүний хөл, гарыг хайрч гэмтээхээс хамгаалах шаардлагатай юм. Гав хүний биед шигдэж орох, чангарах зэргийг анзаарч хянаж байх.

Гав хэрэглэхдээ заавал түгжиж хэрэглэнэ. Зарим тохиолдолд гавыг хүний бугуйнд түгжээгүй орхисны улмаас гав чангарч хүний мах, арьсанд шигдэж, хүний эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэл үргэлж үүсэж байдаг.

Сэжигтэн буюу яллагдагчийг гавлаад дагуулж явахдаа урд нь ба чанх ард нь явж болохгүй зөвхөн баруун зүүн хажууд нь эсвэл баруун хойно нь буюу зүүн хойно нь явах, аль болох аль нэг гараас нь барьж зугтаах болон бүдэрч унахаас хамгаалж явах хэрэгтэй. Энэ нь нэг талаас алба хаагч өөрийн аюулгүй байдлаа хангах нөгөө талаас тухайн этгээдийн амь нас, эрүүд мэндийг учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байна. Гавтай этгээд өөрөө гаваа чангалж судаснуудыг боож үхжүүлдэг тул байнгын хяналттай байх тал дээр анхаарвал зохино.

Гавын бүрэн бүтэн байдал гэдэг бол чухал асуудлын нэг юм. Учир нь гав гацах, шүд нь гажих, зэврэх зэрэг эвдрэл гэмтэл учирсан байж болзошгүй. Иймд гавын бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг шалгах ажлын хүрээнд доорх заалтыг баримтална.¹²³

-Хоёр цагариг, бугуйвч чөлөөтэй эргэж байгаа эсэх

-Цагариг, бугуйвчийн зуух төхөөрөмж бүрэн бүтэн байгаа эсэх

-Түлхүүрийг хийж, цагийн зүүний эсрэг болон цагийн зүүний дагуу эргүүлж, цоожлогч бүрэн ажиллагаатай байгаа эсэхийг тус тус шалгаж үзэх нь зүйтэй.

Дүгнэлт. Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахал 2020-2022 оны сүүл хүртэл дэлхий дахинд тархаж, олон зуун хүний амь нас үрэгдсэн харамсалтай үйл явдал болсон. Тухайн үед бүхий л байгууллагууд хүн хүчний нөөцийн асуудалтай учирч байсны нэг нь мэдээж цагдаагийн байгууллага юм. Энэ үед цагдаагийн байгууллага бүхий л хүн хүчээ хорио цээрийн дэглэм сахиулах үйл ажиллагаанд татан ажиллуулж, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн ажил хоцорч эхэлсэн. Иймд цагдаагийн байгууллага дотоод нөөц бололцоогоо ашиглан алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага дээр нь 2-3

¹²² Ш.Чулуун. Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл. УБ.,2015.144 дэх тал

¹²³ ХЗДХС, УЕП-ын хамтран баталсан 2017 оны А-224/А/102 тушаалын хавсралт “Цагдаагийн алба хаагчийн биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”-ын 3.5 дахь хэсэг

удаагийн элсэлтийг хүлээн авч, цахимаар богино хугацаанд сургалтыг зохион байгуулж дутагдалтай байсан хүний нөөцийн асуудлыг шийдсэн гэж үздэг.

Гэвч цахимаар суралцаж төгссөн залуу алба хаагчид нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх, ашиглах, хадгалах талаар онолын тодорхой мэдлэгтэй боловч ашиглах арга зүй тал дээр алдаа гаргаж эхэлсэн юм.

Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх нь өөрт болон бусдад хохирол учрахаас урьдчилан сэргийлэх арга болж байна.

Мөн албаны нэг бүрийн тусгай хэрэгслийг цагдаагийн алба хаагч бүр хэрэглэх шаардлага тулгарах тул тусгай хэрэгсэл хэрэглэх арга зүйг бие даан болон мэргэшүүлэх сургалтад хамрагдаж хуульч ажиллагааг дээшлүүлэх нь алба хаагч бүрийн заавал эзэмшсэн байх нэг чадвар болоод байна.

Цагдаагийн алба хаагчийн өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол ашигладаг нэг бүрийн тусгай хэрэгсэл нь резинэн бороохой болон гав гэж ойлгож болно. Эдгээр нэг бүрийн тусгай хэрэгслийг алба хаагч бүр өөрийн биеийн нэгэн хэсэг мэт мэдэрч, ашиглаж чадваас өөрийн болон иргэдийн аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой гэж үзлээ.

Санал. Дээрх дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1.Цагдаагийн байгууллагын зарим алба хаагчид Цагдаагийн албаны тухай хууль, ХЗДХС, УЕП-ын хамтран баталсан 2017 оны А-224/А/102 тушаалын хавсралт “Цагдаагийн алба хаагчийн биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам зэрэг холбогдох хууль, дүрэм, журмыг сайтар судлаагүйн улмаас нэг бүрийн тусгай хэрэгслийг буруу хэрэглэж, гэмт хэрэг зөрчилд холбогдох, сахилгын шийтгэл хүлээх тохиолдол гарсаар байгаа тул алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага бүр холбогдох хууль, журамд заасан онолын суурь мэдлэгийг богино хугацааны сургалтаар алба хаагчдад олгож, эзэмшсэн мэдлэгийг биеэр хийж гүйцэтгэх дадлага сургалтаар баталгаажуулан алба хаагчдыг тасралтгүй мэргэшүүлэх сургалт зохион байгуулах.

2.Нэг бүрийн тусгай хэрэгсэлтэй холбоотой практикт гарсан алдаа дутагдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, түүнд тулгуурласан сургалт зохион байгуулах, гарын авлага боловсруулан алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын алба хаагчдад хүргэх.

3.Цахимаар суралцаж төгссөн цагдаагийн алба хаагчдыг биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх талаар мэргэшүүлэх давтан сургалтад үе шаттай хамруулах.

1. Цагдаагийн албаны тухай хууль
2. ХЗДХС, УЕП-ын хамтран баталсан 2017 оны А-224/А/102 тушаалын хавсралт “Цагдаагийн алба хаагчийн биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”
3. Ш.Чулуун. Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл. УБ.,2015

**ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ЗӨРЧИХ
ЗӨРЧИЛД ОНОГДУУЛЖ БУЙ ШИЙТГЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ
VIOLATION OF ROAD SAFETY LAW
ANALYSIS OF PENALTIES FOR VIOLATIONS**

*С.Индра
Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн
тэнхимийн багш, цагдаагийн дэд хурандаа,
хууль зүйн магистр
INDRA.S*

*Lecturer of the Law Department at the Police
School, police lieutenant colonel, master of Laws*

Хураангуй: Хүн төрөлхтний техникийн хурдацтай хөгжил эрэн зууны хандлага Монгол орны хөгжил дэвшил, хүн амын амьжиргааны түвшний дээшилж байгаа зэргээс хамааран сүүлийн жилүүдэд автомашины тоо эрс өсч, хөдөлгөөнд оролцогч болон тээврийн хэрэгслийн тоо хурдацтайгаар нэмэгдэж байна. Нийгмийн хөгжлийн энэ хандлагыг дагаж сөрөг үзэгдэл болох зам тээврийн гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирох болсон нь дэлхий нийтийн анхаарах гол асуудал болсоор байна.

Abstract: The rapid technical development of mankind is a trend of the century, depending on the development of Mongolia and the improvement of the living standards of the population, the number of cars has increased dramatically in recent years, and the number of participants in the movement and vehicles is increasing rapidly. Following this trend of social development, the loss of human life and health due to road traffic crime, which is a negative phenomenon, continues to be the main concern of the world.

Түлхүүр үг: Замын хөдөлгөөн, зөрчлийн тухай хууль, шийтгэл, олон улсын туршлага
Key words: Law of traffic, violation, punishment, international experience

Үндсэн хэсэг. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг осол, зөрчил тогтвортой буурахгүй байгаа, гарч буй хохирлын хэмжээ улам нэмэгдэх хандлагатай болж байгаа нь шийтгэлийн хэмжээ бага, урьдчилан сэргийлэх нөлөөлөл байхгүй, энэ ажлын үр нөлөө хүссэн үр дүнд хүрэхгүй байгааг илэрхийлж байгаа юм. Эрх зүйн шинэтгэл хийж буй өнөөгийн нөхцөлд “Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”, Монгол Улсын Зөрчлийн тухай хууль зэрэг эрх зүйн зохицуулалтыг холбон судалж зарим доголдолтой асуудлыг нээн харуулах, түүнийг даван туулах, боловсронгуй болгож, замын хөдөлгөөний зөрчилд хүлээлгэж буй хариуцлага шийдвэрлэлтийн биелэлтийн өнөөгийн болон цаашдын нөхцөл байдлыг сайжруулах, гадны орны хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээг нэвтрүүлэх шаардлага урган гарч байгааг дурдах нь зүйтэй юм.

Зөрчил хэмээх ойлголт нь улс орон бүрийн эрх зүйн онцлог байдлаас хамаарч өөр өөр агуулгаар тайлбарлагддаг. Гэмт хэргийн нэгдмэл нэг тодорхойлолт байдаггүй улс оронд зөрчил нь хариуцлагын үр дагаврыг үүсгэх бүх салбар эрх зүйд хамаарал бүхий ухагдахуун ба үүнд гэмт хэрэг ч мөн хамаарна. Тухайлбал: Эдгээр улсуудад Англи, АНУ, Франц, ӨАБНУ, Япон, Бразил, Албана, Венесуэль, Аргентин гэх мэт улсууд хамаарна. Ийм

тогтолцоо бүхий улс оронд хариуцлагын үр дагаврыг үүсгэх бүх үйлдлийг нийтээр нь эрх зүйн зөрчил гэх ойлголтод хамааруулдаг ба үүнийгээ гэмт хэрэг хэмээн үздэг.


Эрүүгийн эрх зүйг зохицуулах зүйл, аргын хувьд системчлэгдсэн (Эх газрын систем) ба системчлэгдээгүй (Америкийн систем) гэж ангилна. Эх газрын эрүүгийн эрх зүйг дотор нь зүүний ба барууны гэсэн хоёр чиглэлд авч үзнэ.

Барууны чиглэлд (Франц, Герман, Итали, Ислани зэрэг) гэмт хэргээс гадна захиргааны зөрчлийг (эрүүгийн үйлдэл) эрүүгийн эрх зүйд шууд хамааруулдаг бол зүүний чиглэлд дээрх хоёр үйлдлийг маш хатуу зааглан тус тусад нь ялгаатай авч үздэг. Тухайлбал: ОХУ-ын хувьд гэмт хэргийг нэг категорт ангиллаар авч үздэг тогтолцоонд хамаарах бөгөөд зөвхөн "преступление" буюу гэмт хэрэг гэсэн дан ганц ойлголтын хүрээнд нийгмийн хор аюул, ялын санкцийн хэмжүүрээр дотор нь ангилдаг. Захиргааны зөрчил буюу "Административное правонарушение" гэмт хэргээс зааглан ялгадаг бөгөөд "Кодексу Российской Федерации об административных правонарушениях" буюу "ОХУ-ын захиргааны зөрчлийн тухай кодекс"-оор захиргааны зөрчлийн харилцааг зохицуулдаг.

Манай улсад Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн зөрчилд гудамж замын хяналт шалгалтаас гадна замын хяналтын камер болон цахим дүрс бичлэг ашиглан замын хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавьж гарч болзошгүй осол, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж байна.

Улсын хэмжээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн 6575708 зөрчил илрүүлсэн байна.

График №1 Улсын хэмжээнд бүртгэгдсэн зөрчлийн үзүүлэлт



Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөн 1758613 (67.8%) зөрчлийг гудамж замын хяналт шалгалтаар илрүүлсэн бол 836861 (32.2%) зөрчлийг замын хяналтын камер, дүрс бичлэг болон бусад цахим хэлбэрээр илрүүлсэн байна.

Улсын хэмжээнд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомж зөрчсөн зөрчил өнгөрсөн оны үзүүлэлтээс 673587 нэгжээр буюу 35.1%-иар өссөн байна.


Зөрчлийн тухай хуулийн ерөнхий ангийн нэгдүгээр бүлэг 1.3 дугаар зүйлд Шударга ёсны зарчим; 2 дахь хэсэг Энэ хуульд заасан зөрчил тус бүрт шийтгэл оногдуулна гэж заасан. Хоёрдугаар бүлэг 2.1 дэх хэсэгт Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ. Мөн гуравдугаар бүлгийн 3.3 дахь хэсэгт шийтгэлийн төрлийг тодорхой зааж өгсөн байдаг.¹²⁴

¹²⁴ Төрийн мэдээлэл. 2017. №24. Зөрчлийн тухай хууль

Манай Улс цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд анх 2013 онд бэлэн бусаар торгууль оногдуулж эхэлсэнтэй холбоотой Монгол Улсын Засгийн газрын 2013 оны “Түр журам батлах тухай” 388 дугаар тогтоол¹²⁵, Хууль зүйн сайдын 2015 оны “Журам батлах тухай” А/188 дугаартай тушаал¹²⁶, уг тушаалаар батлагдсан “Бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах журам”, “Зөрчилд оногдуулсан торгуулийн мэдэгдэх хуудас”-ны загварыг мөрдлөг болгон ажиллаж байсан. Улмаар эрүүгийн болон зөрчлийн тухай багц хуулиуд батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Шийтгэлийн хуудасны маягт батлах тухай” 194 дүгээр тогтоолоор батлагдсан журам, маягтын загвар шинэчлэгдэн батлагдаж, батлагдсан загварын дагуу бэлэн бус торгуулийн шийтгэлийн хуудсыг зөрчил гаргасан иргэнд хэвлэж өгөх ажлыг хэрэгжүүлж ирсэн.

Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хууль баталсантай холбоотой уг хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “...болон бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах,” гэснийг хасаж, мөн зүйлийн 8.4.2 дахь заалтыг хүчингүй болсон нь бэлэн бусаар торгосон шийтгэлийн хуудасны загвар, үйл ажиллагааг зохицуулж байсан Хууль зүйн сайдын 2015 оны “Журам батлах тухай” А/188 дугаартай тушаал хүчингүй болох нөхцөл үүссэн бөгөөд энэ журмаар дан ганц Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд заасан зөрчлийг торгох боломжтой байсан зохицуулалт өөрчлөгдсөн.

График №2 Тээврийн хэрэгслийн болон жолоочийн тоон үзүүлэлт



Зөрчлийн мэдээллийн сан цахим хэлбэрээр Замын хөдөлгөөний удирдлагын төвийн Төлбөр хяналтын хэлтэст хадгалагддаг байна. Зөрчлийг баталгаажуулахдаа тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар, өнгө зэргийг сайтар тулгаж нягтлан алдаа дутагдал гаргахгүй байхад анхаарч ажилладаг байна.

Цагдаагийн байгууллагын нийт алба хаагчдын дунд бэлэн бус торгуулийн системийг нэвтрүүлснээр алба хаагчдын ажлын ачаалал, бичиг хэргийн зардал, алба хаагчдад учрах эрсдэл бэлэн мөнгөтэй харьцахгүй болсноор авлига, ашиг сонирхолтой холбоотой гэмт хэрэг, зөрчилд холбогдох эрсдэл багасч, зөрчлийн илрүүлэлт, шийдвэрлэлт нэмэгдэж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа түргэн шуурхай болж, иргэдэд чирэгдүүлэхгүй байх зэрэг эерэг нөлөө үзүүлсэн. Манай Улс сүүлийн 10 жилд тээврийн хэрэгсэл, автомашины тоо 2.8 дахин өссөн ба жилд дунджаар 62.3 мянга орчим автомашин, тээврийн хэрэгсэл

¹²⁵ Монгол Улсын Засгийн газрын 2013 оны “Түр журам батлах тухай” 388 дугаар тогтоол

¹²⁶ Засгийн газрын 2017 оны “Шийтгэлийн хуудасны маягт батлах тухай” 194 дүгээр тогтоол

шинээр нэмэгдэж бүртгэгджээ. 2022 он болон 2023 онд тээврийн хэрэгсэл өнгөрсөн онуудын үзүүлэлтээс 3.1%-иар өссөн үзүүлэлттэй байна.¹²⁷



Замын хөдөлгөөний аюулгүй байдлын шинэчлэн батлагдсан хууль 2015 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. ЗХАБТХуулийн 8.3 дугаар зүйлд Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах болон бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах, зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж заасны дагуу Хууль зүйн сайдын 2015 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/187 тоот тушаалаар Жолоочийн зөрчлийн оноо тооцох журам батлагдан гарсан.


Улсын хэмжээнд 2023 оны байдлаар 249592 жолоочийн зөрчлийн оноо хасагдаж жолоочийн оноо дуусч эрх түдгэлзсэн 4419 жолооч байна. Жолоочийн бүртгэлийн сангаас жолоочийн зөрчлийн онооны төлөв байдлыг авч үзвэл:

Жолоочийн зөрчлийн оноо хасагдсан 321009, зөрчлийн оноо дууссан 1683, урамшуулал олгогдсон 6814, оноо сэргээгдсэн 7530 гэсэн төлөвтэй байна.

Жолооч замын хөдөлгөөнд хамгаалалх бүс, хамгаалалтын малгай хэрэглээгүй замын хөдөлгөөнд оролцож байгаад жолоочийн оноо их хасагдаж нийт хасагдсан жолоочийн онооны 96892 буюу 44.2% нь хамгаалах бүс хамгаалалтын малгай хэрэглээгүй зөрчил эзэлсэн байна.

Монгол Улсад сүүлийн 20 жилийн хугацаанд:¹²⁸

¹²⁷ Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл УБ., 2022, 8 дахь тал



Аливаа улс оронд хууль тогтоомжийн шинэчлэл хийхдээ бусад улс орнуудын туршлагыг судалж алдаа оноог дүгнэх нь зүйтэй. Гэхдээ үүнд шалгуур байх хэрэгтэй. Тухайлбал: харьцуулж болох судлагдахуун, харьцуулах боломжгүй судлагдахуун гэж байдаг. 2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуулийг авч үзвэл эрүүгийн эрх зүйд хамаарах хэм хэмжээ зонхилсон байна гэж олон судлаачид үзэж байна. Эндээс үзвэл хуулийн төслийг боловсруулсан ажлын хэсэг эсхүл хууль тогтоогчид зарим талаараа захиргааны зөрчил гэдгийг АНУ-д байх "жижиг гэмт хэрэг" гэсэн ойлголттой адилтган авч үзсэн байх магадлалтай. Цаашлаад харьцуулан судалсан улс орнуудын эрх зүйн эх сурвалжийг авч үзэхэд хариуцлагын үр дагаврыг хуульчлаагүй хууль гэж байдаггүй ажээ. Чухам ямар үндэслэлээр ийнхүү салбарын хуулиудаас бүх хариуцлагын хэм хэмжээг салган авч төрөлжүүлэн нэгтгэх болсныг үзэл баримтлалын хүрээнд илүү нарийвчлан оновчтойгоор тайлбарлаж чадахгүй байгаагаас үүдэж практикт маргаан өрнөж байна гэж үзэж байна.¹²⁹

Захиргааны зөрчлийн үндсэн шинж нь түүний бүтэцтэй салшгүй холбоотой" ойлголт юм. 2017 онд батлагдсан "Зөрчлийн тухай хууль"-ийн 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх хэсэгт "Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчил гэнэ" хэмээн тодорхойлсон. Захиргааны зөрчил нь онолын хувьд гэмт хэргийн бүтэцтэй яг ижил байдаг. Учир нь захиргааны зөрчил нь эрүүгийн гэмт хэргийн нэгэн адил араасаа хариуцлагын үр дагаврыг үүсгэж байдаг учир заавал хуульд бичигдсэн, мөн түүндээ гэм буруутай байх шинжийг агуулах учиртай.

Захиргааны зөрчлийн эрх зүйд эрүүгийн эрх зүйн адил "nullum crimen, nulla poena sine lege" зарчим үйлчилдэг. Үүнийг бид захиргааны зөрчлийн үүднээс: Хуулиар хориглоогүй бол зөрчил биш бөгөөд шийтгэл хүлээлгэхгүй гэж тайлбарлаж болох юм. Онолын хувьд хуульд заасан байх зарчим таван агуулгыг өөртөө багтаана.¹³⁰

Зөрчлийн тухай хуульд зааснаар "Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн" гэсэн шинж нь зөрчилд тооцогдоход дор дурдсан хэд хэдэн нөхцөл бүрдсэн байх шаардлагатай. Үүнд:

Нэгдүгээрт: Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан ийм үйлдэл, эс үйлдэхүй нь илрэх гадна байдлаараа Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжгүй байх;

Хоёрдугаарт: Тухайн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас учирсан хохирол нь өчүүхэн бага (ялимгүй) учир нийгэмд аюулгүй байх;

Гуравдугаарт: Гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан үйлдэл, эс үйлдэхүйг санаатай хийсэн байх зэрэг болно.

¹²⁸ Монгол Улсад бүртгэгдсэн зам тээврийн осол, гэмт хэрэг зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл 132 тал

¹²⁹ Д.Баярсайхан Харьцуулсан эрүүгийн эрх зүй. -Уб., 2011. 125 дахь тал

¹³⁰ Мөн бүтээл. 189 дэх тал

Үйлдэл гэдэг нь хүний хүсэл зоригийн илэрхийлэл юм. Захиргааны зөрчлийн шинж бүхий үйлдэл гэж хуулиар хамгаалагдсан иргэн, нийтийн эрх, ашиг сонирхолд хохирол учруулсан, эсхүл тийм хохирол учруулах шинжтэй байсан, хуульд шийтгэл оногдуулахаар заасан, субъектын хүсэл зоригийн дагуу хийгдсэн, бүрэн ухамсарлагдсан, ямагт идэвхитэй хөдөлгөөнөөр илрэх хууль бус зан үйл юм. Эс үйлдэхүй гэдэгт тухайн тодорхой нөхцөлд заавал хийх ёстой, хийх боломжтой үүргээ биелүүлээгүй, хүний идэвхгүй зан үйлийг ойлгоно.

Эдүгээ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуульд зөрчил үйлдэгчийн гэм буруугийн талаар зохицуулаагүй. Зөрчил үйлдэгчийн гэм буруу зөрчилд шийтгэл хүлээлгэхэд хамаарах ёстой. Гэм буруу бол хүний ухамсар, хүсэл зоригийн нийлбэр буюу сэтгэхүйн үйл ажиллагааны дотоод мөн чанарыг илэрхийлдэг. Тиймээс гэм буруугийн зарчим бүх зөрчилд үйлчилж хамаарах нь зүйтэй.

Хүснэгт 5. Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 14.7-р зүйлийг Их Британи, АНУ-ын хуулиудтай харьцуулсан судалгаа

Монгол улс	Их Британи улс	АНУ-зарим хот
31.Жолооч замын хөдөлгөөний дүрэмд заасан тээврийн хэрэгслийн хурдыг зөвшөөрөгдсөн дээд хязгаараас 10-50 хүртэл хувиар хэтрүүлсэн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. ¹³¹ 32.Жолооч замын хөдөлгөөний дүрэмд заасан тээврийн хэрэгслийн хурдыг зөвшөөрөгдсөн дээд хязгаараас 50-иас дээш хувиар хэтрүүлсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг зургаан сарын хугацаагаар хасаж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Тогтоосон хурдыг хэтрүүлсэн бол 100 фунтээр торгоно. Мөн торгуулийн 3 оноо нэмэгдэнэ. 3 жилийн дотор 12 оноо цуглуулбал эрх хасагдана. /Хурдны заалт дээр зөвхөн оноо нэмэгдэнэ энэ нь жолоодох эрхийн онооноос тусдаа ойлголт юм/ Хэрэв торгуулиа төлөөгүй тохиолдолд шүүхээр ордог. Мөн хурдаа хэрхэн тохируулж замын хөдөлгөөнд оролцох талаар сургалтад хамруулна.	Тогтоосон хурднаас цагт 10 миль хүртэл хэтрүүлбэл 148 доллар, 30 миль хүртэл хэтрүүлбэл 203 доллар гэх мэт.
22.Тээврийн хэрэгсэл жолоодох үед хөдөлгөөнт утас хэрэглэсэн бол жолоочийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Тээврийн хэрэгслийг жолоодох үедээ гар утсаар ярьсан бол 1000 фунтээр торгох шийтгэл оногдуулна.	Тээврийн хэрэгсэл жолоодож явахдаа утсаар яривал 138 доллароор торгох
23.Жолооч гэрлэн, эсхүл зохицуулагчийн дохиог зөрчин замын хөдөлгөөнд оролцсон бол хүнийг хорин нэгжтэй хэмжээний тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Гэрлэн дохио зөрчвөл 100 фунт торгож 3 оноо хасдаг.	Анх удаа 278 доллар Хоёр дахь удаагаа 463 доллар Гурав дахь удаагаа 1028 доллар Дахин зөрчил гаргасан тохиолдолд эрх хасах арга хэмжээ
20.Замын хөдөлгөөний дүрэмд зааснаар тээврийн хэрэгслийн жолооч, эсхүл зорчигч хамгаалах бүс хэрэглээгүй бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Хамгаалах бүс зориулалтын дагуу зүүгээгүй бол 500 фунтээр торгох арга хэмжээ тооцдог. Энэ нь арын суудалд сууж байгаа хүн бүрд хамаарна.	Хамгаалах бүс зүүгээгүй бол 138 доллароор торгох
1.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/, эсхүл тээврийн хэрэгсэл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн тээврийн хэрэгсэл жолоодсон бол хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 2.Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй /жолоодлогын дадлага хийхээс бусад тохиолдолд/, эсхүл эрх нь дуусгавар	Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон бол 3000 фунтээр торгож, жолоодох эрхийг 1 жилээр хасаж, 6 сар хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож яваад зам тээврийн осол гарган хүний амь, биед хохирол учруулсан бол 5000	Зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэн хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдолд шүүхийн шийдвэрээр дараах шийтгэлийг оногдуулдаг. 1. 48 цагаас 6 сар хүртэл хугацаагаар хорих 2. 390-1000 доллароор торгох

¹³¹ Төрийн мэдээлэл. 2017., №24. Зөрчлийн тухай хуулийн 14 бүлэг 14.7 дахь хэсэг

болсон хүнд тээврийн хэрэгслийн жолоог шилжүүлсэн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 4.Согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн хүнд тээврийн хэрэгслийн жолоог шилжүүлсэн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 5.Жолооч: 5.1.согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон; 5.2.тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон; 5.3.согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.	фунтээр торгож, 14 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	3. Жолоодох эрхийг 6 сараар хасах 4. Жолоодож явсан тээврийн хэрэгсэл нь өөрийн эзэмшил дээр байвал тээврийн хэрэгслийг 6 сараар хураан авч журмын хашаанд байрласан төлбөрийг өөрөөр нь гаргуулдаг байна. 5. Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон дээрх зөрчлийг 7 жилийн дотор давтан үйлдвэл илүү хатуу шийтгэл оногдуулдаг. Үүнээс гадна согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодоход саад хийгээгүй буюу хөхүүлэн дэмжсэн этгээдийг захиргааны хариуцлагад татдаг байна.
37.Замын хөдөлгөөний дүрэмд зааснаар жолооч энэ зүйлийн 35, 36 дахь хэсэгт зааснаас бусад байдлаар тээврийн хэрэгслийг түр, удаан зогсоох журам зөрчсөн бол хүнийг арван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Хориглосон газар тээврийн хэрэгслээ байрлуулсан бол 50-с дээш фунтээр торгох шийтгэл оногдуулна.	Зориулалтын бус газар тээврийн хэрэгслээ байршуулсан бол 115 доллар
48.Замын тэмдэг, тэмдэглэлийн заалтыг зөрчиж зүүн гар тийш эргэсэн, эсхүл буцаж эргэсэн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 50.Энэ зүйлийн 48, 49 дэх хэсэгт зааснаас бусад байдлаар замын тэмдэг, тэмдэглэлийн заалтыг зөрчсөн бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Үргэлжилсэн давхар шугамаар буцаж эргэсэн бол 190 фунтээр торгох шийтгэл оногдуулна.	Давхар зураасаар эргэвэл 150 доллар

Дээрх судалгаанаас үзэхэд Америкийн нэгдсэн Улс болон Их Британи улсуудын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчилд хүлээлгэж буй торгуулийн хэмжээ нь Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 14.7-р заалт буюу Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг тухай хууль тогтоомжид хүлээлгэх торгуулийн хэмжээ буюу 20.000-50.000 төгрөг буюу 5.8-14.7 доллар байгаа нь шийтгэлд хүлээлгэж буй хариуцлага харьцангуй бага байна.

Энэ нь улс орны эдийн засаг, иргэдийн орлогын хэмжээнээс хамаарч харилцан адилгүй байгаа боловч манай улсын хувьд зөрчилд хүлээлгэж байгаа хариуцлагыг нэмэгдүүлж замын хөдөлгөөнд оролцогчдын сахилга хариуцлагыг дээшлүүлж, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, торгуулийн шийтгэлийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага үүсэж байна. Харин ОХУ-ын хувьд сануулах шийтгэл нь Захиргааны зөрчлийн шийтгэлийн төрөлд багтдаг бөгөөд Эрүүгийн холбогдолтой зөрчилд сануулах шийтгэл өгдөггүйгээрээ дээрх 3 улсаас ялгаатай харагдсан.

Торгуулийн шийтгэлийг хэрэгжүүлж байгаа байдлын хувьд дээрх улсууд оногдуулсан торгуулийг заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд төлүүлэх арга хэмжээ эсхүл дараагийн шатны арга хэмжээг авдаг нь ижил төсөөтэй байсан бөгөөд харин авч хэрэгжүүлж

буй арга хэмжээнүүд нь ялгаатай байсан юм. ХБНГУ-ын хувьд болгоомжгүйгээр үйлдэгдсэн зөрчилд санаатайгаар үйлдсэн зөрчилд оноож байгаагаас бага дүнгээр торгууль оногдуулахыг хуульчилсан байх бөгөөд торгууль төлөгч этгээд эдийн засгийн боломжгүй тохиолдолд тодорхой хугацаанд хуваан төлж болох ба хугацаандаа төлж чадаагүй тохиолдолд уг эрхийг цуцлах арга хэмжээг авдаг байна.

ОХУ-ын замын хөдөлгөөний зөрчил гаргагчдыг торгуулиа сайн дураараа заасан хугацаанд төлүүлэхийн тулд өгдөг боломж болох захиргааны шийтгэл ногдуулсан шийдвэр гарснаас хойш 20 хоногийн дотор торгуулиа төлсөн бол оногдуулсан торгуулийн хагастай тэнцэх хэмжээний мөнгөн дүнгээр торгууль төлөх боломжийг олгосон нь авууштай санагдсан.

Дүгнэлт. Зам хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн зөрчлийн өнөөгийн байдал, зөрчил гарахад нөлөөлсөн хүчин зүйлийг бууруулах, зам тээврийн осол, зөрчлөөс урдчилан сэргийлэх чиглэлээр гадаадын зарим оронд нэвтрүүлж буй хариуцлагын туршлагауудыг авч үзээд дараах дүгнэлтийг хийж байна.

Дэлхий дахинд замын хөдөлгөөний бодлого, зорилтыг тодорхойлж хэрэгжүүлэхдээ жолоочийн хурд хэтрүүлэхгүй байх ёс зүй, ухамсар, боловсролд чиглэсэн арга хэмжээг цагдаагийн хяналттай хослуулах, тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах болон хянах, инженерийн буюу зам барилга байгууламжийн бүтцэд чиглэсэн зохион байгуулалт, шийдэлд анхаарах мөн замын хөдөлгөөнд оролцогчийн соёлд түлхүү анхаарч, соёлжуулахад чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ зэргийг зохион байгуулах нэн тэргүүний шаардлага тулгарч байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг осол, зөрчил тогтвортой буурахгүй байгаа, гарч буй хохирлын хэмжээ улам нэмэгдэх хандлагатай болж байгаа нь шийтгэлийн хэмжээ бага, урьдчилан сэргийлэх нөлөөлөл байхгүй, энэ ажлын үр нөлөө хүссэн үр дүнд хүрэхгүй байгааг илэрхийлж байгаа бөгөөд зам тээврийн осол, зөрчлийн шалтгаан нөхцөлийг зөв тодорхойлж, түүнд чиглэсэн урьдчилан сэргийлэх оновчтой арга замыг эрэлхийлэх шаардлага бйгааг харуулж байна.

Гадаадын зарим орны туршлагаас судлахад олон төрлийн шийтгэлийн терлийг ашиглаж байгаа нь оновчтой байна. Зарим төрлийн зөрчилд шийтгэлийн аюулын нөхцөл байдлыг судалж, түүнд тохирсон багц шийтгэлийг ногдуулах талаар тусгаж өгөх

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Тухайн жилд зам тээврийн осол, зөрчил гаргаагүй жолооч нарыг урамшуулж байх. Тухайлбал: замын татвар, хураамж, жолоочийн хариуцлагын даатгалын хураамжаас чөлөөлөх, хөнгөлөлт үзүүлэх, автомашины хүүхдийн суудлыг хөнгөлөлттэй үнээр олгох, автомашины засвар үйлчилгээний байгууллагатай хамтран ажиллах;

Тухайлбал: тээврийн хэрэгслийн тос, тосолгоо, компьютер оношилгоо, дугуй засвар гэх мэт. Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг авто засварын үйлчилгээ явуулдаг байгууллагуудтай хамтран урамшуулах аяныг зохион байгуулснаар байгууллага болон жолооч, жолоочдоо нөлөөлөхөд чухал ач холбогдолтой.

2. Цагдаагийн алба хаагчдын хүний нөөц дутмаг байгаатай холбоотой цагдаагийн байгууллагаас зам тээврийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр маш олон төрлийн нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж байгаа боловч зам тээврийн осол, зөрчил, түүнээс үүдэлтэй нас баралт, гэмтэл, хохирлыг бууруулах талаар үр дүнд хүрэхгүй байна. Иймд иргэд, олон нийтийн оролцоог зам тээврийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол, давтамжтай зохион байгуулах

зорилгоор цагдаагийн байгууллагад сайн дурын ажилтныг тодорхой хөтөлбөрийн дагуу сургалтад хамруулан гудамж, замд үүрэг гүйцэтгүүлэх.

3. Зам тээврийн осол, хэрэг, зөрчил үйлдсэн жолооч нарын судалгааг жолооны курсийн харьяаллаар гаргаж, олон нийтэд мэдээлэн, сургалтын чанарыг сайжруулах талаар албан мэдэгдэл, шаардлага өгч, хариуцлага тооцож байх зэрэг болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

1. Зөрчлийн тухай хууль
2. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
3. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны “Түр журам батлах тухай” 388 дугаар тогтоол
4. Засгийн газрын 2017 оны “Шийтгэлийн хуудасны маягт батлах тухай” 194 дүгээр тогтоол
5. Д.Баярсайхан. Харьцуулсан эрүүгийн эрх зүй Уб., 2011 он
6. Зам тээврийн ослын өнөөгийн байдал. ҮСХ/. Уб., 2022 он
7. Төрийн мэдээлэл 2018 он
8. Төрийн мэдээлэл 2019 он

ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ROAD SAFETY ANALYSIS OF THE CURRENT SITUATION

М.Ринчинбу

*ТЦА-ны ЗЦГ-ын Замын хөдөлгөөний удирдлагын хэлтсийн
Цахим зөрчил хөдөлгөөнт эргүүлийн тасгийн зохицуулагч,
магистрант, цагдаагийн ахлах дэслэгч*

Хураангуй: Энэхүү сэдвийн хүрээнд Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал, чиг хандлага, түүнийг хангахад тулгамдаж буй асуудлыг нээн илрүүлж, гадаадын зарим орны туршлагыг харьцуулан судаллаа.

Abstract: Within the framework of this topic, the current situation and trends of road safety in Mongolia, the problems faced in ensuring it were discovered, and the experiences of some foreign countries were compared.

Түлхүүр үг: замын хөдөлгөөн, аюулгүй байдал, нөхцөл байдал, чиг хандлага, тулгамдсан асуудал.

Key words: raffic, safety, conditions, trends and issues.

Удиртгал. Дэлхий даяар өдөр бүр 3500, жил бүр 1.3 сая орчим хүн нас барж, 50 сая орчим хүн гэмтэж бэртэж, дэлхий даяар хүүхэд, залуучуудын амь насанд аюул учруулж байна гэх судалгаа байдаг. Энэ нь ойрын арван жилд, ялангуяа бага, дунд орлоготой орнуудад 13 сая хүн нас барж, 500 сая хүн гэмтэж бэртэх магадлалтай байна¹³². Эдгээр нь үнэмлэхүй болон харьцангуй утгаараа хүлээн зөвшөөрөгдөхгүй тоо юм. Хэдийгээр эдгээр нас баралт, гэмтэл бүрээс урьдчилан сэргийлэх боломжтой ч зам тээврийн осол дэлхийн хэмжээнд нас баралтын гурав дахь гол шалтгаан болж байна.

Автомашин зохион бүтээснээс хойш дэлхий дээр 50 сая гаруй хүн зам дээр нас барсан. Энэ нь Дэлхийн нэгдүгээр дайн эсвэл хамгийн аймшигтай тахал өвчний үед нас барсан хүний тооноос ч илүү юм. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас 2021 онд гаргасан мэдээгээр дэлхий дахинд зам, тээврийн ослын улмаас жилд 1.24 сая хүн амь насаа алдаж, 50 гаруй сая хүн бэртэж, гэмтэн хөгжлийн бэрхшээлтэй болж байгаагийн дотор 15-29 насны хүүхэд, залуучуудын үхлийн үндсэн шалтгаан нь зам тээврийн осол болж байна гэж тэмдэглэсэн. Монгол Улсад гарч байгаа нийт осол, гэмтлийн 20.6 хувийг зам тээврийн осол эзэлж байна. Тээврийн хэрэгслийн тоо жил бүр тогтмол өсч, сүүлийн 10 жилд 4 дахин нэмэгдсэн байна¹³³.

Үндсэн хэсэг. Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 1-д заасан “Амьд явах эрхтэй; 2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 2.1-т замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль, захиргааны хэм хэмжээний актаас бүрдэнэ гэж заасан. Эдгээр заалт нь иргэдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчил, ослоос ангид байж эрүүл, аюулгүй

¹³² Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тайлан. 2021.

¹³³ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан ном. УБ. 2021 он. 1 дэх тал.

орчинд амьдрах, хамгаалуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн гол эрх зүйн зохицуулалт юм. Уг хууль нь замын хөдөлгөөний зохион байгуулалт, зам тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эрх ашгийг хамгаалахад чиглэгдэж, 2015 онд шинэчлэн батлагдсан.

Өнөөгийн нийгэмд хамгийн их эрсдэл учруулж байгаа зүйл бол авто машины осол, аваар бөгөөд зөрчил гарахад согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, хамгаалалтын бүс, малгай, аюулгүйн бүс хэрэглэхгүй байх, хурд хэтрүүлэх, гар утсаар ярих, нүүрээ будах /эмэгтэйчүүд/, тамхи асаах, хүүхэдтэйгээ зууралдах зэргээр анхаарал сарнихад жолоочийн хөдөлгөөн удаашрах, гэрэл дохио анхаарахгүй, эгнээ байр эзлэхдээ бусдыг анзаарахгүй байх, хажуу хоорондын зайг тохируулахгүй байх нь жолоочийн ур чадварт шууд нөлөөлж, зам тээврийн осол гардаг. Мөн зам тээврийн ослын шалтгаан нь замын нөхцөл байдал, тээврийн хэрэгслийн эвдрэл гэмтэл, жолоочийн буруугаас, орчны нөлөөлөл гэсэн зүйлүүдээс хамааралтай.

Дэлхий дахинд хүн амын нас баралтын найм дахь шалтгаан нь зам тээврийн осол гэж Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тодорхойлон авч үзсэн бөгөөд нийгэмд нөхөж баршгүй, ноцтой байдлаар нөлөөлдөг эд материалын болон эдийн бус хохирол учруулж, нийгэм, соёл, эдийн засагт ноцтой нөлөөлдөг¹³⁴.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) 2016 оны мэдээгээр дэлхий даяар 1.35 сая орчим хүн зам тээврийн ослоор амь насаа алдсан бөгөөд хөгжиж буй орнуудад зам тээврийн осол нь эзлэх хувь 80 орчим хувь, хөгжингүй орнууд 7 хувь байна. Түүнчлэн осол, аваар нь 2030 он гэхэд дэлхийн хүн амын нас баралтын тав дахь шалтгаан болно гэж таамаглаж байна¹³⁵.

Зам тээврийн осол, зөрчил гарахад жолоочийн буруутай үйлдлүүдийн гол шалтгааны нэг нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрмийг зөрчих, захирагдахгүй байх явдал байдаг. Тухайлбал, замд улаан гэрлээр зорчих, хурд хэтрүүлэх, тээврийн хэрэгслийн бүсээ зүүхгүй байх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зэрэг зөрчлүүдийг үйлдсээр байна. Тиймээс замын хөдөлгөөний дүрэм, журмыг дагаж мөрдөх асуудалд анхаарал хандуулах нь иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн чухал арга замуудын нэг юм.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчил, ослын өнөөгийн байдал¹³⁶.

Аймаг, дүүрэг	2016	2017	2018	2019	2020	2021	2022
Улаанбаатар	1080168	1078800	1230074	1659618	1580126	1489089	2012191
Орон нутаг	248392	245757	401922	548059	478221	432798	583283
Улс	1328560	1324557	1631996	2207677	2058347	1921887	2595474

Хүснэгт 1. ЗХАБ-ын хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн үзүүлэлт

Улсын хэмжээнд 2016 онд 1328560 зөрчил бүртгэгдсэн бол 2020 онд 2058347, 2021 онд 1921887 зөрчил бүртгэгдсэний 1489089 буюу 77.5 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил өнгөрсөн оны үеийнхээс

¹³⁴ Баасансүрэн, Д. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчилд хүлээлгэх хариуцлага, түүнд хийсэн шинжилгээ. УБ., 2023 он.

¹³⁵ Pompili, M., Serafini, G., Innamorati, M., Montebovi, F., Palermo, M., Campi, S., Stefani, H., Giordano, G., Telesforo, L., Amore, M. and Girardi, P. (2012) "Car accidents as a method of suicide: A comprehensive overview", Forensic Science International, Vol. 223, No. 1–3, pp. 1-9. Doi: 10.1016/j.forsciint.2012.04.012.

¹³⁶ Монгол Улс дахь Зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл. УБ., 2020 он.


136460 нэгж буюу 6.6%-иар буурсан. Гэхдээ сүүлийн 5 жилийн үзүүлэлтийн дундаж буюу 2016 оны үзүүлэлтэй харьцуулан үзэхэд өссөн байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийн өнөөгийн байдал, зөрчлийн өсөлт бууралтыг дараах хүснэгтээр

Аймаг, дүүрэг	2016	2017	2018	2019	2020	2021
Улаанбаатар	1080168	1078800	1230074	1659618	1580126	1489089
Орон нутаг	248392	245757	401922	548059	478221	432798
Улс	1328560	1324557	1631996	2207677	2058347	1921887

Хүснэгт 2. ЗХАБ-ын эсрэг зөрчлийн үзүүлэлт

Улсын хэмжээнд 2016 онд 1328560 зөрчил бүртгэгдсэн бол 2020 онд 2058347, 2021 онд 1921887 зөрчил бүртгэгдсэний 1489089 буюу 77.5 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил өнгөрсөн оны үеийнхээс 136460 нэгж буюу 6.6%-иар буурсан. Гэхдээ сүүлийн 5 жилийн үзүүлэлтийн дундаж буюу 2016 оны үзүүлэлтэй харьцуулан үзэхэд өссөн байна. Үүнээс орон нутагт гарч байгаа замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийг дараах графикаар харуулъя.



Зураг 1. ЗХАБ-ын эсрэг зөрчлийн сүүлийн 5 жилийн үзүүлэлт

Графикаас харахад орон нутагт 2018 онд улсын хэмжээнд 1631996 зөрчил бүртгэгдсэнээс нийслэлд 1230074 зөрчил бүртгэгдсэн нь 2022 онтой харьцуулахад улсын хэмжээнд 2595494 зөрчил бүртгэгдсэн нь тус оноос 60 орчим хувиар өссөн үзүүлэлтэй байна. Мөн 2019 оноос зөрчлийн үзүүлэлт буурсан нь ковид цар тахлын хорио цээрийн дэглэмтэй холбоотой буурсан байх магадлалтай юм. Гэсэн хэдий ч замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчлийг бууруулахад урьдчилан сэргийлэх ажил хэрхэн нөлөөлсөн, Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл үр нөлөө үзүүлж буй эсэхийг судлах хэрэгцээ шаардлага байсаар байна.

Монгол Улсад “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай хууль” 1996 онд анх батлагдсанаас хойш 20 жилийн дараа буюу 2015 онд 7 бүлэг, 55 зүйлтэйгээр батлагдсан бөгөөд тус хуулиар замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил, түүнд хүлээлгэх шийтгэл, жолоочийн бүртгэлийн оноо зэргийг шинэчлэн тусгаж өгсөн¹³⁷. Жолоочийн бүртгэлийн оноо тооцох асуудал нь жолоочийн хариуцлагыг нэмэгдүүлэх, дахин зөрчил гаргахгүй байхад чиглэж, хариуцлагын үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн¹³⁸.

¹³⁷ Төрийн мэдээлэл. Эмхэтгэл. УБ. 2015. №28.

¹³⁸ Зөрчлийн бүртгэлийн оноо тооцох журмын төслийн танилцуулга 2015 он УБ. Жолоочийн бүртгэлийн оноо тооцох журам 2015 он УБ.

Монгол Улсад сүүлийн 5 жилийн тээврийн хэрэгслийн тоо болон жолоочийн тоон үзүүлэлтийг дараах хүснэгтээр үзүүллээ.

Он	Тээврийн хэрэгслийн тоо	Өсөлт, бууралт	Жолоочийн тоо	Өсөлт, бууралт
2020	1137208	9	1335000	5.4
2019	1043028	7.4	1265544	4.7
2018	970880	7.8	1207690	4.6
2017	900127	6.9	1153621	5
2016	841537	-	1098638	-

Дээрх хүснэгтээс харахад 2016 онд тээврийн хэрэгсэл 841537 байсан бол 2020 онд 1137208 буюу 35.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн 2016 онд жолоочийн тоо 1098638 байсан бол 2020 онд 1335000 байсан нь 21.5 хувиар өссөн байгаа нь зөрчлийн гаралтад шууд нөлөөлж байна.

Дээрх нөхцөл байдлыг судалж үзэхэд замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчилд хүлээлгэж буй зөрчилд хүлээлгэж буй хууль зүйн хариуцлагыг улам нэмэгдүүлсэн хэдий ч зөрчил жилээс жилд нэмэгдэж байна. Тиймээс Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл нь жолоочид хэрхэн нөлөөлж, хариуцлагыг нэмэгдүүлэх, эрх зүйн ухамсарт нь нөлөөлж байгаа эсэхийг судлах нь зайлшгүй шаардлагатай юм¹³⁹.

Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас баталсан 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилтод 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 25 хувиар, зам тээврийн ослын нас баралтыг 50 хувиар бууруулах зорилт дэвшүүлэн осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулахыг улс орнуудад уриалсан байдаг.

Үүний хүрээнд манай улсад “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2019-2023)”-г боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа юм.

Зам тээврийн осол, гэмтлийн гол хүчин зүйл нь тээврийн хэрэгслийн хажуу хоорондын зай тохируулаагүй (43,4 хувь), уулзвар, гарц нэвтрэх журам зөрчсөн (15,3 хувь) зөрчил болж байгаагаас гадна хурд хэтрүүлснээс шалтгаалсан ослын тоо 19,9 хувиар нэмэгдсэн, мөн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зохицуулж байгаа хууль, дүрэм, журам, стандартын биелэлт хангалтгүй, хот төлөвлөлт өнөөгийн шаардлага хангахгүй, тээврийн хэрэгслийн парк хэт хуучирсан, хөдөлгөөнд оролцогчдын соёл дутмаг, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах байгууллагуудын ажлын уялдаа хангалтгүй зэрэг дутагдлууд байгаа нь судалгаагаар тогтоогдсон тухай Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан номонд дурдсан байдаг. Тээврийн цагдаагийн албаны 2021 оны тайлангаас харахад осол хэргийн 97,8 хувь нь жолоочийн буруугаас шалтгаалсан байна¹⁴⁰ гэж үзсэн байх бөгөөд дээрх зам тээврийн осол гаргасан жолоочийн 34 хувь нь 5 жил хүртэл автомашин жолоодсон байгаа нь 100 жолооч тутмын 34 нь гэсэн үг юм. Эдгээр жолооч нарын буруугаас жилд 304 хүн амь насаа алдаж байгаа нь замын хөдөлгөөнд оролцогчийг бага наснаас нь бэлтгэх, жолооч бэлтгэх үйл ажиллагааг цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатайг харуулж байна.

Судалгаанаас үзэхэд зам тээврийн ослын хоёрны нэгд зам тээврийн сүлжээ, замын нөхцөл ямар нэг байдлаар нөлөөлж байна гэх дүгнэлт гарсан байдаг. Сүүлийн 10 жилийн хугацаанд тээврийн хэрэгслийн өсөлтөөс үүдэлтэй хөдөлгөөний саатал 5 дахин

¹³⁹ Баасансүрэн, Д. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчилд хүлээлгэх хариуцлага, түүнд хийсэн шинжилгээ. Уб., 2023 он.

¹⁴⁰ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан ном. Уб. 2021 он. 15 дахь тал.

нэмэгдсэнээс гадна түгжрэл саатлаас үүдэлтэй иргэдийн бухимдал эрс нэмэгдсэн байна. Эрдэмтдийн тооцоолж байгаагаар 1кв.км газар нутагт ноогдох замын урт 0,3 км-ээр багасахад замаас үүдэлтэй нас баралтын тоо 15 хувь нэмэгддэг гэж үзсэн бөгөөд суурин газрын зам тээврийн сүлжээг боловсронгуй болгох асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

Өндөр хөгжилтэй Франц, Англи, АНУ зэрэг улсад замаас шалтгаалсан осол 28-30 хувь, тээврийн хэрэгслээс шалтгаалсан осол 18-23 хувь байна. Зам тээврийн ослоос үүдэлтэй нийгмийн эрсдэл 2012 онд /100 мянган хүнд ногдох зам тээврийн ослоос үүдэлтэй нас баралт/ 21 байсан бол 2018 онд 16,9, 2021 онд 11,2 болж тус тус буурсан хэдий ч Европын орнуудтай харьцуулахад ихээхэн өндөр байна. Энэ тоо ОХУ-д 13,8, Европын холбооны улсын хэмжээнд 5, Шведэд 2,7, Германд 3,9, Их Британид 2,8 тус тус байна. Энэ тоог тухайн улсын хэд хэдэн үзүүлэлттэй тухайлбал: хөдөлгөөнд оролцогчдын сахилга, соёл, хуулийн хариуцлага зайлшгүй хүлээлгэх тогтолцоо, жолооч бэлтгэх үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн ашиглалт, замын сүлжээний зохион байгуулалт, аюулгүй байдлын зохион байгуулалттай холбон үзэж байна.

Мөн хүн ба ачаа тээврийн үед оновчтой бус зохион байгуулалт, замын хөдөлгөөний аюулгүй байдлын удирдлагын алдаатай үйл ажиллагаа нь зам тээврийн осолд нөлөөлдөг болохыг тогтоосон байна.

Япон Улс 1960-аад оны үед зам тээврийн ослын улмаас нас баралт геометр прогрессоос өсөн нэмэгдэж, олон хүний амь нас эрсдэж байсныг тухайн үеийн Ерөнхий сайд нь анхааралдаа аван системтэйгээр тэмцэж эхэлсэн бөгөөд замын цагдаа болон мэргэжлийн судалгааны байгууллагаар зам тээврийн ослын шалтгааныг маш нарийн, шинжлэх ухааны үндэслэлтэй судлуулсны үндсэн дээр автозам барьдаг аж ахуйн нэгж, компаниудад жолооч зам дээр осол гарахгүй байх, нөхцөл, орчинг бүрдүүлэх, зорчин явахад аюулгүй байдлыг талаар шаардлага тавьж ажилласнаар хэдхэн жилийн дараа зорьсон үр дүндээ хүрсэн нь зам тээврийн ослын 100000 хүн амд ноогдох тоо нь 4.7-оос 2 болж буурсан байдаг бөгөөд замыг шинээр барьж байгуулах, засварлахдаа технологийн шаардлагыг чанд мөрдөж иж бүрнээр нь /замын инженерийн байгууламж, хөдөлгөөн зохицуулах хэрэгсэл гэх мэт/ шийдвэрлэж байх шаардлагатай гэж олон улсад үздэг байна.

Дэлхий дахинд замын хөдөлгөөний бодлого, зорилтыг тодорхойлж хэрэгжүүлэхдээ жолоочийн хурд хэтрүүлэхгүй байх ёс зүй, ухамсар, боловсролд чиглэсэн арга хэмжээг цагдаагийн хяналттай хослуулах, тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах болон хянах, инженерийн буюу зам барилга байгууламжийн бүтцэд чиглэсэн зохион байгуулалт, шийдэлд анхаарах мөн замын хөдөлгөөнд оролцогчийн соёлд түлхүү анхаарч, соёлжуулахад чиглэсэн нөлөөллийн арга хэмжээ зэргийг зохион байгуулдаг байна.

Манай улсын хувьд ч дээрх арга хэмжээнүүдийг үе шаттайгаар зохион байгуулж байгаа боловч үр дүн хараахан зорилтод хүрэхгүй байгаа нөхцөл байдал ажиглагдаж байгаа нь харамсалтай юм.

Дүгнэлт, санал. Улсын хэмжээнд 2016 онд 1328560 зөрчил бүртгэгдсэн бол 2020 онд 2058347, 2021 онд 1921887 зөрчил бүртгэгдсэний 1489089 буюу 77.5 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгджээ. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг зөрчил өнгөрсөн оны үеийнхээс 136460 нэгж буюу 6.6%-иар буурсан. Гэхдээ сүүлийн 5 жилийн үзүүлэлтийн дундаж буюу 2016 оны үзүүлэлтэй харьцуулан үзэхэд өссөн байна. Энэ нь захиргааны шийтгэлийн хэмжээ бага, урьдчилан сэргийлэх нөлөөлөл байхгүй, энэ ажлын үр нөлөө хүссэн үр дүнд хүрэхгүй байгааг илэрхийлж байгаа бөгөөд зам тээврийн осол, зөрчлийн шалтгаан нөхцөлийг зөв тодорхойлж, түүнд чиглэсэн урьдчилан сэргийлэх ажлын оновчтой арга замыг эрэлхийлэх шаардлага байгааг харуулж байна.

Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал нь олон улсын стандартад бүрэн нийцсэн авто зам төдийлөн байхгүй. Мөн ашиглагдаж буй техник хэрэгсэл, технологи хоцрогдсон, замын хөдөлгөөнд оролцогчдын ёс зүй, ухамсарт зан төлөв маш дорой байгаа гэх мэт хүчин зүйлийн нөлөөгөөр энэ олон зам тээврийн осол өдөр алгасалгүй бүртгэгдэж байна гэж үзэж байна. Иймд энэхүү сэдвийн хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна.

1. Монгол Улсад ашиглагдаж байгаа авто замуудыг олон улсын стандартад нийцэж буй эсэхийг мэргэжлийн байгууллагаар шалгуулах, стандартад нийцээгүй авто зам, замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрэл дохиог бүрэн шинэчлэх;

2. Олон улсад хэрэглэгдэж буй шинэлэг, дэвшилтэт технологийг Монгол улсад нэн даруй нэвтрүүлэх, богино хугацаанд нутагшуулах;

3. Замын хөдөлгөөнд оролцогчдын ухамсарт зан төлөв, ёс зүйд нөлөөлөх олон талт үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Нэг. Хууль тогтоомж

1. Монгол улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
2. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
3. Зөрчлийн тухай хууль

Хоёр. Ном, сурах бичиг, гарын авлага, өгүүлэл

1. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан ном \2018\
2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан ном \2019\
3. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан ном \2021\

Гурав. Цахим эх сурвалж.

1. Police.gov.mn
2. <https://mrtd.gov.mn/i/1996> Монгол улсын засгийн газар Зам тээврийн хөгжлийн яам.
3. Төрийн мэдээллийн эмхэтгэл 2015 он.

ХАРУУЛЫН АЛБАНЫ ЖУРАМ ЗӨРЧИХ ГЭМТ ХЭРЭГТ
ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА
RESPONSIBILITY FOR CRIMES OF VIOLATING
POLICE OFFICE RULES

Г.Мэндбаяр

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн
сургуулийн Дотоодын цэргийн албаны тэнхимийн
ахлах багш, хошууч

G.Mendbayar

Department of Internal Troops Service of the Police
School, University of Internal Affairs Mongolia
Senior Lecturer, Major

Хураангуй: Дотоодын цэргийн алба ажиллагаанд тусгагдсан харуулын албаны зохион байгуулалт, албан үүрэг гүйцэтгэж байхдаа харуулын албаны журам зөрчсөн, гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнд бүртгэсэн зарим зөрчлийн хэлбэр, нэр томъёо, гаргасан гэмт хэрэг, зөрчлийг бүртгэж, дүн шинжилгээ хийж байгаа байдлыг судлан үзэж энэхүү өгүүлэлдээ авч үзлээ.

Abstract: The organization of the guard service included in the internal military service, violation of the rules of the guard service while performing official duties, forms and terms of some violations recorded in the statistics of crimes and violations, and the recording and analysis of the committed crimes and violations. considered in the article.

Түлхүүр үгс: Цагдаагийн байгууллага, Дотоодын цэрэг, хугацаат цэргийн алба хаагч, цэргийн алба хаагч, Улсын онц чухал объект

Key words: Police, Internal military, conscripts, military service, State objects

Үндсэн хэсэг. Эзэн Чингис хааны хэвтүүл цэргээс эхтэй Дотоодын цэрэг нь 1922 онд дотоодын харуул хамгаалалтын үүргийг дагнан гүйцэтгэх зорилгоор ардын хувьсгалын партизанууд тулгын чулууг нь тавьсанаас хойш өнөөдрийг хүртэл төр засаг, командлалаас даалгасан үүргийг нэр төртэй биелүүлж байна.

1990 онд нийгмийн аюулаас хамгаалах яамыг татан буулгаж, цагдаагийн ерөнхий газар, биеэ даасан байгууллага болоход дотоодын цэрэг түүний бүрэлдэхүүнд шилжин харуул хамгаалалтын үүргээ урьдын адил гүйцэтгэх болсон байна.

Дотоодын цэрэг нь ЦЕГ-ын явуулж байгаа ажиллагаанд туслалцуулах зорилгоор олон нийтийн хамарсан арга хэмжээ /нийгэм-улс төрийн, соёл олон түмний, биеийн тамир спортын болон бусад/ явагдах үед элдэв төрлийн гоц халдварт өвчин гарсан үед хорио цээрийн дэглэм журмыг сахин хамгаалах, төв суурин газруудад гарсан нийгмийн хэв журмыг бүлэглэн зөрчих үйл ажиллагааг таслан зогсоох ба арилгах, гал түймэр, байгалийн төрөл бүрийн аюулаас улс нийгмийн өмч, нийгмийн хэв журмыг хамгаалах болон бусад ажиллагаануудад тогтоосон журмын дагуу оролцож хамгаалж байгаа үйлдвэрийн болон Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн колониудын дэглэм журам сахиулах үүрэгтэй болсон байна.¹⁴¹

¹⁴¹ <https://intr.gov.mn>. //Татаж үзсэн: 20.03.2024. Дотоодын цэргийн түүх

Дотоодын цэрэг нь өнөөдөр Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хангаж, улсын онц чухал объектыг хамгаалах, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсоох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх гамшиг, аюулт үзэгдэл, осол аюул тохиолдсон үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч ачаа тээшийг харгалзан хүргэх зэрэг үндсэн үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.¹⁴²

Дотоодын цэрэг нь тайван цагт бие даасан үйл ажиллагаа явуулдаг, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй, төрөл мэргэжлийн цэрэг юм.

Монгол Улсын Засгийн газраас тогтоосон онцгой ач холбогдол бүхий байгууллага, үйлдвэр, барилга байгууламжийг Улсын онц чухал объект гэдэг. Объектын хамгаалалт гэж улсын онц чухал объектын хэвийн ажиллагааг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалж байгаа объектод нэвтрэх хүн, эд зүйл, тээврийн хэрэгслийг шалгах, хамгаалалтын бүсэд тогтоосон дэглэм, журмыг сахиулах цогц үйл ажиллагааг ойлгодог.

Дотоодын цэрэг дэлхийн олон оронд байдаг. Жандармери, үндэсний гвард, зэвсэгт цагдаа гэх мэтчилэн өөр өөр нэршилтэй боловч гүйцэтгэж байгаа чиг үүргийн хувьд манайхтай ижил төстэй. Аль ч орны дотоодын цэрэг улс орныхоо дотоод аюулгүй байдлыг хангах чиглэлээр цагдаа, хууль сахиулах салбарын байгууллагуудтай харилцан ажиллаж, террорист халдлага, үймээн самуун гарсан үед дэг журам тогтоох, сөрөг тусгай ажиллагаа явуулахаас гадна улсын онц чухал объектыг хамгаалах, томоохон осол, сүйрэл, байгалийн гамшиг тохиолдсон үед сэргээн босгох, хорио цээрийн дэглэм сахиулахад дэмжлэг үзүүлж ажилладаг чухал алба.

Тийм ч учраас УИХ-аас 2017 онд Дотоодын цэргийн тухай хуулийг шинээр баталснаар дахин байгуулсан. Дотоодын цэрэг нь тайван цагт мэргэжлийн бие даасан үйл ажиллагаа явуулж, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлдэг төрийн цэргийн байгууллага болсон юм.

Дотоодын цэрэг нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, нууцыг чанд хадгалах, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх, захирах, захирагдах, хамгаалалт, аюулгүй байдлыг уян хатан, шуурхай тасралтгүй зохион байгуулах зарчмыг баримтална.

Дотоодын цэргийн анги байгууллага, алба хаагч нь Дотоодын цэргийн тухай хуулийн 11.1-д заасан дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Тухайлбал:

1. улсын онц чухал объектыг хамгаалах;
2. нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсооход дэмжлэг үзүүлэх;
3. гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул тохиолдсон үед болон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулашгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
4. шаардлагатай үед зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг харгалзан хүргэх;
5. террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагаанд оролцох;
6. хуулиар тогтоосон бусад чиг үүрэг.¹⁴³

¹⁴² <https://police.gov.mn> //Татаж үзсэн: 11.04.2024. Дотоодын цэрэг нь “Үндэсний аюулгүй байдлыг хангах” тусгайлсан чиг үүрэгтэй төрийн цэргийн байгууллага

¹⁴³ Төрийн мэдээлэл. 2017. №12 Дотоодын цэргийн тухай хуулийн 11 дүгээр зүйл 11.1

Дотоодын цэргийн алба хаагчийн албаны үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон нь Дотоодын цэргийн хуулиар зохицуулаагүй бусад харилцааг **дотоодын цэргийн алба-ажиллагааны** дүрэм болон цэргийн нийтлэг дүрмээр зохицуулдаг байна.

Монгол улсын засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 283 тогтоолоор батлагдсан Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэмд Анги, салбарт алба-ажиллагааг зохион байгуулах ажиллагааг зааж өгсөн байдаг. Гэвч Дотоодын цэргийн алба хаагчдаас зөрчил гаргаад байгаа нь тулгамдсан асуудал болоод байна.

Дэлхийн жишигт цэргийн алба хаахыг үүрэг болгосон, сонголт болгосон гэсэн хоёр үндсэн хувилбар үйлчилдэг. Монгол Улсын иргэний хувьд цэргийн алба хаах нь эр хүн болж төрсний ҮҮРЭГ бөгөөд заавал хаахаар хуульчилсан байна. Энэ нь үүрэг болохоос бахархал биш гэдгийг тодотгох хэрэгтэй" хэмээн дурдаж байсан. Ийнхүү үүргээ биелүүлэхээр цэрэгт очсон аавын хүү хэн нэгний /бусад цэргийн/ доог тохуу болж байгаа нь өөрөө хүний эрхийн зөрчил, хүчирхийллийн хэмжээнд хүрч байна. Бүх зүйл дээр хүний эрх нэн чухлаар тавигдаж буй 21 дүгээр зуунд цэрэгт алба хаах хугацаандаа учир шалтгаангүйгээр зодуулж, сэтгэл санаа, бие махбодь болон амь насаараа хохирч, хүний ёсноос гажууд үйлдлийн золиос болж буй тохиолдол манай улсад гарсаар байна.¹⁴⁴

Дотоодын цэргийн штаб, анги, тусгай салбаруудын сүүлийн 3-5 жилийн харуулчдын гаргасан зөрчилд судалгаа хийж үзлээ.

График №1. Алба хаагчдаас гаргаж буй зөрчлийн хэлбэр



Нийт зөрчлийн 27% хувийг харуулын цэгт унтсан зөрчил эзэлж байна. Зөрчлүүдийн дийлэнх хувийг, харуулын цэгт унтсан зөрчлүүд эзэлж байгаа ба алба хаагчдаас шөнийн цагаар үүрэг гүйцэтгэж байхад ихэвчлэн зөрчлүүд гардаг байна.

№	Гаргасан зөрчил	2018	2019	2020	2021	2022	Нийт
---	-----------------	------	------	------	------	------	------

¹⁴⁴ <https://ikon.mn> //Татаж үзсэн: 24.04.2024. Хуульч Б.Даваабазарын ярилцлагаас хэсэгчилэн авав.

1.	Хариуцсан харуулаа хангалтгүй удирдсан.	9	8	2	0	1	20
2.	Албаны бэлэн байдал хангаагүй	0	5	0	0	10	15
3.	Сонор сэрэмж сул	34	36	6	1	5	82
4.	Томилолтоос хоцорсон	6	5	2	1	0	14
5.	Томилолт тасалсан	6	2	4	22	37	65
6.	Харуул цэг түр орхисон	3	0	2	1	1	7
7.	Таних нрээр харьцаагүй	5	3	0	0	0	8
8.	Биед тусгай хэрэгсэл зүүгээгүй	18	3	0	0	3	24
9.	Үүрэг гүйцэтгэх журам, стандарт зөрчсөн	39	16	6	4	5	70
10.	Албаны үнэмлэхгүй	0	3	1	1	2	7
Нийт		120	81	23	30	74	238

Дээрхи хүснэгтээс үзвэл 2018 онд Дотоодын цэргийн алба хаагчдаас 120 зөрчил гарч байсан бол Ковид-19 гарсан 2020, 2021 онуудад эрс багассан ч 2022 онд буцаад өссөн нь анхаарал татаж байна. Алба хаагчдаас гаргасан зөрчлүүдээс сонор сэрэмж сул, томилолт тасалсан, үүрэг гүйцэтгэх журам зөрчсөн гэх зөрчлүүд давамгайлж байгааг анхаарах шаардлагатай байна.

График №3. Зөрчил илрүүлсэн хугацаа



Графикаас үзвэл Дотоодын цэргийн алба хаагчдаас гаргасан зөрчлүүдийн илэрсэн хугацааг харвал ихэвчлэн шөнийн цагаар зөрчил гаргадаг нь анхаарал татаж байна.

Хүснэгт №1. Зөрчлийн илрүүлэлт

№	Зөрчил илрүүлсэн арга	2018	2019	2020	2021	2022	Нийт
1.	Шуурхай удирдлагын жижүүр, хяналт шалгалтын офицерын хяналтар илрүүлсэн зөрчил	110	73	4	0	15	202
2.	Сорил шалгалтаар	25	28	0	0	15	68
Нийт		135	101	4	0	30	270

Зөрчил илрүүлсэн хэлбэрийг авч үзвэл ихэнхидээ Шуурхай удирдлагын жижүүр, хяналт шалгалтын офицерын хяналтар илрүүлсэн зөрчил эзэлж байгаа нь тухайн анги, салбарын дотоод хяналт шалгалт сайн явж байгаа гэж үзэхэд хүргэж байна.

Цэргийн нийтлэг дүрэмд зааснаар харуулын албыг зохион байгуулах, гүйцэтгүүлэх харилцааг дараах байдлаар зааж өгсөн байна.

Харуулын алба нь тайван цагийн байлдааны үүрэг бөгөөд харуулын бие бүрэлдэхүүнээс энэ дүрмийн бүх заалтыг дагаж мөрдөхдөө “Төрийн нууцын тухай”, “Төрийн нууцын жагсаалтын тухай”, “Батлан хамгаалах хууль”, “Зэвсэгт хүчний тухай хууль”, “Цэргийн албаны тухай хууль”, “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль” хуулиудын холбогдох заалтуудыг удирдлага болгон сонор сэрэмжтэй, шийдвэртэй, зориг тэвчээртэй байж идэвх санаачлагатай ажиллахыг шаардана.

Энэ дүрмийн шаардлагыг зөрчсөн цэргийн алба хаагчид цэргийн сахилгын болон эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна.

Цэргийн хүрээний ба харуулын албаны дүрмийн 5.4 дүгээр зүйл Улсын онц чухал байгууламжийн харуул, хамгаалалтыг Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрмээр зохион байгуулна.¹⁴⁵

Сахилгын зөрчлийг шалгахдаа Сахилгын дүрмийн 1.1-д заасан “Цэргийн сахилгын дүрмийн зорилго нь цэргийн сахилга, түүнийг сахин биелүүлэхэд цэргийн алба хаагчийн хүлээх үүрэг, сайшаал болон сахилгын шийтгэлийн төрөл, тэдгээрийг хэрэглэх захирагчийн эрхийг тодорхойлж, сайшаал хүртээх, сахилгын шийтгэл ногдуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино”¹⁴⁶ гэсэн агуулгын хүрээнд шийдвэрлэдэг байна.

Цэргийн сахилгын дүрмийн сахилгын дүрмийн 7.1 дүгээр зүйлд “Сахилгын шийтгэл гэж Монгол Улсын хууль тогтоомж, Цэргийн нийтлэг дүрмүүд, Цэргийн тангараг, цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, ангийн дотоод журмыг зөрчсөн, захирагчийн хууль ёсны тушаалыг биелүүлээгүй цэргийн алба хаагчийн үйлдэл, эс үйлдэхүйг сахилгын зөрчилд тооцно”¹⁴⁷ хэмээн тодорхойлсон байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 28.12 дугаар зүйл /Байлдааны жижүүр хийх журам зөрчих/-ийн 1.Гадаад улсын цэргийн халдлагыг цаг тухайд нь илрүүлэх үүрэг бүхий цэргийн алба хаагч байлдааны жижүүр хийх журмыг зөрчсөн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.2.Энэ гэмт хэргийг дайны байдалд шилжсэн, эсхүл онц байдал зарласан үед үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ гэсэн заалтуудыг үндэслэн эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байна.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 28.13 дугаар зүйл /Дотоод албаны журам зөрчих/-ийн 1.Цэргийн анги, байгууллагын хоногийн манааны /харуулаас гадна/ үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн алба хаагч дотоод албаны журам зөрчсөн бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ, мөн 28.14 дүгээр зүйл /Харуулын албаны журам зөрчих/-ийн 1.Харуулын албаны журам, түүний дагуу гарсан захирагчийн тушаал, захирамжийг зөрчсөн бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ¹⁴⁸ гэсэн заалтууд нь Дотоодын цэргийн алба хаагчдаас гаргаж буй ноцтой үйлдэлд хариуцлага хүлээлгэхээр тусгагджээ..

Дүгнэлт. Дотоодын цэргийн анги байгууллага, алба хаагчид хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Улсын онц чухал объектын хэвийн ажиллагааг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалж байгаа объектод нэвтрэх хүн, эд зүйл, тээврийн хэрэгслийг шалгах, хамгаалалтын бүсэд тогтоосон дэглэм, журмыг сахиулах бүхийл үйл ажиллагааг хийж гүйцэтгэж байгаа нь тайван цагийн байлдааны үүрэг.

Дотоодын цэргийн алба хаагч нь цэргийн дүрэм, Дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэм бусад холбогдох дүрэм журмыг, ягштал дагаж мөрдөх, нь хууль тогтоомжийг хэлбэрэлтгүй сахиулж байгаа үйл ажиллагаа юм.

Хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд алба ажиллагааны болон цэргийн дүрмийн хэрэгжилт, үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахад алба хаагчийн үйл ажиллагаа ихээхэн чухал юм.

¹⁴⁵ <https://www.academia.edu>. // Цэргийн хүрээний ба харуулын албаны дүрмийн 5.4 дүгээр зүйл

¹⁴⁶ Мөн дүрмийн 1.1 дүгээр зүйл

¹⁴⁷ Мөн дүрмийн 7.1 дүгээр зүйл

¹⁴⁸ Төрийн мэдээлэл. 2016., №07. Эрүүгийн хуулийн 28.14 зүйл

Иймд алба хаагчид албаны зохион байгуулалт харуулын албаны үүрэг гүйцэтгэлтэд идэвх зүтгэлтэй оролцож, холбогдох хууль дүрэм журам, зэргийг сайтар судалж, алба ажиллагаандаа ягштал мөрдөн биелүүлэх нь анхаарах асуудал юм.

Мөн алба хаагчид нь өөрсдийн ажил албан тушаал дээрээ эрх, үүрэг, хариуцлагаа ухамсарласнаар алба ажиллагааны зохион байгуулалт хангагдана гэж үзэж байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Алба хаагчид Дотоодын цэргийн алба-ажиллагааг зохион байгуулахтай холбогдсон хууль, эрх зүйн баримт бичиг, дүрэм журам, зааврыг нарийвчлан судалж суралцах.

2. Дээр дурдсан холбогдох дүрэм журам, зааврын хэрэгжилт хэрхэн хангагдаж байгаад анги байгууллагын эрх бүхий албан тушаалтангууд дотоод хяналт шалгалтыг тогтмол зохион байгуулж үр дүнг тооцох.

3. Алба хаагчдад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам зааврын талаар болон хариуцлагын тухай сургалтуудыг зохион явуулж, алба хаагчдыг чадваржуулах саналуудын тус тус гаргаж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

Нэг. Хууль тогтоомж, эрх зүйн актууд

1. Дотоодын цэргийн тухай хууль 2017 он
2. Цагдаагийн албаны тухай хууль 2017 он
3. Эрүүгийн хууль 2015 он
4. ЦБҮАЖ-Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам
5. ДЦҮАЖ-Дотоодын цэргийн үйл ажиллагааны журам

Хоёр. Ном сурах бичиг гарын авлага

1. МУ ерөнхийлөгчийн зарлиг Цэргийн дүрэм 2022 он

Гурав. Цахим эх сурвалж

1. <https://www.legalinfo.mn/>
2. <https://police.gov.mn/>